



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ



ЭНЭ ДУГААРТ:

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Монголын байгаль (өнгөрсөн, өдгөө, ирээдүй)- Хойч үе
/Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, гавьяат
хуульч **О.Амархүү** /.....4-7

**БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх-Ази дахь Үндсэн
хуулийн хяналтын тэргүүлэх загвар**
/Үндсэн хуулийн цэцийн ажилтан **Э.Лхагвасүрэн**/.....8-10

**Гадаадад амьдарч буй Монгол Улсын иргэдийн
сонгуулийн эрхийн тухайд**
/ХБНГУ-ын Бонн хотын Их сургуулийн докторант
Д.Үүрцайх/.....11-15

**Хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь орчин үеийн
төрийн эрх зүйн бодлого**
/ОТИС-ийн ХЗС-ийн захирал **Ц.Алтанцэцэг**/.....16-20



Шүүх эрх мэдэл

Нийслэлийн шүүхийн 80 жил
/Нийслэлийн шүүхийн шүүгч **Д.Дамдин-Од**/.....21-23

Дэлхий шүүхэд итгэнэ
/Улсын дээд шүүхийн шүүгч **А.Доржготов**/.....24-27



Криминологи

Шүүхээс ял ногдуулахад учирч буй бэрхшээл
/Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн тэнхимийн тэргүүн
Б.Сарантуяа/.....28-30

ДНК шинжилгээ
/Хуульч **Д.Батхуяг**/.....31-34

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд Эрүүгийн
хуулийн гүйцэтгэх үүрэг, тулгамдаж буй зарим
асуудал**
/Цагдаагийн академийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш,
докторант **О.Амарсайхан**/.....35-38

Өмгөөлөгч ба мөрдөн байцаагчийн харилцаа
/ОТИС-ийн ХЗС-ийн багш **Ж.Наранцацрал**/.....39-41

Танхайг тандахуй
/МБХ-ны Сургалтын хорооны дарга **О.Алтангэрэл**/.....42-43



Прокурорын хяналт

**Эрүүгийн хууль дахь хээл хахуулийн гэмт хэргийн
зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал**
/УЕПГ-ын хяналтын прокурор **Э.Амарбат**/.....44-46



Иргэний хууль тогтоомж

**Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн
үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн
харилцааны зохицуулалтын харьцуулалт**
/МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш,
докторант **С.Болормаа**/.....47-49

**Бараа, үйлчилгээний тэмдгийн эрх зүйн
зохицуулалтын талаарх зарим асуудал**
/ОТИС-ийн ХЗС-ийн багш **С.Эрдэнэболор**/.....50-55

Арбитрын тухай хуулиудыг харьцуулан судалсан нь
/ОТИС-ийн ХЗС-ийн багш **М.Сувд**/.....56-63

**Интернетээр гэрээ байгуулах эрх зүйн зохицуулалтыг
боловсронгуй болгох зарим асуудал**
/ОТИС-ийн ХЗС-ийн багш **Р. Очирбал**/.....64-69

Гэрлэлт болон түүнтэй холбогдох зарим асуудал
/ИБМУТ-ийн Төв орон нутгийн иргэний бүртгэл хариуцсан
ахлах мэргэжилтэн **Д.Янжмаа**/.....70-71



Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

**Монгол Улсын хууль тогтоомжийг Палермогийн
конвенцод нийцүүлэх нь: Өнөөгийн байдал**
/ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрхлэгч,
хууль зүйн доктор, профессор **Д.Зүмбэрэлхам**/.....72-74

БНХАУ-ын гэр бүлийн эрх зүйн зохицуулалт
/ХЗҮТ-ийн (ЭЗМНС-ийн) ажилтан **И.Түвшинзаяа**/.....75-76

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
/ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм
шинжилгээний ажилтан **П.Баяр**/.....77-81

**Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан
зарим конвенцын судалгаа**
/ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм
шинжилгээний ажилтан **С.Ганцэцэг**/.....82-86



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

**Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны
зарим асуудал**
/МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах
багш **Н.Дугармаа**/.....87-92

**Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ажиллагааны тулгамдсан асуудал**
/ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм
шинжилгээний ажилтан **Д.Оросоо**/.....93-94



Эрх зүйн үйлчилгээ

**Нотариатчийн ёс зүйн үндсэн зарчим , нотариатч
төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг болох нь**
/Баянгол дүүргийн тойргийн нотариатч **Д.Дуламцоо**/.....95-96



Огуулаг

Багш нь гэмт хэрэгтэн байжээ.....97-98

CONTENT:

State organization legislation

Mongolian natural environment (past, present and future) – Future generation /O.Amarkhuu, Prof, ScD/.....	4-7
The Constitutional court of Korea as the best model in Asia of Constitutional control /E.Lkhagvasuren, officer of the Constitutional court/.....	8-10
Right to vote of Mongolians who live in abroad /D.Uurtsaikh, PhD candidate of University of Bohn, Germany/.....	11-15
Contemporary Legal policy of the state in the sector for protecting child's right /Ts.Altantsetseg, Teacher of "Otgotonger" University, Law school/.....	16-20

Judicial power

The 10th anniversary of Metropolitan court /DDamdin-Od, Justice of Metropolitan court/.....	21-23
The world believes in Court /A.Dorjgotov, Justice of Supreme court/.....	24-27

Criminology

Issues on difficulty in Prosecution /B.Sarantuya, Justice of Metropolitan court/.....	28-30
DNA (Deoxyribonucleic) /D.Batkhuuyag, Researcher of NLC/.....	31-34
A role of the Criminal code in prevention of crime and issues on it /O.Amarsaikhan, PhD candidate, Teacher of Police Academy/.....	35-38
Communication between advocate and investigator /J.Narantsatsral, Teacher of "Otgotonger" University, Law school/.....	39-41
Pay attention Raffish /O.Altangerel, Head of Training center of Mongolian Advocate committee/.....	42-43

Prosecutors supervision

Issues on elaborating regulation of bribe in Criminal law /E.Amarbat, Supervising prosecutor, State General Prosecutor's office/.....	44-46
---	-------

Civil legislation

Comparison of regulation in Labor relations among public real servants and public service /S.Bolormaa, PhD candidate, Teacher of Mongolian National University/.....	47-49
--	-------

Issues on legal regulations of trademark /S.Erdenebolor, Teacher of "Otgotonger" University, Law school/.....	50-55
---	-------

Comparative studies of Arbitration laws /M.Suud, Teacher of "Otgotonger" University, Law school/.....	56-63
---	-------

Issues on elaborating the legal regulations in concluding a contract via internet /R.Ochirbal, Teacher of Otgotonger University, Law school/.....	64-69
---	-------

Issues on Marriage /M.Yanjmaa, Senior Employee of /.....	70-71
--	-------

International law, comparative law

Consummating legislations of Mongolia with Convention on Palermo: Present and Future /D.Zumberellkham, Prof, PhD, Head of Criminology studing sector, NLC/.....	72-74
---	-------

Family law regulations in Republic of China /I.Tuvshinzaya, LL.M, Employee of Legal Information System, NLC/.....	75-76
---	-------

Non-alignment /P.Bayar, Researcher of NLC /.....	77-81
--	-------

Issues on some Conventions of International Labor Organization /S.Gantsetseg, Researcher of NLC/.....	82-86
---	-------

Executory process

Studing some issues on Civil case of Executive procedure /A.Dugarmaa, Senior Teacher of Mongolian national University, Law school/.....	87-92
---	-------

Problems in administrative case of Executive procedure /D.Orosoo, Researcher of NLC/.....	93-94
---	-------

Legal service

Basic moral disciplines of Notary and impersonating state function /D.Dulamtsuo, Notary/.....	95-96
---	-------

Story

Teacher was criminal	97-98
-----------------------------------	-------

МОНГОЛЫН БАЙГАЛЬ (өнгөрсөн, өдгөө, ирээдүй) ХОЙЧ ҮЕ

ТҮҮХЭЭС ТОВЧХОН

Газар нутгийг төрөөс тусгайлан хамгаалалтад авах нь байгаль орчныг хамгаалах дэлхий дахины шалгарсан нэг арга мөн.

Монгол Улс энэ асуудлаар өнө эртний баялаг түүх, уламжлалтай орон. Дэлхийн анхны тусгай хамгаалттай газар нутаг бол Богд Хан Хайрхан уул юм. Энэ хайрханыг 1778 онд Дархан цаазтай болгожээ.

Ард олны уламжлалт зан үйл, эртний сүсэг бишрэл, бурхан шашины жаяг ёслол, төрийн хүндэтгэлийн үйл ажиллагааны ёс журмаар Монгол оронд:

- Хан Хэнтий нурууны Бурхан Халдун уул;
- Богд Хан Хайрхан уул;
- Очирваань Хайрхан буюу Отгонтэнгэр уул;
- Дарь овоо буюу Алтан Овоо зэрэг уул 300 гаруй жилийн тэртээгээс гусгай хамгаалалтад оржээ.

Эдгээр нь өдгөө ч хэвээр байж, төрийн тахилгат уул, овоо хэмээн өргөмжлөгдөн зон олнохоо бишрэл хүндэтгэлийг хүлээсээр байна.

Их Монгол Улсын үеэс эхлэн үндсэндээ ХХ зууны дунд үе хүртэл, өөрөөр хэлбэл, одоогоос тавь, жараадхан жилийн өмнө бид онгон тансаг байгальтай байж, түүнтэйгээ шүтэлцэн зохицож аж төрж түүгээрээ баясан бахархаж байсан. Түүнчлэн ирсэн, явсан, сонсож дуулсан харийн зочид гишчидийн сэтгэл зүрх, анхаарал гайхшрал баяр бахдалыг ч өөрийн



Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, гавьяат хуульч О.Амархүү

эрхгүй татаж, ёстой л нүдийг нь бүлгийлгэж байсныг хэн хэнгүй мэднэ гэдэгт итгэл дүүрэн байлаа.

Өнгөрснийг санагдуулах онгон тансаг байгаль маань өөрөө аяндаа үлдээд байсан хэрэг огт биш ээ.

Монгол хүний алсын хараатай уужуу мэргэн арга ухаан, байгальтайгаа энэрэл хүндэтгэлтэй, сүсэг бишрэлтэй, зүй зохистой, хайр гамтай хандан харьцаж сурсан ард түмний маань уламж-лалт зан үйл, Монгол төрийн холч мэргэн бодлого, нэн эртний хууль цааз зэрэг ухаалаг үйл явдлын хур шим бид бүхнийг тийм сайн сайхан байгаль орчинтой учруулсан, золгуулсан, ажиллаж

амьдруулсанд хамаг учир нь байгаа юм.

Чухам энэ нь өнөөдөр шинжлэх ухааны сонирхлыг илүүтэй татаж байгааг онцлон хэлмээр байна.

Монголчууд бидэнд тийм сайхан өв соёл, тийм сайхан философи сэтгэлгээ, тийм сайхан сүсэг бишрэл, ирээдүй хойч үеэ гэсэн энэрэнгүй зөөлөнт тийм сайхан хайр сэтгэл, төр, хууль цаазаа төвшитгөн дээдэлж ирсэн тийм сайхан төр ёс байсан, байсаар ирсэн гэдэг нь байгальдаа хандахад ч нэгэн адил хэрэглэгдэж байсан нь түүх шашир, ууль цаазын шарласан хуудсуудаас уул улмаар тодорсоор байгаа билээ.

Харин одоо байдал нэг л бишдэж, уламжлал ч бүрхэгдэн бүүдийж, хууль цааз ч нэг их тоогдохгүй болж байгаа нь байгалийн баялгийн хямралд ойртуулж байгаа биш үү. Үүнд л олон нийт бүхмидэж, амар амгалан байж чадахгүйд хүрээд байгааг хэлээд яриад байгаа нь сэтгэл түгшээж буй.

ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛААС ТОВЧХОН

Монгол эх орон маань 156 сая 400 мянган га нутаг дэвсгэртэй. Энэ хэмжээ хязгаарын дотор бэлчээр, тариалан, хадлангийн талбай, уул ус, ургамал, ой мод, ан амьтан, ашигт малтмал, агаар мандал гээд бүх баялаг оршин байршиж, амьдарч үржин төлжиж, бас ч үхэж мөхөж үгүй болж байдаг билээ. Монгол Улс нутаг дэвсгэрийнхээ хэмжээгээр дэлхийд 17 дугаар байрт, нэг хүнд ногдох газрын хэмжээгээрээ дэлхийд эхний байранд ордог. Энэ бол маш сайхан тоо баримт, статистик мөн гэдгийг сонордоход бахархахаас өөр аргагүй.

Гэсэн ч сэтгэл сартхийлсэн, бас түгшээсэн хэдэн тоо баримт хэлэх нь зүйн хэрэг болоод байна. Айлгаж, сандраах гэсэндээ биш асуудал бишдэж байгааг ухааруулж, санах сэдэв, ажиллах, хийж бүтээхгүй бол юунд ч хүрч болохыг анхааруулах гэсэндээ тэр юм.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал /хувиар/



Монголын байгаль орчин, байгалийн баялгийн төлөв байдал 1960-аад оноос эхлэн жилийн жилд муудан доройтсоор байгаа нь судалгаа шинжилгээ, бүр энгийн ажиглалтаар ч алба, амины аль алинд нь сүрхий мэдрэгдэн тодорсоор байна. Цөөн хэдэн зүйлээр жишээ болгоё.

Газар нутаг

Албан ёсны бэлчээр болоод, бэлчээрт тохиромжтой гэж тооцогддог газар 130,7 сая га. Энэ нь улсын нийт нутгийн 83.6 хувийг эзэлдэг. Гэтэл бэлчээрийн 80 орчим хувь нь эзгэдэл, эвдрэлд ямар нэг хэмжээгээр өртсөн:

- 70-аад хувь нь талхлагдсан;
- 24 сая га бэлчээрт үлийн цагаан оготоно тархсан;
- 20 гаруй сая га-д царцаа ургамлын бүрхэвчийг идэж сүйтгэсэн.

Эдгээр тоо баримт уламжлалт бэлчээрийн мал аж ахуй Бодитой, тодорхой бэрхшээлтэй тулгарч байгаагийн гарцаагүй баримт.

Тариалан

Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ бол хүн ардын хоол хүнсний эрхэмлэхүй эрдэнэ. Бүгдийг газраас хүртэнэ. Гэтэл газар тариалангийн байдал ямар болчихоод байна вэ?

- Сүүлийн 10 жилд 436 мянга 500 га тариалангийн талбай атаршиж хаягдсан;
- Тариалангийн талбайн 46.5 хувь нь эзгэдэж эвдэрсэн, үүний 12.9 хувь нь хүчтэй эвдэрсэн.

Ийм болчихсон талбайгаас хүнсний сайн чанарын болон их ургац авах боломжийг нь ойлгомжтой.

Нэг га-гаас 20-40 хүртэл центнер үр тариа хураан авч багтаах сав суулгагүй болж Голын цэнгэлдэх –наадым талбайдаа нуруудан хурааж байгаад гадаадад худалдаагаж байсан ойрхоны түүхийг манай тариаланчид тун сайн санаж байгаа.

Харин одоо янз бүрийн улс орноос үр тариа, гурил гуйж амь зууж ядаж байгааг ялтай билээ.

Монгол орны газрын харилцаанд цоо шинэ эрх зүйн үндсийг 1992 оны Үндсэн хуулиар анх удаа баталгаажуулан тавьж, 2002 онд “Монгол Улсын иргэнд газар

өмчлүүлэх тухай” хууль баталсан.

Газрыг хувьд өмчлүүлэх нь манай орны хувьд түүхэн цоо шинэ асуудал байв. Энэ бол ардчилал, зах зээлийн эдийн засгийн жамаар гарсан үндсэн эргэлт юм.

Монголчууд “газар” хэмээх хувийн үндсэн хөрөнгөтэй байж, ахуй амьдралаа өөд татах нэг бололцоо тийнхүү нээгдэв.

Харин гол нь хугацаа алдах, маргаан, тэмцэл гарах, гачигдал, дутагдал их байгаагаас иргэд газрыг хувийнхаа өмч болгож авах ажил сэтгэл хангалуун бус байгаа.

Орон нутгийн төр, захиргааны байгууллага, холбогдох албан тушаалтны хүнд суртал, хууль бус ажиллагааны нөлөө ч байдаг бололтой.

2006 оны 8 дугаар сарын 1-ний байдлаар Монгол Улсын иргэн 142019 айл өрхөд 16067 га газар өмчлүүлж өгөгдөж байжээ. Үүний 83441 айл өрх нь хөдөө нутгийн, 58578 айл өрх нь Улаанбаатарынх байна.

Газар өмчлүүлж эхэлснээс хойш бүтэн 4 жил өнгөрөөд байхад дээрх тоо их чамлалттай байна.

Манай иргэд ч санаачилга хүсэлтээ сайн болгох, орон нутгийн захиргаандаа шаргуу, тулгуулан, хүчтэйхэн хандах цаг болчихсныг дээрх баримт харуулж байгааг сануулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ус

Монгол орон усны нөөцөөр бага боловч цэвэр цэнгэг усныхаа нөөцөөр дэлхийд дээгүүр тооцогддог улс. Гэтэл цэвэр ус маань хомсодсон, бохирдсон, чанар нь доройтсон ийм аюултай учрах боллоо.

- 2003 онд хийсэн усны тооллогын дүнгээр 372 гол горхи, 1158 булаг шанд, 573 нуур, тойром ширгэсэн мэдээтэй.

Улсын хэмжээнд жилд 120 сая гаруй шоо метр ус бохирдож байгаа.

Туул голын ус Улаанбаатар хот, Сонгино хайрхан уулаас доош хэсэгт хүлцэх хэмжээгээс 10-30 дахин давж бохирдож байгаа.

Манай улсын 329 сумын төвийн 72-ынх нь ус эрдэсжилттэй, 86-ынх нь хатуужилттэй гэсэн судалгаа байдаг. Энэ бол эрүүл мэндэд хортой усаар ундаалж суугаа гэсэн үг.

Ой

Манай орон ойг нөөцөөр ядуу орны тоонд ордог. Нийт нутгийн дөнгөж 9.4 хувийг ойн сан бүхий газар эзэлдэг. Ийм жахан ой маань хорогдон хорогдоосор байх юм.

- Сүүлийн 5 жилд ойг эзэрийн талбайг дөнгөж 2 сая шахам га-гаар хорогджээ. Үүнээс зөвхөн модыг нь огтолсон талбай 1 сая 800 мянган га байгаа.
- Манай орны ой модонд 400 орчим төрлийн хөнөөлт шавьж онцгой хохирол учруулдаг.
- Модны хулгайчид малын хулгайчдаас дутахааргүй боллоо.

Ой мод дуусчихвал ус чийг, агаар тээд амьдралын амин сүнс арилна. Хүн бүр жилд ганц мод тариад арчлаад, ургуулаад байвал Дурдсан аюулыг цааш түлхээд, бүр арилгаж ч чадах учиртай.

Багаас эхэлж арвижуулан өргөжүүлээд байвал илүү үр дүн өгнө гэж бодож байна. Үүнтэй уялдуулан нэг жишээ хэлэхэд Засгийн газар 30 жилийн дотор 200 мянган га газрыг ойжуулж, Монгол Улсыг “Ногоон хэрэм”-ээр хүрээлүүлэх хөтөлбөрийг 2005 онд баталсан. Тэгж чадвал түүн шиг сайхан юм хаа байхав.

Мод тарьж ойжуулах нь их зардал, хүч чармайлт, ийггүй нямбай ажиллагааг цаг үргэлж шаарддаг адармаатай ажил гэдгийг мэргэжлийн хүмүүс төдийгүй, энгийн ард ч сайн мэднэ. Зөвхөн Туулын гүүрээс “Чингис хаан” олон улсын нисэх буудал хүртэлх 10-аад км замд мод тариад 46 сая төгрөг хэрэгтэй гэсэн тооцоо гарчээ. Энд мод тарьж ургуулах гэсэн оролдлогыг миний л мэдэхийн 2 ч удаа хийгээд олигтой амжилтад хүрээгүй. 10 гаруй жилийн өмнө тэр ажлыг Япон улсын аялал жуулчлалын ажилтан Янагасава гэдэг хүн эхлүүлсэн. Гэтэл одоо ямаруу байдалтай байгаа билээ дээ? 250 мянган га мод тарьж ургуулахад хэд хичнээн хөрөнгө шаардагдах бол?

“Ногоон хэрэм” гэж сүржингэний оронд Улаанбаатар хотгоо ноооруулах, зулзгүүлэх хөтөлбөрөөс эхэлсэн бол нүдэнд харагдах, гарт баригдах юмтай болох биш үү гэж мэтийн ухаалаг ажилч хэрэгтэй баймаар.

Ашигт малтмал

Монгол нутагт маань алт, мөнгө, зэс, молибдин, хар, цагаан тугалаг, гянтболд, төмөр, уран, жонш, нүүрс гээд 80 гаруй төрлийн ашигт малтмал газрын хэвлийд оршдог гэдэг. Тэдгээрээс 8000 гаруй илэрцийг тогтоогоод байгаагийн 50 орчим хувийг нь ашиглаж байгаа. Байгалийн баялгийг хав дарж суудаггүй, байгалийг ашиглаж хамгаалдаг онол, сургааль дэлхий дахины жишиг байдаг. Ашиглахдаа хамгийн зүй зохистой, иж бүрэн, шинжлэх ухаанчаар хандаж, ашиглалт, хамгаалалтыг зэрэгцүүлэн хийдэг дэлхий дахины жишиг аль хэдийнээ хэвшил болсныг онцлон дурдмаар байна.

Гэтэл манайд:

- Хайгуул, ашиглалтын лицензийг хууль бусаар олгодог, дамлан буюу дамжуулан худалдаж хууль бус ашиг орлого олдог;
- Олзворлосон баялгаа дэлхийн жишиг үнээс доогуур, хямд үнээр гадаадад ил, дагд гаргадаг;
- Ашигт малтмал олзворлолтыг иж бүрнээр биш сорчлон ашиглаж, хагас хугасыг нь ухсан малтсан газартаа үлдээж хаядаг.

Ашигт малтмал олзворлолтын явцад жилдээ 86 сая м³ газрын хөрс, хэвлийг хуулж, баргийг нь нөхөж сэргээлгүй онгорхой цоорхой, хагархай сэглэж хаядаг. Ингэж хаясан газрын ихэнх хувийг бэлчээр, тариалангийн талбай эзэлж байгаа нь ёстой л "Алтыг нь аваад, авдрыг нь хаядаг" үлгэр, араншин Монгол нутагт л үзэж, харж болдог байна. Шинэ хууль гарсан ч байдал өөрчлөгдөж олигийг үр дүнд хүрэх оролдлого багасч, хууль эхнээсээ л шүүмжлэгдэж, дахин засвар өөрчлөлт хийгдэх яриа шуугиан байнга л чих дэлсэх боллоо.

Ан амьтан, ургамал

Дэлхийд болон Төв Азид онц ховордсон олон төрлийн ан амьтан Монгол оронд нутагладаг, амьдардаг, өсч үрждэг гэсэн чихэнд чимэгтэй мэдээ олныг баясагдаг цаг саяхан байж. Гэтэл Монголд тэрхүү ховор амьтад төдийгүй олон зүйл онц ховор ургамал цөөрсөөр, хорогдсоор, зарим нь бүр устаж үгүй болж байгаа

баримт гуниг төрүүлсээр.

- Хамгийн сайн мэддэг тарвага гэхэд л хэдэн жилийн өмнө 13 сая гэж тоологдож байсан бол одоо 4 сая болжээ.
 - Халиун буга 60 мянга гэдэг байсан бол 6 мянга болжээ.
 - Бусад ан амьтан, жигүүртэн шувуу, загас мөн л ихээхэн цөөрсөөр.
 - Соргог бөхөн, цөөвөр чоно устсан.
- Ер нь судалгаагаар нотлогдсон тоог бөөндүүлж хэлбэл, цаашидаа 102 зүйл амьтан, 128 зүйл ургамал устах аюулд хүрч болзошгүй гэсэн мэдээтэй.
- Эмчилгээ болон хүнсний зориулалтаар ашигладаг 382 зүйл ургамлаас 195 зүйлийг зайлшгүй хамгаалтад авах шаардлага тулгарсан байна.

Ийм их үнэ цэнтэй байгалийн баялаг бид бүхнээс, төр, засгаас "аврал эрж хүлээсээр л" байна.

Агаар

Хийн мандлын агаар бол эрүүл мэнд бий, амьд явахын гол баталгаа мөн.

Монголчууд агаарын бохирдлыг мэддэггүй байсан цаг үе ердөө 60, 70 жилээр л тоологддог.

Өдгөө агаарын бохирдлыг "гамшиг" гэж цоллодог боллоо.

Улаанбаатар хот маань агаарын бохирдол ихтэй хотуудын тоонд орлоо. Хүйтний улиралд агаарын бохирдол хүлцэх хэмжээнээс 10 дахин давдаг болжээ:

- Гэр хорооллын түлш, 100 шахам мянган автомашины угаарын шатсан хий агаарын бохирдлын гол эх үүсвэр боллоо;
- Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал агаарын бохирдолд бас их нөлөөлж байна.

Агаарын бохирдлыг бууруулж хүн амаа эрүүлжүүлэхийн төлөө төр, засаг, түмэн олон их ч ярьж, янз янзын л арга сэдэж байна:

- Улаанбаатар хотыг нүүлгэнэ л гэнэ;
- Гэр хороололгүй болгож бугдийг цэвэр цэмцгэр байшинтай болгоно л гэнэ.

Чаддаг бол сайхан л хэрэг. Даанч их цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардах бэрхшээл цаана нь зогсож

байна шүү дээ.

Арай хялбар, бодит боломжийн ажлаас нь даруйхан эхэлбэл үр дүн нь түргэн тусах болов үү гэж бодох юм:

- Утаагүй буюу утаа багатай түлш нэвтрүүлж;
- Бүрэн шаталттай зуух нэвтрүүлж;
- Түлшний хэрэгцээг хий, цахилгаанаар орлуулах;
- Халаалтын жижиг өврын техник тоног төхөөрөмж хэрэглэх;
- Нар, салхины цахилгаан үүсгүүр хэрэглэх.

Энэ бүхэнд улсаас зориуд тусгайлан хөрөнгө гаргаж өгөх, ядуу зүдүүд нь гар таталгүй тусалцаа үзүүлж, үнэ төлбөргүй олгох гэх мэтийг эхний ээлжийн арга хэмжээ болгож хэрэгжүүлбэл шийдлийн эхний боломжийн хувилбар болох биш үү гэж санагдана.

Байгаль орчин жилээс жилд доройтсоор байхад төр, засаг түмэн олон юу ч хийхгүй, зүгээр суугаад байгаа юм бишээ. Янз бүрийн л ажил арга хэмжээ авч байна. Үгүйсгэх учиргүй, гэсэн хэдий ч байгалийн өөрчлөх нь хувьсал өөрчлөлт, хүний хүчин зүйлийн нөлөө тийм ч амархан дийлдэж давагдаж, цаана нь хурдан гарч болохооргүй бодит учир байдал байсаар байгааг анхаарахгүй байж болохгүй. Тэгэхээр гэнэдээ ч, гоондоо ч байгаа гэдэг үг таармаар юм шиг бололтой.

Одоо л зоригтой, дорвитой, үзэгдэж мэдэгдэхүйц, бодитой ажил цаг ацалгүй эхлэхгүй бол "галт тэрэг аль хэдий нь хөдөлчихсөн" шүү дээ.

**БАЙГАЛЬ, ХОЙЧ
ҮЕИЙНХНИЙ ХУВЬ ЗАЯА**

Юуны өмнө гутрангүй үзэлд автагдаж болохгүй. Байгалийг сэргээж, засварлаж, сайжруулж, сайн сайхан байдалар нь байлжа, тийм байдалд нь оруулж болдог шинжлэх ухаан, технологи, арга ажиллагаа байдаг. Тэр нь үргэлж хөгжиж дэвшина. Гэхдээ "өргөс авсан шиг" биш гэдгийг санах ёстой.

Хойч нь маань эрүүл, аюулгүй орчинд амьдрах хувь заяатай төрсөн гэдэгтээ итгэж байх учиртай. Харин хувь заяа өөрөө хүрээд ирэхгүй, гагцхүү хүн өөрөө ажиллаж байж

бий болгоно.

Байгаль дэлхий хэн хүний амьдрах орчин, гэр орон. Гэр орондоо цэвэр цэмцгэр, элбэг дэлбэг хоол унд, гоё ганган хувцас хунартай амьдрахыг хүсдэггүй хүн гэж дэлхий ертөнцөд үгүй. Энэ нь Монгол байгаль, Монгол хүн бүхэнд бүр ч илүүтэй хамаарна. Ингэхээр байгалиа хамгаална гэдэг бол өргөн утгаараа хүн өөрийгөө хамгаална гэсэн үг юм.

Өнгөрсөн нийгэмд байгалийг хүнээс хамгаалдаг байсан бол, өдгөө хүний төлөө байгалийг хамгаалдаг шинжлэх ухаанч үзэл баримтлал төлөвшөөд байна. “Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд “Байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.” гэж энэхүү утга санааг хуульчлан баталгаажуулж өгсөн нь ердийн хэрэг биш.

Байгаль орчноо дан ганц төр, засгаар хамгаалуулчихаад сууж байна гэж бодож санах хүн гарахгүй бизээ. Хүн бүр төр, засагтайгаа хамтарч, харилцан туслалцаж, нэгдэн нийлж байгалиа хамгаалж, сэргээж, зөв зохистой ашиглах учиртай, тийм хуультай.

Хүн бүрийн хувьд байгалиа хамгаална гэж нэг их том том юм бодоод суух хэрэггүй. Тэрийг төр, засаг бодно. Хүн бүрийн санах, сэдэх зүйл бага байлаа ч гэсэн жижигдэхгүй.

Хамгийн наад захын зарим зүйлийг жишээ болгон хэлбэл:

- Юуны өмнө хуулиа дээдлэн сахиж, дүрэм журмаа сахилгатай, ухамсартай биелүүлж сурцгаая. Байгаль орчны хууль зөрчсөн статистикийг улсын хэмжээнд авч үзвэл:
- Ойн хуулийн зөрчил – 41.5 хувь;
- Газрын хуулийн зөрчил – 19.6 хувь;
- Ангийн хуулийн зөрчил – 13.9 хувийг тус тус эзэлж байна. Ер нь манай орны эдийн засаг, нийгмийн салбарт хамгийн олон хуультай нь байгаль орчин, 40-өөд төрөлжсөн хуультай байгаа юм. Хүний амьдрал, эрүүл мэнд учир аргагүй шүү дээ.
- Өвөг дээдсийн уламжлалт зан үйлийг судалж, суралцаж, үр хүүхэд, ач, зээ нартаа сургаа.
- Байгалийн баялагт шунаж сувдаглалгүй хэрэгцээндээ тааруулж ашиглаж сурцгаая.
- Гэр, хашаа, байр, байшингийнхаа орчин тойрныг тохижуулан мод бут тарьж, зүлэг суулгаж ногооруулан арчилцгаая.
- Хөг хаягдлаа “Үйлдвэрлэлийн болон ахуйн хөг хаягдлын тухай” хуулийн ёсоор хуурай, нойтноор нь ялган уутлан савлаж хэвшицгээе.
- Ундааны сав, чихрийн цаас, тамхины иш зэргийг ил задгай хаядаггүй байж хэвшицгээе.

- Гудамж талбайн мод, бут, цэцэг зүлгээ хугалахгүй, гэмтээхгүй, гишгэхгүй, гарц замаар явж сурцгаая.

- Ил задгай гал түлж, түймрийн аюул гаргахаас үргэлж болгоомжлон сэрэмжилцгээе.

- Өт хорхой, эрвээхэйнээс эхлэн амьтай бүхнийг энэрсэн хайрлаж, сүйтгэхгүй, алж устгахгүй байцгаая.

- Байгалиас хулгайлахыг цээрлэн тэвчицгээе.

- Байгалийнхаа хувьд чадахгүй, мэдэхгүй, хүсэхгүй гэсэн бодол, сэтгэлгээнээс бүрнээ салцгаая.

Төр, засагтаа хандаж бас хэдэн үг хэлмээр байна:

· Бэлчээрийн тухай маш нарийн бодож зохицуулсан тусгай хуультай болмоор байна;

· Агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлөх хууль боловсруулж баталмаар байна;

· Байгаль орчны мэргэжлийн хяналтыг Байгаль орчны яаманд байлгахаар бүтцийн өөрчлөлт хийж, яамны гол гол албаны хүмүүст улсын байцаагчийн эрх эдлүүлмээр байна.

Ер нь бодлогынхоо, хуулийнхаа хяналтыг хийдэггүй “бодлогын яам” байх нь шинжлэх ухаанаас холдон хөндийрч байгаа хэрэг гэж үзэж байна.



БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх- Ази дахь Үндсэн хуулийн хяналтын тэргүүлэх загвар

VI Бүгд найрамдах улсын үеэс буюу 1988 оноос БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн гэж үздэг. Тухайн үед батлагдсан Солонгосын Үндсэн хуулиар хууль дээдэлж, ардчилал, шинэчлэлд суурилсан шинэ шүүхийн системийг буй болгох, Үндсэн хуулийг зөрчигдөөхөөс хамгаалах, иргэдийн Үндсэн эрхийг хамгаалах чиг үүрэгтэйгээр Үндсэн хуулийн шүүхийг байгуулжээ.

Өдгөө БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуульд албан ёсны тайлбар гаргах, Үндэсний ассамблейгээс батлагдсан хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, эрх зүйн бусад акт Үндсэн хуульд нийцсэн эсэх, импичмент буюу төрийн өндөр албан тушаалтныг огцруулах эсэх талаар шийдвэр гаргах, улс төрийн намыг татан буулгах асуудлыг хэлэлцэх, эрх мэдлийн маргаан буюу төрийн байгууллага хоорондын, төрийн байгууллага болон орон нутгийн байгууллага хоорондын Үндсэн хуулийн маргааныг хэлэлцэх, түүнчлэн иргэдийн үндсэн эрх зөрчигдсөн эсэх тухай маргааныг тус тус хянан шийдвэрлэх эрх хэмжээг хэрэгжүүлж байна.

Тус улсад Европ загварын Үндсэн хуулийн хяналтын механизм нэвтэрч эхэлсэн үеийг харьцангуй эрт үеэс эхлэн тооцдог. Учир нь Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн систем нь улс төрийн тогтолцооноос хамаарч байнга өөрчлөгдөж ирсэнтэй холбоотой. Тухайлбал, анхны буюу I /1948-1960/, IV /1972-1981/, V /1981-1988/ Бүгд найрамдах улсын үед Үндсэн хуулийн зөвлөл, II /1960-1961/ Бүгд найрамдах улсын үед Үндсэн хуулийн шүүх, III /1961-1972/ Бүгд найрамдах улсын үед Америк загварын Үндсэн хуулийн хяналтын байгууллагыг буй болгох зорилгоор эрх зүйн үндсийг хуульчилсан



Үндсэн хуулийн цэцийн
ажилтан Э.Лхагвасүрэн

байдаг. Гэвч эдгээр байгууллага нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаггүй, зарим тохиолдолд "бэлгэ тэмдэг"-ийн ч гэж хэлж болохоор шинэжтэй байсан.

Харин II Бүгд найрамдах улсын үед байгуулагдсан Үндсэн хуулийн шүүх нь тодорхой хүрээнд үйл ажиллагаа явуулж эхэлсэн хэдий ч Иргэний дайны улмаас цаашид ажиллах боломжгүй болсон байна.

Иймээс VI Бүгд найрамдах улсын Үндсэн хуулийг санаачлагчид шинэ, ардчилсан Үндсэн хуулийн шүүхийг бий болгох асуудлаар санал нэгдэж, улмаар шинэ маягийн Үндсэн хуулийн шүүх Солонгос Улсын Үндсэн хуулийг сахин хамгаалах үүргээ бодитойгоор хэрэгжүүлж эхэлсэн түүхтэй.

1988 оноос хойш өнөөг хүртэл 6870 хэрэг, маргааныг Үндсэн хуулийн шүүхээр хэлэлцэж, үүнээс 6370 гаруйг эцэслэн шийдвэрлэсэн, мөн 500 орчим маргааныг хэлэлцэхээр бэлтгэж байгаагаас харахад Солонгосын Үндсэн хуулийн шүүх ямар их ачаалалтай ажилладаг болох нь тодорхой юм.

Энх тайвныг эрхэмлэх, өгтөгс өвгөдөөс өвлөсөн ёс заншлаа

хамгаалах, сайн сайхан ирээдүйг бий болгох, ардчилал, шударга ёсыг төлөвшүүлэхийн төлөө гэх Солонгос үндэстний 5000 орчим жилийн эрмэлзлэлийг шинээр байгуулагдсан Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн төвшинд шударгаар хамгаалж чадахаа өнгөрсөн 20 жилийн практикаараа нэгэнт нотолсон болно. Түүнчлэн Солонгосын ард түмний ардчиллын төлөө сэтгэл зурх нь Үндсэн хуулийн шүүхийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд цаг ямагт өмөг түшиг болсоор иржээ.

Нөгөөтэйгүүр шинэ Үндсэн хуулийн шүүх өмнө нь "ажиллаж" байсан I-V Бүгд найрамдах улсын үеийн Үндсэн хуулийн зөвлөл, Үндсэн хуулийн шүүх нь, Америк маягийн Үндсэн хуулийн хяналтын механизмаас үйл ажиллагаа, эрх хэмжээ, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт зэрэг бүхий л талаараа өөр байсныг дурдах хэрэгтэй. Түүнчлэн энэхүү Үндсэн хуулийн шүүхийг Солонгосын Үндсэн хуулийн түүхэнд цоо шинээр буй болсон Үндсэн хуулийн байгууллага гэдэгт өдгөө маргах хүн үгүй болжээ.

БНСУ-ын шинэ Үндсэн хуульд "Үндсэн хуулийн шүүх нь Солонгосын ард түмний бүрэн эрхийг илэрхийлж..., иргэдийн үндсэн эрх зөрчигдөөхөөс хамгаалах..., гэхчлэн тодорхойлсон явдал нь Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн дагуу ард түмнийг төлөөлөх байгууллага болсны тод ирлэл юм.

Солонгост Үндсэн хуулийн шүүхийг Үндэсний ассамблей, Засгийн газар, Улсын дээд шүүхтэй адил төвшинд ойлгодог бөгөөд эдгээр байгууллагын эрх хэмжээний хүрээ хязгаарыг хянадаг шинээр нь 4 дэх засаглалыг төлөөлдөг ч гэх хандлага бий.

Үндсэн хуулийн шүүхийн бүтэц, зохион байгуулалт

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь хууль зүйн дээд боловсролтой, 40 нас хүрсэн Солонгос улсын иргэн байна. Мөн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр томилогдохын өмнө дараах албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан байхыг шаарддаг. Үүнд:

1. Шүүгч, прокурор, өмгөөлөгч;
2. Төрийн, Үндэсний болон олон нийтийн байгууллага, Засгийн газрын санхүүжилттэй хүрээлэн, болон бусад корпорацид мэргэжлээрээ;
3. Улсын их дээд сургууль, коллежид хууль зүйн туслах профессороос дээш зэрэгтэйгээр багшилж байсан.

Үндсэн хуулийн шүүх нь 9 шүүгчийн бүрэлдэхүүнтэй бөгөөд тэдгээрийн 3-ыг БНСУ-ын Ерөнхийлөгч, 3-ыг Үндэсний Ассамблей, 3-ыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс нэр дэвшүүлж, БНСУ-ын Ерөнхийлөгчөөс 6 жилийн хугацаагаар томилдог.) Үндсэн хуулийн шүүхийн даргын нийт шүүгчдийн дотроос нэр дэвшүүлж, Үндэсний Ассамблейн саналыг харгалзан Ерөнхийлөгч томилоно. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч дахин томилогдох эрхтэй. Шүүгчийн насны дээд хязгаар 65, харин даргын хувьд 70 нас байдаг.

Үндсэн хуульд нийгцсэн эсэх тухай аливаа маргааныг шийдвэрлэхэд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бие даасан байдлыг хангах явдал хамгаас чухал болохыг Солонгос улсад ихэд анхаарч, энэ талаархй зохицуулалтыг ч холбогдох хууль тогтоомжид тусгасан.

Тухайлбал, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг өөрийн хүсэлтээ гаргасан, эсхүл эрүүгийн хэрэгт холбогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гарснаас бусад тохиолдолд түүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө албан тушаалаас нь очруулах эрхгүй.

Үндсэн хуулийн шүүхийн дарга, шүүгчдийн цалин, хангамж нь Улсын дээд шүүхийн шүүгчдийн цалин, хангамжтай адил төвшинд байдаг. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, аль нэг улс төрийн намын харьяалалтай байхыг хориглохос гадна Үндэсний ассамблей, дотоод зөвлөлийн

гишүүн; Үндэсний ассамблей, Засгийн газар, ердийн шүүхийн болон олон нийтийн байгууллагын албан тушаалтан; компани, нөхөрлөл, төрийн бус байгууллагын зөвлөх, удирдах болон бусад албан үүргийг давхар хашихыг хуулиар хориглодог.

Үндсэн хуулийн шүүхийн дарга шүүхийг гадаад, дотоодод төлөөлөх, шүүгчдийн зөвлөлгөөн болон их хуралдааныг даргална. Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн өөрийн үйл ажиллагаандаа баримтлах дүрэм, журмыг нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэн батлах бөгөөд энэхүү дүрэм нь төрийн албан ёсны мэдээлэлд нийтлэгддэг.

Мөн Үндсэн хуулийн шүүхэд шүүгчдийн зөвлөгөөн ажилладаг. Энэхүү зөвлөгөөнөөр шүүхийн удирдлагын тулгамсан асуудал, шүүхийн практик, хэрэг маргаан шийдвэрлэлтийн явцад тулгарч буй бэрхшээл болон бусад шаардлагатай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээс гадна:

- Үндсэн хуулийн шүүхийн дүрмийн хэрэгжилт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал;
- Үндсэн хуулийн шүүхийн төсвийн талаар холбогдох төрийн байгууллагад хүсэлт гаргах, нөөцийн сангийн хуваарилалт, дансны төлбөр тооцоо хийх асуудал;
- Үндсэн хуулийн шүүхийн ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох, чөлөөлөх. Үндсэн хуулийн шүүхийн судлаач, мэргэжилтнүүд болон Тамгын газрын удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх зэрэг асуудлыг хэлэлцдэг.

Зөвлөлгөөн бүх шүүгчээс бүрдэх бөгөөд хуралдааныг Үндсэн хуулийн шүүхийн дарга удирддаг.

Үндсэн хуулийн шүүхийн Удирдлагын газар /Тамгын газар/ нь 1 газар, 2 агентлаг, 1 хэлтэстэй. Тухайлбал, Төлөөлөгөө, зохион байгуулалтын газар, Шүүн таслах ажиллагаа хариуцсан агентлаг, Шүүхийн архив, мэдээллийн агентлаг, Ерөнхий үйлчилгээний хэлтсээс бүрдэнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга эдгээр газар, агентлаг, хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд Үндсэн хуулийн

шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнд мэдээлэл танилцуулна.

Мөн шүүн таслах ажиллагааны чиглэлээр Судалгааны төв, Үндсэн хуулийн шүүхийн даргын дэргэд Ажлын алба, шүүгч бүрт шүүгчдийн туслах ажиллагааг.

Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн номын сан Үндсэн хуулийн шүүх байгууллагдан үеэс эхлэн бий болсон. Номын цуглуулга харьцангуй бага ч гэсэн одоогийн байдлаар 80.000 гаруй ном, товхимол байдаг гэж үздэг.

Маргааны харьяалал

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх дараах маргаантай асуудлыг хянан хэлэлцэх эцсийн шийдвэр гаргах эрхтэй. Үүнд:

- Үндэсний Ассамблейгээс баталсан хууль, бусад шийдвэр нь Үндсэн хуульд нийцсэн эсэх тухай маргааныг ердийн шүүхийн хүсэлтээр хянан шийдвэрлэнэ / хууль, тогтоол, олон улсын гэрээ, Ерөнхийлөгчийн зарлиг хамаарна. Хэрвээ хууль Үндсэн хууль зөрхсөн байна гэж үзвэл тухайн шийдвэр гарсан үеэс хуулийн холбогдох зүйл, заалт хүчингүй болно/;
- Импичмент /Хэрвэ эрх бүхий албан тушаалтнууд нь өөрийн үйл ажиллагаагаар Үндсэн хууль зөрхсөн гэж үзвэл Ерөнхий ассамблей шийдүүлэхээр Үндсэн хуулийн шүүхэд хандана. Шүүхээс импичментийг шийдсэн шийдвэр гарах хүртэл тухайн албан тушаалтан нь албан тушаалаасаа түдгэлздэг. Шүүх тухайн албан тушаалтныг очруулах шийдвэр гарснаар огцорно/;
- Улс төрийн намыг татан буулгах /улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нь Үндсэн хуулиар тогтоосон ардчиллын үндсэн зарчимд харшилж байгаа тохиолдолд/;
- Төрийн байгууллагуудын хоорондын маргаан;
- Үндсэн эрх зөрчигдсөн эсэх тухай маргаан /Үндэсний ассамблей болон Засгийн газар, харьяа төрийн бусад байгууллагаас гаргасан эрх зүйн акт нь иргэдийн Үндсэн эрхэд халдсан гэж үзвэл

иргэд Үндсэн хуулийн шүүхэд хандаж эрхтэй. Мөн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад хэрэглэгдэх эрх зүйн акт нь үндсэн эрхийг зөрчсөн гэж үзвэл шүүхээс тухайн маргааныг шийдвэрлэж тогтоол гаргахаас үл хамааран Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно/.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа

Улс төрийн намыг татан буулгах, импичмент, төрийн байгууллагуудын хоорондын маргааныг шийдвэрлүүлэх тухай хүсэлтэй гүүх амаар болон бичгээр; харин хууль, эрх зүйн бусад акт Үндсэн хууль зөрчсөн эсэх, үндсэн эрх зөрчигдсөн эсэх тухай маргааныг шүүх бичгээр авна.

Үндсэн хуулийн шүүхийн их хуралдаан талуудын хүсэлт болон өөрийн санаачилгаар дараах арга хэмжээг авна. Тухайлбал, талууд болон гэргийг тогтоох, талуудад байгаа эд мөрийн баримтыг шаардаж хамгаалалтад авах, шинжлэх, эд юмс, холбогдох этгээд, бусад зүйлийн нөхцөл байдлыг тодруулж болно. Үндсэн хуулийн шүүхийн төсвийг улсаас батлах хэдий ч талуудын хүсэлтээр хийсэн шалгах ажиллагаа, шинжилгээний зардлыг зөрчил гаргасан байгууллага, албан тушаалтнаас, зөрчил нь тогтоогдохгүй бол хүсэлт гаргасан талаас гаргуулдаг.

Их хуралдаанаар шийдвэр гаргахад бүрэлдэхүүнд орсон бүх шүүгч гарын үсэг зурах бөгөөд эсрэг саналтай шүүгчид тусгай саналаа бичгээр гарган хэрэгт хавсаргана. Үндсэн хуулийн шүүхээр хэлэлцэгдэж буй бүхий л маргаанд Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, процессын хууль хэрэглэгдэхээс гадна Иргэний хууль, импичментийн маргаанд Эрүүгийн хууль, Төрийн байгууллагуудын хороондын болон Үндсэн эрх зөрчигдсөн тухай маргаанд Захиргааны процессын хуулийг хэрэглэдэг.

Үндсэн хуулийн шүүхийн хуралдаан

Үндсэн хуулийн шүүхийн хуралдаан нь 2 төрлийн бүрэлдэхүүнтэй. Үүнд:

1. Их хуралдаан. Үндсэн хуулийн шүүхээр үүсгэн шалгах байгаа бүх маргааныг их

хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг нийт шүүгчийн олонхийн саналаар; хууль, эрх зүйн бусад акт Үндсэн хууль зөрчсөн эсэх, импичмент, Улс төрийн намыг татан буулгах эсэх тухай маргааныг 2/3 буюу дийлэнхи олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн шүүхийн дарга их хуралдааныг даргалж, 7 ба түүнээс дээш шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдана.

2. Бага хуралдаан. Үндсэн эрх зөрчигдсөн эсэх тухай маргааныг их хуралдаанаар хянан хэлэлцэхээс өмнө тухайн асуудал нь Үндсэн хуулийн зөрчил бүхий маргаан мөн эсэхийг урьдчилан шийдвэрлэхийн тулд Үндсэн хуулийн шүүхийн бага хуралдааныг зарлаж болно. Өөрөөр хэлбэл, бага хуралдаанаар зөвхөн иргэний үндсэн эрх зөрчигдсөн тухай маргаан нь Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудал мөн эсэхийг л хэлэлцэнэ.

Жишээ нь, 2006 оны зэцийн байдлаар үндсэн эрх зөрчигдсөн тухай нийтдээ 1300 орчим өргөдөл, хүсэлт ирсэнээс 500 гаруй нь бага суудлын хуралдаанаар хэлэлцэж буцаасан байна.)

Маргааны талууд: нэхэмжлэгч ба хариуцагч

Хууль, Ерөнхийлөгчийн зарлиг Үндсэн хуульд нийцсэн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн шүүхээр хэлэлцэхэд хүсэлт гаргасан тал болох ердийн шүүх, цэргийн шүүх нэхэмжлэгч талаар. Үндсэн хууль зөрчсөн гэх хууль, зарлигийг баталсан байгууллага, албан тушаалтан хариуцагчаар, албан тушаалтныг огцруулах үндэслэл байгаа эсэхийг хянан хэлэлцэхэд Үндэсний ассамблей нэхэмжлэгчээр, тухайн албан тушаалтан нь хариуцагчаар гэх зэрэг Үндсэн хуулийн шүүхэд хандаж байгаа тал нь нэхэмжлэгч, Үндсэн хууль зөрчсөн гэх шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан нь хариуцагчаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

Их хуралдааны явцад уг хуралдаанд оролцож байгаа сонирхогч бусад этгээд хуралдаан даргалалтын зөвшөөрөлтэйгээр

маргаантай холбогдолтой өөрийн байр суурийг илэрхийлж болно.

Өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд өөрсдийн өмгөөлөгч болон холбогдох байгууллага, албан тушаалтан итгэмжлэгдсэн төлөөлөгчөө томилон оролцуулах эрхтэй. Үндсэн хуулийн шүүхээс ч өмгөөлөгч маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь хууль зүйн хувьд илүү ач холбогдолтой гэж үздэг байна.

Үндсэн хуулийн шүүх албан тушаалтныг огцруулах асуудлаар шийдвэр гаргах

БНСУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Сайд нарын зөвлөлийн гишүүн, Үндэсний ассамблей дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Үндэсний сонгуулийн комиссын дарга, Аудитын зөвлөлийн даргыг албан тушаалаас нь огцруулах эсэх асуудлыг Үндсэн хуулийн шүүх хянан шийдвэрлэх эрхтэй.

Үндэсний ассамблейн нийт гишүүдийн олонхийн саналаар Ерөнхийлөгчийг огцруулах тохиолдолд 2/3-ын саналаар түүнийг огцруулах үндэслэл байгаа эсэхийг хянуулахаар Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргана. Ийнхүү хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтны бүрэн эрхийг Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргал түгэлзүүлдэг.

Эрх мэдлийн маргааныг хянан шийдвэрлэх

Хэрвэ төрийн болон орон нутгийн байгууллагын хооронд эрх мэдлийн маргаан гарсан тохиолдолд уг асуудлыг шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн шүүхэд хандана. Энэхүү хүсэлтэй эрх мэдлийн зөрчил гарснаас хойш 180 хоног, мэдсэнээс хойш 60 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхэд гаргах боломжтой.

Гадаадад амьдарч буй Монгол Улсын иргэдийн сонгуулийн эрхийн тухайд

ХБНГУ-ын Бонн хотын Их сургуулийн докторант Д.Үүрцайх

Монгол Улс чөлөөт ардчилсан тогтолцоонд шилжиж эхэлснээс өнөөг хүртэл монголын нийгэмд улам бүр эрчимжсээр байгаа нэгэн үзэгдэл нь боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэж амьжиргаагаа дээшлүүлэх гэж хөгжингүй гадаад орнуудыг чиглэсэн олон мянган монголчуудын шилжилт хөдөлгөөн билээ. Сүүлийн үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр бичигдээд буй албан бус тоогоор бол монголын 110-200 мянга орчим харьяат гадаад улсад “хууль ёсоор” болон “хууль бусаар” оршин сууж байна. Сонгуулийн ерөнхий хороо, Гадаад хэргийн яам, төрийн бусад байгууллагатай хамтарч ажиллаад чухам хичнээн монгол хун эх орнынхоо гадна амьдарч буйг яг нарийвчлан тогтоож чадахгүй ойролцоогоор 200 мянга орчим гэсэн барагцаа тоотой л байна. Монгол төр өөрийн харьяат ардуудаа чухам хэд нь хаана юу хийж явааг мэдэх чадамжгүй болсон нь тун харамсалтай бөгөөд ийм нөхцөлд монголын төрөөс нийгмээ зөв, үр дүнтэй удирдан зохицуулах бодит чадавхитай эсэхийг төсөөлөхөд ч бэрх байна.

Сүүлийн үед гадаад улсад амьдарч буй монголчуудын сонгуулийн эрхийн тухай нэлээд яригдах болжээ. Үнэхээр 200 мянга орчим монгол гадаад улсад амьдарч байгаа болоод сонгох эрхтэй гэж үзвэл 2004 оны УИХ-ын сонгуульд сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн 1 сая 280

мянган сонгогчийн тоо даруй 15.6 хувиар нэмэгдэх болно. Гадаад улсад амьдарч буй монголчуудын бүтэцэд үнэндээ монголын нийгмийн тодорхой ачааг нуруундаа үүрч яваа, харьцангуй чадварлаг сэхээрсэн хэсгийнхэн давамгайлж байгаа бөгөөд Монгол Улсын эдийн засгийн хөгжил дэвшилд ч өөрсдийн үнэлэгдэхүйц хувь нэмрийг оруулж, олон мянган гэр бүлийн амьжиргааг залгуулан, ядуурлын туйлд хүргэчихэлгүй, гудамжинд гарган бослого, тэмцэл өрнүүлүүлчихгүй авч яваа учир монголын нийгмийн энэ жинтэй хэсгийн сонгох эрхийг хуульчлах, баталгаажуулах нь цаг үеийн шаардлагаар нөхцөлдсөн нэгэн тулгамдсан асуудал мөнөөс мөн. Монгол төрийн доройтол, монголын улс төрийн ялзралыг харж, мэдээд хий бүхимдахаас өөрөөр нөлөөлөх боломжгүй явсан ийнхүй хувьд ч ялгаагүй монголын төрийг зөв, шударга хүмүүсээр бүрдүүлэхэд иргэний хувиар сонгох эрхээ эдлэн оролцох боломжтой болсон нь тун таашаалтай мэдээ юм.

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6.3-т “Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцох эрхтэй” хэмээн хуульчилжээ. Үүний дараахан Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга Б.Баттулгын хэвлэлд өгсөн ярилцлагууд¹ болон Гадаад

хэргийн сайд Н.Энхболд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын хамт 2 дугаар сарын 24-ний өдөр Парис хотноо Франц улсад суугаа монголчуудыг хилээн авч уулзахдаа нэгэн оролцогчийн асуултад өгсөн хариулт², түүнчлэн Сонгуулийн вээр баримтлах дүрэм, журмын төслийг СЕХ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс зарласан Сонгуулийн дүрэм, журмыг боловсруулах төндөрт ялан боловсруулсан Соёлогчдын боловсрол төвийн захирал Р.Бурмаагийн гадаадад амьдарч байгаа монгол иргэдээс санал авах, сонгуулийн санал авах өдрийн зохион байгуулалтыг журамлах “Хамгийн чухал хоёр журам үлдсэн” хэмээн мэдэгдсэн³ зэргээс үзэхэд:

1. Олон нийтэд таалагдах, гадаад улсыг хуулбарлах, нийгмийн бодит шаардлагыг хүлээн зөвшөөрч, харгалзан үзсэн гэх мэт сэдэлтүүдийн алинд нь ч үндэслэсэн байлаа гэсэн “гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд”-ийн сонгуулийн “идэвхитэй” эрх буюу сонгох эрхийг нь УИХ-ын сонгуулийн хуулийн шинэчилсэн найруулгаар хуульчилж өгсөн нь хэдийгээр дэвшилттэй ч “даахгүй нохой булуу хураана” гэгчийн үлгэрээр болж, эрх зүйн зохицуулалтын болон эдийн засаг, зохион байгуулалтын талаасаа ч ялгаагүй монголын төрийн “толгойн өвчин”, томоохон хариуцлагын асуудал болоод байгаа аж.

¹ Баттулгын ярилцлага, “Өнөөдөр” сонин, 2007.1.8-9, Б.Баттулга: Намууд “но”-той шvv шvv, “Зууны мэдээ” сонин, 2007.2.9.

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн Франц дахь монголчуудын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэл, 2007.3.15, <http://www.tshahinurduu.mn/show.php?Table=news&id=508>, 2007.3.18-нд дуудаж үзэв.

³ Сонгуулийн вээр баримтлах дүрэм, журмын “боть” мэндлэх нь, “Өдрийн сонин”, 2007.3.15.

Үнэхээр ч сонгох эрх гэдэг бол төрийн эрхийг баригч ард түмний үнэмлэхүй дээд эрх бөгөөд түүнийг баталгаатай эдлүүлэх үүднээс нийтийн, чөлөөтэй, шууд, тэгш, нууц байх гэсэн хууль зүйн тодорхой зарчмуудаар хамгаалагдсан байдаг. Энэ үнэмлэхүй дээд эрхийг баталгаатай хэрэгжүүлэх нь ардчилсан, эрх зүйт төр нь засгийн бүх эрхийг мэдэлдээ байлгач ард түмнээсээ¹ хүлээн зөвшөөрөгдөн оршихуйн эх үндэс учраас амин чухал үүрэг нь болдог.

2. Хэнд чухам энэ эрхийг эдлүүлэх вэ, тэдний тоо хэмжээ нь хэд вэ гэдэг асуудал ч монголын төрд тодорхой бус байгаа бололтой. „Гадаад улсад амьдарч буй” гэдэг ойлголт нь үнэндээ хэт ерөнхийлсөн зохицуулалт болжээ. Гэхдээ энэ ойлголтыг тодорхойлоход манай төрийн зарим албан тушаалтны ойлгож буй шиг тухайн Монгол Улсын харьяат амьдарч байгаа улсынхаа хууль ёсыг сахин биелүүлж байгаа эсэх нь ямар ч хамааралгүй, монголын төр тухайн хүний оршин суух эрх нь тухайн улсын хувьд хууль ёсны болоод хууль бусыг нь тогтоох эрх зүйн ямар ч боломжгүй. Энэ нь гагцхүү тухайн асаудалын төрийн эрх мэдлийн гэдэг асуудал юм. Гадаад улсад „хууль бусаар” болон „хууль ёсоор” амьдарч байгаа Монгол Улсын харьяатуд бүгд Монгол Улсын Харьяатын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын харьяат гадаад улсад оршин суух нь иргэний харьяаллаа алдах үндэслэл болохгүй”, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Монгол Улсын харьяат хаана оршин сууж байгаагаас үл хамааран төрийн ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулна” гэсний дагуу Монгол Улсын харьяат гэдгийг нотлох бичиг баримтдаа үндэслэн УИХ-ын сонгуулийн хуулийн энэхүү шинэчилсэн зохицуулалтаар сонгох эрхтэй болсон гэсэн үг. Монгол

Улс гадаад улсад оршин суух эрхийн ямар нэг зөрчилтэй байгаа ч өөрийн улсын харьяатуудаа Монгол Улсынхаа хуулийн дагуу сонгох эрхээ эдлэх боломжоор хангах дээрх хуулиар хүлээсэн үүрэгтэй учир ямар нэг асуудал үүсгээгүй учиргүй. Үүнтэй нэгэн адил санал авах өдөр санал авах газарт буюу хууль бусаар оршин сууж буй монголчууд олноор цугларч болошгүй газарт тухайн улсын төрийн байгууллагуудын зүгээс хууль тогтоомжоо хэрэгжүүлэх аливаа ажиллагаа явуулах нь бас л тухайн улсын төрийн эрх мэдлийн асуудал бөгөөд тэрхүү эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь монголын төрийн зүгээс оролцох болоод нөлөөлөх ямар ч үйлдэл хийж болохгүй гэдэг нь хэнд ч тодорхой болов уу. Нөгөө талаас монголчууд олноор зорчих болсон улсуудын дийлэнх нь ардчилсан эрх зүйт төртэй, хөгжингүй орнууд байгаа бөгөөд тэдгээр улсын төртэй монголын төр парламентынхаа сонгуулийг явуулах үеэрээ тухайн улс өөрийн Үндсэн хуулиараа тодорхойлсон эрх зүйт төрийн хууль дээдлэх зарчмаасаа тудгалзан, хуулиа хэрэгжүүлэхгүй, үл төмсөрлөх талаар тохиролцоод хийнэ гэдэг бол тухайн улсын хувьд тэсөөлөх ч аргагүй, өөрийнхөө оршихуйг үгүйсгэсэн асуудал болох тул манай СЕХ-ны даргын бодол² гүйцэлдэхэд зарим цөөн дарангуй болоод бурангуй засагтай улсуудаас бусадтай нь тун ч их бэрхшээлтэй асуудлыг үүсгэж болов уу гэж эмээмүй. Тиймээс гадаад улсад амьдарч буй Монгол Улсын харьяатуд сонгох эрхээ эдлэхэд нь монголын төрийн зүгээс „хар, цагаан”-аар нь ялгаварлах үйл хандлагыг гаргах нь хууль бус болох ба сонгох эрхээ эдлэх эсэх нь тухайн хүний сонгох эрхээ „чөлөөтэй” эдлэх зарчмаар хамгаалагдсан хувийн шийдвэр нь байх ёстой. „Хууль бусаар” оршин сууж байгаа хүмүүс тухайн улсын хууль сахиулах байгууллагад баривчлагдах эсэх нь гагцхүү

өөрийнх нь үүрэх „эрсдэл” байх ёстой.

Өөр нэг анхаарал татаж буй ноцтой асуудал бол гадаад улсад амьдарч буй Монгол Улсын харьяатуд 100 хувь сонгох эрхээ эдлэх чадахгүй байж болошгүй тухай³ болон „монголчууд олноор ажиллаж амьдарч байгаа 10 улсад” амьдарч байгаа нь л сонгох эрхээ эдлэх боломжтой байх тухай төрийн албан тушаалтнуудын мэдэгдэл юм. Энэ тохиолдолд Үндсэн хуулиар баталгаажсан сонгуулийн эрхийн „бүх нийтийн” байх зарчим болон хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг үгүйсгэсэн ноцтой зөрчил болно. Хэрэв Монгол Улсын нутаг дэвсгэр, хилийн дэвсгээс гадна л амьдарч байгаа бол, африкийн ширэнгэнд ч, алсын Америкт ч оршин сууж байсан ч Монгол Улсын сонгуулийн эрх бүхий харьяат „ард” гэдэг нотолж чадаж байгаа л бол монголын төрөөс сонгох эрхээ баталгаатай эдлэх бүхий л боломжоор хангагдсан байхыг шаардах эрхтэй юм.

Түүнчлэн Сонгогчдын боловсрол төвөөс гадаад улсад амьдарч буй монгол иргэдээс санал авах журмыг боловсруулахаар ажиллаж байгаа энэ үед сонгуулийн эрх зүйн сэдвийг сонирхон судлагч миний бие өөрийн саналыг болон суралцаж буй ХБНГ-У-ын сонгуулийн эрх зүй дэх адилтгах зохицуулалтын талаар өгүүллийн төгсгөл хэсэгт төвч тоймлон хүргэхийг хүсэж байна.

Уг нь хууль тогтоох, төрийг удирдан зохион байгуулах үйл хэрэгт судалгаа, шинжилгээ нь эхлэн хийгдсэний үндсэн дээр бодлогоо боловсруулаад, тэрхүү бодлогоо хэм хэмжээ тогтоосон эрхийн баримт бичиг буюу хууль, тогтоомж болгон баталдаг ерөнхий хандлага, аливаа хэргийг тэр дундаа төрийн хэргийг шийдвэрлэхдээ „долоо хэмжиж, нэг огтлох” гэсэн ардын сургаалыг санан, баримталж

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг.

² Баттулгын ярилцлага. “Өнөөдөр” сонин, 2007.1.8-9.

³ Б.Баттулга: Намууд “но”-той шув дээ. “Зуны мэдээ” сонин, 2007.2.9.

⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Франц дах монголчуудын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэл, 2007.3.15. <http://www.isahimurtuul.mn/show.php?Table=news&id=508>, 2007.3.18-нд дуудаж үзэв.

⁵ Б.Баттулга: Намууд “но”-той шув дээ. “Зуны мэдээ” сонин, 2007.2.9.

баймаар. Харин хуулиа баталсныхаа дараа „одоо яаж зохицуулах вэ, ямар туршлага, ямар боломж байгаа“ гээд яаж байгаа нь Монгол Улсын хууль тогтоох болон төрийн бусад байгууллагын үйл ажиллагааны сул дорой байдал, асуудалд судалгаа шинжилгээ, тодорхой бодлогогүй ханддаг „бүхнийг мэдэгч“ албан тушаалтнуудын салан авирын илрэл гэхээс өөрөөр дүгнэх аргагүй болой. Монголын төр шинжлэх ухаанаасаа хэт холдсоны, шинжлэх ухаанаа “хөг дээр хаясны” нэг илрэл, хохирол нь энэ болой.

4. Гадаад оронд суугаа Монгол Улсын ЭСЯ, Консулын газар, Байнгын төлөөлөгчийн газарт юуны өмнө сонгуулийн хэсэг байгуулагдаж, тэдгээр нь санал авах байр болж магадгүй бололтой. Гадаад оронд суугаа Монгол Улсын ЭСЯ-ны нутаг дэвсгэр хэдийгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт тооцогдох боловч тухайн нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлж болох Монголын төрийн эрх мэдэл нь олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр улс бүр харилцан адилгүй зохицуулагдсан байдгийг зохих мэргэжлийн төрийн албан хаагчид бас бодолцож, нөгөө “хүн хулгайлдаг түүх” шиг ичгэвтэр байдал дахин үүсгэхгүйн тулд судлан шалгах хэрэгтэй болов уу.

Хэрэв зөвхөн дипломат төлөөлөгчийн газрыг санал авах байр болгох, тэнд биечлэн очиж, саналаа өгөхийг санал өгөх хэлбэр болговол Монгол Улсаас дипломат төлөөлөгч суудаггүй орнуудад амьдарч байгаа сонгогчдын сонгуулийн эрх зөрчигдөхөд хүрэх ба нэг улсад 1-ээс илүү газарт монголын дипломат төлөөлөгчийн газар байхгүй тул бүтэн улсын нэг захаас нөгөө захад байгаа дипломат төлөөлөгчийн газарт хүрч саналаа өгөх нь олон сонгогчдод эдийн засгийн хувьд ч, эрүүл мэндийн хувьд ч хэтэдсэн нөхцөл, шаардлага болох бөгөөд ийм эрхийн зохицуулалтаар тухайн сонгогчийн сонгох эрх нь үлэмж хязгаарлагдах болно.

Саналыг авч болох өөр нэг хувилбараар орчин үеийн техникийн дэвшил буюу интернетийг ашиглах санал гаргаж буй бололтой. Ингэхдээ сонгуулийн эрхийн зарчмыг хэрхэн хангах гэж буй нь тодорхойгүй бөгөөд зохиогчийн үзэж буйгаар интернетээр санал авахад сонгуулийн эрхийн зарчмуудыг баталгаатай хангах техникийн боломж одоогоор үгүй юм.

Техник, технологи өндөр хөгжсөн Герман улсад ч одоо болтол интернет сонгуулийн талаар шинжлэх ухааны хэлэлцүүлгийн хэмжээнд байгаа бөгөөд харин 1999 оноос цахим тооцоолуураар удирдагдсан сонгуулийн төхөөрөмж ашиглан саналаа өгөх эрхийн зохицуулалтыг хийж, зарим сонгуулийн хэсэг дээр санал авах төхөөрөмж ашигласан нь тухайн төхөөрөмжийн хувьд саналын үр дүнг хувирган өөрчлөх бодит боломж байгаа учир сонгуулийн эрхийн зарчмыг зөрчиж байгаа гэсэн үндэслэлээр он дамжсан эрх зүйн маргаан, шинжлэх ухааны хэлэлцүүлэг өрнүүлээд байгаа билээ.

Санал өгөх үед саналаа нууцаар гаргах зарчмыг хэрхэн хангах, интернетээр дамжуулах үед саналыг техникийн аргаар хувирган өөрчлөх боломжийг хэрхэн баталгаатай хаах гэх мэт бидний хэрээс хэтэрсэн асуудлууд байгаа. Эцсийн эцэст интернетийг ашиглуулах, хянах эрх нь “харь гүрний гар”-т байдаг тул монголын төрийн эрхийг хэн барихыг гаднаас зохицуулах, нөлөөлөх боломжийг ч нээж өгч болох юм. Тиймээс энэ талаар санахын ч хэрэггүй гэдгийг цохон тэмдэглэж байна.

ХБНГУ-ын адилтгах зохицуулалтын тухайд

ХБНГУ-ын Бундестагийн сонгуулийн хуулийн 1985 оны 7 дахь

нэмэлт, өөрчлөлтөөр, уг хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Бусад урьдчилсан нөхцөл шаардлагуудыг хангасны үндсэн дээр Үндсэн хуулийн 116 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлогдсон Герман хүн гэсэн ойлголтод хамаарагсад нь сонгуулийн өдөр:

1. Дээд удирдлагынхаа томилсноор нийтийн албанд ажиллаж буй төрийн албан хаагч, цэрэг, ажилтан, ажилчдын хувир болон тэдний гэр оронд (гэр бүл биш) хамаарагдан ХБНГУ-аас гадна амьдарч буй бол;

2. ХБНГУ-аас бусад Европ зөвлөлийн¹ гишүүн оронд амьдарч буй бөгөөд хэрэв 1949 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс хойш болон гадаадад гарахаасаа өмнө ХБНГУ-д 3 сар тасралтгүй орон сууцтай байсан болон бусад байдлаар хэвийн оршин сууж байсан бол;

3. ХБНГУ-ын гадна орших бусад нутаг дэвсгэрт амьдарч буй бөгөөд хэрэв гадаадад гарахаасаа өмнө ХБНГУ-д 3 сар тасралтгүй орон сууцтай байсан болон бусад байдлаар хэвийн оршин сууж байсан ба гадаадад гарснаас нь хойш 25² жил өнгөрөөгүй бол сонгох эрхтэй. Дээрх заалт нь холбооны улсын далбааг мандуулаагүй усан онгоцон дээрх далайчид болон тэдний гэр оронд хамаарагсад мөн адил үйлчилнэ.

1 дэх өгүүлэлт дурдагдсан сонгох эрхтэй хүмүүс ХБНГУ-д буцаж ирсэн тохиолдолд 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дугаар 2-т заагдсан³ 3 сарын хугацаа хамаарахгүй. Дугаар 2 болон 3-ийг хэрэглэх тохиолдолд хоёр Герман нэгдэх гэрсэний 3 дугаар зүйлд дурдагдсан нутаг дэвсгэрт (Зүүн Германы нутаг дэвсгэр) хамаарах урьдын орон сууцтай байсныг болон оршин сууж байсныг мөн адиллаар харгалзан үзнэ.” гэсэн өөрчлөлтийг оруулжээ.

Дугаар 1-д хамаарагсад нь өөрийн хүслээр бус “дээд удирдлагынхаа томилолтоор” ХБНГУ-ыг орхин гарч байгаа

¹ Европ зөвлөл (Europarat – Council of Europe) нь 1949 онд Лондоны 10 засгийн пактаар байгуулагдсан эдүгээ 46 гишүүнтэй европын нэг олон улсын байгууллага юм. Европ зөвлөл нь бүтцийн хувьд Европын холбоотой (Europäische Union – European Union) ямар ч холбоогүй бөгөөд түүнийг мөн Европын зөвлөл (Europäische Rat – The European Council), Европын холбооны зөвлөл (Rat der Europäischen Union – The Council of the European Union) зэрэгс алган ойлгох хэрэгтэй.

² Анх 1985 оны өөрчлөлтөөр 10 жил байгаар хуульчлагдсан байсныг 1998 оны 14 дэх өөрчлөлтөөр “гадаад улсаас ХБНГУ-д болж буй уг төрийн үйл явцад орохгоо мэдэллийн боломж нэмэгдсэн” гэсэн үндэслэл гарган 25 жил болгож өөрчилсөн байна.

³ 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Сонгох эрхийг сонгуулийн өдөр 18 нас хүрсэн, доод тал нь 3 сарын өмнөөс ХБНГУ-д орон сууцтай байсан болон бусад байдлаар хэвийн оршин сууж байсан бөгөөд 13 дугаар зүйлийн дагуу сонгох эрхээ хасуулаагүй байгаа Герман хүн эздэлээ”.

тул тусгайлсан зохицуулалттай бөгөөд нэг бол хамгийн ойр хиллэж байгаа Холбооны нутаг дэвсгэр дэх сонгуулийн хэсгийн эсвэл тэдний харьяалах хамгийн дээд байгууллагын оршин буй сонгуулийн хэсгийн сонгогчдийн нэрсийн жагсаалтад өргөдөл гарган бүртгүүлнэ.

Дугаар 2-т хуульчлагдсан "Европ зөвлөлийн шийдэл" нь ямар нэг хугацааны хязгаарлалтгүй байгаа нь газар зүйн харьцангуй ойр байрлалтай, олон талын улс төрийн харилцаа хөгжсөн, мэдээллийн өргөн солилцоотой улсуудад амьдарч буйтай нь холбоотой гэж үздэг байна.

Харин дугаар 3-т хуульчлагдсан Европ зөвлөлийн гишүүн бүс бусад оронд амьдарч байгаа Герман хүмүүсийн сонгох эрхийн "хугацааны шийдэл" нь газар зүйн болоод бусад талаар ХБНГУ-тай ойр холбоогүй улсуудад амьдарч байгаа хүмүүст тус улс дахь улс төрийн хүсэл зориг болон үзэл бодол төлөвшин бүрдэх үйл явцад идэвхтэй оролцох мэдээлэлжсэн оролцооны боломж нь тодорхой хугацааны дараа үгүй болно гэдгээр тайлбарлагддаг.

Түүнчлэн дугаар 2 ба 3-т хуульчлагдсан 3 сарын хугацаанд ХБНГУ-д тасралтгүй орон сууцтай байсан ба бусад байдлаар хэвийн оршин сууж байсан байх шаардлага нь тухайн нийгмийнхээ талаар хамгийн наад захын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын ухагдахуунтай байх, сонгох гэж буй төртэйгээ тодорхой хэмжээгээр холбоотой байхыг нөхцөлдүүлнэ. Нөгөө талаас урд нь ХБНГУ-ын нутаг дэвсгэр дээр амьдарч байсныг тогтоох нь Үндсэн хуулийн эрх зүйн талаасаа сонгуулийн тэгш байдлын зарчмыг хангахад чиглэгдэж байгаа хэдий ч бас сонгуулийн үйл ажиллагааны эрх зүйн хувьд чухал түшиц болно. Учир нь эдгээр сонгуулийн эрх бүхий этгээд нь өргөдөл гаргасны үндсэн дээр хаанаас ХБНГУ-ыг орхин гарсан тэр нутаг дэвсгэрийнхээ сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлдэг байна. Ингэснээр сонгох эрх

бүхий "гадаад дахь германчууд"-ын нэг юмуу цөөн хэдэн тойрог дээр төвлөрөөс сэргийлж, нийт сонгууль явуулах нутаг дэвсгэрээр тархан байршуулах боломжийг бүрдүүлдэг байна. Гэхдээ олон дахин сонгуульд оролцох, саналаа өгөх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд Холбооны Сонгуулийн журмын 16-18 дугаар зүйлд нарийвчилсан зохицуулалт, явсан шалгах ажиллагааг тогтоож өгсөн байна. Энэхүү сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлэх өргөдлийн маягтыг ХБНГУ-ын бүх ЭСЯ-д болон Консулын газрууд, Холбооны сонгуулийн удирдагч, тойргийн сонгуулийн удирдагчаас авч бөглөөд сонгуулийн өдрөөс 21 хоногийн өмнө өөрийн хамаарах сонгуулийн хэсэгтээ хүргүүлсэн байх ёстой байна.¹

"Орон сууцтай байсан" болон "бусад байдлаар хэвийн оршин сууж байсан" гэдэг нь Иргэний бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу нарийн зохицуулагдсан ойлголт юм.

ХБНГУ-д саналыг захидлаар авч болдог бөгөөд санал авах энэ хэлбэр нь дээр дурдагдсан "гадаад дахь германчуудад" хэрэглэгддэг ГАНЦ хэлбэр нь юм. Тэднээс сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлэхээр гаргаж буй өргөдлийг нь сонгогчийн үнэмлэх, саналын хуудас гэх мэт сонгуулийн баримт бичиг олгохыг хүссэн өргөдлийн дэд үздэг байна. Захидлаар саналаа өгөх нь улс дотроо ч бас сүүлийн үед улам бүр өргөн хэрэглэгддэг санал авах хэлбэр болоод байгаа бөгөөд тэр хэрээр нарийвчилсан зохицуулалтыг нь хуулиар тогтоож өгсөн байна.

Санал, дүгнэлт

Зохиогч миний хувьд хэдийгээр Монгол Улсын сонгуулийн хуульд захидлаар санал өгөх хэлбэрийг хуульчлаагүй боловч гадаад улсад амьдарч буй Монгол Улсын сонгуулийн эрх бүхий харьяатуудын саналыг авах ЦОРЫН ГАНЦ боломжит хэлбэр тул сонгуулийн хуульд зохих өөрчлөлтийг оруулан зохицуулах шаардлагатай гэж үзэж

байна.

Ингээд "гадаадад амьдарч буй монголчууд"-ын сонгох эрхийг хэрхэн хэрэгжүүлэх эрх зүйн боломжийн талаар өөрийн саналыг илэрхийлэхийг хүсч байна.

Хэн сонгох эрхтэй байх вэ гэдэг дээр хууль тогтоогч нэгэнт ерөнхий ч гэсэн тодорхой хуульчилсан учир Монгол Улсын Харьяатын тухай хуулийн 3 дугаар зүйлд хамарагдах Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна амьдарч байгаа бөгөөд Монгол Улсын харьяат гэдгээ нотлох баримт бичигтэй хэн бүхэн сонгуульд "оролцох" эрхтэй. Тэгэхээр энэхүү сонгох эрхэд хугацааны, газар зүйн гэх мэт алив байдлаар хязгаарлалт тогтоох шаардлагатай бол гагцхүү хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж л хийх боломжтой.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 6.1-д "...сонгуульд оролцох, саналаа өгөх эрхтэй" гэж томьёолсон атлаа 6.3-т нь "...сонгуульд оролцох эрхтэй" гэж өөрөөр томьёолсны ялгааг зохиогч миний бие сайн ойлгохгүй байгаа бөгөөд сонгуульд оролцох "идэвхтэй" буюу сонгох эрх, "идэвхгүй" буюу сонгогдох эрхийн аль нэг нь эсвэл аль аль нь гадаадад амьдарч буй монголчуудад олгогдсон уу гэдэг нь тодорхойгүй байна.

Гадаадад амьдарч буй монголчууд өөрийн Монгол Улсад хамгийн сүүлд амьдарч байсан хаягийн хамрагдах сонгуулийн тойрогт саналаа өгөх нь зүйтэй тул мөн тухайн хэсгийн хороодод сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлэх хэрэгтэй.

Гэвч энд нэг онолын асуудлыг хөндөлдгүй орхиж болохгүй байна. Гадаадад амьдарч буй монголчууд тойрог байгуулахаас өмнө буюу УИХ-ын сонгуулийн хуулийн 12.2-т заасан 6 сараас доошгүй хугацаанаас өмнө сонгуульд оролцох эсэхээ мэдэгдэн бүртгэгдсэн байвал сайн юм. Тэгснээр тухайн тойргийг байгуулахдаа харгалзан үзэх хүн амын тоонд тоологдох боломж бүрдэж, хэт томорсон тойргууд үүсч, сонгуулийн тэгш эрхийн болон тэгш байдлын зарчим

¹ Schreiber, Wolfgang: Handbuch des Wahlrechts zum Deutschen Bundestag 7., neubearb. und erw. Aufl. Koeln, Bonn (Carl Heymanns) 2002. §12 und §36, S. 255-296 und S. 518-533.

алдагдахаас сэргийлэх боломж бүрдэнэ. Сонгуулийн тойргийн том, жижиг байх нь олонхи дийлэнхийн системийг сонгосон энэ үед маш чухал ач холбогдолтой бөгөөд нэр дэвшигчдийн хувьд ч гэсэн нэг нь цөхөн сонгогчтой тойргоос, нөгөө нь хэт олон сонгогчтой тойргоос сонгогдох нь өрсөлдөөний тэгш боломжийг бас алдагдуулж байгаа хэрэг юм. Энэ үүднээсээ хэрэв саналаа өгөхөөр нэрсийн жагсаалтад бүртгүүлсэн гадаад амьдарч буй монголчуудыг тойрог байгуулахдаа харгалзан үзэхгүй бол Үндсэн хуулийн ноцтой зөрчил үүсч болозошгүй.

Монгол Улсаас гадаад улсад амьдарч байгаа гэж тооцолсон хамгийн багаар 110 мянган хүний маань мэдээж дийлэнх хэсэг нь Улаанбаатар, хүн ам төвлөрсөн хот суурин газраас гадагшаа гарсан хүмүүс байгаа бөгөөд тэдний дийлэнх нь саналаа өгөхөөр болоход тухайлбал, нийслэлийн тойргууд хэт томрох асуудал үүсэхгүй гэх, эдгээр сонгогчид адил хэмжээгээр улс даяар сонгуулийн тойргуудад тархан байрлана гэх, аль нэг тойрог дээр нөлөө бүхий тодорхой бүлэг сонгогчдын бүтэц үүсэн бүрэлдэхгүй гэх баталгаа, судалгаа үгүй билээ.

Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлэхийн тулд СЕХ-ноос баталсан өргөдлийн маягтыг ЭСЯ-д, Консулын газрууд, СЕХ-ны цахим хуудас, ар гэрийнхнээрээ дамжуулан бүхий л сонгуулийн тойргийн болон хэсгийн хороодоос авч бөглөнө. Энэ өргөдлөөр сонгуульд оролцох болон сонгуулийн холбогдох бичиг баримтуудыг онгуулах хүсэлтээ илэрхийлээд Монгол дахь бүртгүүлэх хаягаа болон гадаад дахь сонгуулийн баримт бичгийг хүлээн авах хаягаа зөв, тодорхой бичиж гарын үсгээ зураад холбогдох нотлох бичиг баримтын баталгаажуулсан хуулбарын хамтаар гадаадад амьдарч буй монголчуудын саналыг захидлаар авах ажлынхааг зохион байгуулахаар тусгайлан байгуулагдсан илүү өргөн бүрэлдэхүүнтэй сонгуулийн хэсгийн хороо (цаашид "гадаад сонгуулийн хэсгийн хороо" гэх)-нд явуулна. Энэхүү хэсгийн хороо нь гадаадаас ирсэн

нэрсийн жагсаалтад бүртгүүлэх өргөдлүүдийг хүлээн авч үнэн зөв эсэхийг нь хянаад, хасалт хийж холбогдох тойргуудын сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлэхээр илгээнэ. Тэнд бүртгэж, аваад хасалт хийсэн болоод давхардсан бүртгэлийг хянаж баталгаажуулсан хариу ирсний дараа шуудангаар тусгайлан хэвлэсэн буцаах дугуй, сонгогчийн үнэмлэх, сонгогч саналаа ямар нэг гадны нөлөөгүй, өөрөө биелчлэн өгсөн гэдгээ гарын үсгээрээ илтгэн баталгаажуулах хүүдас, саналын хуудсыг хийж битүүмжлэх тусгайлан дугуй, саналын хуудас зэргийг бүртгэгдсэн сонгогчийн гадаад улсад суугаа хаягаар нь илгээнэ. Ийнхүү илгээхдээ гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчдийн газруудтайгаа нягт хамтран ажиллаж, туслалцааг нь авах хэрэгтэй. Тухайлбал, олон сонгогч байгаа улс руу бүх сонгуулийн баримт бичгийг захиргааны зардлыг хэмнэх үүднээс нэгдсэн дипломат шуудангаар явуулаад, ЭСЯ-аас холбогдох сонгогч бүрт тухайн улсынхаа дотоодын шуудангийн байгууллагатай хийсэн хэлцлийн үндсэн дээр илгээх ажлыг зохион байгуулж болно.

Сонгогч сонгуулийн баримт бичгүүдийг хүлээн авагч саналын хуудсаа бөглөөд тусгайлан нэр хаяггүй саналын хуудасны дугуйд хийж, санал өгснөө баталгаажуулсан бичигтээ гарын үсгээ зураад дугуйтай саналын хуудасныхаа хамтаар буцаах дугуйд хийж гадаад сонгуулийн хэсгийн хороонд хүргүүлэхээр ЭСЯ-ны хаягаар эс бөгөөс шууд гадаад сонгуулийн хэсгийн хорооны хаягаар гарын үсг зурж хүлээн авах баталгаат шуудангаар сонгуулийн өдрөөс 3 өдрийн өмнө хүрсэн байхаар тооцож илгээнэ. Мэдээж хэрэг хуулийн дагуу шуудангийн бүхий л зардлыг төсвөөс хариуцна.

Гадаад сонгуулийн хэсгийн хороо нь захидлыг хүлээн авагч аль санал, аль тойрогт хамаарахыг тогтоож ялгаад холбогдох хэсгийн хороодод саналын хуудасны дугуйны нууцлалыг хөндөлгүйгээр төрийн дотоод шуудангаар хүргүүлнэ.

Хэсгийн хороод ирсэн дугуйтай саналын хуудсыг санал авах хугацаа дуусах хүртэл задлаагүй хадгалж

байгаад эцсийн мөчид дугуйнаас гаргаж, дэлгэн үзлгүйгээр зохих хэмжээний биелчлэн саналаа өгсөн сонгогчдын саналын хуудастай саналын хайрцаг хийж нийлүүлээд тоолно.

Сонгуулийн сурталчилгааны ажлыг бол нэр дэвшигчид болон намууд цахим хуудсаар дамжуулан дэлхийн хаана ч хүргэж болох бөгөөд мэдээллийг хүргэх, хүлээн авах нь гагцхүү нэр дэвшигчид болон сонгогчдын хариуцах асуудал боловч СЕХ нь өөрийн цахим хуудсаараа нэр дэвшигчдийн талаарх бас тодорхой мэдээллүүдийг түгээвэл мэдээж тустай л байх болов уу.

Дээр санал болгосон хэлбэр, журмаар энэхүү санал авах ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, зохион байгуулвал Үндсэн хуулиа зөрчиж, хуулийг элдвээр өргөтгөн тайлбарлах, ёс бус алив үйлдэл, маргаан шууган гаргалгүйгээр, харьцангуй зардал багатайгаар УИХ-аа сонгоход гадаадад амьдарч буй монголчууд бидний оролцуулах, олсон дэвшлээ "хураасан яс" бус хоол болгоод шингээчих, төр толгойныхоо нэг өвчнөөс салж, түвшин амгалан байх боломж нь бүрдэх мэт санагдаж байна.

Нөгөө талаас бид сонгуулиа өгөөд эхэлбэл Монголын төрийг төлөөлж суудаг ЭСЯ-ныхан монголоос ирэх том дарга нарт үйлчилж гүйх, хил дамнуулан тамхины наймаа хөөцөлдөж байх нь багасч, хүний нутагт яваа иргэдээ бас нааштайгаар хандааг, үйлчилдэг, хамтран ажилладаг ч болж магадгүй юм.



Хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь орчин үеийн төрийн эрх зүйн бодлого

Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Ц.Алтанцэцэг

Хууль зүйн шинжлэх ухааны судлах зүйлийн нэг болох "Эрх зүйн бодлого"-ын асуудлыг ихээхэн анхааран судлах болжээ.

Нийгмийн ашиг сонирхлын үүднээс эрх зүйн арга хэрэгслийг аль болох үр ашигтай хэрэглэхэд чиглэсэн төрийн шинжлэх ухааны үндэслэлтэй хууль зүйн бодлого нэн чухал байна.

Төрийн эрх зүйн бодлогыг эрх зүйн үндэсний тогтолцооны түгээмэл болон онцлог зүйл тогтолд үндэслэгдсэн зарчим, чиг хандлага, практик арга хэмжээний цогц гэж төмөөлдөг.

Хуулийн бодлого, үйл ажиллагаа нь эрх зүйг дээдлэн сахиж, төр, нийгэм, иргэдийн аюулгүй байдлыг хангах, иргэдэд эрх зүйн өндөр соёл, эрх зүйн механизмыг ашиглах чадвар төлөвшүүлэхэд ач холбогдолтой.

"Эрх зүйн бодлого"-д эрх зүйн механизмын цогц арга хэрэгслийг бүрэн ашиглах, эрх зүйт төрийн үндсэн зарчмын дагуу түүнийг хэрэгжүүлэх замаар төрийн бодлогыг бүрдүүлэх процессууд багтана.

Төрийн бодлого эрх зүйн шинж чанарыг агуулна.

Эрх зүй ч, төрийн бодлого ч өөрт тохирсон ага механизмээр нийгмийн жил төстэй асуудлуудыг шийдвэрлэдэг. Нийгэм, төрийн амьдрал, үйл ажиллагаанд эрх зүйн үүрэг улам бүр өсч түүний зохицуулалт нийгмийн хөгжлийн бодит хэрэгцээ шаардлагад хэр нийцдэг байна, төрийн төдий чинээ хязгаарлах боломжтой болно. Төрийн бодлого нь боломжийн, бодит нөхцөл, зүй ёсны шаардлагад нийцүүлэхийн урлаг бол, эрх зүй нь хэн юуг хийх, ямар үйлдэл хийх эрхтэй болохыг тодорхойлдог шударга ёсны урлаг юм. Эдгээр нь хоорондоо зөрчилдөөнгүй байх ёстой. Оросын эрдэмтэн Н.И.Матузов

нь "Төрийн эрх зүйн бодлого" гэдгийг "эрх зүйн үйлчлэлийн хүрээнд түүний тусламжтайгаар хэрэгжих цогц зорилт, арга, асуудал, хөтөлбөр" гэж тодорхойлжээ. Энэ ойлголтод эрх зүйн орчинд хамаарах нийтийн засаглал буюу төрийн зүгээс зайлшгүй зохицуулалттай байх нийгмийн харилцаа, холбоо, ашиг сонирхол хамаарна.

Эрх зүйн бодлого бол төрийн бодлогын илрэх онцгой хэлбэр, хууль зүйн хүлээн зөвшөөрсөн хэрэгсэл төдийгүй улс орны улс төрийн бодлогыг бататгах, хэрэгжүүлэх, төрийн тэргүүн, өндөрлөгүүдийн хэлэл зоригийг хэрэгжүүлэх хэрэгсэл болно. Энэхүү бодлого нь Үндсэн хууль болон бусад хууль түүнчлэн, эрх зүйн бусад хэм хэмжээгээр илрэн хэрэгжиж, нийгмийн үнэт зүйлсийг хамгаалах, нийгмийн харилцааг зохицуулах, өөрчлөх, хөгжүүлэх үр нөлөө бүхий хүчтэй хэрэгсэл болдог. Н.И.Матузов, А.В.Мачыко, К.В.Шуджиков нар эрх зүйн бодлогыг тодорхойлохдоо: "энэ бол төрийн бодлон орон нутгийн байгууллагуудаас явуулах шинжлэх ухааны үндэслэлтэй, тууштай, тогтвортой үйл ажиллагаа. Энэ үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтын зохистой, үр дүнтэй механизмыг бүрдүүлэхэд чиглэгдэж хүн бүрийн эрх, эрх чөлөөг бүрэн хангах, нийгмийн хэв журам, хуулиа дээдлэн сахиж, эрх зүйт төрийн ёсыг бүрдүүлэх, нийгмийн болон хувь хүний эрх зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ" гэжээ.

Төрийн эрх зүйн бодлогын бүтэц нь: Эрх зүйн салбар дахь төрийн бодлого, эрх зүйгээр дамжуулан хэрэгжүүлж байгаа төрийн бодлого гэсэн харьцангуй бие даасан хоёр зохицуулалтаар илэрнэ. Төрийн эрх зүйн бодлогыг эрх зүйг бүтээх, эрх зүйг хэрэглэх гэсэн хоёр чиглэлээр тодорхойлно. Төрөөс эрх зүйд нөлөөлөх үүрэг нь эрх зүйг бүтээх ба

эрх зүйг хэрэгжүүлэх явцад илэрнэ.

Эрх зүйг бүтээх: Энэ нь эрх зүйн агуулга, мөн чанарыг танин мэдэх түүнчлэн хууль ёс бэхжих, нийгмийн даг журмыг тогтоох, үндсэн хэрэгсэл болсон хууль тогтоомжийг чанарыг үнэлж, дүгнэх боломжийг олгодог. Ялангуяа эрх зүй үүсэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлд илүү анхаараал хандуулах нь чухал. Тухайлбал, эдийн засгийн, улс төрийн, нийгмийн, үндэсний гэх мэт хүчин зүйлс тэдгээрийн хамаарал өөрчлөгдөх, хөгжих үйл явц зэргийг тооцох хэрэгтэй. Хууль бүтээх ажиллагаа нь үйл ажиллагааны тогтоосон журам гэхээсээ илүү эрх зүйн ирээдүйн зохицуулалтын объектыг танин мэдэхийн талаас хандах нь чухал ач холбогдолтой.

Үүнээс үзэхэд эрх зүйг бүтээх ажиллагаа нь эрх зүйг амьдрүүлж, түүнийг хэлбэржүүлж, төлөвшүүлдэг асуудал болох нь харагдаж байна.

Эрх зүйг хэрэглэх: Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх гэдэгт тухайн хэм хэмжээнд заагдсан эрх, үүргийг хангах, хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтны засаглал, зохион байгуулах үйл ажиллагааг ойлгоно. Хэрэгжих хэлбэр нь тодорхой үйл ажиллагаа ба хууль зүйн баримт бичиг гаргах үйл явц юм. Эрх зүйн зохицуулалтын нийгмийн тодорхой харилцаанд тулгуурлан байгаа орчны, эдийн засгийн, батлан хамгаалах, гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого гэх зэргээр эрх зүйн бодлогын бие даасан салбарууд үүснэ.

Эдгээрээс нийгмийн, хүн амын тодорхой хэсэг буюу хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн төрийн эрх зүйн бодлого нь нийгмийн болон хүмүүсийн анхаарлын төвд байдаг. Хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь төрийн эрх зүйн бодлого нь

хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд хэрэгжүүлж байгаа цогц үйл ажиллагаа юм. Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой эх сурвалж болон судлаач, мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар бол хамгийн хамгаалалт сунтай эмзэг давхарга бол хүүхэд юм. Энэ асуудлыг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 39 дүгээр чуулганаас 2005 онд хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт зөвлөмжийн хүрээнд авч үзвэл:

1. Дотоодын хууль тогтоомждоо эерэг алхам хийсэн ч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй, хууль нь амьдралаас хол байгаа, хуулийн зарим заалт хүүхдийн эрхийг хангалттай хамгаалж чадахгүй, хоорондоо зөрчилтэй;
2. Орон нутагт хүүхдэд зориулсан нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн суурь үйлчилгээ, тахир дутуу хүүхдэд хүртээх үйлчилгээний хүртээмж, хөрөнгө нөөцийн төв болон орон нутагт зохистой хуваарилах, зүйл зөрчсөн хүүхдийн эрх зэргийг бүрэн шийдвэрлэж чадаагүй;
3. Гэрээсээ дайжсаны улмаас хүүхдийн халамжийн төвд байгаа хүүхдүүд болон халамжийн газар байгаа хүүхдийн тоо нэмэгдсээр байгаа, хүүхдийг гэр бүлээс ангид орчинд байршуулахтай холбоотой журмууд нь конвенцийн агуулга, зарчимтай бүрэн нийцээгүй;
4. Хүүхэд үрчлүүлэх талаарх хууль тогтоомж нь конвенцийн зарчимтай бүрэн нийцэхгүй байгаа;
5. Хүүхэдтэй зүй бусаар харьцах, хүчирхийлэхийн сөрөг үр дагавар, ноцтой уршгийг бий болгох асуудал байсаар байгаа;
6. Тахир дутуу хүүхдийн онцлог хэрэгцээнд зохисон орчин бүрдүүлэх талаар хууль тогтоомж байхгүй;
7. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлын эрх зүйн

зохицуулалт (суллагдсан хүмүүст зориулсан нийгэмшүүлэх үйлчилгээ хомс, хүүхэд хууль зүйн зөвлөгөө авах боломжгүй гэх мэт) хангалтгүй байгааг дурдсан.

Мөн Монголын Хүүхдийн эрхийн үндэсний төвөөс 2006 онд хийсэн "Гэр бүл, эцэг, эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийн нийгэмшилтийн судалгаанаас харахад: 1993 оны байдлаар улсын хэмжээнд 3700 хүүхэд хараа хяналтгүй гудамжинд байсан бол 2006 оны 6 дугаар сарын байдлаар гаргасан судалгаагаар 55 халамжийн төвд 1817 хүүхэд байна гэж үзэхэд гэр бүл, орон гэрээсээ дайжсан нийт 5517 хүүхэд байгаа болохыг дурдаад уг судалгааны талаар гаргасан санал зөвлөмжид "Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, мэргэжил олгох, халамжийн төвүүдийн үйл ажиллагааг хүүхдийн эрхэд суурилсан нөхцөлөөр хангах, стандарт тогтоох түүнтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай" болохыг тусгасан байна.

Нийгмийн үнэт зүйлсийг хамгаалал бэхжүүлэхэд эрх зүйн зохицуулалтын салбар дахь төрийн үйл ажиллагаа чиглэнэ. Монгол Улсын төрийн эрх зүйн бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг салбар бол хүүхдийн эрхийг хамгаалах явдал билээ.

1996 онд батлагдсан Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь төрийн бодлогын үндсэн зорилго нь:

1. Хүүхдийн эрхийг баталгаажуулах, хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;
2. Нийгмийн үндэс, хүүхдийн өсч бойжих, аж төрөх, жам ёсны орчных нь хувьд гэр бүлийг нийгмийн хүрээнд хууль ёсны үүргээ бүрэн хариуцах эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх;
3. Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, ёс суртахууны хөгжлийг дэмжихэд тус тус оршино.

Энэхүү төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ тодорхой зарчимд

тулгуурлана. Үүнд:

- § Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байлгах;
- § Төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаагаа явуулахдаа хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангахыг эрхэмлэх;
- § Хүүхдийн бие бялдар, оюун санаа, ёс суртахууны хөгжлийг хангах, сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэх, түүний эцэг, эх, асранхамгаалагч, харгалзан хүүхэд адил үүрэг хариуцлага хүлээх;
- § Хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах нь төр, гэр бүлийн үндсэн үүрэг байх зэрэг зарчмыг баримтална.

Хүн төрөлхтөний ирээдүйг хөгжил, хувь заяаг тодорхойлох нэн чухал асуудал бол хүүхэд тэдний хөгжил, хамгаалал юм. Тийм учраас НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулган хүүхдийн асуудлыг онцлон хэлэлцэж "Хүүхдийн эсэн мэнд амьдрах нөхцөлийг ханган хамгаалах, хэрэгжүүлэх" тухай дэлхий дахины тунхаглалыг 1990 онд гаргасан. Энэхүү баримт бичигт Монгол Улс нэгдэн орж тунхаглалын үзэл санааг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан. Үүнийн нэг тод илрэл бол 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг баталснаар энэ салбар дахь эрх зүйн орчлон шинэчлэлтийн үйл явц эхэлсэн юм. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор "Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг баталснаар хүүхдийн эрхийг хамгаалах төрийн эрх зүйн бодлогын шинэчлэлтийн 2 дахь шатны үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд хүүхэд хамгааллын салбарт үндэсний хэмжээнд баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлж түүний хүрээнд нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Ингэснээр хүүхдийн талаарх төрийн бодлого нь хүн амын эрхэн буюу гэр бүлийн хүрээнд дэх бодлогын дагавар салбар байхаа больж бие даасан шинж чанартай болж чадсан. Бие даасан салбарын

хүрээнд хүүхдийн тухай асуудлыг дараах 5 төвшинд тодорхойлж тус бүрт эрх зүйн тодорхой механизмүүд үйлчилнэ. Үүнд:

1. Хууль тогтоох;
2. Хөтөлбөрийн;
3. Удирдлагын;
4. Гүйцэтгэх;
5. Боловсролын.

Дээрх 5 төвшинд хүүхдийн эрхийн хамгаалалтыг хэрхэн хэрэгжүүлж байгааг товчхон авч үзье.

Хууль тогтоох төвшинд:

Хүүхдийн үндсэн эрхийг баталгаажуулсан олон улсын эрх зүйн үндсэн баримт бичиг бол Хүүхдийн эрхийн тухай конвенц юм. Энэхүү баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж 1990 оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчилсэн бөгөөд Монгол Улс 1990 оны 7 дугаар сарын 5-ны өдөр соёрхон баталсан. Үүний зэрэгцээ тодорхой асуудлын хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, бэхжүүлэх чиглэлээр олон улсын гэрээг соёрхон баталсан. Тухайлбал:

- Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн 33 дугаар конвенц /2000 он/;

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчигшүг хэлбэрийг нэн даруй устгах, хориглох тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц /2001 он/;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц /2002 он/;
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол /2002 он/;
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц /2002 он/;
- Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай

конвенцийн нэмэлт протокол /2003 он/;

- Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол /2004 он/.

Хүний эрхийг хангах механизм нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бүхий л нэхцөл, боломжийг хангахын тулд төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хууль зүйн арга хэрэгслүүдийн цогц юм. Монгол Улс хүүхдийн эрхийг хамгаалах бие даасан хуультай орны нэг (Финланд Улс Хүүхдийн эрхийн, Куба Улс Хүүхэд залуучуудын тухай төрөлжсөн хуультай). 1996 онд баталсан Хүүхдийн эрхийн тухай хуульд тулгуурлан хүүхдийн эрхийг хамгаалах, бэхжүүлэх чиглэлээр 50 гаруй хууль баталсан байна. Тухайлбал:

- ✓ Хараа, хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль /1994 он/;
- ✓ Тахир дутуу болон хууль ёсны асран хамгаалалтгүй өнчин хүүхдэд хүртээх нийгмийн халамжийн хэлбэр, хамрах хүрээг тогтоосон Нийгмийн халамжийн тухай хууль /1998 он/;
- ✓ Хүүхдэд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх тухай тусгасан Эрүүл мэндийн тухай хууль /1998 он/;
- ✓ Хүүхдийн хөдөлмөр, тэдгээрийн ажиллах нөхцөлийг зохицуулсан Хөдөлмөрийн тухай хууль /1998 он/;
- ✓ Эцэг, хүүхдийн үүрэг, үрчлэлт, асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой асуудлыг зохицуулсан Гэр бүлийн тухай хууль /1999 он/;
- ✓ Хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, хүүхэд, гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэргийн талаар тусгай бүлэг оруулан тусгасан Эрүүгийн хууль /2002 он/;
- ✓ Иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон Боловсролын тухай хууль /2002 он/;

✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хохиоргчийн эрхийг хамгаалах талаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2004 он/;

✓ Эх, хүүхдэд тэтгэмж олгох, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль /2007 он/.

Хүүхэд бол эрх зүйн харилцааны онцгой суб'ект. Хүүхдийн бие бялдар, оюун санаа гүүцэт төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөөс өмнө болон төрөний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай. Иймээс нийгмийн бүхий л хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн онцлог механизм үйлчилнэ.

Хүүхдийн эрхийг хамгаалах талаархи хууль тогтоомж хэт олон байх, хүүхдийн эрхийн тухай асуудал нь эрх зүйн олон салбаруудаар зохицуулагдаж байгаа, хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжийн нэгдмэл систем бүрэн тогтоогүй байдал нь хууль тогтоомжийн харилцан уялдааг хангах чадахгүйд хүргэхийн зэрэгцээ хүүхдийн асуудалтай холбоотой эрх зүйн актуудыг хүлээн авах, хэрэгжүүлэх процессыг хангалттай болгож улмаар хууль тогтоомжийн "цоорхой"-г нуудмал байдалд оруулахад хүргэх талтай.

Хөтөлбөрийн төвшинд:

Хүүхдийн эрхийг хамгаалах салбардахь төрийн эрх зүйн бодлогыг бататган хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн эрх хугацааны тусгай хөтөлбөр боловсруулан ажиллах явдал юм.

Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг 1990-2000 онд хэрэгжүүлж эхэлсэн. Түүнчлэн 2 дахь шатны хөтөлбөрийг 2002-2010 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

2002-2010 онд хэрэгжих "Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр" нь 7 дэд хэсэгтэй /Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан/.

Хөтөлбөрийн эрхэм зорилго нь Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд өөрийгөө хөгжүүлэх, ажиллаж амьдрахад шаардлагатай боловсрол, мэргэжил эзэмших орчин нөхцөлийг бүрдүүлж, тэдний аж байдлыг улам сайжруулахад оршино. Хүүхэд эсэн мэнд аж төрж, нэр төртэй, өв тэгш хөгжих эрхийг хангахад үндэсний хэмжээнд баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

- ✓ Хүүхдийг нэн тэргүүнд тавих;
- ✓ Үгээгүй ядуу байдлаас сэргийлж, хүүхдийн төлөө хөрөнгө оруулах;
- ✓ Хүүхдийг үл ялгагарлах;
- ✓ Хүүхэд бүрийн төлөө халамж анхаарал тавих;
- ✓ Хүүхэд бүрт боловсрол олгох;
- ✓ Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах;
- ✓ Хүүхдийг болзошгүй аюулаас хамгаалах;
- ✓ ДОХ-той тэмцэх;
- ✓ Хүүхдийн санал бодлыг сонсож, тэдний оролцоог хангах;
- ✓ Эх дэлхийг хүүхдэд зориулж хайрлаж хамгаална.

Энэхүү хөтөлбөрийг 3 үе шаттайгаар 9 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр тусгасан.

1 үе шат: 2002-2004

2 үе шат: 2005-2007

3 үе шат: 2007-2010

Энэ хөтөлбөрт: Манай оронд хүүхдийн эрхийг хангах эрх зүйн орчин төлөвшиж байгаа боловч тэдгээрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс хамгаалах асуудлыг олон улсын холбогдох гэрээнд нийцүүлэх зэрэг эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлага байгааг тэмдэглэж хүүхдэд ээлтэй эрх зүйн шинэтгэл хийх хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна:

1. Хүүхдийг дээдлэх зарчимд нийцүүлэн Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах;

Энэ хүрээнд Хүүхдийн эрхийн үндэсний хууль тогтоомжийг олон

улсын хүүхдийн эрхийг хамгаалах гэрээний агуулгад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, мониторинг хийх.

2. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах;

Үүнд, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах сүлжээг бүрдүүлэх, Хүний эрхийн комиссын дэргэд хүүхдийн эрхийн салбар зөвлөл ажиллуулах, хэрэгжилтэд хяналт тавих, омбудсман ажиллуулах, хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх мэдээллийн сан байгуулах, олон нийтийг татан оролцуулах, төрөлжсөн судалгааг хийх, насанд хүрээгүйчүүдийн цагдан хорих, баривчлах байр, хорих ангийн нөхцөл байдлыг сайжруулах, мэргэшсэн багш бэлтгэх, нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, иргэд олон нийтэд хүүхдийн эрхийн талаарх мэдлэг олгох ажлыг өргөжүүлэх талаар тусгажээ.

Хөтөлбөрийг хүн амын талаар төрөөс баримтлах бодлогын бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх ба үндэсний хэмжээнд мөрдөж буй бусад хөтөлбөртэй уялдуулах шаардлагатайг дурджээ.

Удирдлагын төвшинд:

Хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь төрийн эрх зүйн бодлого нь орон нутгийн бүх төвшинд удирдлагын байгууллагууд байхгүй бол төрийн бодлого амжилттай хэрэгжихгүй нь ойлгомжтой.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар хүүхдийн талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг хүн амын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцдаг. Энэхүү Засгийн газрын гишүүн дэргэд Хүүхдийн төлөө үндэсний байгууллага ажиллаж байна.

Харин орон нутгийн хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах төрийн чиг үүргийг харьяа нутаг дэвсгэрийнхээ хүрээнд Засаг дарга хариуцах бөгөөд түүний дэргэд Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөл байна.

Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, төр олон нийтийн болон бусад байгууллага, аж ахуйн

нэгж, иргэдийг оролцуулах үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн үндэсний зөвлөл байна. Энэхүү зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд зөвлөлийн ажлын албаны үүргийг Хүүхдийн төлөө үндэсний байгууллагаар гүйцэтгүүлэхээр заажээ. Мөн хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах олон нийтийн байгууллага болох Хүүхдийн төлөө сан байна.

Удирдлагын төвшинд цаашид салбар хоорондын зохицуулалтыг сайжруулах, Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг хангахад тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх нь нэн чухал ач холбогдолтой юм.

Гүйцэтгэх төвшинд:

Хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг харьцангуй олон байгууллага, газар шийдвэрлэж байгаа нь нэг талаас нааштай үзүүлэлт боловч тэдгээрээс хүүхэд, залуучуудад үзүүлж буй нийгмийн, сэтгэл зүйн, сурган хүмүүжүүлэх, эрүүл мэндийн, эрх зүйн арга хэмжээнуудийг цоц нэг гольдролд чиглүүлэн хүүхэдтэй ажиллах бүх субьектийн үйл ажиллагааг нэгтгэх зайлшгүй шаардлагатай. Зөвхөн хамтын ажиллагаа, нэгдсэн хүч чармайлтаар тэдгээрийн ажлын уялдаа, үр дүнгээр хүүхдийн эрхийн хамгаалалтыг бүрэн хангах нөхцөл бүрдэнэ. Иймэрхүү алба, газрууд үүсэн бий болж, хүүхдийн чиглэлээр ажиллаж байгаа тохиолдолд хүүхдийн асуудлын салбар судалгааг хийх, зохих мэргэжилтэнг бэлтгэх, давтан сургахыг зайлшгүй шаардана. Жишээ нь: Боловсролын их сургуульд нийгмийн ажилтан бэлтгэж байна.

Хүүхдийн эрхийн асуудлаар хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад салбар нэгжүүд байгуулагдсан байна. Харин одоо шүүх эрх мэдлийн салбар хүүхдийн эрхийн талаар мэргэшсэн шүүгчид, түүнд зохицсон бүтцийн бусад элементийг бий болгох шаардлагатай.

Хэвлэл мэдээллийн хэрэгсүүдийн анхаарлыг мөн хүүхдийн эрхийн асуудалд хандуулах нь чухал байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсүүд нь мэдээлэл түгээх, нөлөөллийн маш том нөөц боломж

байгаа тул түүнд тулгуурлан хүүхдийн эрхийн асуудлын ач холбогдлыг зохих төвшинд хүргэх бүрэн боломжтой юм.

Хүүхдийн асуудлаархи төрийн бус байгууллагаар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэн үйл ажиллагааг өргөжүүлэх, нэгдсэн сүлжээ, мэдээллийн сан бүрдүүлэх хэрэгцээ шаардлага гарч байгааг ч анхаарах нь зүйтэй. Иймээс хүүхдийн эрх ашгийн төлөө ажилладаг төрийн бус байгууллагуудын зсвэл сүлжээний зохицуулагч байгууллагатай харилцах, хамтран ажиллах зохистой хэлбэрийг бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд Буяны байгууллагууд хүүхдийг хамгаалах хүрээнд явуулах үйл ажиллагаа өргөжиж байгаа нь нэг талдаа ач холбогдолтой боловч нөгөө талдаа хүүхдийн эрхийг зөрчих, хууль тогтоомжийг хүүхдийн эрхийн хүрээнд гэхээсээ илүү байгууллагын явцуу ашиг сонирхлын хүрээнд хэрэгжүүлэх хандлагатай болсон.

2006 онд Хүүхдийн эрхийн үндэсний төвөөс хийсэн судалгаанаас үзэхэд хараа хяналтгүй хүүхэд нь 38 байгууллагын 55 халамжийн төвд харьяалагдаж байна. Халамж, асрамжийн төвүүдийн үйл ажиллагааг хүүхдийн эрх ашигт суурилсан нөхцөл боломжоор хангахын тулд стандартыг бий болгох, тэдгэрийн

үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай.

Боловсролын төвшинд:

Хамгийн чухал зорилт бол Хүүхдийн эрхийн тухай конвенцод Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийг судлах, сурталчлах ажлыг нийгмийн бүхий л давхаргын хүрээнд болон бус нутагт зохион байгуулах явдал юм.

Хүүхэдтэй ажиллаж байгаа, тэдний хувь заяаг бүх шатанд шийдвэрлэж байгаа ихэнх хүн буюу албан тушаалтан, багш, эцэг, эх төдийгүй хүүхдүүд ч өөрсдөө дээрх баримт бичгийг судлахгүй байна. Хуулийн дагуу амьдрах, хуулиа дээдлэх, хуулийг сахихыг хүн бүр бага наснаасаа буюу гэр бүлээсээ, цэцэрлэгээсээ эхлэх хэрэгтэй. Хүүхэд бүрийн, хүн бүрийн эрх нь иргэний үүрэг, хариуцлагатай уялдаж, өөрийн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрх, ашиг сонирхлыг хүндэтгэж байх эрх зүйн ухамсрыг хүүхэд насанд нь төлөвшүүлэх хэрэгтэй. Үүний тулд дээрх баримт бичгийг нийгмийн бүхий л хүрээнд судлах ажлыг зохион байгуулж мэдээллийг хүргэх ажиллагаанд хэвлэл мэдээллийн бүх хэрэгслийг ашиглах нь зүйтэй. Ялангуяа, боловсролын байгууллагууд маш чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Хүүхдэд эрх зүйн орчинд амьдарч байгааг

таниулан ойлгуулахад чиглэсэн "Мэдлэг+Чадвар+Хандлага" -ын цогц үр дүнд суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь илүү ач холбогдолтой. Үүний тулд:

Бага ангиудад: Эрх зүйн боловсролыг эдлэх эрх, хүний эрхийг судлахуй талаас авч үзэх хүүхдийн эрхийн тухай болон хүний эрхийн тунхаг бичигтэй танилцах хүрээнд ойлгох;

Дунд ангиудад: Иргэн судлалын хүрээнд эрх зүйн боловсролыг олгох хичээлүүдийг судалснаар сурагчдад дэлхий ертөнц, нийгэм, улс төр, засаглал, нийгмийн харилцааны тухай тодорхой хэмжээний мэдлэг, төсөөлөлтэй болгох боломж олоно;

Ахлах ангиудад: Эрх зүйн боловсролыг онолын илүү өндөр түвшинд олгох шаардлагатай.

Монгол Улсын төрийн эрх зүйн бодлогын хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь эрх зүйн бодлого чухал байр суурь эзэлнэ. Түүний ач холбогдлыг хүлээн зөвшөөрч бүх нийтийн анхаарлыг хандуулах үйл явц эрчимжиж хандлагатай байна. Энэхүү процесс нь экзалийн шатанд бус харин илүү эерэг шинж чанартай, үр дүнгээ хэрүүлсэн өөрчлөлтөд хүргэсэн байх ёстой.



Жинлэллийг шүүхийг

80 жил



Нийслэлийн шүүхийн шүүгч
Д.Дамдин-Од

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 2 дугаар Их хурлын тогтоолыг үндэслэн Засгийн газрын 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 15 дугаар Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаас "Аливаа шүүх таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай дүрэм"-ийг 3 бүлэг, 24 зүйлтэйгээр баталжээ. Энэ дүрмийн дагуу Монгол Улсад ардын ардчилсан шүүх таслах газруудыг ээлж дараатайгаар үүсгэн байгуулж эхэлжээ.

Улаанбаатар хотын Захиргааны газрын 3 дугаар Их хурлын, 1926 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн оройн гурван цагт хуралдсан 2 дугаар хуралдааны тогтоолын 1 дүгээр зүйлд "Тус хотын Шүүх таслах газрыг эсрэгэн 17 дугаар оны 1 дүгээр сарын 1-ний өдөр нээн байгуулах учир, Түшмэл, төлөөлөгч нарыг дүрмийн ёсоор сонгуулах хэмээсэн тухайг хэлэлцээд Түшмэлд "Шүүхийн дарга", зох. Д.Д./ тус Захиргааны газрын дарга С.Батсүх, 12 төлөөлөгчид Жамсран, Балжирлхундав, Бат-Очир, Занабазар, Мэндбаяр, Рэнцэн, Гончигдулам, Сономханд, Ишдулам, Цэнд-Аюуш, Гэндэн, Баяр, 6 орлогчид Нацаг, Дамдинжав, Дэндэв, Гомбо, Гомбожав, Элбэгбат нарыг сонгов." хэмээжээ.

Энэхүү түүхэн баримтад үндэслэн Улаанбаатар хотын шүүх

таслах газар буюу одоогийн "Нийслэлийн шүүх"-ийн цагид түүх эхэлдэг.

Тус шүүх нь анх дарга, байцаагч түшмэл буюу шүүгч, нарийн бичгийн дарга, хэлмэрч, бичээч, их гяндан салааны харуулууд, хуяг, морьтой,

явган зарлага зэрэг 39 орон тоотой эмхлэн зохион байгуулагдаж, дарга С.Батсүх нь ардын төлөөлөгч Д.Гончигдулам, Г.Занабазар, нарийн бичгийн дарга Н.Жамсран нарын хамт Шүүх явдлын яамнаас "Хотын шүүх таслах газрын тамга" гэсэн үзэг бүхий анхны тамгыг гардан авсан байна.

1927-2007 он хүртэл наян жилийн хугацаанд Улаанбаатар хотын шүүх буюу одоогийн Нийслэлийн шүүхийн дарга, ерөнхий шүүгчээр С.Батсүх, Ч.Чойдогсүрэн, Д.Чимэдцэрэн, Ж.Намсрай, Ж.Дамдин, С.Хорлоо, Д.Ханд, Г.Цэдэндамба, Д.Лодойсамбуу, Ч.Найдан, Д.Содномцэрэн, Д.Мижиддорж, Д.Пүрэв, Б.Санжмятав, Д.Ёндон, Д.Данзандорж, Н.Ганбаяр, Г.Дашгүдэв, Н.Төрбат, Б.Пүрэвдорж, С.Батдэлгэр нар ажиллаж байв.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Ардын ардчилсан шүүх байгуулагдсан нь аливаа дарлал мөлжлөг, харгис хатуу эрүү шүүлт, бурангуй дэглэмийг устгаж, нийт ард олны эрх, эрх чөлөө, язгуур ашиг сонирхлыг тууштай хамгаалах Ардын шүүхүүдийг орон нутагт үүсгэн байгуулах үндэс суурь болсон билээ.

Ардын шүүх байгуулагд-санаар эрүү, иргэний аливаа хэрэг маргааныг

шүүгч, ардын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга, маргалдагч талууд болон бусад оролцогчдийг суулцуулан олны өмнө нээлттэй хэлэлцэх, хууль, бодит үнэн, шударга ёсыг баримтлан, зөвхөн нотлох баримтад тулгуурлан, Монгол Улсын нэрийн өмнөөс шүүхийн шийдвэр гаргах, шүүн таслах ажиллагаанд оролцогч нарт анхан шатны шүүхийн шийдвэрийн талаар дээд шатны шүүхэд давж заалдах боломж олгох зэрэг ардчилсан шүүхийн зарчмыг хэрэгжүүлж эхэлжээ.

1931 онд орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчилсөнтэй холбогдуулан Шүүх явдлын яамны сайдын 1931 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 8 дугаар тушаалаар Улаанбаатар хотын шүүхийг 1 дүгээр ангийн шүүх болгон Төв аймгийн шүүхэд харьяалуулсан байна.

Улаанбаатар хот жилээс жилд хүрээгээ тэлж хөгжихийн зэрэгцээ шүүн таслах ажиллагааны цар хэмжээ ч улам нэмэгдэж байсантай холбогдуулан иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай барагдуулахад онцгой анхаарч БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1933 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн тогтоолоор хороодын дарга нарт шүүхийн даргын үүргийг хавсаргаж, жижиг хэрэг маргааныг захиргааны журмаар шийдвэрлэх эрх олгосон нь шүүн таслах ажиллагааг ард иргэдэд улам ойртуулсан тухайн цаг үедээ нийцсэн түүхэн үйл явц байлаа.

Шүүх явдлын яамны сайдын 1934 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар тушаалаар Улаанбаатар хотын 1 дүгээр ангийн шүүхийг "Улаанбаатар хотын шүүх" болгон Улсын дээд шүүхэд харьяалуулсанаар тус шүүх нь хуулиар тусгайлан харьяалуулсан хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэх, харин хороодын шүүхийн шийдвэрийг давж заалдах

болон хяналтын шатны журмаар хянан эхэлдэг эрхтэй болжээ.

1935 оноос Улаанбаатар хотын шүүх нь дарга, орлогч дарга, шүүхийн прокурор, байцаагч түшмэл, тогтоол гүйцэтгэгч, хэлмэрч, зарлага зэрэг олон орон тоотой болж, зохион байгуулалтын хувьд өргөжин бэхжсэн байна.

1940 онд шинээр Үндсэн хууль батлагдаж, шүүн таслах ажиллагааны ардчилсан зарчим болон шүүхийг зохих шатны хурлуудаас сонгож байгуулах журмыг хуульчлан баталгаа-жуулснаар шүүн таслах ажиллагааг зөвхөн мэргэжлийн шүүн таслах газрууд эрхлэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлжээ. Энэ үндсэн дээр 1943 оноос хороодын дарга нарыг шүүн таслах үүрэгээ чөлөөлж, 1945 оны дунд үеэс Улаанбаатар хотод Ардын хэсгийн шүүх, 1965 оноос Районы Ардын шүүхүүдийг тус тус үүсгэн байгуулж ажиллуулжээ.

1978 онд батлагдсан "БНМАУ-ын шүүхийн байгууламжийн тухай" хуулиар шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим, зорилго, чиглэлийг нарийвчлан тодорхойлж, бүх шүүхийг сонгуулиар байгуулах болсны дагуу Улаанбаатар хотын шүүхийг Хотын Ардын Депутатуудын хурлаас 3 жилийн хугацаагаар сонгож байгуулах болжээ. Хотын шүүх нь дарга, орлогч дарга, шүүхийн гишүүн, ардын төлөөлөгчдөөс, Районы ардын шүүх нь шүүхийн дарга, шүүгч, ардын төлөөлөгчдөөс тус тус бүрдэж, Районы Ардын шүүхийн дарга нь хотын шүүхийн гишүүний эрхээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж байв. Энэ цаг үед Улаанбаатар хотын шүүхийн харьяалалд Ажилчны районы Ардын шүүх, Октябрийн районы Ардын шүүхүүд ажиллаж байв.

1990 оны цагаан морин жилд Монгол оронд өрсөсөн, ардчилсан хувьсгал ялснаар эрх зүйн шинэтгэл хийгдэж, шүүхийн бүтэц зохион байгуулалтад зарчмын өөрчлөлтүүдийг хийх үндэс суурь тавигдав.

1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаж, 1993 оны 2 дугаар сарын 4-ний өдөр "Монгол Улсын Шүүхийн тухай" хууль шинэчлэгдэн мөрдөгдсөнөөр шүүгчдийн зохих шатны Ардын Депутатуудын хурлаас сонгодог хуучин тогтолцоог бүрэн халж, бүх шатны шүүхийн шүүгчдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар

томилдог болсноор шүүгч хэний ч нөлөөнд авталгүй, хараат бус байх ардчилсан зарчмыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн билээ.

1993 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын Их хурлаас баталсан "Шүүх байгуулах тухай" хуулиар Нийслэлийн давж заалдах шатны шүүх, Багануур-Багахангай дүүргийн шүүх, Баянгол дүүргийн шүүх, Сүхбаатар дүүргийн шүүх, Хан-Уул дүүргийн шүүх, Чингэлтэй дүүргийн шүүхийг шинээр үүсгэн байгуулж, дүүргийн шүүхүүдийг Нийслэлийн шүүхэд харьяалуулсан бөгөөд 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн дээрх хуульд өөрчлөлт оруулж, дүүргийн шүүхүүдийг Багануур, Багахангай дүүргийн шүүх, Баянгол дүүргийн шүүх, Баянзүрх дүүргийн шүүх, Налайх дүүргийн шүүх, Сонгинохайрхан-Жаргалант дүүргийн шүүх, Сүхбаатар дүүргийн шүүх, Хан-Уул дүүргийн шүүх, Чингэлтэй дүүргийн шүүхийг шинээр үүсгэн байгуулж, дүүргийн шүүхүүдийг Нийслэлийн шүүхэд харьяалуулсан бөгөөд 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн дээрх хуульд өөрчлөлт оруулж, дүүргийн шүүхүүдийг Багануур, Багахангай дүүргийн шүүх, Баянгол дүүргийн шүүх, Баянзүрх дүүргийн шүүх, Налайх дүүргийн шүүх, Сонгинохайрхан дүүргийн шүүх, Сүхбаатар дүүргийн шүүх, Хан-Уул дүүргийн шүүх, Чингэлтэй дүүргийн шүүх хэмээн нэрлэх болжээ. Сүүлд 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар Багануур, Багахангай дүүргийн шүүх, Налайх дүүргийн шүүхийг Налайх, Багахангай дүүргийн шүүх болгон өөрчилж, Улаанбаатар хотын шүүхийг "Нийслэлийн шүүх" хэмээн нэрлэж, бие даасан Тамгын хэлтэстэй болгосноор анхан болон давж заалдах шатны шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангахад туслах, иргэд, хуулийн этгээдээс ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавих, шүүхийн статистик, эрүү, иргэний хэргийн шүүхийн практикийг нэгтгэн судлах, шүүх, шүүгчдийг холбогдох мэдээлээр шуурхай хангах, сургалт, семинар зохион байгуулах, шүүхийн санхүү, хангамж үйлчилгээний үйл ажиллагааг дагнан гүйцэтгэж, шүүгчдийг санхүү, захиргаа, аж ахуйн ажлаас бүрэн чөлөөлсөн юм.

Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтэс нь анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор нийт шүүхүүдийг өөрийн гэсэн конторын барилгатай болгож, шүүгч бүр тусдаа өрөө тасалгаатай, орчин үеийн бичгийн ширээ, сандал болон бусад техник хэрэгслээр хангах асуудлыг амжилттай шийдвэрлэж ирлээ. Түүнчлэн давж заалдах шатны

шүүх, дүүргийн шүүхүүдийг тус бүр 50-150 хүний судал бүхий иргэний болон эрүүгийн шүүх хуралдааны танхимтай болгож, Нийслэлийн шүүхийн дэргэд төрийн статустай төрөлжсөн архив, компьютерийн сургалтын төвийг шинээр байгуулан, тэдгээрийг олон улсын жишгээр шинэчлэн орчин үеийн өндөр хүчин чадал бүхий техник хэрэгслэр, тоног төхөөрөмжөөр хангасан байна.

Нийслэл, дүүргийн шүүхийн шүүгчдийг гадаад, дотоодод сургалт, семинарт хамруулах, компьютер, мэдээлэл, технологийн сургалт зохион байгуулж нийт шүүгч, албан хаагчдыг хамруулах, ном, сонин, судалгаа шинжилгээний мэдээллээр хангахыг хэрэгцээ шүүгч, албан хаагчдын ажлын нөхцөлийг чадал бүхий техник хэрэгслэр, тоног төхөөрөмжөөр хангахыг хэрэгжүүлж байна. Тус шүүхийн иргэний болон эрүүгийн танхимаас эрхлэн гаргаад "Мэдээлэл" сэтгүүл нь аймаг, сумын шүүхүүдэд ч эрэлт хэрэгцээтэй гарын авлага болж байна.

1997 оноос эхлэн Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг, Ханс Зейдлийн сан, "Монголын нээлттэй нийгэм хүрээлэн" /Соросын сан/, Шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөр зэрэг гадаад улс орнуудын төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран гарын авлага, ном, сурах бичиг хэвлүүлэх, хөтөлбөр боловсруулах, төрөл бүрийн семинарыг зохион байгуулж, тэдгээрээс гарсан шийдвэрийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, албан хаагчдад хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтэс 1993 оноос хойш удирдлага, бүтэц зохион байгуулалтын хувьд байнга өргөжин бэхжиж, Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2002 оны 59 дүгээр тогтоолын дагуу албандын зохион байгуулалтад шилжсэн бөгөөд эдгээс Захиргаа, хүний нөөцийн алба, Хангамж, үйлчилгээний алба, Санхүүгийн албадад төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт 230 гаруй албан хаагч, ажилтан тогтмол ажиллаж байна.

Монгол Улсын дээд шүүхийн 2002 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 277 дугаар тогтоолоор Нийслэлийн шүүхэд Эрүүгийн болон Иргэний хэргийн танхим байгуулагдаж, тэдгээрийн тэргүүний Монгол Улсын Ерөнхийлөгчийн

зарлигаар 3 жилийн хугацаагаар томилдог болсноор дүүргийн шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Нийслэлийн давж заалдах шатны шүүх, анхан шатны найман дүүргийн шүүхээс "Нийслэлийн шүүх" хэмээх "Их айл" бүрддэг бөгөөд одоо Нийслэлийн давж заалдах шатны шүүхэд 18 шүүгч, дүүргийн шүүхэд 104 шүүгч, нийт 122 шүүгч эрүү, иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байна.

Нийслэлийн шүүхийн шүүгчдээс зөвхөн сүүлийн 10 жилд тус шүүхийн дарга, ерөнхий шүүгч, орлогч дарга, шүүгчээр ажиллаж байсан Д.Төрбат, И.Цэрэндүлэм, М.Могноо, одоо шүүгчээр ажиллаж байгаа А.Чимэдцогзол нар Монгол Улсын төрийн дээд шагнал "Гавьяат хуульч" цолоор, Б.Ганбаатар Сүхбаатарын одонгоор, С.Батдэлгэр Хөдөлмөрийн гавьяан улаан тугийн одонгоор шагнагдсан, ерөнхий шүүгч С.Батдэлгэр Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчээр, шүүгч Ц.Амарсайхан Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүнээр, О.Зандраа нар Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүнээр, шүүгч Л.Бямбаа, Л.Атарцэцэг, Б.Ундрах нар Улсын дээд шүүхийн шүүгчээр, Ц.Зориг Нийслэлийн шүүхийн ерөнхий шүүгчээр тус тус дэвшин ажиллаж байгаа нь тус шүүхийн хамт олны бахархал төдийгүй шүүх эрх мэдлийн байгууллагын дотор энэ "Их айл"-ын эзлэх байр суурийн нэгэн үнэлэмж гэж үздэг.

Оноогойн байдлаар Нийслэлийн давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхийн шүүгчдээс гавьяат хуульч 1, Монгол Улсын шүүхийн тэргүүний ажилтан 40, Хууль зүйн тэргүүний ажилтан 37 ажиллаж байна.

Эдүгээ Нийслэлийн найман дүүргийн шүүх жилд дунджаар 2700 гаруй эрүүгийн хэрэг, 8300 гаруй иргэний хэрэг, 9300 гаруй захиргааны зөрчлийн хэргийг анхан шатны журмаар, Нийслэлийн давж заалдах шатны шүүх, дүүргийн шүүхийн шийдвэртэй эрүүгийн 700 гаруй хэрэг, иргэний 800 гаруй хэрэг, маргааныг давж заалдах журмаар хянан шийдвэрлэж байгаа нь улсын хэмжээний нийт шүүн таслах ажлын 40 гаруй хувийг эзэлдэг. 2006 оны тайлан мэдээгээр жилд Нийслэлийн шүүхийн нэг шүүгчид дунджаар эрүүгийн 53 хэрэг, иргэний 160 хэрэг,

захиргааны 90 гаруй хэрэг ногдож байв.

Шүүхийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад салбар хуулийн хүрээнд ардчилсан, шударга ёсыг хангах явдал бөгөөд үүнийг хэрэгжүүлэх үндэс нөхцөл болох шүүгчдийн мэдлэгийн хүрээ, хууль хэрэглэх үр чадварыг байнга дээшлүүлэх, шүүгчийг ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж мөрдөх шаардлагыг хангах үүднээс Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс харьяа дүүргийн шүүхүүдийг мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангах чиг үүргээ нэр төртэй хэрэгжүүлж байна.

Энэ чиглэлээр Нийслэлийн давж заалдах шатны шүүх, Тамгын хэлтсээс тэдгээрийн үйл ажиллагаанд жилд хоёроос доошгүй удаа иж бүрэн шалган туслах ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг давтан гаргуулахгүй байх зорилгоор эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд анхаарвал зохих тодорхой асуудлуудар шүүхийн практикийг нэгтгэн судаж, "Мэдээдэл", "Тойм", "Зөвлөмж"-үүдийг тогтмол гаргаж, шүүгч, найрын бичгийн дарга нарын гарын авлага болгож байгаагийн зэрэгцээ сар бүрчингээст Улсын дээд шүүх, Хууль зүйн үндэсний төв болон холбогдох хуулийн байгууллагууд, хуулийн их, дээд сургууль, мэргэжлийн бусад байгууллагуудын эрдэмтэд, багш, судлаачидтай хамтран онол, практикийн бага хурал, хэлэлцүүлэг, мэргэжлийн хичээл сургуулийг зохион байгуулж байна.

Тус шүүхээс АНУ-ын Муж улсуудын шүүхийн үндэсний төвөөс хэрэгжүүлж буй "Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр" төслийн санаачилга, дэмжлэгтэйгээр "Шүүгчийн гарын авлага", "Тамгын хэлтсийн ажилтны гарын авлага" номыг боловсруулан хэвлүүлж, Монгол Улсын нийт шүүхийн ажилтнуудын хүртээл болгосны зэрэгцээ "Нийслэлийн шүүхийн хөгжлийн стратеги төлөвлөгөө", "Дүүргийн хэргийн хөдөлгөөний судалгаа", "Шүүх ахвалдааны танхим", "Бүртгэлийн автоматжуулалт" зэрэг олон төслийг амжилттай хэрэгжүүлээд байна.

Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсээс шүүхийн хамт олны ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, шүүгч, ажилтнуудын хөдөлмөрийг хөнгөвчлөх талаар орчин үеийн ололт амжилтыг амьдралд нэвтрүүлэн ажилласны үр дүнд 2004

онд Хуулийн байгууллагын дотроос "Хамгийн таатай орчныг бүрдүүлэгч хамт олон"-оор шалгарч байв.

Одоо Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчээр Монгол Улсын шүүхийн дэд түшээ Ц.Зориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүнээр шүүгч Б.Сарантуяа, Иргэний хэргийн танхимын тэргүүнээр шүүгч Ц.Өрнөндэлгэр, Эрүүгийн хэргийн шүүгчээр Гавьяат хуульч А.Чимэдцогзол, шүүгч Д.Цэвээндэрэн, З.Цэнгэнбаяр, Л.Даваасүрэн, Д.Дамдин-Од, Д.Мөнхтуул, Ш.Бат-Эрдэнэ, Б.Батцэцэг, Иргэний хэргийн шүүгчээр Ц.Тогоохүү, Т.Гариймаа, О.Гэрэл, Ч.Оюунцэцэг, Х.Сонинбаяр, Ц.Ичинхорлоо, М.Наранццог, Тамгын хэлтсийн даргаар зөгийн захиргааны дэд түшээ Н.Даваа, Хангамж, үйлчилгээний албаны даргаар Б.Мөнхдөл, Захиргаа, хүний нөөцийн албаны даргаар Д.Батхүрэл, Санхүүгийн албаны даргаар Н.Наранццэг, Нэгдсэн эрхийн эрхлэгчээр Д.Доржжанд, Тамгын хэлтсийн нярааар Ш.Осорхүү, Багануур дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Д.Оюунбат, Налайх, Багахангай дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Л.Гансүх, Баянгол дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Н.Ичинхорлоо, Баянзүрх дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Е.Цогтзандан, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Д.Цогтсайхан, Сүхбаатар дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Н.Сүхбаатар, Хан-Уул дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Б.Баатар, Чингэлтэй дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Л.Сарангэрэл нар ажиллаж байна.

Нийслэлийн шүүхийн хамт олон өргөсөн тангарагтаа үнэнч байж, Монгол Улс ард иргэдийнээс өмнө хүлээсэн үүрэг, шударга үнэний төлөө ариун үйлсдээ өөрийн мэдлэг, авьяас чадвар, бүхий л хүч хөдөлмөрөө зориулан ажилласны үр дүнд шүүн таслах ажиллагааны чанар, шүүхийн хэвийн ажиллах нөхцөлийг улам сайжруулахаар хийсэн бүтээл ажил, их ойг угтан зохиосон урлаг, спортын тэмцээн, наадамд үзүүлсэн өндөр амжилтаар 80 жилийн түүхт ойтгойгоо золгож байна.



Дэлхий шүүхэд итгэнэ

Дэлхийн улс түмэн, ирээдүй үе шүүхэд итгэж байна. Энэ үгийг Энэтхэгт болсон дэлхийн Ерөнхий шүүгчдийн олон улсын бага хурлын индэр дээрээс олон дахин сонссон билээ. Энэ бага хуралд миний бие оролцох завшаан олдсон юм. Энэ хуралд Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэрийн илтгэлийг өргөн мэдүүлсэн ба үг хэлэх боломж олдсон билээ.

Дэлхийн Ерөнхий шүүгчдийн бага хурал

Дэлхийн улс орнуудын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчдийн бага хурлыг жил тутамд зохион байгуулдаг уламжлал БНЭУ-д хэвшил болон тогтсон байна. Энэ бага хурлаар Дэлхийн олон улсын тулгамдсан асуудал түүний эрх зүйн зохицуулалтын талаар хэлэлцэн орон орны төлөөлөгчид өөрсдийн санал бодлоо илэрхийлдэг байна. Дэлхийн шүүгчдийн 7 дугаар бага хурал 2006 оны 12 дугаар сард болж дэлхийн ирээдүй-үе, хүүхдийн эрх ашгийг хамгаалахад ихээхэн анхаарал тавьсан юм. Энэ талаар тавигдах гол шаардлага нь хүний амьдрах аж төрөх, амар амгалан өсч хүмүүжихэд: а) аюулгүй цэвэр дэлхий ертөнц хэрэгтэй; б) дайн байлдаангүй амар амгалан байх шаардлагатай байна; в) гэмт явдал гарч улс хоорондын олон улсын шинжтэй боллоо. Энэ нь мөнгө угаах, хүчирхийлэл үйлдэх, бэлгийн мөхлөг, хар тамхи зэргээр илэрхийлэгдэнэ. Ийм аюул заналгүй бол сайхан амьдрах боломжтой гэж үзэж байна.

Энэ удаагийн бага хуралд дэлхийн 86 орны 250 гаруй зочид, төлөөлөгчид оролцсоноос арав гаруй орны Ерөнхий шүүгч хүрэлцэн ирснээс гадна Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, зарим орны Хууль зүйн сайд оролцсон юм.

Сити Монтессори сургууль Бага хурлыг энэ сургууль зохион



Улсын дээд шүүхийн шүүгч А.Доржготов

байгуулдаг. Тус сургууль БНЭУ-ын Лакнау хотод байдаг. Энэ сургууль 30 000 гаруй оюутан сурагчдыг эгнээндээ багтаасан. Дэлхийн дээд амжилтын Геннесийн номонд дэлхийн хамгийн том сургууль хэмээн алдаршжээ.

Мөн сургууль нь 2002 оны Энхтайван боловсрол хэмээх UNESCO-ийн шагналын эзэн болжээ.

Сити Монтессори сургуулийн 30000 гаруй оюутан дэлхийн хоёр тэрбум хүүхэд багачуудын нэрийн өмнөөс Дэлхийн шүүх засгийн төлөөлөгчдөд хандан уриалга гаргасан юм. Энэхүү уриалга нь аюулгүй, экологийн цэвэр, энх амгалан дэлхий ертөнцийг өвлөн авах хүүхдийн эрхийг баталгаажуулахад оршиж байлаа.

Өнөөдөр дэлхийн олон оронд нийтдээ 36000 гаруй цөмийн, химийн болон биологийн зэвсэг хадгалагдаж байна. Үүнээс гадна олон улсын алан хядах ажиллагаа, хар тамхи хил дамнуулан

наймаалах, улс орнуудын хооронд дахь зөрчил, мөргөлдөөн, дэлхийн нийтийг хамарсан дулааралт, экологийн тэнцвэргүй байдал, цөлжилт, ойгүйжилт зэрэг асуудлууд биднийг, нэн ялангуяа, бидний хойч ирээдүйг байнгын түгшүүрт байлгаж байна.

НҮБ-ын статистик мэдээнээс үзэхэд 5-аас доош насны 40 000 хүүхэд өдөр болгон хоол хүнсний дутагдал, өвчний улмаас нас барж, сүүлийн 10 жилийн хугацаанд 2 сая хүүхэд дайны золиос болж, 12 сая хүүхэд гэр оронгүй, 1 сая хүүхэд ацэг, эхээ алдаж, 300 мянга гаруй хүүхэд цэрэг дайны болон уул уурхайн хүнд нөхцөлд ажил хийж байна. Үүнээс гадна дэлхий даяар нийт 100 сая гаруй хүүхэд хортой, хүнд нөхцөлд албадан хөдөлмөр эрхэлж, 10 сая гаруй хүүхэд-дүрвэгсэд байгаагаас гадна 113 сая хүүхэд хэзээ ч сургуульд явж номын дуу сонсож байгаагүй байна. Үүнээс үзэхэд дэлхийн маш олон тооны хүүхэд багачууд сурч боловсрох, хоол хүнс, гэр орон, өмсөх хувцсаар хангагдах зэрэг наад захын эрхээр хангагдаж чадахгүй байхад асар их хэмжээний хөрөнгийг үй олноор устгах зэвсэг, дайн байлдааны бэлтгэл ажилд зарцуулсаар байна. Зөвхөн 1995 онд НҮБ-аас хийсэн судалгаагаар янз бүрийн улс орнуудад минут тутамд 1.5 сая ам.долларгүй батлан хамгаалах салбарт зарцуулж байсан бөгөөд энэ нь нэг жилд нийтдээ 800 тэрбум ам.доллар болж байна. Гэтэл дээрх хүүхдүүдэд ерөнхий боловсрол олгох, эрүүл мэндийг хамгаалах, хоол хүнс, цэвэр ундны усаар хангахад зөвхөн 28 тэрбум ам.долларын хөрөнгө хэрэгтэй гэсэн тооцоог НҮБ-аас хийсэн байдаг байна.

Тийм учраас дэлхийн нийтийн энэхүү өнөөгийн байдлыг өөрчилж, байгалийн гамшиг, алан хядах ажиллагаанаас ангид нэгдмэл, энх амгалан дэлхийн ертөнцийг бидний гэрэлт ирээдүй болсон хойч үедээ өвлүүлэхийг Сити Монтессори

сургуулийн нийт оюутан сурагчид уриалсан билээ.

Дэлхийн ирээдүй үе дэлхийн улс түмний шүүгчдэд хандаж байна. Дэлхийд улс орон бүрт шийдэгдэхгүй асуудал олон байна. Энэ бүхэн зохицуулагдахгүй байна. Цөөн хэдхэн хүний л эрх ашгийн төлөө ажиллагаа явагддаг болсон байна. Энэ талаар хэлж ярих боллоо. Иймээс хүмүүс шударга шүүхэд найдах боллоо. Асуудалд шударгаар хандаж, шийдвэрлэх эрх мэдэл байгаа хүмүүс бол шүүгчид юм. Иймээс шүүх эрх мэдэлд найдлага тавьж итгэх хэрэгтэй. Иймээс ч шударга үнэний баталгаа болсон дэлхийн улс орнуудын шүүгчдэд хандсан уриалга гаргаж байна.

Дэлхий хуульчдааа тэр дундаа шүүгчдэд итгэл хүлээлгэж байна.

Уг бага урлыг зохион байгуулагч, менежер Жагдиш Ганди "дэлхийн ирээдүй үе, шүүгчид, шүүх эрх мэдэлд найдлага тавьж байна. Яагаад гэвэл шударгаар шүүгдэж, Шударгаар шүүх ёстой. Хараат бус байдаг. Энэ нь шударгаар шүүх эрх мэдэлтэй байдаг оршино" гэж ярьж байна. Ирсэн төлөөлөгчид ч энэ санааг даван даван өгүүлж байв.

Энд дашрамд дурдахад Энэтхэг оронд шүүх эрх мэдэл зөв төлөвшиж тогтсон юм болов уу гэсэн бодол төрсөн билээ.

Монголын Элчин сайдын яамны ойролцоо зарим үйлчилгээний газрыг хааж лацадсан байх юм. Түүнд Дээд шүүхийн шийдвэрээр битүүмжилсэн, үйл ажиллагааг зогсоосон тухай бичиг өлгөсөн байв. Энэ талаар манай элчин сайдын яамны ажилтан сонин болгож өгүүлээд "Энэтхэгт их сонин юм. Шүүх нь Парламент, Засгийн газартаа захирагдахгүй гэнэ. Тухайлбал, энд битүүмжилсэн газрууд нь 60,70-иад оны үед хувьчлагдсан, одоогийн эздийн мэдэлд шилжсэн гэх. Гэвч энэ асуудлыг Дээд шүүх хуулийн дагуу аяагүй бол битүүмжлэн, хурааж, өмнөх өмчлөлийг нь сэргээж байгаа тухай ярилаа". Энэ талаар Засгийн газар нь хүсэхгүй байгаа ч шүүх нь Засгийн газар, парламентын эсэргүүцэл, санал хүсэлтийг үл хэргэсэж байгаа гэнэ...

Дэлхийн хууль тогтоох дээд байгууллага

Бага хурлын хэлэлцүүлгийн нэг сэдэв нь энэ. Дэлхийн загвар парламентын тухай байлаа. Энэ талаар Шри Ланк, Англи, Украины оюутны төлөөлөгчид жишээ баримт иш татан бүр тодорхой санал, санаачилга дэвшүүлж байв. Дэлхийд нэг парламент байх ёстой гэж үзэв. Дэлхийд хууль тогтоох нэг байгууллага байхын шаардлага нь Дэлхий ертөнц, байгаль орчин сүйдэж байна. Цөмийн туршилт, дайн байдлаар гэх мэт олон янзын шаардлага бий болсон. Орон орны цөөн хэдхэн хүний дураар аашлах, эрх ашгийнхаа төлөө ажиллагаа явуулдаг, хүүхдийн эрх ашгийг зөрчдөг, дайн байлдаан шийдэж явдлыг хагаарлаж зогсоох ёстой. Энэ нь дэлхийн парламент байгуулахыг шаардаж байна гэх үзэл санааг илэрхийлэв. Үүнтэй холбоотойгоор НҮБ-ын үйл ажиллагаа хангалтгүй байгаа талаар хөндөгдөв. Тухайлбал, Буурай хөгжилтэй улс орнуудад зовлон зүдгүүр өслөгөнгийн эсрэг төсөл хэрэгжиж мөнгө тэргэгдэж ч зарцуулалтаар нь зарцуулалтгүй буруу ашигладаг. Эрх баригчид нь өөрсдийн эрх ашгийн төлөө буруу зарцуулдаг тухай ч яригдсан юм. Нөгөө талаар орчин үеийн хөгжил, даяарчлалын үед улс орны бүх асуудлыг тухайн орны парламент дангаараа шийдвэрлэж чадахгүй болов. Жишээ нь: гэмт хэрэг л гэхэд улс дамжсан үйл ажиллагаа болсон тул шийдэж чадахгүй байна.

Энд боловсрол чухал. Хүүхдийг багаас нь сургаж боловсрол эзэмшүүлэхэд ч энэ асуудал хамаатай гэнэ. Энэ мэтээр Дэлхийн нэг парламент бий болгох дэлхийн хэмжээнд дагаж мөрдөх хууль тогтоох шаардлага бий болсныг илэрхийлэв. Энэ парламент нь дэлхийн бүх улс орноос тэгш эрхтэй төлөөлөгчид/парламентын гишүүд/өөс бүрдэнэ. Улс орон бүр адил тэгш эрхтэйгээр оролцоно. Улс орон бүрт дагаж мөрдөх хүчин чадалтай хууль батална.

Дэлхийн хууль

Дэлхийн хууль тогтоох байгууллага бий болсноор бүх дэлхийн улс дагаж мөрдөх хууль батална. Аль ч улсад хүчин

төгөлдөр дагаж мөрдөнө. Зөрсөн бол тухайн улс олон улсын өмнө хариуцлага хүлээнэ. Эрх зүйн хувьд тийм дэлхий ертөнцийн бий болгог гэж үзэж байна. Олон улсын хууль хэрэгтэй гэж олон төлөөлөгч үзэж байна. Энэ нь одоогийн олон улсын гэрээ, конвенци шиг биелэх биелэхгүйн хооронд байж болохгүй. Зарим улс орон биелүүлдэг зарим нь биелүүлдэггүй байж болохгүй. Энэ хуулийг биелүүлэх шударга үнэний баталгаа нь шүүх эрх мэдэлд хамаарна. Энэ талаар олон төлөөлөгч үг хэлж санал бодлоо илэрхийлж байлаа. Үүний дотроос БНЗУ-ын Хууль зүйн сайд Шри Каул Синх Такур өнөө үед улс орнууд харилцан хамааралтай болсон. Ямар ч улс орон дан ганцаар оршин тогтнож чадахгүй. Сүүлийн үед соёл, шинжлэх ухаан, технологийн хөгжил, ялангуяа тээвэр харилцаа хоёоноо салбарын хөгжил дэлхий нийтийг нэгдмэл гэр бүл болгов. Харилцан хамаарал дэлхийд энэ тайвнаар зэрэгцэн оршихын тулд олон улсын эрх зүйн дүрэм журмыг сахин мөрдөх шаардлага бий болов. Энэ нь зохистой хөгжилд нэн шаардлагатай.

Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн тулд гишүүн орнуудаас баталсан журмыг чандлан сахихгүй бол дэлхий дэлж эмх замбараагүй байдал бий болж эргээд олон улсын нийгэмлэгийн хөгжил дэвшилд эсрэг нөлөө үзүүлнэ.

Олон улсын эрх зүй гэдэг нь энэхүү нэр томьёоны бодит утга санаа юм уу эсвэл улс орнуудын зөлдөг байдлаар дагаж мөрддөг зөрөг ёс суртахуун юм уу гэдэг асуудал дээр эрдэмтэд, судлаачид маргалддаг. Олон улсын эрх зүйн хөгжлийг хэн ч үгүйсгэх аргагүй юм гэдгийг тэмдэглэхийн зэрэгцээ дэлхийн хөгжил дэвшил улс орнууд дагаж мөрдөх шинэ дүрэм журмыг шаардаж болов. "Үүнийг шийдвэрлэхэд бидний өмнө хэрэглэж заншсан олон улсын эрх зүйн асуудал мухардалд ороод байгаа"-г тэмдэглэсэн, бас өнөөгийн шаардлагыг анхааралдаа авч системтэй хөгжиж байгаа ч дурдаж байв.

Тэгэхлээр тэд олон улсын хуультай больё гэж байна. Олон улсын хоорондын харилцааг хуулиар зохицуулна. Улс орны эдийн засаг ч, иргэн ч эрх баригч ч

хуулиа биелүүлэх болно. Шүүх гэрээ хэлэлцээр биш гадгүч олон улсын хууль хэрэглэнэ. Түүнд шүүхийн хяналтыг хэрэгжүүлнэ. Шүүх эрх мэдлийн хүч чадлыг ашиглана. Олон улсын хуулийг зөрчөөл Засгийн газар, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэнэ. Хэрэг маргааныг шударгаар шийдвэрлэнэ. Хүний эрх, хүүхдийн хууль ёсны ашиг сонирхол, улс орны эрх тэгш харилцааны баталгаа нь шүүх эрх мэдэл болох юм.

Үндсэн хуулиа дээдлэн сахидаг

Дээр дурдсан үзэл бодол, бага хурлаар хэлэлцүүлсэн асуудлуудын гол үндэслэл, үзэл санаа нь Энэтхэгийн Үндсэн хууль юм. Энэтхэгчүүд Үндсэн хуулиа улс орондоо дээлэн сахихаар хязгаарлахгүйгээр түүний үзэл баримтлалыг дэлхийн дэвжээнд гаргахаар эрмэлзэж байна. Энэ үзэл санааг хэрэгжүүлэх ажлыг Лакнау хотын Сити Монтеessori сургууль санаачлан хийж эхэлжээ. Энэтхэг улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлд

Энэтхэг улс нь дараах зүйлүүдийг хэрэгжүүлэхийн тулд хүчин чармайна:

- Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг дэмжих;
- Улс хоорондын шударга, эрхэм харилцаа холбоог дэмжих;
- Олон улсын эрх зүйг хөхиүлэн дэмжих;
- Олон улсын хэрэг маргааныг арбитраар шийдвэрлүүлэхийг хөхиүлэн дэмжих гэж заасан байдаг.

Энэхүү 51 дүгээр зүйлийн /С/ заалт нь эдгээр үзэл санааг дэвшүүлэн гаргах, олон улсын бага хурал зохион байгуулах үндэслэл болсон байна.

Үүнээс бид ихээхэн зүйлийг эргэцүүлэн бодох ёстой мэт санагдана.

Манайд Үндсэн хуулийг дээдлэх сахиж ёстой. "Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим" гэдгийг Үндсэн хуулиараа тодорхойлон заасан байдаг. "Үндсэн хуульд" хууль зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл

ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэдгийг заан тодорхойлжээ. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 12 цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө гэдгийг Үндсэн хуульд өөрт нь тунхаглан зарлаж, "мэдэгтүн, сахитун" хэмээсэн билээ. Гэвч энэ үеэс хэрхэн дээдлэн мөрдөв. Ямар үр дүн гарав. Заалт нэг бүрийг хэрхэн сахин биелүүлэх талаар ямар ажил хэн зохион байгуулав. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний зөв нэгдлийг хангах зарчмыг төрийн байгууллага, албан тушаалтан бүр хэрхэн хэрэгжүүлэв. Үндсэн хуулийн заалтад намуудын хоорондын гэрээ, хэлцэл, зөвшилцөл мэтийн баримт бичиг нийцэж байв уу. Ер нь эдгээрийн аль нь илүү үйлчлэв гэх мэт олон зүйлийг эргэн харж шинжлэх ухаанчаар судлан дүгнэх нь зүйтэй мэт санагдсан даа.

Энэтхэгчүүдээс их юм сурах хэрэгтэй мэт бодогдсон. Монголд Үндсэн хуулиа дээдэлж, дэлхийн дэвжээнд гаргахын төлөө эрмэлзэж санаачилга байна уу, үгүй юу. Үндсэн хуулийн эрх зүйн сургалт ямар байна вэ? Энд асуудал байж магадгүй. Миний бие хууль зүйн болон бусад сургуулиуд, төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулж байгаа онол практикийн хурал, семинарт олон оролцсон. Энд Үндсэн хуулийг хэрхэн дээдлэн сахиж, яаж биелүүлэх талаар хөндөх нь тун ч цөөндөө. Харин ч түүнийг өөрчлөх талаар бол хангалттай ярьдаг. Энэ нь Үндсэн хуулийг дээдлэн сахижгүй байх, хуулийг сахин биелүүлэх биш харин ч төрийн албан тушаалтан өөрийн үйл ажиллагаанд хуулийг нийцүүлэх үзэл санааг дэлгэрүүлэх хөрс суурь болдог байж мэднэ. Их, дээд сургуулийн оюутны диплом, эрдэм шинжилгээний илтгэлд ч мөн л нийтлэг шинж нь хуулийг биелүүлэх онол, арга зүй, ач холбогдлыг авч үзэхээс өмнө түүнийг өөрчлөх санал давамгайлна. Энэ нь их, дээд сургуулийн сургалтын чанар, багшийн чадал чансаа, сэтгэлгээнээс шалтгаалдаг байж болзошгүй.

Би санаж байна. Хэдэн жилийн өмнө дөө. Олон улсын харилцааны сургуулийн док.

профессор н.Баясгалангаас эрдэм шинжилгээний хуралд шүүгч хийх урилга хүлээн авч билээ. Тэр хурал дээр Чечины Үндсэн хуулийн талаар итгэл тавьсан оюутан охин /нэрийг нь маргээ! тэргүүн байр эзэлсэн юм. Түүний итгэлд улс орно тусгаар тогтнол гэж ямар агуу болохыг Үндсэн хуулиа дээдлэн сахиж ёстойг; түүнийг дээдлэн хэрэгжүүлсний ач холбогдлыг энгийнээр яруу сайхан илэрхийлсэн байж билээ. Энэ илтгэлийг сонсоод биднийг тэргүүлж байсан Г.Совд гуай үнэлэхдээ "энэ сургуулиудын сургалтад учир байж мэднэ. Үндсэн хуулийн ач холбогдол, түүнийг хэрхэн биелүүлэх, дээдлэн сахиж талаар юу хийх, онол арга зүйн асуудлыг авч үзсэн оюутан ер байдаггүй. Энэ охин харин Үндсэн хуультай байхын ач холбогдол, түүнийг заавал биелүүлэхийн учир холбогдлыг зөв гаргасан их сайн илтгэл бичсэн байна" гэж сайшааж байж билээ.

Энэ явдлыг би Сити Монтеessori сургуулийн үйл ажиллагаатай харьцуулан дурсаж байгаа юм. Сити Монтеessori сургуулийн хийж байгаа ажлыг талархан хүлээж авах ёстой. Үндсэн хуулиа дээдлэн сахижын ач холбогдлыг үлгэр жишээ үзүүлсэн энэ сургуулийн номын санд Монгол Улсынхаа Үндсэн хууль /Хууль зүйн үндэсний төвөөс эрхлэн хэвлүүлсэн долоон хэлээр бичигдсэн/-ийг бэлэглэн үлдээсэн. Тэд манай Үндсэн хуулийг бас судлаг.

Шүүгчийн үг

Бидэнд тус бага хурлын төлөөлөгчөөр очсон олон хүн, олон орны шүүгч найрсгаар хандаж байв. Энэтхэгчүүд, АНУ-ын төлөөлөгчид, Бутан, Балба, бүр Өмнөд Африкийн нэгдсэн улсаас оролцож байгаа парламентын гишүүн хүртэл ирж бидэнтэй найрсгаар талархалтай яриа өрнүүлэнэ. Олон орны шүүгчийн илтгэл, хэлсэн үгийг сонсох. Бас ч дэлхийн улс түмэн Монголыг мэддэг, зарим нь Монголд ирж үзсэн хүмүүс байх юм. Бид ч бас нэг үеэ бодвол дэлхийн улс орны түвшинд хурчихсэн тэдэнтэй үг яриа нийлэхтэйгээ болчихсон байна. Орон орны онцлог бий боловч шүүгчдийн үзэл санаа нийтлэг юм. Эдгээрээс Балбын

Дээд шүүхийн шүүгч Монголтой гарал угсаа нэг хэмээн дотносож хамт зураг татуулсан. Бас Бутаны шүүгч Гүнлүф Цэрэн биднийг хармагц инээснээр ирж мэндэлсэн. Бас Монгол гарал угсаатайгаа мэдүүлж ихэд дотносов. Түүний ярьснаар Бутан бол жижигхэн орон. Хаант засагтай. Гэвч төлөөлөгчдийн байгууллагатай.

Төрийн байгуулалтын тогтолцоо нь манай 1910-аад оны үеийн Богд хаант засагтай төстэй мэт санагдсан. Энэ улсад Үндсэн хууль байхгүй. Улс төрийн намгүй. Гагцхүү Буддист үзэл санаанд тулгуурладаг. Энэ шүүгч өөрөө баруун Европын хөгжилтэй оронд хуульчийн боловсрол эзэмшиж, магистрын зэрэг хамгаалсан боловсролтой нэгэн аж. Бутанд цөөхөн шүүгчтэй. Гэмт хэрэг бараг гардаггүй. Цөөхөн хэрэг маргаан шийдвэрлэдэг. Дээд шүүх 5 шүүгчтэй. Цалин хангамж хангалттай. Сардаа 1500 ам.доллартай тэнцэх цалин авна. Энэ нь амьдралын өртөг хямд тус улсад хангалттай хүрэлцдэг. Эхнэр нь хүүхдүүдээ өсгөж хүмүүжүүлнэ. Ажил хийх ч шаардлагагүй. Хүүхдүүдээ эрүүл энх, боловсролтой хүн болгон хүмүүжүүлэх нь чухал ажил гэнэ. Харин тус улсад Хааны санаачилгаар 2008 он гэхэд

Үндсэн хууль батлагдана. Одоо хэлэлцэж байгаа. Дэлхийн нийтийн жишигт хүрсэн Үндсэн хуультай болно. Бас парламентын гишүүн 150 хүн байна. Парламентыг нэг намаас бүрдүүлэхийг хориглоно. Гурваас дээш нам парламентад суудалтай байх ёстой. Цөөн шүүгчтэй боловч шүүх эрх мэдэл байр сууриа эзэлсэн. Шүүхийн шийдвэрийг Хаан ч, Засгийн газар ч хууль тогтоох засаг ч өөрчлөх ёсгүй. Хэн ч шүүхийн ажилд хөндлөнгөөс оролцохгүй. Энэ улсад хуулийн сургууль байхгүй. Хуульч мэргэжлийг гадаадад эзэмшинэ. Хуульч ховор бас нэр хүнд сайтай. Харин одоо хуульч бэлтгэх сургууль байгуулахаар яригдаж байгаа гэнэ.

Цөөн хүн амтай жижиг оронд парламентын 150 гишүүн олон биш үү. Монголд Улсын Их хурлын 76 гишүүнтэй байдаг гэхэд тэрээр шууд л цөөн гишүүн байж болдоггүй юм. 150 гэдгийг нэмж магадгүй. Би олон орны туршлагыг судалсан. Улс төрийн нам бий болчихно. Тэгэхлээр бас үгсэх, хуйвалдах явдал бий болж магадгүй. Төлөөлөгч цөөн байх тусмаа үгсэх, бие биенийхээ нөлөөнд автах боломж илүү байдаг. Тэд чинь улс нийтийн эрх ашгийг хамгаалсан хууль батлах ёстой. Ямар нэгэн хэсэг, бүлгийн эрх

ашигт нийцүүлсэн хууль гаргачихгүй байхын тулд парламентын гишүүний тоо олон байх нь ашигтай байдаг гэж өгүүлсэн юм. Тэрээр бас дэлхийн жишигт хүрсэн Үндсэн хуультай болно. Түүнээ ягштал дагаж мөрдөнө. Энэ бол улс орны бахархал, хөгжил дэвшлийн чухал алхам болно. Шүүх эрх мэдэл Үндсэн хуулиар улам баталгаажна гэж ярьсан юм.

x x x

Дэлхий нийтээрээ шүүхэд итгэж байна. Шүүхэд итгэх итгэлийг хамгийн түрүүнд төрийн өндөр албан тушаалтнууд, хууль тогтоох байгууллагын гишүүд, төр, засгийн албан хаагчдаас эхэлдэг ажээ.

Төр, Үндсэн хууль бусад хуулиа дээдлэн сахидга байх ёстой гэнэ. Төрийн албан тушаалтан алдаа, зөрчил гаргавал шүүхийн өмнө хариуцлага хүлээдэг байх ёстой. Тэдгээр нь шүүхийн шийдвэрт үг дуугүй захирагдах учиртай. Хууль, шүүхийн өмнө бусад иргэдийн нэгэн адил эрх тэгш байдаг. Хаан хэдий том ч хуулийн дор амьдардаг. Заан хэдий том ч замын аясыг дагадаг ажээ.



ШҮҮХЭЭС ЯЛ НОГДУУЛАХАД УЧИРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

2002 оны Эрүүгийн хуулийн 3 дугаар хэсгийн 9 дүгээр бүлгийн 45 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагын талаар заажээ.

Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн гэжээ.

Өмнөх хуульд эрүүгийн хариуцлагыг зөвхөн ял гэдэг утгаар нь илэрхийлж байсныг зарчмын хувьд өөрчилсөн.

Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тогтоосон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэж биеэ даасан 2 төрөлд хуваасан боловч иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас эерчигдсэн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ижил зорилготой юм.

Ер нь гэмт хэрэг гэдэг ойлголтын салшгүй бүрэлдэхүүн хэсэг хамгийн чухал. Хүмүүст хүрдэг зүйл нь ялын төрөл хэмжээ байдаг. Ялын төрөл бүр нь өөрийн гэсэн тоон хэмжээ, тодорхой утга агуулгатай байна.

Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д Шүүх энэ хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд чанд нийцүүлж, шударга ёс, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон тусгай ангид заасан төрөл хэмжээний дотор ял оногдуула.

Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т Шүүх ял ногдуулахдаа гэмт хэргийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, уруулан хор уршигын шинж чанар,



Нийслэлийн шүүхийн
Эрүүгийн хэргийн танхимын
тэргүүн Б.Сарантуяа

хохирлын хэр хэмжээ, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэх ёстой. Шүүх энэ зарчмыг хэрэгжүүлж хуульд заасан ял ногдуулж байна.

2006 оны жилийн эцэст Нийслэл, дүүргийн шүүхүүд нийт ял шийтгүүлэгчдийн 75,0 хувьд нь хорих ял оноосон. Үүний 53,4 хувийг биечлэн эдлүүлээд байна.

Хорих ялыг хүндэвтэр гэмт хэрэгт 21,8 хувийг, хүнд гэмт хэрэгт 86,3 хувийг, онц хүнд гэмт хэрэгт 100 хувь биечлэн эдлүүлжээ.

Хорих ял биечлэн эдлүүлэлт 53,4 % байгаа нь хуучин хуулийн үеэс 20 орчим хувиар өндөр байна. 2002 оны Эрүүгийн хуулиар хорих ялыг биечлэн эдлүүлэх байдал жил бүр өсөх хандлагатай байна.

Миний хувьд 30-аад жил шүүх хийж Эрүүгийн шинэчлэн найруулсан 3 хуультай ажиллав. /1962 он, 1986 он, 2002 он/

Гэтэл 2002 оны хуульд ял өндөр тусгагджээ.

Хуучин хуулийн үед жилд 6000 орчим хүн ял эдэлдэг байсан. Одоо 7000 гаран ялтан байна. Ял эдлэгч 1000-аар нэмэгдсэн. Энэ тоо жил бүр өсөх хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, шинээр орж байгаа ялтны тоо гарч байгаагаасаа олон болохоор ял эдлэгчдийн тоо жил бүр өсч байна.

1. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт ногдуулж болох хорих ялын доод хэмжээг хатуу тогтоосноос шүүх хэргийн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдалд тохируулсан, ялыг ялгамжтай ногдуулах боломжгүй болгож, улмаар Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан "ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна гэсэн заалттай зөрчилдөж байна. Иймд хуульд заасан ялын доод хэмжээнээс доогуур тогтоох, эсвэл өөр төрлийн хөнгөн ял шийтгэх тухай хуучин хуулийн 39 дүгээр зүйлтэй ижил заалт оруулах шаардлага амьдралаас урган гарч байна.

2. Хүнд хэрэгт ногдуулах ял хэт өндөр, хүнд хэргийг тэнсэж болохгүй, мөн тухайн зүйлд заасан ялын доод хэмжээнээс доогуур ял оноож болохгүй байгаа одоогийн хуулиар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч, шүүгчид ял болох хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэх, хэргийг олон дахин буцааж чирэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар гарч байна.

3. Торгуулийн ялын хэмжээ одоогийн амьжиргааны түвшинтэй харьцуулахад хэт өндөр байгаагаас уг ялыг шүүх

хэрэглэх боломжгүйд хүрч шүүх энэ ялыг ногдуулахдаа түүний бодитой биелэгдэх эсэхээ хамаарч амьжиргааны баталгаахыг доод түвшингээс доогуур орлоготой этгээдэд ногдуулах боломжгүй байгаагаас шалтгаалан оронд нь баривчлах болон хорих ял ногдуулж байна.

4. Баривчлах ялыг Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасан "тодорхой дэглэмд" эдлүүлж чадахгүй байна. Тийм нөхцөл бололцоо ч алга байна. Иймд баривчлах ял эдлүүлэх газар нь дэглэмийн ялгаагүй байхаас гадна уг газрын нөхцөл нь жирийн дэглэмтэй хорих ангийн нөхцөлөөс хөнгөн байх учиртайг анхаарах цаг болжээ.

Одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийг практикт нэг мөр ойлгож зөв хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл нь:

1. Шүүгч Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд заасан ял хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзаж ялгамжтай ял оноож чадахгүйд хүрч байна. Мөн зарим ял нь хэрэглэж болохгүй, зарим ял нь хэрэглээд ч ач холбогдолгүйд хүрэхээр байна.

Эрүүгийн хуульд шинээр бий болсон Албадан ажил хийлгэх ялын тэнцвэрт харьцаа алдагдсан. Учир нь Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-т "Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтыг эдлээгүй үлдсэн ялын 24 цагийг 1 хоног баривчлах ялаар тооцож солино" гэсэн нь тухайлбал, 100-500 цагийн ажил хийхийн оронд зайлсхийчихээд 4-20 хоног баривчлах ял эдлэхээр байна. Энэ нь ял эдэлснээс санаатайгаар зайлсхийвэл ялтанд ашигтайгаар тусаж болохоор байна.

Нөгөө талаар Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан ялын төрөл нь хөнгөнөөс хүнд рүү явсан зарчмыг алдагдуулахаар байна.

2. Мөн торгуулийн ял нь хүнд хэрэгт хөдөлмөрийн хөлсийн доод хэмжээг 251-500 дахин

нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байна. Өнөөдөр хөдөлмөрийн хөлсийн доод хэмжээ 69.000 төгрөг /17.319.000-34.500.000 төгрөг/ байна. Тэгвэл Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.3-т заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд аль болох торгуулийн ял аваад уг ялаас зайлсхийвэл баривчлах, 3 жил хүртэл хорих ял болгож нэг ёсондоо ялаа хөнгөлөх арга болгож байгаа нь амьдралд нийцэхгүй байна.

3. Мөн Эрүүгийн хуулийн 50, 51 дүгээр зүйлд заасан Албадан ажил хийлгэх болон баривчлах ялыг жирэмсэн эмэгтэй, 3 хүртэл насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт ногдуулахыг хориглосон.

Гэтэл Эрүүгийн хуулийн 107.1, 114.1, 117.1, 129.1, 136.2, 178.1 гэсэн зүйл ангиудад албадан ажил хийлгэх болон баривчлах ялаас өөр ял байхгүй. Ийм тохиолдолд жирэмсэн эмэгтэй, 3 хүртэл насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт онох ял байхгүй байна.

4. Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим зүйл, заалтад ялын доод хэмжээ хөнгөнд, дээд хэмжээ нь хүндэвтэр ангилалд багтсан осхүл эсрэгээр байгаа нь тухайн гэмт хэрэг ямар ангилалд орох нь ойлгомжгүй байдал үүсч байна.

Жишээ нь: тухайн зүйлийн торгуулийн хэмжээ нь хүнд ангилалд, баривчлах ялын хэмжээ нь хөнгөн ангилалд багтаж байгаа нь шүүгчдэд эргэлзээ төрүүлж, хөнгөн хэрэгт эвлэрүүлж эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болох боломжийг алдагдуулахад хүрч байна.

Эрүүгийн хуулийн 149.1, 152.1, 154.2, 183.1, 196.2, 197.1, 218.1, 230.4, 232.1, 237.1, 237.2, 246.1, 258.1, 265.1, 267.1, 271.1/-16 зүйл байна.

5. Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4-т "тэнгэсгдсэн ялтанд цагдаагийн байгууллага, цэргийн албан хаагчид цэргийн анги нэгтгэлийн дарга хяналт тавина" гэж заасан атлаа Эрүүгийн хуулийн 62, 63 дугаар зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан үед хэн хяналт тавихыг орхигдуулсан.

6. Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т "энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт ногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын хоёрны нэгээс хэрэггүй байна" гэснийг шүүхүүд өөр өөрөөр хэрэглэж байна.

Тухайн зүйл нь торгох, хорих ялтай тохиолдолд аль хүнд ял нь хорих ял гэж ойлгогдож байна. Хорих ялын хэмжээ нь 5-аас дээш 10 жил гэж заасан байхад гэмт хэрэгт завдсан, бэлтгэсэн гэж хөнгөрүүлэхдээ 5 жилээс доош нь татах уу, 10 жилээс доош нь татах уу гэдэг нь эргэлзээтэй байна.

Төгссөн үйлдэлд 5 жил 1 хоног хорих ял өгдөг бол завдсан үйлдэлд мөн 5 жил 1 хоног хорих ял өгөхөөр байна.

7. Одоогийн Эрүүгийн хуулиар завдсан, бэлтгэсэн гэмт хэрэг, төгссөн гэмт хэрэг, санаатай гэмт хэрэг, болгоомжгүй гэмт хэрэгт ялгамжтай ял ногдуулж болохгүй байна.

8. Торгох ялаас ноцтойгоор зайлсхийсэн тохиолдолд өөр ялаар хүндрүүлж солих тухай Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т заасан боловч баривчлах ялын хэмжээг зааж өгөөгүй, мөн 3 жил хүртэл хорих ялаар солино гэсэн боловч хорих ялын доод хэмжээг зааж өгөөгүй байна.

9. Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч 1 жил өнгөрсөн бол ялтыг үндсэн болон нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй гэж заасан.

Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай зөрчилдөж байна.

Өндөр торгуулийн ял авсан хүмүүс 1 жил хүртэлх хугацаанд торгуулиа бага багаар төлсөн дүр үзүүлж байгаад ялаас чөлөөлөгдөх боломж байна. Үүнийг шүүхүүд өөр өөрөөр хэрэглэж байна.

10. Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ насанд хүрсэн этгээдэд ногдуулж байгаа ял

эрүүгийн хариуцлагаас ялгамжтай хандаж болохгүй байна.

11. Бусдын машиныг барьж яваад бусдад хөнгөн гэмтэл учруулсан бол Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байхад жолоогоо бусдад шилжүүлсэн этгээд нь Эрүүгийн хуулийн 222 дугаар зүйлээр ял шийтгүүлж байна. Учир нь 222 дугаар зүйлд хөнгөн гэмтэл учруулсныг гэмт хэрэгт тооцсон.

12. Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд хохирлын хэмжээг:

- бага бус;
- үлэмж;
- их;
- онц их хэмжээг зааж өгсөн.

Бага бус хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэхээр тогтоожээ. Гэтэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур хохирол учирсан байхад ч эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь ойлгомжгүй байна.

13. Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.1-д "эрх хасах

нэмэгдэл ялыг 2 жилийн хугацаагаар хасах" гэж доош татах аргагүй, доод хэмжээгүй хатуу тогтоосон атлаа 215.2-т илүү хүнд зүйлд нь "эрх хасах ялыг 3 жил хүртэл" гэж заасан нь арай хүнд зүйлд нэмэгдэл ял нь бага хугацаатай эдлүүлэхээр тогтоогдсон байна.

Шүүхээс ял ногдуулахад учирч буй олон бэрхшээлийн зарим хэсгээс энд дурдлаа.

Иймд Эрүүгийн хуульд нэн яаралтай нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна.



Хууль зүйн үндэсний хүрээлэн
WWW.NIA.GOV.MN

ДНК шинжилгээ

Хуульч Д.Батхуяг

Өнөөгийн нийгмийн шинжлэх ухаан технологийн эрчимтэй хөгжил нь хүн нийгмийн таатай оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлж байгаа хэдий ч араасаа байгалийн гамшиг үзэгдэлүүд, үндэстэн хоорондын мөргөлдөөн, шинэ төрлийн гэмт хэргүүд түүний дотор терроризм зэрэг олон хүнийг үхэлд хүргэх сөрөг үзэгдэлүүдийг дагуулж байгаа билээ. Өчигдөрхөн боломжгүй байсан мэт зүйл өнөөдөр ердийн болон хувирч 20-30 жилийн өмнө зөгнөлт зохиолоос л уншиж байсан зүйл нь өнөөдөр бидний амьдралын нэгэн хэвийн зүйл болж байна. Амьд организмын талаар бүхий л мэдээлэл агуулж байдаг ДНК-молекулын шинжилгээ нь одгээрний нэгэн жишээ юм. Генийн шинжилгээг амьдралын бүх салбарт, тэр дундаа гэмт хэрэгтэй тэмцэх үйл хэрэгт өргөнөөр ашиглаж байгаа билээ. Амьд организм ДНК нь дахин давтагдашгүй бөгөөд түүний амьдралын бүхий л хугацаанд, тэр ч бүү хэл түүний үхлийн дараа ч өөрчлөгддөггүй байна. Энэ нь ялангуяа шүүх эмнэлэгт нэн чухал ач холбогдолтой болж байна.

"Ген", "генийн код" гэсэн ойлголт нь хагас зуун жилийн өмнөөс л тодорхой болсон бөгөөд түүнээс өмнө эрдэмтэд эдгээрийн талаар ямар ч ойлголтгүй байсан гэж хэлж болно. Тэр үед хүний удамшил, түүгээр дамждаг шинж тэмдэг, өвчнүүд хэрхэн удамшил дамждаг байсан нь онсого мэт байсан.

Хүний биологийн гаралтай зүйлс болох шүлс, урийн шингэн, хэлс, цус, үс, үсний хаг, арьсны хэсэг, ясны үлдэгдэл зэргээр хэн болохыг нь тогтоох асуудал сүүлийн жилүүдэд маш их анхаарал татаж байгаа юм. Энэ нь онц хүнд гэмт хэргийн гаралт өсч, хүний эрүүл мэнд, байгалийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг нэмэгдсэнтэй, мөн хэн болох нь танигддаггүй цогцос олширсонтой холбоотой байж болох юм. Дээрх гэмт хэргүүдийг сайтар төвлөвж нууц далд аргаар үйлдэх нь ихсэж, гэмт этгээдүүд тэр болгон

хурууны хээ, гутлын мөр бусад ул мөр үлдээх нь багасаж байгаа билээ. Тэгсэн хэдий ч орчин үеийн багаж хэрэгслийн тусламжтайгаар нүдэнд үл үзэгдэх үл мөр түүн дотор биологийн гаралтай үл мөрүүдийг илрүүлэн бэхжүүлэх боломжтой болж байна. Өнөөдөр, гарсан гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд хэргийн газраас илрүүлсэн биологийн үл мөрөөр гэмт этгээдийг тогтоох шинжилгээ гол байр суурь эзэлж байна. 1983 оны намар Английн нэгэн жижиг хотод 15 настай, Линда Манн гэдэг эмэгтэйн цогцос гэрээс нь холгүй олдсон байсан. Цагдаа нар гэмт этгээдийн талаар ямар нэгэн сэжүүр таамаг юу ч байхгүй байжээ. Гэмт этгээд хохирогчийн биен дээр өөрийнхөө үрдийн шингэний үл мөрийг үлдээсэн байв. Үүнээс 4 жилийн дараа мөн энэ хотод 15 настай Дона Ашкрофтыг хүчирхийлэн амь насыг нь боомилон хороосон хэрэг гарав. Дээрх 2 гэмт хэрэг хоорондоо холбоотой байх магадлал илэрхий байсан тул цагдаа нар энэ 2 гэмт хэргийг нэг хүн үйлдсэн гэж таамаглаж байв. Хэргийг шалгах явцад нэг этгээдийг сэжигтэнээр байцаахад тэр этгээд Донаг алсан гэдгээ хүлээжээ. Энэ үед тухайн хэрэг дээр ажиллаж байсан цагдаагийн нэгэн ажилтан сэтгүүлээс ДНК шинжилгээний талаар уншсанаа санан ДНК шинжилгээг гэмт этгээдийн гэм бурууг тогтоохын тулд хэрэглэж болох юм байна гэж үзэн шалгаж үзэхээр шийджээ. Үүнээс өмнө ДНК шинжилгээг иймэрхүү төрөлд ашиглаж байгаагүй юм. Энэ шинжилгээг Английн генетикч Алек Жефрис хийсэн байна. Жефрис хүн болгоны ДНК нь дахин давтагддаггүй / нэг өндгөн эсийн ихрүүдээс бусад, тэдний ДНК ижил байдаг байна/ гэдгийг харуулжээ. Ингээд Жефрис сэжигтэн этгээдийн ДНК-г хэргийн газраас илэрсэн урийн шингэнээс авсан ДНК-тай харьцуулж шинжилжээ. Шинжилгээний хариу сэжигтэн дээрх 2 гэмт хэргийн алинд нь ч холбоогүй юм байна гэж гарцээ.

Дээрх гэмт хэргийг үйлдсэн байж болзошгүй гэж үзсэн бүх хүний ДНК-г шинжилж олон сарын нөр их ажил хийгдсэн боловч нааштай үр дүн гарахгүй байсаар л байв. Гэтэл энэ үед талхны худалдагч нэгэн эмэгтэй, нэг хүн өөрийнхөө нэр дээр өөр хүний цусыг өгүүлж тэр хүндээ мөнгө төлсөн гэдгийг сонссон талаараа мэдээлжээ. Тэр мөнгө төлсөн хүнийг Колин Питчфорд гэдэг байсан бөгөөд түүний ДНК-ийн шинжилгээгээр дээр өгүүлсэн 2 гэмт хэрэгт буруутай гэж үзэн яллажээ. Ингээд ДНК шинжилгээг зөвхөн гэм бурууг нотлох биш мөн гэм буруугүй болохыг нь нотлоход хэрэглэж болох юм байна гэдгийг ойлгож мэдсэн байдаг.

48 настай Жерри Миллер 1981 оны 9 сард Чикаго хотод 44 настай эмэгтэйд халдсан хэргээр баривчлагджээ. Халдсан этгээд хохирогчийг хүчиндэж, дээрэмдээд машиныг нь багажинд хийн цоожиж орхисон байжээ. Гэрчүүд сэжигтний аман зургийг гаргаж дараа нь таньж олуулах ажиллагаан дээр Миллерийг мөн байна гэж заасан байдаг. Шүүх хурал дээр Миллер өөрийгөө хэрэг гарах үед гэртээ байсан, тухайн хэргийг үйлдээгүй гэж мэдүүлсэн байсан боловч түүнийг хүчин, дээрэм, хүн хулгайлсан хэрэгт буруутгажээ. 2006 оны 3 сард 25 жил шоронд суусны дараа Миллер батлан даалтаар суллагдаж одоо хамаатан садны хүмүүсийн хамтаар Чикаго хотод амьдарч хотын захад 2 гэжээ ажиллаж байгаа юм байна. 2007 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр болсон шүүх хурлаар түүнийг бүрэн цагаатгасны дараа тэрээр инээмсэглэн " миний шинэ амьдрал эхэлж байна, би энэ өдөрт маш их талархаж байна" гэж хэлжээ. Нью-Йорк хотын The Innocence Project хэмээх хууль бусаар хорих ял элдгээсдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын идэвхтэн гишүүдийн шалгалтаар өнгөрсөн жил хохирогч эмэгтэйн



Жерри Миллер /зүүн гар талд/
www.santafenewmexican.com

хувцаснаас илэрсэн үрийн шингэний ДНК-г Миллерийн гентэй харьцуулж шинжлэхэд Миллерийнх биш болох нь тогтоогдсон байна. Энэ явдал Америкт ДНК-ийн шинжилгээгэр ял эдэлж буй алтан гэм буруугүй гэдэг нь батлагдаж цагаадсан 200 дахь тохиолдол болсон юм. Гэм буруу нь цагаадсан хүмүүсийн өргөст торны цаана өнгөрөөсөн он жилүүдийн нийлбэр нь 2475 жил болсон байна. Генийн шинжилгээний ололтыг анх шүүх эмнэлэгт амжилттай хэрэглэсэн гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Английн эрдэмтэн Алекс Жефрис ДНК шинжилгээний тусламжтайгаар маргаантай байсан эцэг тогтоох асуудлыг шийдвэрлэж байжээ. Түүний бүтээлүүдэд л анх удаа "генийн дактилоскопи" гэсэн нэр томьёо бий болж 1985 оноос ДНК-ийн шинжилгээг өргөн хүрээтэйгээр ашиглаж эхэлсэн байна. 1988 онд тэр үеийн ЗХУ-ын хэвлэлд, хүний ДНК-ийн бүтэц нь дахин давтагдашгүй болох тухай Алекс Жефрисийн нээлтийг нийтэлсэн байжээ. Англид үг нээлтийн нь шүүх эмнэлэгт хэдийн ашиглаж болжээ. Энэ явдал тухайн үеийн Оросын удирдлагуудын анхаарлыг ихэд татаж М. Горбачёв ДНК судалгааны лаборатори байгуулах тухай тусалд гарын үсэг зурсан байдаг. Тэр үед энэ чиглэлээр судалгааны ажлуудыг ДЯЯ, УАХХ, БХЯ-ны эрдэм шинжилгээний албадуудад хийж байсан боловч мэргэсэн мэргэжилтнүүд болон бааз суурь

байхгүй байсан юм. Ингээд 1988 онд ЗСБНХУ-ын ДЯЯ-ны Шинжлэх ухаан, Криминалистикийн төвд генийн судалгааны лаборатори байгуулсан байна. Эхний үед лаборатори Анагаах ухааны академийн сэтгэцийн өвчний төвийн баазд түшиглэн ажиллаж байсан бөгөөд тухайн үед энэ төвд зарим төрлийн өвчнийг судлах зорилгоор ДНК шинжилгээ хийж байсан юм. 1990 оноос Криминалистикийн Шинжилгээний Төвд ДНК шинжилгээг бүрэн хэмжээгээр хийж эхэлжээ. Өнөөгийн байдлаар ОХУ-ын 32 бүсэд ийм төрлийн лаборатори ажиллаж, энэ чиглэлээр 200 орчим мэргэжилтэн ажиллаж байна.

ДНК шинжилгээний аргаар авсан хариу хэр зэрэг найдвартай вэ?

ДНК шинжилгээг амьдралд хэрэгжүүлэхээс өмнө биологийн гаралтай ул мөрийг цусны бүлэг мэтэийн шинжилгээгээр шинжилж байсан нь хэн нэгэнд энэ биологийн ул мөр хамаарна гэсэн тодорхой дүгнэлт хийх боломжгүй, группын шинжтэй байжээ. Өөрөөр хэлбэл, цусны нэг бүлэг хэдэн ч хүнд хамаарах боломжтой байдаг. Тэгвэл ДНК-ийн боломж нь маш ховор, хосгүй юм. Нэгдүгээрт, хүний цусны ДНК нь түүний үс, шүлсний ДНК-тай ижил байдаг. Хоёрдугаарт, ДНК нь хүний бүхий л амьдралын туршид өөрчлөгддөггүй химийн нэгдэл бөгөөд энд ямар нэгэн өөрчлөлт гардаггүй байна. Энэ нь биологийн гаралтай ул мөрийг хэдэн ч жил болон цүүнийг шинжлэхэд үр дүнгээ өгнөө гэсэн үг. Гуравдугаарт, ДНК нь өөрөө нөхөн төлжих чадвартай байдаг.

ДНК шинжилгээг яаж хийдэг вэ?

"Толбонуудыг" хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж дээр янз бүрийн явцуулаар судалдаг, үр дүнд нь ДНК-ийн системийн кодын тодорхой эмжээний тоонуудаас бүрдсэн тоон томьёолол гаргаж авна. Ингэсний дараа энэ томьёог харьцуулж шинжилдэг юм байна. Тоо их байх тусам шинжилсэн

молекулын олон шинжийг шинжилж тэр хэмжээгээрээ давцах магадлал нь бага байдаг байна. Барууны орнуудад 9 шинжийн тоон код хэрэглэдэг бол Орос, АНУ-д 13 шинжийн тоон код хэрэглэдэг.

2 өөр хүнд ДНК-ийн шинж нь давцах магадлал хэр өндөр вэ?

ДНК-ийн шинж нь хүн болгонд давтагдашгүй байдаг гэдгийг дээр хэлсэн. ДНК-ийн молекул тус бүр нь 3 млрд нуклеотидтой байдаг ба цагаан толгойн үсгээс хэдэн үг зохиож болдог билээ тэгвэл тэр 3 млрд нуклеотидээр хэдэн ДНК-ын молекул бүтээж болохыг бодоод үз дээ. Англид ДНК шинжилгээг хэрэгжүүлж эхэлснээс хойш ДНК-ийн мэдээллийн санд 3.5 сая хүний биологийн ул мөр хадгалагдсан байна. Англи улсад ДНК-ийн 9 шинжийн шинжилгээг хэрэглэснээс хойш ДНК-ийн шинж нь давхацсан нэг ч тохиолдол гараагүй юм. Английн цагдаагийн газар гэмт хэргийн газраас илэрсэн биологийн ул мөрийг ДНК-ийн санд байгаа мэдээлэлтэйгээ харьцуулж шинжилсэн үндсэн дээр долоо хоногт 1000 орчим гэмт хэргийг илрүүлдэг байна. Уг мэдээллийн сангийн тусламжтайгаар гэмт хэргийн илрүүлэлт Англи улсад мэдэгдэхгүй өсч, илрэх ямар ч найдлагагүй мэт санагдахаар хэргийг хүртэл илрүүлж байгаа юм.

ОХУ-ын ДЯЯ-наас бүтээсэн "Генийн бүртгэлийн тухай хуулийн" төслийн талаар

Юуны өмнө Оросын мэргэжилтнүүд ДНК-ийн мэдээллийн санд одоог хүртэл илрээгүй байгаа гэмт хэргийн газраас олж байгаа мэдээллийн биологийн ул мөрийн ДНК шинжилгээний хариуг оруулж байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй. Хэрэв энэ талаар хууль батлагдвал эдгээрээс гадна хэн болох нь тогтоогоогүй цоцос, сураггүй алга бологсдын төрөл садны хүмүүсийн ДНК шинжилгээний хариу, хүнд, онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдүүдийн шинжилгээний хариуг оруулах болно. Мөн ирээдүйд генийн бүтцийн шинжилгээнд заавал хамрагдавал зохих иргэдийн бүлгийн тоог нэмэх, генийн мэдээллийн санд амь насанд аюултай мэргэжлийн хүмүүсийн тухайлбал, цэрэг, цагдаагийн ажилтнуудын цусны дээжгийг оруулах зэргээр ДНК шинжилгээний мэдээллийн санг

өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа юм байна. Мөн мэдээллийн санд биологийн материалын дээжгийг оруулж тусгай нөхцөлд хадгалах зарилготой байгаа юм. Өөрөө хэлбэл, хүмүүсийн гадна төрх, зан төлөв уг санд байхгүй харин генийн шинжилгээний хариу байна гэсэн үг. Уг хуулийн төсөлд генийн бүртгэлд сайн дураараа төлбөртэй хамрагдах боломжийг олгож байгаа. Үүсэл ч иргэн өөрөө хүсвэл цусны дээжээ ДНК шинжилгээнд өгч хариуг ДНК-ийн мэдээллийн санд оруулах боломжтой.

ДНК шинжилгээний өртөг нь хэр өндөр байх вэ?

Нэг "толбыг" шинжлэхэд 100-200 ам. доллар болдог. Дээр өгүүлж байсан хуулийн төслөөс үзэхэд зөвхөн шинжилгээ хийхэд ашиглах материалд зориулж жилд 2 млрд рубль заруулах тооцоо гарч байгаа юм. Гэвч энэ зарлага нь зайлшгүй байх ёстой гэж бодож байна. Оросын гаж донтон Чикагиллогийн хэргийг саная. Тухайн хэргийн мөрдөн байцаалтын явцад урийн шингэний цусны бүлгийг буруу тогтооход явдал гарч байсан бөгөөд хэрэв тухайн үед ДНК шинжилгээг хэрэглэсэн бол гэмт этгээдийг хамаагүй эрт барих боломжтой байсан гэдэг. Ингэснээрээ олон хүний амь насны аварч, эрэн сурвалжлах болон мөрдөн байцаалтын ажиллагаанд их хэмжээний зардал гаргахгүй байх байсан. Өнөөдөр ДНК шинжилгээний үндсэн дээр шинжээч тодорхой дүгнэлт гаргаж гэмт хэргийг бараг шууд илрүүлж байгаа. Хэдийгээр хуульд шинжээчийн дүгнэлт шууд нотлох баримт болохгүй гэдэг ч хэргийн газар бусдын татсан тамхины биш хаях боломжтой байдаг бол бусдын урийн шингэний авчирч хэргийн юу л бол гэдгийг шүүгч хэргийн шийдвэрлэхдээ харгалзан үзэх нь дамжиггүй. ДНК-ийн шинжээчид зөвхөн эрүүгийн биш мөн иргэний шугамаар ч хандадаг байна. Тухайлбал, эцэг тогтоох гэх мэт. Шинжилгээ явуулах ажиллагаа нь өндөр үнэтэй аппарат хэрэгсэл шаарддаг, өртөг өндөртэй байдаг ч нэг эрүүгийн хэрэгт хэдэн арваар тогтохгүй бүр хэдэн зуун шинжилгээ хийх тохиолдол ч гардаг. Гэвч энэ шинжилгээ өөрийн өртөгөө бүрэн нөхдөггүйн учир нь нэг шинжилгээний ард хэдэн ч хүний хувь заяа шийддэг байна. Үүнээс гадна ДНК шинжилгээний хариу нь нотолгооны өндөр хүчин чадалтай

байдгаар тайлбарлаж болно. Хүний эрх, эрх чөлөө маш өндөрт яригдаж болсон өнөө үед аливаа хэрэгт хүнийг яллах, цагаатгахад ДНК шинжилгээний хариу маш чухал ач холбогдолтой юм.

Оросын Самар мужид гарсан бага насны үхүүхдийг хүчиндсэн цуврал гэмт хэргийг ДНК шинжилгээний тусламжтайгаар л илрүүлжээ. 3 хохиргоочоос илэрсэн хэрэгтний биологийн дээжид хийсэн ДНК шинжилгээгээр энэ хэргийг нэг хүн үйлдсэн болохыг нь тогтоосон байна. Ингээд бусад ижил төрлийн илрээгүй 8 хэргийг сөхөхөд бүх хэргийг нэг хүн үйлдсэн болох нь тогтоогдож байжээ. Дээрх хэргийн нэг нь үйлдэгдсэн байшгүйн дээврийн хонгилоос гэмт этгээдийн гарын мөрний дардас илэрсэн байдаг. Уг гарын мөр урд нь зам тээврийн осол гаргаж байсан хүнд хамаарах юм байна гэдгийг тогтоомоц тэр хүнийг олж баривчлан урийн шингэнд нь ДНК шинжилгээний хийхэд хохирогч нараас илэрсэн урийн шингэн түүний урийн шингэн болох нь тогтоогдож тухайн этгээд дээрх бүх хэргийг үйлдсэн болох нь илэрч хэргийг шүүхэд шилжүүлсэн байна. Өнөөгийн байдлаар ОХУ-д практикт хэрэглэгдэх болсон хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр хийсэн шинжилгээний тоо 59 хувийр өсч, түүний дотор гэмт этгээд хэн болохыг тогтоосон шинжилгээний тоо 77.5 хувь өссөн байна. ДНК шинжилгээг амьдралд хэрэгжүүлсэнээр гэмт хэрэгтэй хийх тэмцэл шинэ шатанд гарч, иргэдийнхээ Үндсэн Хуульд заасан эрх, эрх чөлөөг хангах асуудалд ч ахиц гарах юм. Одоогийн байдлаар ДНК-ийн тусламжтайгаар хүний нүд, арьс, үсний өнгө, эрүү, хамрын хэлбэр, тэр ч бүү хэл ямар өвчтэй хийгээд сэтгэцийн өөрчлөлт байсан эсэхийг тогтоох боломжтой гэсэн шинжлэх ухааны онолын нийтлэлүүд гарсан байгаа. Ингээд удахгүй энэ бүх шинжийг нь ДНК-ийн тусламжтай тогтоох арга зүй боловсруулагдах өндөр магадлалтай болж байна.

Симпсоны хэрэг

Хэдэн жилийн өмнө Лос Анжелос хотын шүүх америк хөл бөмбөгийн од Ж.Симпсоны хэргийг авч хэлэлцсэн. Симпсоны өөрийн салсан эхнэр болон түүний найзын амь насныг хөнөөсөн хэрэгт буруутгажээ. Түүний хүүвээс оймс болон машинаас нь хохирогч нарын цус илэрсэн

байдаг. Үүнийг ДНК шинжилгээгээр тогтоосон байна. Гэвч шүүх ДНК шинжилгээг Симпсоны гэм бурууг нотлох баримт болж чадахгүй гэж үзсэн. Учир нь мөрдөн байцаалтын явц болон шинжилгээний явцад алдаа гарсан байжээ. Ул мөрийг бэхжүүлсэн офицер мэдүүлэхдээ машины арын шилэн дээр байсан цус болон шинжилгээний явцад алдаа гарсан байжээ. Ул мөрийг бэхжүүлсэн офицер мэдүүлэхдээ машины арын шилэн дээр байсан цус болон гэрт нь диваны ард байсан оймсыг сарын дараа илрүүлж бэхжүүлсэн гэсэн байдаг. Мөн цусыг шинжлэх явцад лаборант эмэгтэй дээжгийг асгаж дараа нь дээжтэй савнуудыг андуурсан байж болошгүй нь тогтоогджээ. Өмгөөлөх тал шинжээчийн дүгнэлтэд гарсан тооцооны алдааг илрүүлж /ялах тал генетикийн шинжилгээний нэртэй мэргэжилтэн орооцүүлжээ/, дараа өдөр нь шинжээч үеэ тооцож гаргасан ч түүний мэдүүлэгт өгөх ач холбогдол буурсан байв. Ингээд эрүүгийн шүүхээс Симпсоны гэм буруутай гэж үзээгүй байна.

Дэлхийн стандарт

ДНК-ийн шинжилгээгээр эцэг тогтооход явдал 99.99 хувьтай байдаг. Энэ нь хангалттай тоо мөн үү? Жирийн нэг эцэг тогтооход явдал болон хэн нэгэн этгээдийн гэм буруутай эсэхийг шүүх 2 хоорондоо эрс ялгаатай юм. Ялангуяа хэн нэгнийг цаазаар авах эсэхийг шийдэж байгаа үед 99.99 хувь гэдэг хангалттай байж чадах уу? Өмгөөлөх тал болон ялах тал хоёрын хувьд энэ талаар өөр өөр ойлголтой байдаг нь хувийн хэрэг юм. ДНК-ийн харьцуулах шинжилгээний хамгийн эцсийн зорлиго бол тухайн шинжилж байгаа биологийн дээж яг энэ хүнийх мөн, өөр хэнийх ч биш гэдгийг л тогтооход явдал юм. АНУ-д ДНК-ийн мэдээллийг өрсөн өнгө, үндэс угсаагаар нь төдийгүй оршин сууж байгаа газар хотуудаар нь тус тусад нь гаргасан байдаг байна.

ДНК шинжилгээ нь 2 үндсэн зорилготой байна. Эхний нь хэргийн газраас илрүүлсэн биологийн ул мөрийн ДНК-г тухайн гэмт хэрэгт сэжиглэж байгаа хүнээс авсан ДНК-тай харьцуулж ижил төстэй онцлогуудыг гаргах. Хоёрдахь нь гаргаж авсан ДНК-ийн онцлогуудыг нь хамаатан болохыг тогтоох. Мөрдөн байцаалтын явцад /эцэг тогтооход ажиллагаанд мөн адил хамаарна/ биологийн дээжүүдийг илрүүлж бэхжүүлэх бөгөөд ДНК гаргаж авах дээжид цус, шүлс, урийн шингэн, хялс, үс, ясны хэлтэрхий зэрэг юу ч байж болно.

Шинжилгээний эхний үе шат бол биологи-молекуляр шинжилгээ. Энэ үе шатанд тодорхой арга хэрэглэлийн тусламжтайгаар хүн болгоны ДНК-ын тусгай хэмжээнүүдийг тодорхойлдог. Дараагийн үе шат нь генетик популяцийн шинжилгээ. Эрүүгийн гэмт хэрэг дээр шинжээчид тавих асуултыг мөрдөн байцаагч тодорхойлох учиртай. Ямар хувилбар, таамаг дэвшүүлсэнээс шинжилгээнд хэрэглэгдэх стратеги, томьёо зэрэг нь ихээхэн шалтгаална. Хэрэв хэргийн газраас илэрсэн биологийн үл мөр, ген сэжигтнээс авсан гентэй тохирохгүй байвал хэргийн газар тухайн сэжигтэн үл мөрөө үндэзгээгүй гэдэг нь ойлгомжтой. Харин хэргийн газрын үл мөр сэжигтний үл мөртэй тохирч байвал цааш нь улам нарийн шинжлэх хэрэгтэй болно. Дэлхийд ДНК шинжилгээний хэд хэдэн шалгарсан систем хэрэглэгддэг байна. АНУ-д Холбооны Мөрдөх Товчооны боловсруулсан CODIS нэртэй систем ашигладаг бол Европод ENFSI нэртэй систем ашигладаг байна. ОХУ-д ихэвчлэн АНУ-ын Promega фирмийн системийг ашигладаг байна. Дээрх системийн тусламжтай хийсэн шинжилгээ баталгаатай байдаг. Гэхдээ энэ нь мөрдөн байцаалтын болон ДНК шинжилгээ хийх үед ямар нэгэн алдаа гаргахгүй байх тохиолдолд баталгаатай байж чадна гэсэн үг юм. Алдаа хэзээ ч хаана ч гарч болно, хэргийн газраас биологийн дээж бэхжүүлэх үеэс дүгнэлт гаргах үе хүртэл аль ч үед алдаа гарах боломжтой гэдгийг анхаарах нь зүйтэй.

Эцэг тогтоох

ДНК шинжилгээг иргэний салбарт ихэвчлэн эцэг тогтооход хэрэглэдэг бөгөөд ДНК шинжилгээгээр эцэг

тогтоох явдал нь олон хүчин зүйлээс хамаардаг байна. Тухайлбал, үхүүд боловч оцог нь гэж үзэж байгаа хүн ховор тохиолддог ДНК-ийн шинжтэй бол энэ хүн эцэг мөн гэдгийг хөдөлбөргүй тогтоох боломжтой юм байна. Мөн хэрэв эцэг нь мөн байх магадлалтай хүн энэ хэрэгт холбоотой байж болох төрөл садны хүмүүстэй бол эцэг тогтоох явдал хүндрэлтэй болно. Жишээ нь, АНУ-ын Ерөнхийлөгч агсан Томас Жеферсон болон боол байсан Салли Хеммингс нарын хооронд хайр дурлалын холбоо байсан эсэхийг ДНК шинжилгээгээр шинжилжээ. Саллигаас 1808 онд төрсөн Эстон Хемингс Жеферсоны удмын одоо амьдарч байгаа эрэгтэй талын хүмүүсийн цусыг ерөнхийлөгч агсан Жеферсоны удмын одоо амьдарч буй эрэгтэй талын хүмүүсийн цустай генетикчид харьцуулан шинжилсэн байна. Шинжилгээнд эцгийн талаар удамаас удам дамжигдаж байдаг "Y" хромосомыг шинжилжээ. Шинжилгээгээр Эстоны үр удам ерөнхийлөгч Жеферсонтой эцгийн талаар хамаатй гэдгийг тогтоосон байна. Гэвч ерөнхийлөгч Жеферсон өөрөө энэ асуудалд холбоотой гэдгийг тогтоож чадаагүй юм. Учир нь тухайн хэрэгт ерөнхийлөгчийн ах Рэндольф ч юмуу, Рэндольфын хүү Ишем эсвэл тэдний хамаатны хэн нь ч холбоотой байсан байж болно. Үүнийг одоо тогтоох ямар ч боломжгүй.

ДНК шинжилгээг ашигласан хамгийн дуулиантай хэрэг бол маргаангүй АНУ-ын ерөнхийлөгч асан Билл Клинтонь хэрэг юм. Энэ хэрэгт ДНК шинжилгээний хариу шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ. Харьцуулан шинжилсэн материал нь Моника Левинскийн давшинзнаас илэрсэн үрийн шингэний үл мөр болон ерөнхийлөгч Билл Клинтонь цус байсан. Эдгээр материалаас

гаргаж авсан ДНК-г 7 шинжээр нь хооронд нь харьцуулж шинжлэхэд Моникагийн давшинзнаас илэрсэн үрийн шингэний Биллынх байх магадлал 99.99 хувьтай гэж гарчээ. Өөрөөр хэлбэл, Биллтэй ижил гентэй хүнийх байх магадлал 43,000-д нэг байна гэсэн үг. Энэ тоо нь комиссын хувьд хангалтгүй санагдах дахин өөр 7 шинжээр нэмэлт шинжилгээ хийлгэсэн байна. Үг шинжилгээний хариу Биллийнхтэй яг ижил гентэй тухайнх байх магадлал 7,87 тэрбумд 1 таарахаар гарчээ. Гэтэл 7.87 тэрбум гэсэн тоо дэлхийн хүн амын тооноос их байгаа гэдгийг бид мэдэх юм байна. АНУ-д эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд хэрэглэж буй ДНК шинжилгээний хариу нь хэн нэгэн хүнийхтэй ижил байх магадлал маш бага, харьцуулах тоо нь дэлхийн хүн амын тооноос илүү байх тийм төвшинд тавигдаг. Хэрвээ Б.Клинтон Жеферсон шиг төрсөн ах ч юмуу эсвэл дүүтэй, тэр нь Моника Левинскийтай танил байсан бол асуудал өөрөөр эргэж болох байсан байх л даа.

ДНК шинжилгээ нь шүүх эмнэлгийн шинжилгээний маш хүчтэй арга хэрэгсэл юм. Тухайн шинжилгээг хийхэд ДНК-ийн хэдхэн молекул байхад л хангалттай. Гэвч энэ аргад ч мөн сул тал байдаг байна. Тухайлбал, шинжилгээний дээжийг өөр дээжээр солих, хохил, байсан байрнаас нь зөвхөн өөр газар тавих зэргээр ДНК шинжилгээний дүгнэлтийг хуурамчар гаргуулах, зориудаар дүгнэлтийг будлиулах зэргийг хийхэд маш амархан байдаг байна. Үүнээс болж ДНК шинжилгээг анх хэрэглэх болсон улс орнуудад (Англи, АНУ) ДНК шинжилгээнд үл итгэх, тааламжгүй хандах хандлага эрс нэмэгдэж, ДНК шинжилгээний зөгөндөгөнүүд ч идэвхжиж байгаа ажээ.

Ашигласан материал

Лев Анатолевич (Животовский, биологийн ухааны доктор, профессор, Оросын ШУА-ийн Н.И.Вавиловын нэрэмжит Ерөнхий Генетикийн хүрээлэнгийн дарга, АНУ-ын Стэнфордын Их Сургуулийн мөн Алжс мужийн Их сургуулийн болон Австралийн Эдит Кокавын нэрэмжит Их сургуулийн хүндэт профессор), Евгений Иванович Рогов (биологийн ухааны доктор, Оросын Эрүүл мэндийн ШУА-ийн тархины молекуляр генетикийн лабораторийн эрхлэгч), Михаил Пименов (ОХУ-ын ДЯА-ын КШТ-ийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, хууль зүйн ухааны дэд эрдэмтэн) нарын нийтлэлүүд
www.rumber.ru
www.yandex.ru
www.gazeta.ru

Закон и право. 2005 г., №1, "ДНК анализ на вооружении МВД России".

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд Эрүүгийн хуулийн гүйцэтгэх үүрэг, тулгамдаж буй зарим асуудал

Улс орон ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж байгаа энэ үед эмх цэгц, зохион байгуулалт, сахилга хариуцлага сулран ажилгүйдэл, ядуурал газар авч, гэмт хэрэг өсч, түүнээс улбаалсан хор хохирол ихээхэн нэмэгдэж байгаа билээ. Энэ нь гэмт хэргийн харгис хэрцгий байдал нэмэгдэн улам зохион байгуулалттай, нуугдмал шинж чанартай болж согуугаар буюу бүлэглэн гэмт хэрэг үйлдэх явдал өсч, хүний амь бие, эрүүл мэндийн, өмчлөх эрхийн, нийгмийн аюулгүй байдлын эсрэг болон хүнд, онц хүнд гэмт хэргийн тоо тууштай буурахгүй байна.¹

Нийгмийн ийм нөхцөл байдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбарын хүрээнд тулгамдсан онол, практик, эрх зүйн зохицуулалтын асуудлуудыг нээн илрүүлэх, нэгтгэх, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж энэхүү үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг боловсронгуй болгохыг зүй ёсоор шаардаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсаны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийн нэг нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх явдал байдаг.²

Гэмт хэргээс урьдчилан



Цагдаагийн Академийн
Эрүүгийн эрх зүйн
тэнхимийн багш,
докторант О.Амарсайхан

сэргийлэх эрх зүйн арга хэмжээ нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар хэрэгжиж гол төлөв нийгэмд харш үйлдлийг хязгаарлах хориглох хэм хэмжээг нийгмийн амьдралын бодит харилцааны хөгжилтэй шууд уялдуулан холбох замаар хэрэглэгддэг ба зөвхөн хууль тогтоох үйл ажиллагаанд төдийгүй хууль хэрэгжүүлэх ажиллагааг өөртөө багтааж байдгаараа өргөн цар хүрээтэй арга хэмжээнд тооцогддог.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн арга хэмжээг хэрэгжүүлэхэд Эрүүгийн хууль онцгой байр суурьтай.

Монгол Улсын Эрүүгийн хууль нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин,

эрх зүйн журам, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах³ урьдчилан сэргийлэх зорилтыг хэрэгжүүлдэг.

Эрүүгийн хууль нь энэ зорилтоо хэрэгжүүлэхдээ эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдаж буй нийгмийн амин чухал харилцаанд халдсан хүн, төр, нийгэм д аюултай ямар хэргийг үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэж үзэх, тэдгээрийг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэлбэр, хэмжээ, тэдгээртэй холбоотой эрүүгийн эрх зүйн нийтлэг үндэслэлүүд /эрүүгийн хариуцлага, түүний үндэслэл, эрүүгийн ял ногдуулах, эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх гэх мэт/, түүнчлэн тодорхой гэмт хэргүүд, түүнийг үйлдсэн этгээдэд онгодуулах тодорхой ялын төрөл, хэмжээг тогтоодог учир гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль"-аас илүүтэйгээр "Эрүүгийн хууль"-д үндэслэгддэг байна.

Иймд үйлдэл, эс үйлдэхгүй гэмт хэрэгт тооцож, түүнийг үйлдсэн этгээдэд ногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг болон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл журмыг тогтоосон Эрүүгийн хууль нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн арга хэмжээнд тавигддаг:

¹ Улсын хэмжээнд 2006 онд 18253 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2005 оноос 4.8 хувиар өсч, нийт хэргийн 17.2 хувийг хүнд, онц хүнд гэмт хэрэг эзэлж байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 40.9 хувь нь нууц далд аргаар үйлдэгджээ. Согуугаар болон бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 4.7-17.7 хувиар өсчээ. Гэмт хэрэгт холбогдогсдын 23 хувь нь согуугаар, 23.7 хувь нь бүлэглэн гэмт хэрэг үйлдэжээ. "Улсын хэмжээнд 2006 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ". ЦЕФ-ын Мэдээлэл Судалгааны Төв, УБ., 2007 он.

² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, 3.5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл, 1997 он, №1

³ Монгол Улсын Эрүүгийн хууль, 1 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл, 2002 он, №5

- хууль, тогтоол, бусад шийдвэр нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогод тохирсон байх;

- үндэслэлтэй байх;

- тодорхой байх;

- бодитой, биелэгдэх бололцоотой байх;

- системтэй байх;

- зорилго чиглэлтэй байх¹ гэсэн шаардлагыг хангасан тохиолдолд сая гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоо амжилттай хэрэгжүүлж чадах юм.

Гэвч одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн зарим хэм хэмжээ нь дээрх шаардлагыг хангахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн арга хэмжээг хэрэгжүүлэхэд /гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Эрүүгийн хуулийн зорилтыг хангахад/ сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал:

Нэг. Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насны талаар

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг гэмт хэрэг үйлдсэн этгээд буюу гэмт хэрэгтэн бие хүнээс салагид авч үзэх боломжгүй бөгөөд гэмт хэрэгтэн нь "бие хүн" гэсэн ерөнхий социологийн, "гэмт хэрэгтэн" гэсэн нийгэм хууль цаазын ойлголтын нэгдэл юм².

Криминологийн шинжлэх ухаан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг уг хүнд гэмт хэрэг үйлдэхэд ямар шалтгаан нөхцөл нөлөөлсөн болон тухайн хүнд гэмт зан төлөв бүрэлдэн тогтсон шалтгааныг өөрөөр хэлбэл, гэмт хэрэгтний нийгмийн болон түүний сэтгэл зүй, биологийн онцлог зэргийг анхааран судалдаг.

Харин эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тодорхойлох нийгэм, эрх зүй, сэтгэл зүй, биологийн болон бусад хувийн шинжүүдээс түүний үйлдсэн хэргийг гэмт хэрэг гэж үзэх, зүйлчлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гүйцэтгэх ач холбогдлоор нь

тодорхой шинжүүдийг гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектийн шинж болгон тодорхойлж судалдаг байна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектийг хамгийн өргөн утгаар тодорхойлбол гэмт хэрэг үйлдсэн этгээд юм.

Гэхдээ энэ тодорхойлолт нь гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектийн эрүүгийн эрх зүйн шинжийг өөртөө агуулаагүй, гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын ойлголтыг өргөн утгаар авч үзсэн тодорхойлолт бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хэрэг үйлдсэн этгээд бүр гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект болохгүй, гагцхүү тодорхой хууль цаазын шинжүүдийг агуулсан үед л гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект болно.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын үндсэн шинжийг өмнө нь онолын үүднээс тодорхойлж тайлбарладаг байсан ба харин Монгол Улсын шинэ Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлд "Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын үндсэн шинжүүдийг хуульчилсан байна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын заавал байх нэг үндсэн шинж нь гэмт хэрэг үйлдсэн этгээд Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн байх явдал бөгөөд үүнийг оновчтой зөв тодорхойлох нь онолын болон практик чухал ач холбогдолтой билээ. Гэтэл гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насыг тогтоосон нийтлэг журмыг манай улсын Эрүүгийн хуулийн 21.1-д "Гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж оновчтой тодорхойлсон атлаа тусгай журмыг 21.2-д "Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд энэ хуулийн тусгай ангийн 9 /Хүний санаатай алах/, 96 /Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай

учруулах/, 126 /Хүчиндэх/, 145 /Бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 146 /Бусдын эд хөрөнгийг булаах/, 147 /Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 153 /Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтгэх/, 181.2, 181.3 /Хүндруулах нөхцөл байдалтайгаар танхайрах/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж тун ойлгомжгүй байдалаар хуульчилсан нь туйлын хачирхалтай...

Өөрөөр хэлбэл, эндээс дээр дурдсан 9 гэмт хэргийг 14-16 хүртэл насны этгээд биш, харин 16 насанд хүрсэн этгээд үйлдвэл тэдгээрт эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох уу гэдэг асуудал гарна.

Энэ талаар академик С.Нарангэрэл "Эдгээр гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэр юм. Хууль тогтоогч чухам яагаад эдгээр гэмт хэрэгт 14-16 хүртэл насны этгээдийг эрүүгийн хариуцлагад татахаар тогтооно гэвэл эдгээр гэмт хэргийн хүнд хор уршигт нь бус харин тэдгээр гэмт хэргийн нийгмийн аюулыг ойлгох оюун ухаан, сэтгэл зүйн хэмжээнд хүрсэн байдгийг гол шалгуур болгожээ"³ гэж үзсэн байна.

Харин судлаач Г.Гантөмөр "Бидний үзэж байгаагаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 225 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдээс дээр дурдсан 9 гэмт хэргийн субъект нь 14-16 насны этгээд байхаар заасан нь 1 дүгээрт: тэдгээр нь нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээгээр их, үүний баталгаа нь тэдгээрийн 6 гэмт хэрэг нь гэмт хэргийн ангиллаар хүнд болон онц хүнд гэмт хэрэгт хамаарагд, 2 дугаарт: эдгээр 9 гэмт хэргүүд нь бүгд гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг, 3 дугаарт: эдгээр гэмт хэргүүд нь нийгэмд аюултай гэдгийг, тэдгээрийн нийгмийн хор аюулын шинж чанар, учрах хор аюулын хэмжээ нь насанд хүрээгүй этгээдэд урьдас илэрхий ойлгомжтой байдаг, 4 дүгээрт: насанд хүрээгүй этгээдүүдээс үйлдэж буй гэмт явдлын бүтцэд дээрх хэргүүд голлох байр эзэлдэг,

¹ Ж.Авхиа. "Гэмт явдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал". УБ., 1997 он. 131 дэх тал.

² Н.Жанцан. "Криминологи". УБ., 2004 он. 57 дахь тал.

³ С.Нарангэрэл. "Монгол Улсын эрүүгийн эрх зүй" ерөнхий анги. УБ., 1996 он. 144 дэх тал.

⁴ Г.Гантөмөр. "Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол". УБ., 2003 он. 140 дэх тал.

түгээмэл үйлдэгддэг, 5 дугаарт: дэрх гэмт хэргүүдтэй эрүүгийн эрх зүйн арга хэрэглээс өөр бусад аргаар тэмцэх боломжгүй зэрэг шалтгаантай холбоотой юм” гэж дэлгэрүүлж тайлбарласан байх ба аль аль нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж үзжээ.

Хууль тогтоогчоос ч мөн адил эдгээр 9 гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүнийг үйлдсэн этгээдэд 14 наснаас эхлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж үзэж хуульчилсан гэдэгт эргэлзэх зүйлгүй бөгөөд өнөөдрийн шүүхийн практикт ч мөн адил эдгээр гэмт хэргийг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн болон түүнээс дээш насны бүх этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байна.

Бидний үзэж байгаагаар дээрх судлаачдын хийсэн дүгнэлт, тайлбар, хууль тогтоогчийн үзэл баримтлал, өнөөдрийн шүүхийн практикт нь Эрүүгийн хуульд тусгалаа олоогүй бөгөөд эдгээр 9 гэмт хэргийг үйлдсэн этгээдэд 14 наснаас эхлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэсэн үзэл баримтлал нь буруугаар томъёологдож хуульчлагдсан ба 16 насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэл алга байна.

Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 21.2-д 14 насанд хүрсэн этгээд гэж зөвхөн субъектийн насны доод хязгаарыг хуульчлах байтал 14-16 хүртэл насны этгээд гэж насны дээд болон доод хязгаарыг хамтад нь хуульчилсан¹ учраас 14-16 насны этгээд зөвхөн дээрх 9 гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээх ба бусад гэмт хэрэгт хариуцлага хүлээхгүй болж, харин 16-аас дээш насны этгээд дээрх 9 гэмт хэрэгт хариуцлага хүлээхгүй, бусад гэмт хэргүүдэд эрүүгийн хариуцлага хүлээхээр болж байна. Жишээ нь: Хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд

хүрсэн хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй гэсэн үг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогод үл нийцсэн энэхүү алдаатай хуулийн заалт нь хэдийгээр өнөө үед үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл болохгүй байгаа ч хуулийн энэхүү буруу томъёоллыг ашиглаж эрүүгийн хариуцлага хүлээхгүйгээс хойш яасан ч яадаг юм бэ гэдэг байр сууринаас 16 насанд хүрсэн этгээдүүдээс дээр дурдсан 9 гэмт хэргийг үйлдэх явдал ихээр гарч болохыг үгүйсгэх аргагүй.

Нөгөө талаас өнөөдрийн шүүхийн практикт 14 болон түүнээс дээш насны гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа учраас дээр дурдсан 9 гэмт хэргийг 16-аас дээш настай байхдаа үйлдэж ял шийтгүүлсэн бүх ялтаныг суллах ёстой гэсэн маш аюултай дүр зураг харагдаж байгаа юм.

Иймд Эрүүгийн хуулийн 21.2-д заасан энэхүү буруу томъёоллыг :

“Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн этгээд энэ хуулийн тусгай ангийн 91 /Хүнийг санаатай алах/, 96 /Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 126 /Хүчиндэх/, 145 /Бусдын эд хөрөнгийг хугайлах/, 146 /Бусдын эд хөрөнгийг булаах/, 147 /Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 153 /Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх/, 181.2, 181.3 /Хүндэрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах/- т заасан гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж нэн даруй залруулан зөв томъёолох зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр. Хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшуулах талаар

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг, тусгай болон нэг бүрчилсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд Эрүүгийн хуульд

заасан ялын төрөл, хэмжээ, түүнийг ногдуулах талаар тогтоосон хэм хэмжээ чухал ач холбогдолтой байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд чанд нийцүүлж, шударга ёс, эрх зүйн ухаамсыг удирдлага болгон тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор ял ногдуулах ба ингэхдээ гэмт хэмжээний нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэмжээ, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндэрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ.²

Мөн Эрүүгийн хуулиар энэрэнгүй ёсны зарчим, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ял тэнсэх, ял хойшлуулах институтыг авч үздэг бөгөөд ял хойшлуулах нь насанд хүрээгүй этгээдэд хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшуулах /ЭХ-62/, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшуулах /ЭХ-63/ гэсэн хоёр төрөлтэй байна.

2002 оны шинэ Эрүүгийн хуульд шинээр хуульчлагдсан жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшуулах тухай институтыг Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлд: “Шүүх анх удаа хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, түүнчлэн 3 хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшуулж болно. Ялан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол шүүх цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг бичлэн эдлүүлэх тухай шүүгч захирмаж гаргана. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшуулсан хугацаанд уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял ногдуулна” гэж заажээ.

¹ “14-16 хүртэл насны этгээд гэсэн томъёолол” 1961 оны болон 1986 оны шинэчлэн найруулсан, 1993 оны нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулиудад байсан юм.

² Монгол Улсын Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйл. “Төрийн мэдээлэл”, УБ., 2002 он, №5.

Эндээс үзэхэд хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах явдлыг тодорхой нөхцөл байдлыг харгалзан гэмт этгээдийг нийгмээс тусгаарлахгүй, ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр эрүүгийн хариуцлагын зорилгыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгож хуульчилсан уу, эсвэл шийтгэх тогтоолыг биелүүлэх нь ялтаны хүүхдийн эрх ашигт сөргөөр нөлөөлж болох байдлыг харгалзан тодорхой хугацаагаар хойшуулж дараа нь биелүүлэх агуулгатайгаар хуульчилсан уу гэдэг нь тодорхойгүй байна.

Өөрөөр хэлбэл, гэмт этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр эрүүгийн хариуцлагын зорилгыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгож энэ асуудлыг хуульчилсан гэвэл хүнд гэмт хэрэг үйлдэж 10 жилийн хорих ял шийтгүүлсэн этгээдийг "Жирэмсэн эмэгтэй, 3 хүртлэх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг" гэсэн үндэслэлээр хүүхдийг нь гэрт нь харуулаад хүмүүжүүлчих нь гэж үзэж болохгүй нь ойлгомжтой учир энэ санаа үгүйсгэгдэнэ.

Тэгэхээр ялтаны хүүхдийн эрх ашгийн үүднээс шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг тодорхой хугацаагаар хойшлуулаад дараа нь түүнийг биелүүлэх агуулгатайгаар хуульчилж гэж үзэх үндэстэй байна. Гэтэл Эрүүгийн хуулийн 78.2.1-д хорих ял оногдуулсан

шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй бол тухайн этгээд ялгүй болно гэж заасан учир хэрэв 10 жилийн хорих ял шийтгүүлсэн ганц бие эцгийн ялыг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулаад дараа нь ялыг нь эдлүүлэх гэвэл тухайн этгээд Эрүүгийн хуулийн 78.2.1-д заасан үндэслэлээр нэгэнт "ялгүй" болчихсон тул түүнд хорих ял ногдуулсан шийтгэх тогтоолыг биелүүлэх боломжгүй болж өөрөөр хэлбэл, 8 жилийн ялыг завшуулах болж байна.

Мөн үүнийг дагаад гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд ял завших үүднээс санаатайгаар жирэмслэх, гэр бүлээ цуцлуулах сөрөг үзэгдэл даамжирч шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах сонирхолтой хүмүүс олшрох бөгөөд хуульд заасан үндэслэлээр тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шүүхийг ч буруутгах аргагүй байдалд хүрчихээд байгаа юм.

Энэ байдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Эрүүгийн хуулийн зорилтыг хангахад сөргөөр нөлөөдөөд зогсохгүй хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд ял завших боломж олгож тэдгээрийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх боломжийг алдагдуулсан байна.

Одоогоор шүүхийн практикт жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх

несны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсаны дараа Эрүүгийн хуулийн 78.2.1-д зааснаар ялгүй болсон гэж үзэж шийтгэх тогтоолыг биелүүлээгүй тохиолдол гараагүй байгаа хэдий ч дээр дурдсан сөрөг байдлуудыг цаашид гарахаас сэргийлж хуулийн энэ алдаатай зохицуулалтыг залруулж Эрүүгийн хуулийн 78.2.1-ийн "тэнсэн хянан харгалзсан, хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй" гэсэн заалт нь Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлд хамаарахгүй гэсэн нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулах шаардлагатай байна.

Эцэст нь тэмдэглэхэд дээрх тулгамдаж буй тодорхой асуудлуудыг Эрүүгийн хуулийн хэм хэмжээг шүүмжлэх бус харин түүнийг нэг мөр болгон ойлгож зөв хэрэгжүүлэх, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Эрүүгийн хуулийн зорилтыг хангах үүднээс тавьсан бөгөөд тэдгээрийг судалсны үндсэн дээр тодорхой шийдэлд хүрэх нь шинэ хуулийн хэрэгжилт үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд тус дөхөм болно гэдэгт найдаж байна.



ӨМГӨӨЛӨГЧ БА МӨРДӨН БАЙЦААГЧИЙН ХАРИЛЦАА

1. Өмгөөлөгч, түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг

Монгол Улсад ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлж, хүний эрх, эрх чөлөө шударга ёсыг хангахад өмгөөлөгчийн гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж байна. Ялангуяа, эрх зүйт төртэй хуулийг дээдэлдэг улсын тухайд нийгмийн гол чухал харилцааг хуульчилж тэрхүү хуулийн хүрээнд ажиллаж амьдрахыг хүмүүсээс шаарддаг жамтай. Хүн өөрөө нийгмийн дотор амьдарч, амьдралдаа тухайн нийгмийн маш олон төрлийн харилцаанд оролцдогийгнхөө хэрээр тэдгээр харилцааг зохицуулсан олон тооны хууль тогтоомжийг мэдэх, хэрэглэх шаардлагатай алхам тутамдаа тулгардаг байна. Гэтэл тэдгээр хууль тогтоомжийн талаар хүн бүр бүрэн мэдлэгтэй, практикт зөв хэрэглэх чадвартай байж чаддаггүй ба энэ нь өрөөсөө боломжгүй асуудал гэдэг нь ойлгомжтой. Үүнтэй холбоотойгоор эрх зүйн үйлчилгээний эрэлт хэрэгцээ үүсч, түүнд тохирсон үйлчилгээ явуулах бодит шаардлага буй болдог бөгөөд ардчилсан нийгэмд өмгөөллийн үйл ажиллагаа л энэ орон зайг нөхөж өгдөг юм.

Аливаа эрх зүйн харилцаанд оролцоходоо хүмүүс тэрхүү харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг судлахаасаа илүү энэ талаар мэргэшсэн хуульчийн туслалцаа авах нь илүү хялбар, үр нөлөө сайтай.

Энэ чанараараа өмгөөлөл бол нийгмийн шударга ёс, хүний эрх, эрх чөлөөний чухал баталгаа болно.

Өмгөөлөгч - Латинь Advocatus -урих, уриалах гэсэн үгнээс гаралтай. Монгол хэлэнд өмгөөлөгчийг:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд ял унаагахад хууль зүйг баримталж, шүүмжилж хөнгөтгөхийг эрэн хэлэлцэгч хүн;



Отгонтэнгэр Их сургуулийн
Хууль зүйн сургуулийн багш
Ж.Наранцацрал

2. Хэргийг өмгөөлөгч;

3. Хамгаалгач этгээд¹гэж тайлбарлажээ.

Өмгөөлөгч бол хүний эрхийн баталгаа өмгөөлөлгүйгээр ардчилал, хүний эрхийн талаар төсөөлөхийн аргагүй юм.

Өмгөөлөгч: Хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг өмгөөлөгч гэнэ.²

ЭБША-ны хүрээнд өмгөөлөгч гэдэг нь: Хуульд заасан журмын дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон байгаагаас гадна / ЭБШХ-ийн 38.1 дэх хэсэг/ ЭБШХ-ийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй гэж өмгөөллийн үйл ажиллагааны үндсэн үүргийг баталгаажуулсан

байна.

Энэхүү өмгөөлөгчийн үндсэн үүргийн хэрэгжилтэд ЭБША-г хэрэгжүүлэгч мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, өмгөөллийн үйл ажиллагааг ханган хэрэгжүүлэх боломж олгох явдал бөгөөд Ардчилсан нийгэмд хүн төрийн анхаарлын төвд байж, хүний эрх, эрх чөлөөг дээд эргээр хүндэтгэн, түүний халдашгүй байх эрх, тухайн эрхээ эдлэх боломжийг хангах явдал эрх зүйн зохицуулалтын гол чухал асуудал байдаг. Үүнийг ханган хэрэгжүүлэхэд нэг талаас өмгөөлөгчийн үүрэг, нөгөө талаас ЭБША-г хэрэгжүүлэгч субъект болох мөрдөн байцаагчийн үүрэг ихээхэн чухал гэдэг нь ойлгомжтой.

2. Өмгөөлөгч ба мөрдөн байцаагчийн харьцаа, ЭБШХ-д заасан өмгөөлөгч, мөрдөн байцаагчийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал, өнөөгийн төлөв байдал.

ЭБША-нд "Гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон үеэс эхлэн өмгөөлөгч оролцох эрхтэй" / ЭБШХ-ийн 38.3 дах хэсэг / Энэ үеэс өмгөөлөгч уг ажиллагаанд оролцож, түүнийг хэрэгжүүлэгч мөрдөн байцаагчтай ажил хэргийн хүрээнд харилцаж, үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг тууштай хамгаалах шаардлага бий болдог. Сүүлийн жилийн судалгаа, тоон үзүүлэлтээр: Цагдан хоригдож буй 783 хүний 42.4 хувь нь отг өмгөөлөгч аваагүй гол төлөв яллагдагчаар татагдсанаасаа хойш өмгөөлөгч авдаг байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дөнгөж 19.1 хувь нь өмгөөлөгчтэй байцаалтад оролцдог гэсэн бол 33.1 хувь нь өмгөөлөгчтэй байцаалтад оролцуулах хүсэлтийг мөрдөн байцаагч хангадаггүй гэсэн нь энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна

Өмгөөлөгч, мөрдөн байцаагчид аль алинд нь хамааралтай хүний эрхийн үндсэн баталгаануудыг

¹Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он, 436 дахь тал

²Өмгөөллийн тухай хууль. 5 дугаар зүйл. 2002 он

Танхайг тандахуй

Хулгай хийснийхээ төлөө хорих ялаар шийтгэгдсэн нэгэн эмэгтэйд Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн дагуу уучлал үзүүлж энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийтэд мэдээлэн, хуульч хийгээд хуульч бус олон хүн ерөнхийлөгчийн энэхүү алхмыг сайшааж байсан цаг саххан.

Гэтэл ийнхүү нэгэн эмэгтэй суллагдлаа гэхэд цаана нь өөрийн гаргасан алдаанаас болж залуу насныхаа үнэт он жилүүдийг өргөст торны цаана өнгөрөөж буй залуус хэдэн мянгаараа байгаа нь үнэнтэй. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын дагуу гэмт хэрэг үйлдсэн хэн боловч эрүүгийн хуулийн дагуу ял шийтгэл хүлээж, түүнийгээ эдлэх нь гарцаагүй хэдий ч эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байж болохоор үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан бол эдгээр залуусын тоо улам нэмэгдэх нь гарцаагүй.

Эдгээг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдож буй үйлдлүүдийг нарийвчлан судлах ахул заавал ч үгүй эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагагүй зарим үйлдэл байгаагийн хамгийн том жишээ нь танхайн гэмт хэрэг, тухайлбал, Эрүүгийн хуулийн 181.1, 181.2.5 дугаар зүйлүүд байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 1-д "Олон нийтийн илтэл үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсийн доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх,



Монголын Өмгөөлөгчдийн холбооны Сургалтын хорооны дарга
О.Алтангэрэл

гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заажээ.

Танхайрах нь олон нийтийг үл хүндэтгэн нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн санаатай үйлдэл бөгөөд нийгмийн хэв журам нь хуулиар хамгаалагдах ёстой объект мөн хэдий ч түүнийг ямар тохиолдолд гэмт хэрэгт тооцох, танхайрсан этгээдэд ямар тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай байгаа юм.

Танхайрах үйлдлийг Эрүүгийн хуульд дээрх байдлаар томъёолсон бол Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд "Гудамж, талбай, орон сууц, нийтийн тээвэр, үзвэр үйлчилгээний болон олон нийтийн бусад газар хэрүүл маргаан, зодоон үүсгэсэн, бусдыг өдөөн хороосон, айлган сурдүүлсэн, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулсан, олон нийтийг үл

хүндэтгэсэн, үйлчилгээний болон дарааллын журам зөрчсөн" бол танхайрсанд тооцохоор заасан байна.

Дээрхээс харвал танхайрсан үйлдэлд Эрүүгийн хуулийн 181.1, эсхүл Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн алианаар нь ч хариуцлага хүлээлгэж болохоор ойлгогдож байгаа юм¹. Гэтэл захиргааны зөрчил гэж тооцогдож болохоор энэхүү үйлдлийг 2 буюу түүнээс дээш этгээд хийсэн бол Эрүүгийн хуулийн 181.2.5-д заасны дагуу гарцаагүй эрүүгийн хариуцлага хүлээн хамгийн багадаа 3 жилийн хорих ялаар шийтгэгдэх болж байна.

БНМАУ-ын Дээд Шүүхийн Бүгд хурлын "Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн зарим гэмт хэргээс зөв ялгаж шийдвэрлэх тухай" 1988 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 13 дугаар тогтоолд "...танхайрах гэмт хэрэг нь нийгэм, иргэдэд ихээхэн хохирол учруулдаг төдийгүй танхайрч эхэлсэн үйлдэл нь өөр бусад хүнд гэмт хэрэг болон хувирах явдал цөөнгүй тохиолддог тул танхайрах гэмт хэрэгтэй тийм тэмцлийг улам хүчтэй болгон, нийгэмт хэрэг үйлдэгчдэд оногдуулах ялыг сулруулахгүй ажиллах нь шүүн таслах байгууллагын чухал үүрэг хэмээн үзсэнэй.", "Танхайрах гэмт хэрэг нь олон нийтийг илт хүндэтгэхгүйгээр нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн хор уршигтай байдагаараа жижгээр танхайрсан захиргааны зөрчлөөс ялгагдана. Жижгээр танхайрах үйлдэл нь нийгмийн хэв журмыг зөрчхөдөө иргэдийг хүч хэрэглэн зодож бие махбодид нь гэмтэл учруулах, албан байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдуулах, эд хөрөнгө эвдэж устгах зэрэг хор уршигт хүргэдэггүй зэрэг шинжээрээ

¹ Өмгөөлөгч Г.Эрдэнэбат үүнтэй төстэйгээр Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, бусад хууль дахь захиргааны хариуцлага хүлээлгэсэн хэм хэмжээг харьцуулан 40 орчим зүйл, заалт шууд зөрчилдөж байгааг тогтоон "Өмгөөлөгч" сэтгүүлд цувралаар нийтэлсэн байдаг.

танхайрах гэмт хэргээс нийгмийн хор аюулаар бага байдаг" хэмээн зөвсөн байна.

Өөр гэмт хэрэг болон хувирах магадгүй үйлдэл хийснийх нь төлөө ногдуулах ялыг нь чангатгаж, хэн нэгэнд гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулаагүй бол захиргааны зөрчил, их ч, бага ч ямар нэг хэмжээгээр хохирол учруулсан бол гэмт хэрэг гэж үзэхийн аль аль хандлагын хувьд хуучиржээ. Мэдээж хэрэг гэмт хэрэг нь нийгмийн аюулын шинж чанараараа захиргааны зөрдөөс илүү байх хэдий ч танхайн үйлдлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй олон тохиолдолд эдгээрийг ялгаж зааглахад хүндрэлтэй байна. Тухайлбал, зодоон хийхийг авч үзэхэд олон нийтийн газар хэрүүл маргаан, зодоон үүсгэсэн бол захиргааны зөрчилд тооцогдоор хуульчилсан хэрнээ цагдаагийн байгууллага "хусвал" эрүүгийн хэрэг үүсгэж, зодоон хийхдээ хоёр буюу түүнээс олон хүмүүс оролцсон бол бүлэг хэмээн хүндрүүлэн шалгадаг. Энэхүү "хусвал" хэмээхийн цаана хичнээн хүний эрх ашиг хөндөгдөж, хичнээн гэр бүлд сүүдэр тусч, тэр ч хэмжээгээрээ танил тал, гэр харх явдал хавтгайрч байгааг тооцоолох аргагүй.

Өмгөөлөгчдийн хувьд аливаа асуудлыг яллагдагчид ашигтай байх зарчмын дагуу шийдэхийн тулд танхайрсан үйлдэл нь захиргааны зөрчилд тооцогдож болохоор нөхцөлд хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу захиргааны журмаар шийдүүлэх хүсэлтэй байдаг хэдий ч ийм төрлийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсээр байна.

Нэгэнт адилхан үйлдэлд захиргааны болон эрүүгийн хариуцлагын аль алинийг нь хүлээлгэж болохоор хуульчилж, түүнийгээ хэрэгжүүлж буй энэ нөхцөлд, өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эрх ашигт ямар нэг байдлаар хамгаалахын тулд гарц хайн арай хөнгөн ялтай гэмт хэрэгээр зүйлчлүүлэх /тухайлбал Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйл: Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах/-ийг эрмэлзэж, ингэдээ зарим тохиолдолд цагдаа, прокурорын байгууллагын зарим ажилтны хүнд суртал, зохисгүй

үйлдэлтэй тулгарах явдал цөөнгүй гарсаар байна. Үүнийг дагаад олон нийтийн дунд ч хуулийн байгууллагын шударга ажиллагаанд эргэлзэх, тэдний үйлдлийг авилгатай холбож төсөөлөх хандлага нэмэгдэж байгааг анхаарах ёстой.

Бодит жишээ авъя. Нэг жаал байрныхаа гадаа зогсож байсан 3 охиныг хэл амаар доромжилсных нь төлөө охидын нэг нь түүнийг алгадтал жаалын ах нь гарч ирэн тэрхүү охиныг цохисноор зодоон эхэлж жаалын ахынх нь нүүр шалбарч, охидын нүд хөхөрсөн байна. Цагдаагийн байгууллага жаалын ахад Эрүүгийн хуулийн 99.1, харин охидод тус бүрт нь эрүүгийн хуулийн 181.2.5-д зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Охид болон жаалын ахын аль аль нь 18 насанд хүрээгүй ба дунд сургуулиа ч төгсөж амжаагүй. Энэ тохиолдолд охид хамгийн багадаа 3 жилийн хорих ял авч, зодоон хийсэн хөвгүүн охид түүнтэй эвлэрэхгүй гэвэл ямар нэг байдлаар эрүүгийн хариуцлага хүлээх болж байна. Гэтэл ирээдүй болон хүүхэд залуустай захиргааны зөрчилд тооцож болохоор үйлдлийнх нь төлөө эрүүгийн хариуцлага ногдуулж, амьдрал болон дотоод сэтгэлд нь насан туршид хар толбо үлдээх шаардлага бидэнд бий билүү гэсэн асуулт гарч ирнэ.

Харамсалтай нь хорих ангиудад энэхүү гэмт хэрэгт шийтгэгдсэн, үйлдэл нь хэн нэгэнд хор уршиг учруулаагүй, учруулсан ч ялимгүй шинжтэй, эвдсэн эд хөрөнгө, учруулсан гэмтлээ тэр дор нь сэргээж, хохирлыг хангалттай төлж барагдуулсан хэрнээ хорих ялаар шийтгэгдсэн олон залуу сэтгэл зүйгээрээ шоронжиж, ихийг хийж бүтээх зориг тэмүүлээ алдан, амьдралаараа хохирч байгаа нь гарцаагүй үнэн юм. Уг нь ёстой сайн хүн, хайран ч хүн, даан ч зүйл, анги нь гарцаагүй юм даа гэсэн үгийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар олонтоо хэлдэг. Гэтэл өмгөөлөгч хүн түүнийг хэрэг хянан шийдвэрлэх бүхий л шатанд яс махаараа мэдэрч, өөрийнхөө чадах бүхий л зүйлийг хийдэг ч байцаан шийтгэх ажиллагаа явуулж буй субъектүүд бүгд дотоод сэтгэлдээ мэдэрч, харамсавч хуулийн дагуу гаргаж буй шүүхийн

шийдвэрийн өмнө зүй ёсоор хүчин мөхөсдөг.

Хэрвээ танхайн гэмт хэргийн талаарх ойлголтыг цаашид улам боловсронгуй болгож, зарим хэсгийг нь Эрүүгийн хуулиас хасахгүй юм бол энэ байдал цаашид ч үргэлжилнэ. Танхай бол байж л байсан, ингэж л шийдэгддэг байсан гэмт хэрэг, үүнээс ч өөрөөр байх аргагүй хэмээн хуучинсаг сэтгэлгээгээр муйхарлах тусам хууль тогтоогчдын гэхээсээ илүүтэйгээр хэрэгжүүлж буй хуульд бидний дуу хоолой үгүйлэгдэж, санаачлага дутсаны буруугаас шалтгаалан эрүүгийн хариуцлага хүлээж, амьдралаараа хохирогсдын тоо нэмэгдсээр байх болно.

Нөгөө талаас эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байна гэдэг бол нийгмийн хэв журам зөрчлөсөдийг өөшгүүлнэ гэсэн хэрэг огт биш. Захиргааны журмаар ногдуулж буй хариуцлага ч хувь хүний төлөвшилд чухлаар нөлөөлдгийг бид санах ёстой. Гагцхүү захиргааны хариуцлага, тэр дундаа баривчлах шийтгэлийг хэрхэн үр дүнтэй ногдуулах талаар анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үзэж болохоор байна.



¹ Танхайн гэмт хэргийг бүхэлд нь үгүйсгэх гэсгүй анхаарна уу.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ХЭЭЛ ХАХУУЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

Монгол Улс Авлигын эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцид нэгдэн орсоноор уг конвенцид нэгдсэн улсуудын өмнө зарим үүргийг хүлээх болсон билээ. Тэдгээрийн нэг нь конвенцид нэгдэн орсон улс бүрийн хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ болох Үндэсний болон гадаадын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтооход шаардлагатай хууль тогтоох арга хэмжээ юм.

Тиймээс уг конвенцид заасны дагуу хээл хахуулийн гэмт хэргийн шинэ төрлийн үйлдлүүд болох нэг талаас хээл хахуулийг амлах, санал болгох, нөгөө талаас хээл хахуулийг шаардах, амлуулах үйлдлүүдийг шинээр хуульчлах, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн зарим зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай болж байгааг харгалзан, гагцхүү тэр хүрээнд өөрийн санааг та бүхэнтэй хуваалцахаар үүнийг бичив.

Юуны түрүүнд энэ гэмт хэргийн хамгаалах эрх зүйн үнэт зүйл буюу бидний нэрлэж заншсанаар объектийг зөв тодорхойлох шаардлагатай юм.

Өнөөдрийг хүртэл хээл хахуулийн гэмт хэргийн объект бол төрийн албаны нэр хүнд, төр, засгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа болон нийтийн ашиг сонирхол юм гэж ерөнхийд нь тодорхойлж ирсэнийг хээл хахуулийн гэмт хэргийн хамгаалах эрх зүйн үнэт зүйл нь "төрийн байгууллага, түүний албан тушаалтан гадны нөлөөнд үл автан, шударгаар үйл ажиллагаа явуулаа гэдэгт итгэх олон нийтийн итгэл" байна гэж нийтийн ашиг сонирхолыг ойлгомжтой болгож тайлбарлавал хээл хахуулийг санал болгосон, амласан, шаардсан үйлдлүүдийг төгс үйлдэгдсэн гэмт хэрэгт тооцож болно.

Албан тушаалтан гэж хэн



УЕПГ-ын хяналтын
прокурор Ө.Амарбат

бэ? Практикт багагүй маргаан дэгдээдэг асуудал бол энэ. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн доор "Төрийн албан тушаалтан гэж ..." тайлбарласныг мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төсөөтэй хэрэглэж болохгүй тул энэ тайлбараар асуудлаас гарах гарцыг хийх боломжгүй юм.

Харин Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д "Төрийн албан тушаалыг эдэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсэний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ" гэж заасныг анхаарч, хээл хахууль авах гэмт хэргийн албан тушаалтан нь төрийн албан хаагч буюу хууль тогтоомжийн дагуу төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтныг, түүнчлэн Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан мөн хуульд хамаарах этгээд байхаар ойлгож хэрэглэх нь Авлигын эсрэг дээрх конвенцид заасантай нийцнэ.

Албан тушаал нь гагцхүү төрийн чиг үүргийг хэрэгжүүлж буй Монгол Улсын хуулиар

тодорхойлсон албан тушаал байна. Харин албан тушаалтан нь дан ганц Монгол улсын иргэн бус гадаадын иргэн байх боломжтой бөгөөд тухайн гэмт хэргийг үйлдэхийн өмнө албан тушаалд нэг мөр томилогдсон буюу сонгогдсон байх ёстой. Томилгоо нь байгууллагын бүтцийн аль нэг хэсгийг бүрдүүлэхэд чиглэсэн, албан тушаалтан удаан хугацаанд үйл ажиллагаа явуулах, бие даасан чиг үүрэг бүхий байна. Албан тушаалтны хожим албан тушаалаасаа чөлөөлөгдсөн явдал нь түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Харин гадаадын төрийн албан тушаалтан гэдгийг гадаад улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны буюу шүүхийн байгууллагад томилогдсон буюу сонгогдон алба хашиж байгаа, эсхүл гадаад улсын үйлдвэрийн газарт төрийн чиг үүрэг гүйцэтгэдэг хүнийг, олон улсын байгууллагын албан тушаалтан гэдгийг олон улсын байгууллагын ажилтан буюу тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх олгогдсон хүнийг хэлэхэд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид тодорхойлон ойлгох нь зүйтэй санагдана.

Албан тушаалтны эрх, үүрэг нь түүнийг тодорхойлсон хууль буюу албаны дүрэм, бусад хэм хэмжээнд үндэслэнэ. Өөрөөр хэлбэл албан тушаалтан нь дээрх баримт бичгүүдээр олгогдсон эрх, үүргээ зөрчиж үйл ажиллагаа явуулсан байна. Харин байгууллагын удирдлагын зүгээс уг эрх, үүрэгтэй нь холбоогүйгээр зоргоороо өгсөн үүрэг даалгавар үүнд хамаарахгүй юм. Үүнийг өөрөөр тайлбарлавал, албан тушаалтан хэрэгжүүлэхээс татгалзаж болох буюу гүйцэтгэсэн явдал нь албан үүрэгт нь хамааралгүй байх явдлыг ойлгоно. Эндээс харах юм бол албан тушаалтан нь хээл хахууль авах үедээ албан тушаалыг эдэлж

байх ёстой. Тийм учраас албан тушаалаас чөлөөлөгдсөн этгээд албан тушаалыг эдлэх үедээ гэмт хэргийн бүрэлдэхүүн бүхий үйлдлийг хийгээгүй бол урьд гүйцэтгэсэн үйлдлүүдийнхээ төлөө хэрэг хахууль авсан, албан тушаалд томилогдсоогүй байхдаа хойчийн албан үүрэгтэйгээ холбоотойгоор хээл хахууль авах нь гэмт хэрэг болохгүй. Үүнтэй адил албан тушаалтан албан тушаалыг эрхэлж байх хугацаандаа албаны шугамаар буюу албан үүргийн хувиар хэрэгжүүлэх боломжтой байсан хэдий ч танил талаа ашиглан хувирараа хэрэгжүүлсэн арга хэмжээ нь албаны эрх, үүрэгт хамаарахгүй. Гэхдээ албан тушаалтан олгогдсон эрх, үүрэгт нь харш буюу албаны дүрэм журмаар хориглосон үйл ажиллагаа явуулахын тулд албан тушаалаа урвуулан ашиглах нь албан үйлдэл болно.

Хууль тогтоомжоор тусгай үүрэг хүлээсэн этгээдийн хувьд албан үйлдлийн ойлголт нь түүний үүргийн хүрээг хамарна. Тухайлбал цагдаагийн албан хаагч ажлын бус цагаар хэдий ч албаны шугамаар үйл ажиллагаа явуулсан бол түүнийг үүрэгт ажлаа гүйцэтгэж явсанд тооцно.

Эрх, үүрэг нь хэм хэмжээгээр тодорхой тогтоогдсон албан тушаалтнуудын хувьд түүнээс гажсан тохиолдол бүр хууль бус байдаг бол шүүгчийн хувьд хуулийг удирдлага болгон өөрийн дотоод итгэлээр шийдвэр гаргадаг. Энэ тохиолдолд шийдвэр гаргах доод тал нь хоёр боломж байх бөгөөд гаргах шийдвэрт гагцхүү дотоод итгэлээ урвуулсан нөхцөлд буюу давуу байдлын нөлөөнд автсан эсэх чухал юм.

Хээл хахууль өгөх, зуучлах гомт хэргүүдийн субъект хэн ч байж болно.

Хээл хахууль гэж юу вэ? Гадаадын эрдэмтэн судлаач нар хээл хахууль буюу хууль бус давуу байдал гэдгийг хээл хахууль авагчийн эдийн засгийн, эрх зүйн эсхүл зөвхөн хувийнх нь бодит байдлыг сайжруулж байгаа материаллаг болон материаллаг бус үйлчилгээ байна гэж тайлбарладаг бөгөөд тэдгээрийг шаардах эрх зүйн үндэслэл хээл хахууль авагчид байх ёсгүй гэж тодорхойлдог байна.

Хээл хахууль өгөгчийн эд

хөрөнгө багассан байх, эсхүл хээл хахууль авагчийн баяжсан эсэх давуу байдлын ойлголт хамаарахгүй. Түүнчлэн албан тушаалтанд гагцхүү хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай хэрэгслийг ашиглуулахаар өгөх нь хээл хахуулийн гэмт хэргийн давуу байдал болохгүй.

Бас нэг чухал асуудал бол бэлэг. Бэлгийн хэмжээ албан тушаалтны нэг сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс хэтрээгүй бол өөртөө үлдээж болох, хэрэв түүнээс хэтрэвэл зөрүүг төлж өөрт тэдгээл тухай жишиг байдгийг бид мэднэ. Гэтэл албан тушаалтнуудын цалингийн хэмжээ тэдгээрийн чиг үүргээс хамаарч өөр байгаатай холбоотойгоор авч болох шалдрга хэмжээ нь мөн өөр байх нь бүлэгрэг ёсонд нийцэхгүй гэдэгтэй хүн бүр санал нийлэх байх.

Ямар ч нөхцөлд бэлэг гэдэг бол эелдэг байдал, талархлын илэрхийлэл байх бөгөөд зохист хэмжээнд байх ёстой. Зохист хэмжээ гэдэг нь нийгэм дэх ердийн, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байх явдал. Нийгмийн доторх ерөнхий зохист хэмжээнээс давсан ивээлүүд аливаа тохиолдолд анхаарлын төвд байна. Өөрөөр хэлбэл тухайн нэг тохиолдлын хувьд уг давуу байдлын төрөл, хэмжээнээс хамааралтай алба, амины эрх ашиг холилдож байнга гэх сэжиг илүү байна.

Мэдээж хэрэг бэлэг нь албан тушаалтны хууль бус үйлдэлтэй холбогдсоноор хахууль болж хувирна.

Хээл хахуулийг албан тушаалтан өөрөө бус, харин гуравдагч этгээд түүнийг авах тохиолдол элбэг байдаг. Эг талаар Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд "өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан бол" гэж заасан байна. Эрдэмтэн, судлаачид гуравдагч этгээд хахуулийг авч байгаа явдлыг үүнд хамааруулна гэж тайлбарладаг. Хэдийгээр энэ зөв хэдий ч уг зохицуулалтын түүхийг судлахад "бусдаар дамжуулан" гэж хуульчлахдаа өөр санааг агуулсан байхыг үгүйсгэхээргүй байна.

БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийг 1924 онд батлагдсаны дараа БНМАУ-ын Шүүх цаазын бичиг нэртэйгээр 1926 онд батлагдаж,

өнөөдөргүй хүртэл нийтдээ 6 удаа бүхэлдээ шинэчлэн найруулагдаж, 2 удаа зарчмын шинжтэй томоохон нэмэлт, өөрчлөлт хийгдэж, нэр нь солигдож ирсэн одоогийн Эрүүгийн хууль дахь дээрх зохицуулалт анх 1934 оны Шүүх цаазын бичигт тусгалаа олжээ.

Сонирхолтой нь 1929 оныг хүртэл хээл хахууль өгөх, зуучлах үйлдлүүдийг нэг зүйлийн дор хуульчилсан байсныг 1934 оны Шүүх цаазын бичгээр "Хээл хахууль авах", "Хээл хахууль өгөх", "Хээл хахууль зуучлах" гэж бүрэлдэхүүндийг бие даасан гэмт хэрэг болж хуульчилсантай хамт "өөрөө болон бусдаар дамжуулан" гэдэг зохицуулалтыг хээл хахууль авах гэмт хэргийн бүрэлдэхүүнд шинээр хуульчилсанд оршино. Өөрөөр хэлбэл хахууль өгөх хахуулийн зүйлийг хахууль авагчид өөрөө шууд өгөөгүй, харин зуучлагчаар дамжуулан гагцхүү хахууль авагчид өгөхийг зохицуулсан байж болохор байна. Энэ зохицуулалтыг үгийн шууд утгаар нь авч үзсэн ч албан тушаалтанд өөрт нь хахууль ирж байхаар ойлгогдож байна. Тиймээс албан тушаалтан өөрөө биш, харин түүний садан төрийн хүн юм уу, эсхүл найз нөхөд нь хахуулийг авч байгаа бол энэ гэмт хэргийн бүрэлдэхүүн болохгүй байж болохоор хуулийн хийдэл байгаар цаашид анхаарах хэрэгтэй санагдана.

Зарчмын хувьд албан тушаалтан хахуулийг өөртөө буюу бусдад зориулж авах бөгөөд давуу байдлыг гуравдагч этгээд авсанаар албан тушаалтны тухайд өөрийнх нь ачаалал хөнгөрч, мөнгө нь хэмээгдэх буюу хувийнх нь байдал сайжирна. Эг талаар байдлын шууд өөрт нь бус харин гуравдагч этгээдэд өгөж байгаа албан тушаалтан өөрөө мэдэж, хүлээн зөвшөөрсөн байх ёстой.

Гуравдагч этгээдэд давуу байдал үйлчлэхийн цаана албан тушаалтан болон хээл хахууль өгөгч нар хууль бус тохиролцонд хүрсэн байх учиртай. Тийм учраас хууль бус тохиролцоо нь гэмт хэргийн бүрэлдэхүүний цөм нь юм. Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд "хээл хахууль өгөгчийн ашиг сонирхолын үүднээс" гэж зохицуулсанаас харахад хууль бус тохиролцооны

шинж заавал хадгалагдаж байх бөгөөд албан тушаалтан нь хахууль авсаныхаа төлөө ямар нэг албан үйлдэл хийнэ, эсхүл хийсэн гэдгийг мэдэж байх ёстой. Давуу байдал болон албаны эрх, үүргээ хэрэгжүүлэх хоёрын барилдлага нь тиймээс "хариу төлбөр" болох оролцогчдын тохиролцоог агуулж байна.

Албан үйлдэл нь тодорхой байгаа тэр л нөхцөлд албан үйлдэл болон давуу байдал хоорондын харилцааны тухай хахууль өгөгч, авагч хоёрын шаардлагатай тохиролцоо илэрхий болно. Албан тушаалтны хүлээх үүрэг нь ерөнхий байдлаар танигдахуйц хэмжээнд байгаа л бол албан үйлдэл болон давуу байдлын харилцаа хангалттай байна гэж үзнэ.

Хууль бус тохиролцоонд хүрсэн газар гэмт хэрэг гарсан газар байна.

Хээл хахуулийн гэмт хэргийн хууль бус тохиролцоог зөвөөр ойлгож, нэг мөр тогтоосон тэр л тохиолдолд хээл хахуулийг амлах, санал болгох, эсхүл шаардах үйлдлүүдийн аль хэлбэрээр энэ гэмт хэргийг үйлдсэн болох нь тодорхой болно.

Хээл хахууль авах гэмт хэргийн тухайд албан тушаалтан нь давуу байдлыг шаардах, амлуулах, авах үйлдлүүд нь энэ гэмт хэргийн үйлдлүүд байна.

А. Шаардах гэдэг нь хууль бус үйлдлийнхээ төлөө илэрхий буюу далдуур байдлаар давуу байдлыг

хүсэж байгаагаа мэдүүлэх явдал байна. Шаардлагыг хүлээн авагч мэдсэнээр гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдана. Шаардахад бас авах хүсэл байх ёстой.

Давуу байдал болон албан үйлдэл хоёрын хоорондох холбоог хахууль өгөгч нь мэдэх ёстойсон гэсэн болзолт хүсэл хахууль авагч буюу шаардлага тавигчид байхад хангалттай. Харин хахууль өгөгч хүн энэ хоёрын хоорондох холбоог мэдэж байсан, эсхүл мэдэх байсан нь ач холбогдолгүй юм. Түүнчлэн тэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн эсэх ч бүрэлдэхүүнд нөлөөлөхгүй юм.

Б. Амлуулах гэдэг нь ирээдүйн үйлчилгээний саналыг илэрхий байдлаар, эсхүл эцэслэн авсан байхыг ойлгоно. Үйлчилгээг хүлээж авсан эсэх нь ач холбогдолгүй юм. Албан тушаалтан мэдээж давуу байдлыг авахыг мөн хүсэж байх ёстой. Харин албан тушаалтан төөрөгдлийн улмаас санал гаргаж байна гэж ойлгоод авч байгаа тухайгаа илэрхийлсэн бол хууль бус тохиролцооны нөхцөл болохгүй. Энэ тохиолдолд харин шаардсан эсэхийг анхаарах хэрэгтэй болно.

Саналын талаар хариу хэлээгүй чимээгүй байх нь оролцогчдын хооронд тодорхой болсон нөхцөл байдлын талаар зөвшөөрсөн агуулгатай, өөрөөр хэлбэл тохиролцоонд хүрэхэд чиглэсэн хүсэл зоригийн илэрхийлэл болсон нь тогтоогдвол гэмт хэргийн бүрэлдэхүүн болно.

В. Авах гэдэг нь шаардсан буюу санал болгосон давуу байдлыг бодитойгоор хүлээж авсан байх, тэгэхдээ давуу байдлаар цэнгэх, өөртөө хадгалах буюу өөрийн юм шиг захиран зарцуулах хүсэлтэй байхыг хэлнэ. Давуу байдал гуравдагч этгээдэд очсоноор гэмт хэрэг мөн төгсөнө.

Давуу байдлыг олгоход албан тушаалтан буцаах хүсэлтэй байсан эсэх, эсхүл албан тушаалтан өөрт нь оногдох давуу байдлыг өөрөө хүлээж аваагүй, харин хамтран оролцогч нь хүлээж аваад дансандаа хадгалж байсан эсэх ч ач холбогдолгүй юм.

Хээл хахууль өгөгч гэмт хэргийн тухайд хээл хахууль авах гэмт хэргийн эсрэгээр албан тушаалтан давуу байдлыг санал болгох, амлах болон өгөх үйлдлүүдээр үйлдэгдэнэ.

Санал нь хууль бус тохиролцоонд хүрэх зорилготой байдаг бол амлах нь өөрөө хууль бус тохиролцоог илэрхийлнэ.

Санал болгох, шаардахад нөгөө талын хамтран оролцоо, эсхүл тэр талаархи мэдээлэл шаардлагагүй бол амлах, амлуулахад факт бүхий холбоосыг илэрхийлэх талууд хоорондын хэлэлцээр урьдчилсан нөхцөл болдог. Харин үйлчилгээ үзүүлэх үе шат буюу өгөх, авахад хээл хахуулийг авсанаар мөн цаг хугацаанд хүрсэн тохиролцоо нь биеллээ олно. Энд хахуулийг бодитой хүргэсэн байх чухал.



Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын харьцуулалт

Төрийн албаны тухай хуульд хуульчилснаар " төрийн албан тушаалыг эрхэлж , бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг **төрийн албан хаагч**" гэнэ. Төрийн албан хаагчийн хуульд зааснаар:

1. Улс төрийн албан хаагч;
2. Захиргааны албан хаагч;
3. Тусгай албан хаагч;
4. Үйлчилгээний албан хаагч

хэмээн ангилдаг. Эдгээрээс төрийн захиргааны буюу төрийн тусгай албан тушаалын ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байгаа эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг **төрийн жинхэнэ албан хаагч** гэнэ.

Төрийн жинхэнэ албан хаагч болон хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилладаг төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын зарим асуудлыг:

1. Хөдөлмөрийн харилцаа дуусгавар болох болон түр чөлөөлөх үндэслэлээр нь;
2. Сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болон шийтгэлийн төрлүүдээр нь;
3. Ажлаас үндэслэлгүй халсан маргааныг шийдвэрлэх зохицуулалтаар нь харьцуулан авч үзвэл:

А. Хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан үндэслэлээр дуусгавар болдог. Хөдөлмөрийн тухай хуулийн 37.1.6-д "Ажилтан цэргийн жинхэнэ албанд татагдсан" тохиолдолд хөдөлмөрийн гэрээ дуусгавар болдог.

Монгол Улсын иргэн Үндсэн

¹ Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл, 2002 он, №28

² Б.Уранцэцэг. "Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль" (Онол арга зүйн тайлбар), УБ., 2004 он, 79 дэх тал

³ Л.Баасан. "Хөдөлмөрийн харилцаатай холбоо бүхий гэрээ", УБ., 2004 он, 46 дэх тал

⁴ Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл, 1999 он, №25



МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, докторант С.Болормаа

хуулийн 17 дугаар зүйлийн 4-т заасан цэргийн алба хаах үүргээ биелүүлэхээр цэргийн жинхэнэ албанд татагдах явдал нь түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний харилцаа дуусгавар болох үндэслэл болдог.²

Энэ үндэслэлээр хөдөлмөрийн гэрээ нь дуусгавар болсон ажилтан цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн тохиолдолд түүнийг ажиллуулж байсан ажил олгогч урьд эрхэлж байсан ажил албан тушаалд

нь эргүүлэн авах үүргийг хуулиар хүлээдэггүй.

Харин төрийн жинхэнэ албан хаагч цэргийн жинхэнэ албанд татагдсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2.3-д зааснаар төрийн албанаас **түр** чөлөөлдөг.

Дээрх хуулийн зохицуулалтуудаас үзэхэд төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд цэргийн жинхэнэ албанд татагдахад төрийн албанаас "түр" чөлөөлөгддөг бол харин төрийн үйлчилгээний албан хаагчдын хувьд энэ зохицуулалт хамаарахгүй тэдэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний харилцаа дуусгавар болдог.

Тиймээс үйлчилгээний албан хаагчдын хувьд цэргийн албыг бүрэн хааж дууссан тохиолдолд өмнөх ажилд нь эргүүлэн авах эсвэл түүнтэй адилтгах цалин орлого бүхий өөр ажилд ажиллуулах зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хуульд тусгах шаардлагатай ба энэ нь тэдэнд олгох хөнгөлөлт, дэмжлэг болно.³

Б. Төрийн жинхэнэ албан хаагч болон үйлчилгээний албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болон сахилгын шийтгэлийн төрлүүдийг харьцуулан үзвэл:

№	Харьцуулалт	Төрийн жинхэнэ албан хаагч	Төрийн үйлчилгээний албан хаагч
1.	Шийтгэл ногдуулах үндэслэл	албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн зэрэг тохиолдолд Төрийн албаны тухай хуульда заасан сахилгын шийтгэлийг ногдуулдаг.	хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам зөрсөн тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын шийтгэлийг ногдуулдаг.
2.	Сахилгын шийтгэлийн төрөл	<ul style="list-style-type: none"> ❖ Сануулах ❖ Албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэлх хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах ❖ Төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах 	<ul style="list-style-type: none"> ❖ Сануулах ❖ Үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах ❖ Ажлаас халах

¹ Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл 1999 №25

Төрийн үйлчилгээний албан хаагч болон төрийн жинхэнэ албан хаагчид ногдуулж буй сахилгын шийтгэлийн төрөл болон шийтгэл ногдуулах дээрх үндэслэлээс үзэхэд төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд хийж гүйцэтгэж буй албан үүрэгтэй нь холбогдуулан албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ эзтүүлсэн зэрэг үндэслэлээр л сахилгын шийтгэл ногдуулдаг бол үйлчилгээний албан хаагчийн хувьд хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн гэсэн үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулдаг байна.

В. Мөн төрийн үйлчилгээний албан хаагч болон жинхэнэ албан хаагчийн ажлаас үндэслэлгүй халсан маргааныг шийдвэрлэх зохицуулалтаараа ялгаатай.

Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн харилцаанд Хөдөлмөрийн тухай хууль хамаарч үйлчлэх ба үүнээс үүдэн хөдөлмөрийн гэрээний талуудын хооронд маргаан үүсвэл Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2-д заасны дагуу шууд шүүхэд харьяалан шийдвэрлүүлдэг.

Гэтэл төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн байгууллагын хооронд үүссэн хөдөлмөрийн маргаан ялангуяа, төрийн албанаас халсан, чөлөөлсөнтэй холбоотой маргаан нь шууд шүүхээр шийдвэрлэгдэхгүй байдгаараа онцлогтой.

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.8-д "төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор төрийн дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно" хэмээн хуульчилсан.

Хуулийн дээрх заалтын дагуу төрийн жинхэнэ албан хаагч нь ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл төрийн дээд шатны байгууллага болон шүүхийн аль алинд нь гомдлоо гаргаж болох мэт харагдаж байна. Гэвч Төрийн

албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэл-гүйгээр халагдсан гэж үзвэл гомдлоо төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад 1 сарын дотор, уг шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шүүхэд 15 хоногийн дотор тус тус гаргана" хэмээн хуульчилснаас үзэхэд тус хуулийн 26 дугаар зүйлийн 26.8-д заасан "... төрийн дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно" гэсэн хуулийн заалттай агуулгын хувьд зөрчилдөж байна.

Зарим тохиолдолд практикт Төрийн албаны тухай хуулийн дээрх зөрчилтэй заалтуудаас үүдэн төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэлгүй халсан хэмээн шүүхэд гомдол гаргах эрх нь ямар

Дээрх тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргагч иргэн Б нь хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн албаны тухай хуулийн үйлчлэлийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч хуулийн зөрүүтэй заалтуудын улмаас түүний шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь хязгаарлагдсан гэж үзэж болно.

Мөн нөгөө талаар дээрх тохиолдлын хувьд авч үзвэл шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүхээс

нэгэн байдлаар хязгаарлагдах улмаар эрх нь зөрчигдөх явдал ч гарч байна.

'Практик тохиолдол:

Иргэн Б нь тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагч. Түүнийг 2006 оны 8 дугаар сарын 29-ны өдөр 87 тоот тушаал гарган төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэн орох эрхгүйгээр ажлаас нь халсан байна.

Б уг тушаалыг эс зөвшөөрөн Төрийн албаны тухай хуулийн 26.8-ийн дагуу "Ажлаас халах сахилгын шийтгэлийг үндэслэлгүй ногдуулсан" хэмээн Сүхбаатар дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч шүүх 1917 тоот захирмажар "хэргийг урьдчилан шийдвэрлүүлэх журмыг зорьсон" гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг буцаасан байна.

нэхэмжлэлийг хүлээн авч танилцан нэхэмжлэлийг буцаах зэрэг тодорхой цаг хугацаа өнгөрснөөр зарим тохиолдолд гомдол нэхэмжлэл гаргагч нь Төрийн албаны салбар зөвлөл болон Төрийн албаны зөвлөлд гомдол гаргах хугацаагаа алдах эрх зүйн үр дагаврыг ч бий болгодог. Өөрөөр эгэлбэл хуулийн заалтын дагуу иргэн өөрийн сонголтын дагуу шүүхэд хандсанаар (шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх

	Гэрээ байгуулах хэлбэр	Маргааныг шийдвэрлэх байгууллага	Ажлаас үндэслэлгүй халсан талаар гомдол нэхэмжлэл гаргах хугацаа
Төрийн үйлчилгээний албан хаагчид	TATX-н 11.5, ХТХ-н 24 дүгээр зүйлийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулна.	XMTK, Шүүх	Х.Т.Х-н 129.2-т заасны дагуу тушаал шийдвэрийг хүлээн авснаа хойш нэг сарын дотор шүүхэд гаргана.
Төрийн жинхэнэ албан хаагчид	Х.Т.Х-н 24 дүгээр зүйлийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулах Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулийн 47.1-д заасны дагуу Төрийн албаны төв байгууллага нь ерөнхий менежер төсвийн байгууллагын албан хаагчтай байгуулах үр дүнийг гэрээ, түүнийг дүгнэх зөвөөр, журмыг баталж биелэлтэд нь хяналт тавина.	Төрийн албаны салбар зөвлөл, Төрийн албаны зөвлөл, шүүх	TATX-н 26.8 Төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэлгүй халсан тухай сахилгын шийтгэлийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор төрийн дээд шатны байгууллага эсвэл шүүхэд гаргана. TATX-н 39.4 Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэлгүйгээр үзвэл гомдлоо төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад хойш 1 сарын дотор, уг шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шүүхэд 15 хоногийн дотор тус тус гаргана.

1Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль. Төрийн мэдээлэл 2002 №26

¹ Сүхбаатар дүүргийн шүүхийн 2006 оны 1917 тоот захирмажтай хэрэг

² Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль. Төрийн мэдээлэл, 2002 он, №26

хэргийг хүлээн авах, шүүхээс хэргийг буцаах зэрэг тодорхой үйл ажиллагаа хийгдсэнээр төрийн албаны зөвлөлд хандах 30 хоног өнгөрөх) хууль ёсны дагуу эрхээ хамгаалуулах боломжийг алдах явдал ч практикт гарч байна.

Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах төрийн үйлчилгээний албан хаагчид болон төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх зохицуулалтын харьцуулалтыг схемлэн авч үзвэл:

Мөн нөгөөтэйгүүр төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэлгүй халсан хэмээн төрийн албаны салбар зөвлөл болон Төрийн албаны зөвлөлд хандсан тохиолдолд дээрх байгууллагууд нь зөвхөн тухайн албан хаагчийг ажлаас халсан тушаал шийдвэр нь Хууль Зүйн үндэслэлтэй эсэх талаар "дүгнэлт"-ийг л гаргадаг.

Харин хөдөлмөрийн гэрээтэй ажилтнуудын хувьд ажлаас

үндэслэлгүй халсан хэмээн шүүхэд хандсан тохиолдолд шүүхээс хэрэв ажлаас халсан нь хууль зүйн үндэслэлгүй хэмээн үзвэл ажилтныг ажилд нь эргүүлэн тогтоон түүнд ажилгүй байсан бүх хугацааны олговрыг олгон шийдвэрлэдгээрээ онцлогтой.

Эцэст нь дүгнэхэд төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулсан Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудыг практик жишээ болон агуулгын хувьд судлан дүгнэвэл:

1. Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.8-д заасан "төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор **төрийн дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно**" хэмээн хуульчилсан нь тус хуулийн 39.4-т заасан "Хуульд

өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэлгүйгээр халагдсан гэж үзвэл гомдлоо төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад 1 сарын дотор, уг шийдвэрийг **зөвшөөрөхгүй** бол шүүхэд 15 хоногийн дотор тус тус гаргана" хэмээх заалттай зөрчилдөж байх тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан хуулийн ойлголтыг нэг мөр болгон зөрчилдөхгүй болгох;

2. Төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд ажлаас үндэслэлгүй халсан хэмээн гомдол гаргах хугацааг тухайн шийдвэрийг **мэдсэн өдрөөс хойш** нэг сарын дотор бус харин хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нэгэн адил тушаал шийдвэрийг **хүлээн авснаас хойш нэг сарын дотор** гаргахаар хуульчилбал төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаан дахь эрхийн баталгааны нэг илрэл болох болов уу.



¹ УИХ-ын 2003 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам".

БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭМДГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЗАРИМ АСУУДАЛ

Аливаа улс орны хөгжлийг тодорхойлохдоо газар нутгийн хэмжээ, газрын хөрсөн доорх баялгаар нь бус харин гагцхүү тухайн улсын хүн ардын оюуны чадавхи, түүнийг ашиглаж өөрийн гэсэн технологийг хөгжүүлсэн, соёл шинжлэх ухааны салбарт олсон ололт, амжилтаар хэмждэг болсон энэ эрин үед амьдарч байгаа бид оюун ухаанаа уралдуулж оюуны хөдөлмөрийн үр дүнгээрээ өөрийн гэсэн өмчтэй болох боломж эрх зүйн зохицуулалтын хүрээнд бий болжээ. Иймээс оюуны өмчтэй холбоотой асуудлыг цаашид эрх зүй, эдийн засаг, менежментийн талаас нь харилцан уялдаатай судлах шаардлага зайлшгүй тавигдаж байна. Барааны тэмдгийн ач холбогдол нь зөвхөн барааг ялгахад оршдоггүй. Энэ нь арилжааны бэлгэ тэмдэг, зар сурталчилгааны хэрэгсэл болж байдаг. Зөвхөн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь өнөө үед хангалттай бус, харин энэ үйл ажиллагаагаа бусдад мэдэгдэхүйц бусдын ярианы сэдэв болж байх ёстой. Үүний тулд бусдаас ялгагдах онцлог хэрэгтэй байдаг бөгөөд барааны тэмдэг энэ зорилгыг биелүүлж байдаг. Одоогийн байдлаар Германд ойролцоогоор 17.000 барааны тэмдэг байнга зар сурталчилгаанд оролцож, үүний зардалд хагас сая гаруй марк зарцуулдаг байна. Барааны тэмдэгтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа жилд ойролцоогоор 450 тэрбум маркар хэмжигддэг гэсэн тоо баримт гарчээ.

Манай улс үндэсний үйлдвэрлэлийг дэмжвэ гэвэл барааны тэмдгийн тухай эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй



Отгонтэнгэр их сургуулийн
Хууль зүйн сургуулийн багш
С.Эрдэнэболор

болгохдоо уг асуудлыг эдийн засаг, эрх зүйн талаас нь нарийн уялдаатай судлах шаардлагатай байна. Учир нь үндэсний болон олон улсын өрсөлдөөн өргөжихийн хэрээр аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид зар сурталчилгаанд барааны тэмдгийг чухалчлан үзэх болж энэ хэрээр барааны тэмдгийн тоо өсч байна. Нөгөө талаар шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэх зардал өсөхийн сацуу зах зээл дээр шинэ бүтээгдэхүүнийг танилцуулах зардал мөн өсч байна. Өнөөдөр нэг ч үйлдвэрлэгч борлуулалтын үйл ажиллагаагаа барааны тэмдгийн найдвартай үр дүнтэй хамгаалалтгүйгээр хийх аргагүй болж байна.

Бараа, үйлчилгээний тэмдгийн түүхэн хөгжил

Мянга мянган жилийн тэртээгэс хүмүүс барааг хийсэн хүнийг, эсвэл хаанаас гаралтайг таниулах зорилгоор таних тэмдгийг

хэрэглэж ирсэн байна. Зарим судлаач уран дархны хийсэн шавар ваарын таних тэмдгийг бараацаалбал 9000 жилийн өмнө одоогийн Унгар улсад хэрэглэсэн гэж үзсэн байдаг. Хятадын үйлдвэрлэгчид 2000 жилийн тэртээ Мэдитерраны хэсэгт нэр алдартай болсон төдийгүй маш ихээр хулгайлагдах болсон FORTIS хэмээх тэмдэг хадсан барааг худалдааг байсан бөгөөд өөр хоорондоо алгаатай 1000 гаруй тэмдгийг ашиглаж байсан тухай баримт байдаг.¹

Харин гарал үүслийн тэмдгийг Этрусканы соёл иргэншил буюу манай эриний өмнөх 950-300 оны үед хамаарах байх гэж үзсэн байна. Археологчид Этрусканы бяслаг дээр бусад газрын бяслагаас ялгахын тулд зар зурсан байхыг нь нээсэн байна. Этрусканчуудын урласан таваг, вааран дээр урласан хүнийг болон хийсэн газрыг таних дүрс зурж байжээ. Эрт үед худалдаа арилжаа эрс өссөн учраас Грекийн хот улсууд тэмдэг хэрэглэх явдлыг цааш хөгжүүлсэн. Ийнхүү хэрэглэх болсон нь гар урчуудын бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх хөшүүрэг болсон байна. Оргил үедээ Грекийн хот улсууд 6000 гаруй тэмдгийг хэрэглэж байжээ.²

МЭ 557-581 онд худалдаачид өөрсдийнхөө бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн газрыг бусдад мэдэгдэхийн тулд ялгах тэмдэгтэй байв.

Энэ тэмдгүүд чанарыг мэдэх, бүтээгдэхүүнийг таних суурийг тавьж байв. Ийнхүү ялгах тэмдгүүд цай, торго, керамик, эм цаасан дээр тавигдаж болсон. Амьтан, байгалийн дүрслэл гэр бүлийн болон, гарал үүслийг ялгах тэмдэг болдог байжээ. Жишээ нь: Сонг хааны үед Жинан, Шандонг гэр бүлийнхэн оёдлын зүүний шаазангийн урчууд 4-6 таних тэмдгийг өөрсдийнхөө тавиурын ёроолд хийдэг байсан байна. Энэ тэмдгүүд үйлдвэрлэгч, эзэн хаан

¹ Э.Мягмардорж "Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд". УБ., 2003 он.

² ХБНГУ-Холбооны Патентын Шүүхийн шүүх доктор Марианне Грабрукер: Барааны тэмдгийн үүсэл гарал, түүнийг эрх зүйн хамгаалалт ба эдийн засгийн ач холбогдол. 2001 он.

хоёрт хоёуланг нь зах зээл дээр таниулж байснаараа ашигтай байв.

Бусдын тэмдгийг ашигласан тохиолдолд 1544 онд гарсан Ү Чарльзийн зарлигийн дагуу худалдаа хийх эрхийг хасах бөгөөд баруун гарыг цавчих зэргээр шийтгэдэг байсан байна. 1564 оны Францын хааны зарлигийн дагуу алтан адлалд хуурамч тамга тавьсан тохиолдолд цаазаар авах шийтгэл тогтоож байжээ. Барааны тэмдэг нь гарал үүслийн тэмдгийн хувьд тоосго, савхи, ном, зэвсэг, сав суулга болон бусад зүйлийг эртний соёл, иргэншилд үйлдвэрлэгч нарын дунд хэрэглэгдэж ирсэн байна.

Эдгээр тэмдэг нь бүтээгдэхүүнийг хийсэн хүнийг тодорхойлсон ихэвчлэн үсэг буюу бусад тэмдэглэгээг бараа, бүтээгдэхүүн дээр тамгалах хэлбэрээр ашиглаж байжээ.

Энэхүү тэмдэг нь өнөө үеийн нарийн төвөгтэй эдийн засагт бараа бүтээгдэхүүний борлуулалт, түгээлтийг дэмжих үүрэгтэй байгаагүй нь мэдэжгийн хэрэг. Гэлээ ч барааны тэмдэг нь эрх зүйн зохицуулалтын чухал бүрэлдэхүүнийг илэрхийлж байсан ба тухайлбал, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгч хоорондын харилцаа, холбоог илэрхийлэгч тэмдэг гэсэн ойлголт өнөөг хүртэл хүчинтэй байна.

Энэ тэмдэглэл нь эзэмшлийн тэмдэглэгээ гэж мөн ашиглагддаг байв. Англи хэлний "бренд" /brand/ гэдэг үгийг "Барааны тэмдэг" гэсэн утгаар хэрэглэж байна. Энэ нь фермерүүд үхэр, малдаа халаасан төмрөөр тамга тавихыг "бренд" гэж нэрлэж байсантай холбоотой юм.¹

Барааны тэмдгийг өргөн хэмжээгээр хэрэглэж эхэлснээс хойш хуулбарлаж дуурайж явдал ихэвчлэн гарч эхэлсэн. Тухайлбал, Шеффилдийн үйлдвэрлэгчдийн тэмдгийг хуулбарлаж хямдхан хутга, сэрээ хийж зарах тохиолдол байсан байна.²

Европ тивийн хувьд Британийн нийтлэг хууль мөрдөгдөж байгаагүй

учир барааны тэмдгийн эрхийг хамгаалахдаа зөвхөн хууль зүйн талаас хамааралтай байх шинжийг илүүтэй анхаарч байжээ. Тиймээс 1857 онд Франц улс шинэ хууль мөрдөж эхэлснээс хойш зуу гаруй жил болж байна.

1874 онд бүртгэгдсэн барааны тэмдгийн эрхийг хамгаалсан тухай Пруссийн хууль /Prussian ordinance/ гарсан нь Герман улсад барааны тэмдгийн эрхийг хамгаалах анхны эрх зүйн акт болсон байна. Энэ хууль нь Германы эзэнт улс байгуулагд-санаас хойш 3 жилийн дараа гарсан учир хязгаарлагдмал хүрээтэй байсан бөгөөд зөвхөн зурган тэмдгийг бүртгэдэг байжээ.³ Олон талын зохицуулалтыг агуулсан Германы анхны хууль 1896 онд батлагдсан байна. Хөрш орнуудын хувьд ч мөн адил энэ үеэс эхэлж хууль тогтоомжийн зохицуулалт хийж эхэлсэн байна.

Өнгөрсөн зууны барааны тэмдгийн хуулийн хөгжлийг зөвхөн хэдхэн нэр томъёог дурдахад: бүртгэлийг нэвтрүүлснээр эрхийг бий болгох; барааны тэмдэг /эрх шилжүүлэх, лиценз/ ашиглах орчин үеийн арга замыг танин мэдэх, барааны тэмдгийг хамгаалах шинэ онолыг тодорхойлох гэх мэтийг хэлж болно.

Барууны орнуудын дунд хүчтэй тархсан барааны тэмдгийн эрхийн тухай үзэл хандлага 1893 оны Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц, 1891 оны Барааны тэмдгийн бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийг байгуулж, оюуны өмчийг хамгаалах олон улсын үндсийг тавьсан юм. Эдгээр конвенцоор барааны тэмдгийн эрхийг хүлээн зөвшөөрч, хамгаалсан нь гишүүн орны иргэдийн бараа үйлчилгээний тэмдгийг ашиглах хууль бусаар ашиг олох сонирхолтой худалдаачид болон бусад этгээдүүдийн хууль бус үйл ажиллагааг хориглож хязгаарласан зохицуулалт болсон. Одоо бол барааны тэмдгийн зохицуулалт нь хуулбарлагчид,

дамлагчдын эсрэг чиглэх болсон. Үүний үр дүнд хэрэглэгчид өөрийн гэсэн барааны тэмдэг бүхий дээд чанарын бүтээгдэхүүнтэй болох юм. Түүхэн хөгжлийн явцад барааны тэмдэгт орчин үеийн чиг хандлагаууд зайлшгүй урган гарсан.⁴ Үүнийг дурдвал:

- Ялгаатай байдлыг хөхиүлэх, бүтээх;
- Бараа, бүтээгдэхүүнийг нэрлэх;
- Бараа, бүтээгдэхүүнийг таних боломжтой болгох;
- Бараа, бүтээгдэхүүнийг тогтоож авах;
- Бараа, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох
- Бараа, бүтээгдэхүүний тухай мэдээллийг түгээх;
- Бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах хүслийг өдөөх;
- Хэрэглэгчдэд хүчинтэй байх явдлыг баталгаажуулах.

Эдгээр онцлогууд барууны аж үйлдвэржсэн орнуудын үндэсний эрх зүйл тусгалаа олсон байдаг. Эдгээр эрх зүйн дэглэмийн зорилго бол үйлдвэрлэгчдэд энэ бүрийн төвшиний хамгаалалт үзүүлж, шинэ, бүтээгч бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд оршино. Энэхүү хамгаалалт нь тухайн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч түүнийгээ зах зээл дээр хэрэглэгчдэд таниулах болон нэрийг нь мэддэг болгох, бусад бараа бүтээгдэхүүнээс ялгагдах онцлог тэмдгийг хэрэглэх боломжийг олгодог байна.

Барааны тэмдгийн хуулиар барааны тэмдэг нь бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын баталгааг тогтоох, хэрэглэгч чанартай барааг сонгон авахад тусалцаа үзүүлэх зорилготой гэдгийг мэргэжилтнүүд бүгд хүлээн зөвшөөрсөн.

Глобалчлал даяарчлалын өнөө үед зөвхөн дүрслэлийг илэрхийлсэн, эсвэл энгийн төрлийг заасан барааны тэмдэг хамгаалагдахгүй байж болно гэсэн хандлага илрэх болсон.

¹ Д.Цолмон "Оюуны өмч" /эрх зүйн асуудал/, УБ., 2001 он.

² Д.Уранбилэг "Татент, Барааны тэмдгийн семинар" /эмхтгэл/, УБ., 2002 он.

³ ХЕНТУ-Холбооны Патентын Шүүхийн шүүгч доктор Марианне Грабрукер: Барааны тэмдгийн үүсэл гарал, түүний эрх зүйн хамгаалалт ба эдийн засгийн ач холбогдол. 2001 он.

⁴ Мөн тэнд

Монгол Улсын хувьд 1944 оны 4 дүгээр сарын 28-нд Ардын сайд нарын Зөвлөлийн 54 дүгээр хурлын тогтоолоор "Тус улсын үйлдвэрүүдээс боловсруулсан эзлэхүүнд марк ба ярлик тогтоож явуулах тухай заавар"-ыг баталж гаргаснаар барааны тэмдгийн зохицуулалтын эх үүсвэр тавигдсан байна.

1967 онд Барааны тэмдэг, газрын заалтын тухай дүрэм гарч 1987 онд шинэчлэгдсэн байна.

1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдснаар хувийн өмчийг хүлээн зөвшөөрч мөн оюуны үнэт зүйлийн талаар заалтууд оруулсан. Улмаар Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай Монгол Улсын хуулийг 1997 онд батлан гаргаснаар барааны тэмдгийг жинхэнэ утгаар нь эрх зүйн хамгаалалтад авсан чухал үүрэгтэй хууль болсон. Уг хууль нь 4 бүлэг, 23 зүйлтэй байв. Мөн 1997 онд Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн мэдүүлэгт шүүлт хийх журам гарсан. Энэ нь процессын үйл ажиллагааг зохицуулах гол эрх зүйн хэм хэмжээ болж байсан.

2002 оны Иргэний хуульд бараа, үйлчилгээний тэмдгийн талаар зарим заалт орсон. Өмнөх Иргэний хууль болон бусад хуулиудад бараа, үйлчилгээний тэмдгийн талаар зохицуулалт байгаагүй. Өөрөөр хэлбэл, бараа, үйлчилгээний тэмдэг гэсэн ойлголт энэ хуульд анх тусгагдсан.

2003 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Монгол Улсын Их хурлаас Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг баталсан. Энэ хууль нь 6 бүлэг 30 зүйлтэй бөгөөд урьдах хуулийг бодвол бүтэц хэмжээ агуулгын хувьд нэлээд өргөжсөн.

1979 онд Монгол Улс Дэлхийн оюуны өмчийн байгууллагад нэгдэн орсноор оюуны өмчийг хамгаалах асуудлаар гадаад хамтын үйл ажиллагаа идэвхжиж, оюуны өмчтэй холбоотой Олон улсын олон гэрээ, конвенцид нэгдэн ороод байна.

Монгол Улс нь барааны тэмдэгтэй холбоотой доорх гэрээ, конвенцуудад нэгдэн ороод байгаа билээ.¹

Үүнд:

- 1985 онд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парижийн конвенц;
- 1985 онд Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр;
- 1997 онд Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр;
- 2000 онд Мадридын хэлэлцээрийн протокол болон Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор Бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох Ниццийн хэлэлцээрт тус тус нэгдэн ороод байна.

Барааны тэмдгийн эрхийг хүлээн зөвшөөрөх нь шинэ худалдаачдад дэлхийн зах зээлд байр суурь эзлэх үүд хаалгыг нээж байна.

Бараа, үйлчилгээний тэмдэг, түүний эрх зүйн зохицуулалт

Барааны тэмдгийг хууль эрх зүйн актууд дээр хуульч, эрдэмтэд дараах байдлаар тодорхойлж байна. Манай улсад 1997 оны Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн тухай Монгол Улсын хуульд анх барааны тэмдгийг тодорхойлсон. Уг хуульд барааны тэмдгийг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэн өөрийн бараа, үйлчилгээг бусдынхаас ялгах зорилгоор хэрэглэх тодорхой агуулаа бүхий үсэг, тоо, дүрс буюу эдгээрийн хосолсон дүрсэн илэрхийлэл байхаар тодорхойлсон² боп 2003 оны хуулиар барааны тэмдгийг үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусдын бараа, үйлчилгээгээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг хэлнэ³ гэж тодорхойлжээ.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас гаргасан баримт бичигт нэг газрын бараа буюу үйлчилгээг бусад газрын бараа үйлчилгээгээс ялган, өөрийнхөө бараа болон үйлчилгээг сурталчлах, нөгөө талаас хэрэглэгчдээс тухайн тэмдгээр нь ялгаж бүтээгдэхүүн, үйлчилгээгээс сонгож авахад нь туслах зорилгоор хэрэглэдэг тэмдгийг барааны тэмдэг гэж нийтлэг байдлаар тодорхойлоно⁴ хэмээн дурдсан байна.

Харин "Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах салбарын гэрээнд барааны тэмдгийг нэг этгээдийн бараа буюу үйлчилгээг өөр этгээдийн бараа болон үйлчилгээгээс ялгах чадвартай тэмдэг, тэмдгийн хослол нь барааны тэмдгийн бүрдлийг хангана"⁵ хэмээн тодорхойлжээ.

Хуульч Э.Мягмардорж: Барааны тэмдэг гэдэг нь аж ахуй эрхлэгч тухайн этгээдийн үйлдвэрлэж байгаа барааг тодотгож бусад өрсөлдөгчдийн бараанаас ялгах чадвартай аливаа тэмдгийг хэлнэ⁶ гэжээ. Эдгээр тодорхойлолт нь зарим тохиолдолд барааны тэмдгийн өөр үүргийг илэрхийлэх боловч практик зорилгоор харилцан хамраалтай, үүрлэг хамт мэт ойлгогдох хоёр зүйлээс бүрдэж байна. Өөрөөр хэлбэл, барааны тэмдгээр хэн чухам уг барааг үйлдвэрлэж эсвэл худалдаалж байгааг хэрэглэгчдэд мэдэлнэ гэсэн утга биш юм. Учир нь тухайн барааны тэмдгийн дор хэн бараагаа худалдаалж байгааг зайлшгүй мэдэх шаардлагагүй төдийгүй хэрэглэгчид тухайн аж ахуй эрхлэгчид итгэл үзүүлж байгааг илэрхийлж байдаг.

Учир нь хэрэглэгчид ямар нэг ялгах илэрхийллийн тусламжтайгаар барааг үнэ, чанар, бусад шинжээр нь ялгах шаардлагатай болдог. Ийм учраас хэрэглэгчдэд зах зээлд өрсөлдөж байгаа олон бараанаас сонголт хийхэд туслах сонгомол заалтаг шаардлагатай. Үүнээс үндэслэн бараа бүр ямар нэг байдлаар нэрлэгдсэн байх ёстой. Нэрлэгдсэн барааг зах зээлд тодорхойлогч нь барааны тэмдэг болно.

Зах зээлд байгаа олон төрлийн бараанаас хэрэглэгчдэд сонголт хийлгэх замаар барааны тэмдэг нь хэрэглэгчдийн хэрэгцээ

¹ Оюуны өмчийн газар түүхчилсэн танилцуулга. УБ., 2000 он.

² Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай Монгол Улсын хууль. 1997 он.

³ Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай Монгол Улсын хууль. 2003 он.

⁴ Patent, copyright and trademark. 4th edition. N.O.L.O. 2000 year. P.366.

⁵ Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах салбарын гэрээ. УБ., 1994 он.

⁶ Э.Мягмардорж "Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд". УБ., 2003 он.

хангахуйцаар барааныхаа чанарыг дээшлүүлэхийг эзэддээ байнга сануулж байдаг. Иймд барааны тэмдэг нь өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг нөхцөлдүүлж байдгаараа эдийн засгийн хөгжилтийг хангах нэг хүчин зүйл болж байдаг.

Орчин үеийн худалдаанд хэрэглэгчид олон төрлийн бараанаас өөртөө хэрэгцээтэйг сонгон хэрэглэх боломж чадвартай болсон төдийгүй үндэсний хүрэнээс олон улсын хүрээнд улам бүр шилжиж олон төрөл болон өсөн нэмэгдэж байгаа үйлчилгээний олон төрлөөс сонгож үйлчлүүлэх шаардлага бий болсон. Ийм учраас даатгалын, агаарын нислэгийн, машин хөлслөх, өмгөөллийн гэх мэт олон төрлийн ялгаатай үйлчилгээг хэрэглэгчид өөр хооронд нь ялгах шаардлага бий болсон бөгөөд эдгээр тэмдгүүд нь үйлчилгээний тэмдэг гэж нэрлэгддэг. Үйлчилгээний тэмдэг нь барааг ялгах барааны тэмдгийн адил үйлчилгээний гарлыг тодорхойлж ялгах үүргийг гүйцэтгэдэг. Энэ тэмдэг нь өөрийнхөө үндсэн шинжээрээ барааны тэмдэгтэй тун ойролцоо бөгөөд ерөнхийдөө ижил шалгууртай байдаг.

Үйлчилгээний тэмдгийн хамгаалалт нь зарим тохиолдолд барааны тэмдгийн хуульд бага зэргийн нэмэлт хийх замаар барааны тэмдгийн зуухийн заалтыг *mutatis mutandis*¹ (зохион найрлагатайгаар) хэрэглэдэг. Дээр дурдсан зарчмуудаас үндэслэн үйлчилгээний тэмдэг нь барааны тэмдгийн адил бүртгэгдэж, сунгагдаж, хүчингүй болж болохоос гадна бусад этгээдэд шилжүүлэгдэж, мөн түүнчлэн лицензээр ашиглагдаж болдог. Ийм учраас барааны тэмдгийн нийтлэг журам үйлчилгээний тэмдэгт зарчмын хувьд адил тэнцүү байдал үйлчилдэг.

Барааны гарлын газрын нэрийг барааны тэмдгийн бүрэлдэхүүнд буюу тусад нь барааны тэмдгээр бүртгүүлж болно. Бараа, үйлдвэрлэгчийн оршиж байгаа газрыг шууд заагаагүй газар зүйн нэрийг барааны тэмдгийн бүрэлдэхүүнд буюу тусад нь бүртгэж

болно. Газар зүйн нөхцөл, хүмүүсийн дадал заншилтай шууд холбогдсон онцлог шинж чанартай барааны тэмдэгт, үйлдвэрлэсэн улс, хот, суурин буюу газар нутгийн нэрийг хослон заасныг барааны гарлын газрын нэр гэнэ. Барааны анх бий болсон газрыг шууд буюу шууд бусаар заасан заалтыг барааны гарлын заалт гэнэ. Барааны гарлын заалтад аймаг, хот, сум, муж, дүүрэг, болон газар, уул, ус, нуурын газар зүйн нэрийг оруулна.

Үйлдвэрлэгчийн оршиж байгаа аймаг, хот, сум, муж, дүүргийн нэрийг барааны тэмдгээр бүртгэхгүй бөгөөд харин үйлдвэрлэгчийн оршиж байгаа газрыг шууд заагаагүй, тухайн орны дэвсгэр нутаг дээр оршиж байгаа, эсвэл үйлдвэрлэгчийн ойр орчимд нь байгаа уул, ус, нуур, газрын нэр болон хот, суурины эртний нэрийг барааны тэмдгээр бүртгэнэ.

Барааны тэмдгийн дүрсийн дотор газар зүйн байршлын заалт шууд буюу хамтруулан хэрэглэгдэх байдлаар тусч болно. Энд газар зүйн байршлын заалт нь жинхэнэ байдлаараа буюу хийсвэр маягтай гарч болно. Жишээлэхэд: Тоохуу оймс, Буриад гутал, Дарьганга урлал, ноён хийц гэж гарлаар нь нэрлэдэг бараа байдаг.

Газар зүйн байршлын заалт нь эрх зүйн талаасаа:

А. Барааны үүслийг мэргэжлийн нэрээр юм уу газар зүйн томьёолсон нэрээр, эсвэл газар зүйн тухай хийсвэр ойлголтын байдлаар илэрхийлж бүртгэлд оруулж болох бөгөөд тэдгээр нь хэрэглэгчдийг будлиулахгүй байх шаардлагатай;

Б. Барааны үүслийг мэргэжлийн нэрээр заасан заалтыг барааны тэмдгээр бүртгэхдээ хууль ёсны эзэмшигчийг бүрэн зөв тогтоосны эцэст нэрийн ялгаврын хэллэгтэйгээр бүртгэж авна. Жишээлэхэд: "Болор" архи, "Өргөө" архи, "Чингис" архи гэх мэт. Харин газар зүйн томьёолсон нэрээр илэрхийлсэн болон газар зүйн тухай хийсвэр ойлголтын байдлаар илэрхийлсэн заалтууд нь шууд барааны тэмдэг болж чадахгүй тохиолдолд тэдгээрийг ашиглах бараа нь хэрэглэгчдийг будлианд

хүргэж болох ямар нэгэн нөхцөл бүрэн арилсан онцгой тохиолдолд барааны тэмдэг юм уу түүний бүрдэл болж бүртгэгдэж болно.

Аж ахуйн нэгжийн нэрийг барааны тэмдгээр эрхийн хамгаалалт хийж болно. Тэр нэр нь аж ахуйн үйл ажиллагааны төрөл, хэрэгсэл, оноосон нэр байх бөгөөд барааны тэмдгийн бүрэнд товчлол, хасч хялбарчилсан бус бүрэн нэрээр оруулсан байна.

Барааны тэмдэг нь эзэмшигчээ зах зээлд хөтөлж гаргадаг, эзэмшигчийн барааны чанарын баталгаажилт болдог, хариуцлагыг өндөржүүлдэг, өөрийн бараа, үйлчилгээг зах зээлд сурталчлах, нийтэд танилцуулах үүрэгтэй байдаг.

Барааны тэмдгүүд нь зах зээлд гаргаж байгаа бүтээгдэхүүн болон явуулж буй үйлчилгээний гарал үүслийг тодотгохоос гадна тухайн аж ахуй эрхлэгчийг сурталчилах хэрэгсэл болдог. Зарим оронд тэмдэг болон аж ахуй эрхлэгчийн хоорондын хамаарлыг тодорхойлоход хэрэглэгдэх, бүтээгдэхүүнийг хандартыг тодорхойлох үүрэгтэй хамтын тэмдэг ба гэрчлэх тэмдэг гэрчлэгддэг. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд "хамтын тэмдэг гэж үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид нэгдсэн хяналтын дор ашиглах барааны тэмдгийг ойлгоно" гэж тодорхойлжээ. Эндээс хамтын тэмдгийг зөвхөн хуулийн этгээдүүдийн нэгдэлүүд эзэмшихээр хуульчилсан байсан бол 2003 оны хуулиар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч бүхий л этгээд ашиглах боломжтой болсон нь ажиглагдаж байна.

Түүнчлэн 2003 оны хуульд гэрчлэх тэмдэг гэсэн ойлголт шинээр орж ирсэн. Гэрчлэх тэмдэг гэдэг нь тухайн бараа, үйлчилгээний чанар, үйлдвэрлэх арга, бусад онцлог шинж чанарыг тэмдэг эзэмшигч нь гэрчлэн бусад этгээдэд ашиглуулах барааны тэмдгийг ойлгоно хэмээн хуульд тодорхойлсон.²

Гэрчлэх тэмдэг (certification mark) гэдэг нь газар зүйн үүслийг хамааруулан онцлог чанар бүхий хэрэглэх тэмдэг юм. Гэрчлэх тэмдэг өмчлөгч нь тодорхой чанар бүхий бараа, үйлчилгээг гэрчлэх үүргийг

¹ Э.Мягмардорж "Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд", УБ., 2003 он.

² Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай Монгол Улсын хууль, 2003 он.

гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл ямар нэг барааны чанарыг 100% ноолуур, ноос гэх мэтээр гэрчилж баталгааны тэмдэг олгодог. Гэрчлэх тэмдэг өмчлөгч өөрөө тухайн тэмдгийг бараа, үйлчилгээндээ ашигладаггүй. Практикаас үзэхэд гол төлөв нэг төрлийн бараа, үйлчилгээ эрхлэгч хэд хэдэн этгээд дундаасаа гэрчлэх тэмдэг өмчлөгч этгээдийг хөндлөнгийн байгууллагын журмаар байгуулж тэр нь бусдын бараа, үйлчилгээний чанарыг хөндлөнгөөс гэрчилж тэмдэг ашиглах зөвшөөрөл олгодог. Ингэснээр тухайн бараа, үйлчилгээ зохих чанарын шаардлага хангасан гэдгээр худалдан авагч нарт нэр хүндтэй болдгоороо их ач холбогдолтой юм.

Гэрчлэх тэмдэг нь зөвхөн тогтоосон стандартын дагуу хэрэглэгдэж болно.

Хамтын тэмдгийг гэрчлэх тэмдгээс ялгаж үзэх нь зүйтэй. Хамтын тэмдэг ба гэрчлэх тэмдэг хоёрын гол ялгаа нь хамтын тэмдгийг ижил төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг үйлдвэрлэгчид хэрэглэгдэж явдал юм. Харин гэрчлэх тэмдгийн хувьд тэмдэг эзэмшигч нь тухайн бүтээгдэхүүнийг гэрчлэх бөгөөд гуравдагч этгээд тухайн тэмдгийг ашигладагараа хамтын тэмдгээс ялгагдана. Түүнчлэн гэрчлэх тэмдэг эзэмшигч тухайн тэмдэг хамаарах бүтээгдэхүүнийг төлөөлдөг байх ёстой. Энэ нь хэрэглэгчдийг төвөгшөөлд оруулахаас хамгаалахад чухал ач холбогдолтой зохицуулалт болдог.

Барааны тэмдэг нь оюуны өмчийн эрх зүйд хамаарахаас гадна худалдааны эрх зүйтэй салшгүй холбоотой байдаг. "Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр" /1994 он/-г барааны тэмдгийн тухай зохицуулалтыг нэлээд дэлгэрэнгүй байдлаар тусгасан нь худалдааны /бизнесийн/ эрх зүйд томоохон байр суурь эзэлдэг болох нь харагдаж байна. Энэ хэлэлцээрийн барааны тэмдэгт холбогдох зарим зохицуулалтыг авч үзвэл: нэг этгээдийн бараа болон үйлчилгээгээс ялгаж чадвартай тэмдэг, тэмдгийн хослол нь барааны тэмдгийн бүрдлийг хангана гэж түүнд тавигдах үндсэн онцлог шаардлагыг гаргасан байна. Барааны тэмдгээс үүдэн тухайн бараа болон үйлчилгээгээс сурталчлах, үүнтэй

зэрэгцэн эдийн засгийн харилцаанд оролцох боломжоо өргөтгөх, өөрийн гэсэн хэрэглэгч, хэрэглээний зах зээлтэй болох зэрэгтэй уялдан тэмдэг хэрэглэсэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар өндөр байх шаардлага, хариуцлагын тухай асуудлууд аяндаа гарч ирдэг.

Хувийн нэр, үсэг, тоо, дүрс хэлбэр, өнгөний хослол, тэрчлэн тэмдгийн ямар нэгэн хослолыг багтаасан онцгойлсон үг байх тэмдэг нь барааны тэмдгээр бүртгэгдэх боломжтой. Харин тэмдэг нь бараа болон үйлчилгээнд хамаарах ялгааг заах нөхцөл агуулж болохгүй гэжээ. Хэрэв бараа болон үйлчилгээний хувьд ялгагдах чадваргүй бол гишүүд тэмдгийг хэрэглээгээр дамжуулж бүртгэгдэх бие даасан чадвартай болж болно. Гишүүд тэмдэг бүртгүүлэх нөхцөлд нүдэнд ялгагдаж байхыг шаарддаг байхаар зохицуулсан байна.¹

Дээрхээс үндэслэн судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна.

Үүнд: 1. Парижийн конвенц болон ТРИПС-ийн хэлэлцээрт үйлчилгээний тэмдэг нь оюуны өмчийн бие даасан объект болохыг тусгасан байдаг. Манай улс дээрх 2 конвенцэд нэгдэн орсон;

"Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай" Парижийн конвенцийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын объектод барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг нь биеэ даасан тусдаа хамгаалалтын объект байхаар тусгаж өгсөн байна. Мөн конвенцийн 6 дугаар зүйл "sexies"-д холбооны гишүүн орон нь үйлчилгээний тэмдгийг хамгаалах үүрэг хүлээн гэж заасан байна. Мөн Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протоколын 2 дугаар зүйлийн 3-д "тэмдэг" гэдэгт барааны тэмдэг, үйлчилгээний тэмдгийг ойлгоно" хэмээн тодорхойлж өгсөн байдаг. Харин манай улсад байгаа, үйлчилгээний тэмдгийн ойлголтыг нарын зааглаж өгөөгүй бөгөөд аль алинд нь барааны тэмдгийн гэрчилгээ олгож байгаа нь учир дутагдалтай байна.

Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах салбарын гэрээний 15 дугаар зүйлийн

1-д "Хэрэв тэмдэг бараа болон үйлчилгээний хувьд ялгагдах чадваргүй бол гишүүд тэмдгийг хэрэглээгээр дамжуулж бүртгэгдэх бие даасан чадвартай болж болно" гэжээ. Манай улсын дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар нь оюуны салбар болон үйлчилгээний салбар гэж үздэг. Тэгвэл үйлчилгээний тэмдгийн эрх зүйн зохицуулалтаар энэ байдлыг хөхиүлэн дэмжиж, эрх зүйн хамгаалалтыг улам боловсронгуй болговол зүйтэй. Барааны тэмдгийн хуульд доорхи байдлаар үйлчилгээний тэмдгийн зохицуулалтыг тусгавал эрх зүйн энэ хийдлийг ариглана. "Нэг этгээдийн (байгууллагын) үйлчилгээг өөр этгээдийн үйлчилгээгээс ялгаж чадвартай ямар нэгэн тэмдэг, тэмдгийн хослол нь үйлчилгээний тэмдгийн бүрдлийг хангана. Хувийн нэр, үсэг, тоо, хөдөлгөөн, дуу авиа, дүрс хэлбэр, өнгөний хослол, тэрчлэн элдэв тэмдгийн ямар нэгэн хослолыг багтаасан онцгойлсон үг байх тэмдгийг бараа, үйлчилгээний тэмдгээр бүртгэнэ. Бараа, үйлчилгээний тэмдэг нь бүртгэлийн хувьд ижил зохицуулалтаар зохицуулагдана". Иймд үйлчилгээний тэмдэг нь аж үйлдвэрийн өмчийн эрх зүйн бие даасан объект болох нь зүйтэй.

2. Дуу авиа, үнэрийг бараа, үйлчилгээний тэмдгээр бүртгэж авах нь нэлээд бэрхшээлтэй байдаг. Дуу авиа, үнэрийг бүртгэхдээ утга агуулга, илэрхийллийг нь бичгийн хэлбэртэй буулгах, үүний дараа тухайн дуу авиаг хуурцаг эсвэл CD дээр буулгах, энэ нь барааны тэмдгийн худалгалт болон бүртгэлийн асуудлыг халбарчилж өгөх юм. Бараа, үйлчилгээний тэмдгийг шинэ эсэхийг тогтооходоо одоо мөрдөж буй барааны тэмдгийн хууль, журамд заасан шалгууруудыг удирдлага болгоно. Өөрөөр хэлбэл, дуу авиа, өнгө үнэр, амт хөдөлгөөнийг бүртгэхдээ шинэ эсэхийг тогтоох нь бусад онцгой дүрсийн илэрхийллийн адил шалгуур тавина гэсэн үг юм. АНУ-д дуу авианы тэмдгийг бүртгэдэг ба ингэхдээ дуу авиаг кассет болон бусад байдлаар бэхжүүлж АНУ-ын патент, барааны тэмдгийн

¹ Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр. 1997 он.

газарт явуулдаг. Мөн зарим улсад үнэрийн тэмдгийг хүлээн зөвшөөрч бүртгэдэг ба ингэхдээ үнэрийг шингээсэн үнэрийг байнга хадгалж чадах зүйлсийг мөн мэдүүлэгтээ хавсаргасан байхыг шаарддаг.

Иймд манай улс дуу авиа, өнгө, үнэр, хөдөлгөөнийг бараа, үйлчилгээний тэмдгээр бүртгэхдээ шинэ эсэхийг тогтоох, ялгагдах онцлогтой эсэхийг шалгах мөн хэрхэн хадгалах, хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна. Жишээлбэл: Нэгэн иргэн Булан аймгийн Сайхан сумын айргийн амтыг газар зүйн заалтаар бүртгүүлье гэж бодоход эрх зүйн орчин нь хангалтгүй байна.

3. Мерчандайз нь оюуны өмчийн эрх зүйгээр зохицуулагдан хамгаалагддаг харьцангуй судлагдаагүй шинэлэг ойлголт юм. АНУ-д 1930 аад оны дунд үеэс Мерчандайзыг үүссэн гэж үздэг. Мерчандайз гэдэг нь худалдаа эрхлэх гэсэн утгатай англи үг бөгөөд энэ үгийг орчин үеийн оюуны өмчийн эрхийн худалдаанд түгээмэл хэрэглэх болсон. Учир нь нэрд гарсан урлаг, спортын одууд, улс төрийн зүтгэлтнүүдийн болон хүүхэдлэйн киноны гол дүрүүдийн зураг, төрхийг бизнесийн зорилгоор ашиглах явдал их болсон явдал юм. Онцлог шинжийн агуулгад олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж ихээр тархсан бие хүн, уран сайхны гол дүрүүдийн хувийн онцлог шинж, төрх байдал чухал юм. Эдгээр шинж байдлуудад жишээлбэл, тэдгээр зөвшөөрөгдсөн тодорхой шинжийн

илэрхийлэл, нэр, гадаад төрх, дуу хоолой зэргийг хамааруулдаг. Манай Барааны тэмдгийн хуульд Мерчандайз нь зохицуулагдаагүй боловч Мерчандайзд багтдаг ойлголтууд зарим талаар тусгагдсан гэж үзэж болно. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 5.3.2-т нэрд гарсан хүний бүтэн ба товчилсон нэр, хөрөг, зураг, гарын үсгийг тухайн хүний буюу түүний өв залгамжлагчын зөвшөөрөлгүйгээр ашигласан бол барааны тэмдгээр бүртгэгж болохоор байна. Өөрөөр хэлбэл, энэ нь Мерчандайз юм. Гэхдээ Мерчандайзд нэр алдартай бодит хүнээс гадна, зохиомол уран сайхны болон хүүхэдлэйн киноны дүр болон түүний онцлог шинжүүд багтдаг. Энэ талаасаа Мерчандайз нь манай үндэсний хууль тогтоомжуудад хараахан тусгагдаагүй байна. Практик амьдрал дээр Мерчандайзийг хэрэглэх асуудал өргөн хүрээнд байна. Тухайлбал, 25 дугаар суваг телевиз Зоро киноны "Z" үсэг бэлэг тэмдгийг, жүжигчин Чапи алдартай хүмүүсийн дуу хоолойг дуурайх гэх мэт.

4. 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай Монгол Улсын хууль хүчин төгөлдөр болж, мөн онд процессийн асуудлыг зохицуулахаар барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн мэдүүлэгт

шүүлт хийх журам батлагдсан. Ийнхүү Монгол Улс барааны тэмдгийн хуультай болж оюуны өмчийн эрхийг хамгаалах эрх зүйн үндэслэл бий болсон ч түүнийг нэгдэн орсон гэрээ хэлэлцээрүүдтэй нийцүүлэх, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдсан. 2003 онд Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай Монгол Улсын хууль батлагдан гарсан. Энэ хууль нь манай улсын нэгдэж орсон олон улсын гэрээ конвенцуудад заагдаад өмнөх хуульд тусгагдаагүй байсан нэлээд зүйлс шинээр тусгагдаж өгсөн. Хэдийгээр шинэлэг заалтууд орсон боловч зохицуулагдаагүй үлдсэн зүйлс нэлээд байна. Оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэхэд зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хил дээрх арга хэмжээ чухал ач холбогдолтой талаар ТРИПС-ийн хялалцээрт заасан байдаг, гэтэл энэ талаарх зохицуулалт манай улсын хууль тогтоомжид байхгүй байна. Энэ нь манай улсын үндэсний цөөхөн хэдэн үйлдвэрүүдийн барааны тэмдэг, шогшготой хуурамч бүтээгдэхүүн зах зээл дээр элбэг борлуулагдах эсвэл, гадаадын нэртэй пүүс, компаниудын барааг хуурамчаар үйлдвэрлэж, тэдний барааны тэмдгийг ашиглан манай зах зээл дээр гаднаас оруулж ирж нийлүүлэх, борлуулах явдал элбэг байгаа нь нотлох бизээ. Тэр ч бүү хэл, зарим барааны тэмдэг, шогшгийг их хэмжээгээр үйлдвэрлэж, хил давуулан оруулж, дамлан худалдаж байна.



Арбитрын тухай хуулиудыг харьцуулан судалсан нь

Монгол Улсад 1990-ээд оноос гадаад худалдаа, эдийн засаг, аж ахуйн харилцаа хурдацтай хөгжих болсонтой уялдаж, уг харилцааны эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага үүссэн. Энэхүү эрх зүйн орчинг бүрдүүлэхэд 1995 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан "Гадаад худалдааны арбитр"-ын тухай хууль чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Эл хуулиар Монгол Улсын нутагт иргэн, хуулийн этгээдийн гадаад эдийн засгийн хэлцэл, эд хөрөнгийн шинжтэй маргааныг гадаад худалдааны арбитраар хянан шийдвэрлэхгэй холбогдсон харилцааг зохицуулж байв. Ингэснээр Монгол Улсын эдийн засгийн гадаад худалдаатай холбоотой маргаан Монголын арбитрт харьяалагдах болсон.

Гэвч гадаад худалдааны



Отгонтэнгэр Их сургуулийн ХЗС-ийн багш М.Сувд

арбитрын журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зөвхөн гадаад эдийн засгийн гэрээ, хэлэлцээрээс үүссэн маргааныг хамруулан шийдвэрлэж

байсан нь хэтэрхий явцуу хүрээг хамарч байсан тул эдийн бус баялагтай холбогдсон маргааныг шийдвэрлэж болдог олон улсын жишигтэй гэр бүр нийцэхгүй хүрвэ. Үүнээс шалтгаалан Гадаад худалдааны арбитрын тухай 1995 оны хуулийн заалт арбитрын талаар гаргасан олон конвенцийн заалтуудтай зөрчилдөж эхэлсэн байна. Энэ нь 2003 онд гадаад худалдааны гэх тодотгол байхгүйгээр Арбитрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар заруулагдсан.

Энэхүү хуулийн онцлогыг нь гадаад худалдааны арбитрын тухай 1995 оны хуулийн зарим заалттай харьцуулан судалж, тайлбарлах аргаар авч үзлээ. Үүнд:

№	Шалгуурууд	1995 оны Гадаад худалдааны арбитрын тухай хууль	2003 оны арбитрын тухай хууль	Тайлбар
1	Хуулийн бүтэц	7 бүлэг, 57 зүйлтэй ба I бүлэгт: Нийтлэг үндэслэл, II бүлэгт: Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн, түүний бүрэн эрх, хэргийн оролцогчид, III бүлэгт: Нотлох баримт, IV бүлэгт: Арбитрын зардал, V бүлэгт: Арбитрын хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх, VI бүлэгт: Арбитрын шийдвэр, түүнийг гаргах, биелүүлэх, VII бүлэгт: Хууль хүчин төгөлдөр болох зэрэг асуудлуудыг зохицуулсан.	8 бүлэг, 43 зүйлтэй ба I бүлэгт: Нийтлэг үндэслэл, II бүлэгт: Арбитрын хэлэлцээр III бүлэгт: Арбитрын бүрэлдэхүүн, түүнийг бүрдүүлэх журам, IV бүлэгт: Арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээ, V бүлэгт: Арбитрын ажиллагаа, VI бүлэгт: Арбитрын шийдвэр гаргах, арбитрын ажиллагаа дуусгавар болох, VII бүлэгт: Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлт гаргах, VIII бүлэгт: Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх зэрэг асуудлуудыг зохицуулсан.	1995 оны гадаад худалдааны арбитрын хуулиар нотлох баримт, арбитрын зардлын асуудлыг бие даасан бүлэг болгож, арбитрын бүрэлдэхүүн, түүний бүрэн эрх, арбитрийг солих, бүрэн эрх дуусгавар болох зэрэг асуудлыг нийтлэг байдлаар зохицуулж байсан бол 2003 оны арбитрын хуулиар арбитрын хэлэлцээр, арбитрын бүрэлдэхүүнийг нарийвчилсан зохицуулалттай болгосон ба арбитрын шийдвэр гаргах, арбитрын ажиллагаа дуусгавар болох, түүнийг хүчингүй болгох, хүлээн зөвшөөрч гүйцэтгэх гэх мэт асуудлыг нэлээд өргөн хүрээнд авч үзлээ.

2	Хуулийн зорилт	Иргэн хуулийн этгээдийн гадаад эдийн засгийн хэлцэл, эд хөрөнгийн шинжтэй харилцаанаас үүссэн маргааныг арбитрын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах.	Эрхзүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаанд арбитрын ажиллагаа явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулах.	Гадаад худалдааны арбитрын хуулиар арбитраар зөвхөн гадаад худалдааны гэрээ, хэлэлцээрээс үүссэн эд хөрөнгийн шинжтэй маргааныг шийдвэрлэж байсан бол 2003 оны арбитрын хуулиар арбитрын хэлэлцээр бүхий эд хөрөнгийн төдийгүй эд хөрөнгийн бус маргааныг арбитр хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй болсноороо онцлогтой.
3	Арбитрын статус	3.1. Гадаад худалдааны арбитр нь тус хуульд заасан маргааныг арбитрын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх үйл ажиллагааг эрхлэн явуулах бүрэн эрх бүхий төрийн бус, ашгийн төлөө бус хуулийн этгээд.	5.1. Арбитр нь байнгын болон түр хэлбэртэй байна. 4.1.1. "байнгын арбитр" гэж арбитрын ажиллагааг байнга эрхлэн явуулах зорилгоор байгуулсан арбитрыг хэлнэ. 4.1.2. "түр арбитр" гэж талууд тодорхой маргааныг шийдвэрлүүлэх зорилгоор нэг удаа байгуулсан арбитрыг хэлнэ.	Олон улсын практикт: -Байнгын, Түр /Ad hoc/ арбитр үйл ажиллагаагаа явуулдаг бусад олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор дээр дурдсан арбитрын хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрчээ. 2003 оны арбитрын тухай хуульд түр арбитрын институт бол маргалдагч талууд өөрсдөө сонгон тохиролцох замаар маргаант асуудлыг шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
4	Арбитрын хэлэлцээр	5.1. Гэрээт харилцаанаас үүсэх маргааныг арбитраар шийдвэрлүүлэх талаар талууд харилцан тохиролцож гэрээнд заах буюу бие даасан хэлэлцээр байгуулна. 5.2. Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээрт маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай заасан бол уг хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээний хувьд арбитрын тухай хэлэлцээр байгуулагдсанд тооцно.	11.1. Арбитрын хэлэлцээр гэж (гэрээний шинж, хэлбэр агуулсан эсэхээс үл хамааран) аль нэг эрх зүйн харилцаатай холбогдон үүссэн буюу үүсч болох бүх төрлийн, эсхүл тодорхой төрлийн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх талаар талуудын хооронд хийсэн тодорхой төрлийн хэлцлийг хэлнэ. 11.2. Арбитрын хэлэлцээрийг бичгийн хэлбэрээр хийх ба талууд уг хэлэлцээрийг маргаан гарахаас өмнө болон гарснаас хойш хэдийд ч хийж болно. Гэхдээ Иргэний хуульд заасан стандарт нөхцөл бүхий гэрээний тухайд арбитрын хэлэлцээрийг гагцхүү маргаан үүссэний дараа хийнэ. 11.3. Талуудын гарын үсгээр баталгаажсан бие даасан арбитрын хэлэлцээр (гэрээний шинж, хэлбэр бүхий) болон арбитрын хэлэлцээр хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс, эдгээртэй адилтгах бусад баримт бичиг арбитрын хэлэлцээрт хамаарна. 11.5. Талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээ хүчин төгөлдөр эсэхээс үл хамааран түүний салшгүй хэсэг болох арбитрын хэлэлцээр хүчинтэй байна.	Монгол Улсын Иргэний хуульд заасан стандарт нөхцөл бүхий гэрээний хувьд маргаан үүссэний дараа арбитрын хэлэлцээр байгуулж болох тухай асуудлыг тусгайлан зааж өгсөн ба мөн арбитрын нэмэлт тайлбар /arbitration clause/ талуудын хооронд байгуулсан гэрээний хүчинтэй эсэхээс үл хамааран хууль зүйн бие даасан хүчин чадалтай болохыг хуульчлан баталгаажуулжээ. Тэрчлэн арбитрын хэлэлцээрт чухам ямар хэлцлүүд орж болохыг уг хуульд дэлгэрэнгүй тусгасан нь /арбитрын хэлэлцээр хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс, эдгээртэй адилтгах бусад баримт бичиг арбитрын хэлэлцээрт хамаарна/ хууль зүйн чухал ач холбогдолтой байна.

5	Арбитрын харьяаллын маргаан	<p>6.1.Нэг талаас Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, нөгөө талаас гадаад улсын иргэн, хуулийн этгээдийн хооронд гадаад эдийн засгийн гэрээ, хэлцлээс үүссэн болон мөнхүү гэрээний өмнөх маргаан;</p> <p>6.2. Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дотоодын болон гадаадын үүсгэн байгуулагчдын хооронд үүссэн маргаан;</p> <p>6.3.Гадаадын хуулийн этгээдийн хоорондын маргаан.</p>	<p>6.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2-т заасны дагуу талууд арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргаан арбитрын харьяалалд хамаарна.</p>	<p>Гадаад худалдааны арбитрын тухай хуулиар маргаанаа шийдвэрлүүлэхээр хандах субъектийн хувьд хязгаарлагдмал байсан бол 2003 оны арбитрын хуулиар арбитраар хандах субъект илүү өргөн хүрээг хамрах болсон. Өөрөөр хэлбэл субъектүүд нь заавал олон улсын хувийн эрхзүйн харилцаанд оролцогчид байхыг тус хуульд хязгаарлаагүй. Энэ нь талууд арбитраар хэлэлцээрт хамаарах журмаар маргаанаа арбитраар шийдвэрлүүлэх өргөн бололцоог олгосноороо чухал юм.</p>
6	Хэрэг хэлэлцэх хугацаа	<p>14.1.Хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрээр тусгай хугацаа тогтоогоогүй бол арбитрын хэргийг нэхэмжлэл хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор хянан хэлэлцэнэ.</p>		<p>Гадаад худалдааны арбитрын хуульд хэрэг хянан хэлэлцэх хугацааг 60 хоногийн дотор байна гэж шууд тусгаж өгсөн бол 2003 оны арбитрын хуульд зааж өгөөгүй бөгөөд түүнийг арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмээр зохицуулдаг байна.</p>
7	Хэрэг хэлэлцэх газар	<p>15.1. Хэргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэлэлцэн шийдвэрлэнэ.</p> <p>15.2. Талууд тохиролцон хүсэлт гаргавал өөр улсын нутаг дэвсгэрт хэргийг хэлэлцэхээр хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн шийдвэрлэж болно.</p>	<p>24.1. Арбитрын ажиллагаа явуулах газрыг талууд харилцан тохиролцоно.</p> <p>24.2. Арбитрын ажиллагаа явуулах газрыг талууд харилцан тохиролцоогүй бол маргааны нөхцөл байдлыг харгалзан арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагаа явуулах газраа тодорхойлно.</p> <p>24.3. Талууд өөрөөр тохиролцоогүй бол шаардлагатай тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөх, гэрч, шинжээч, талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг шалгалт хийх зэрэг ажиллагааг арбитрын ажиллагаа явуулах газраас өөр газар явуулж болно.</p>	<p>Гадаад худалдааны арбитрын хуулиар Монгол улсын нутаг дэвсгэр дээр хэргийн хянан хэлэлцэх, хэрэв талууд тохиролцоод өөр улсын нутаг дэвсгэрт хэргээ шийдвэрлүүлэхийг хүсвэл тэдний хүсэлтийг биелүүлэх эсвэл биелүүлэхгүй байх эрх нь хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүний шийдвэрээр тодорхойлогдон шийдвэрлэгдэх зохицуулалттай байв.</p>

8	Арбитрын өмнө талууд тэгш байх	11.Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг иргэдийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, улсын харьяалал болон бусад байдал, аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр, эрх хэмжээ, гишүүний байдал, улсын харьяаллаар нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явуулна	22.1. Талууд арбитрын ажиллагаанд тэгш эрхтэй оролцох ба нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, мэдүүлэг, холбогдох бусад нотлох баримтын талаар тайлбар хийх боломжоор бүрэн хангагдсан байна.	Гадаад худалдааны арбитрын тухай хуулиар Монгол улсын Үндсэн хуульд заасан үл ялгаварлан гадуурхах зарчмыг удирдлага болгон зохицуулсан бол 2003 оны арбитрын хуулиар энэ тухай асуудлыг хуулийн 22-т зааж өгсөн байна.
9	Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх хэм хэмжээ	8.1. Арбитр хэргийг хянан шийдвэрлэхдээ талуудын тохиролцон сонгож авсан улсын хууль тогтоомж буюу олон улсын гэрээ, хэрэв талууд энэ талаар тохиролцоогүй бол аль нэг талын харьяалагдах улсын хууль тогтоомж буюу олон улсын гэрээг баримтална. 8.2. Арбитр ямар ч хэргийг шийдвэрлэхдээ талуудын хооронд байгуулсан гэрээ, тухайн хэлцлийн талаар тогтсон заншлын хэм хэмжээг нэгэн адил баримтална.	34.1. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрхзүйн хэм хэмжээг талууд харилцан тохиролцоо бөгөөд арбитрын бүрэлдэхүүн тэдгээрийн тохиролцсон эрхзүйн хэм хэмжээг хэрэглэн уг маргааныг шийдвэрлэнэ. 34.2. Арбитрын бүрэлдэхүүн талуудын тохиролцсон эрхзүйн хэм хэмжээг хэрэглэхдээ уг тохиролцоонд тусгайлан заагаагүй бол түүнийг тухайн улсын материаллаг эрхзүйн хэм хэмжээ гэж ойлгож хэрэглэнэ. 34.3. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрхзүйн хэм хэмжээг талууд харилцан тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн тухайн маргааныг шийдвэрлэхэд аль тохиромжтой гэж үзсэн зохих материаллаг эрхзүйн хэм хэмжээг хэрэглэнэ. 34.4. Арбитрын бүрэлдэхүүн аливаа маргааныг шийдвэрлэхдээ талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээ болон тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан үзнэ.	Маргаан шийдвэрлэхэд баримтлах хэм хэмжээний хувьд зарчмын ялгаатай зохицуулалт байхгүй.
10	Хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн	16.1.Талууд нэг арбитрчаар шийдвэрлүүлэхээр тохиролцоогүй бол гурван арбитрчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянан шийдвэрлэнэ.	14.1. Арбитрын бүрэлдэхүүн нэг буюу хэд хэдэн арбитрчаас бүрдэж болно. 14.2 Тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулах арбитрчийн тоог талууд харилцан тохиролцоно. 14.3.Хэрэв талууд арбитрчийн тоог харилцан тохиролцоогүй бол тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулах арбитрчийн тоо гурав байна.	Гадаад худалдааны арбитрын хуулиар арбитрын бүрэлдэхүүний хувьд тухайн маргааныг шийдвэрлэх арбитрчийн тоо 1, эсвэл 3 байсан бол арбитрын хуулиар 3-аас илүү тооны арбитр тухайн маргааныг шийдвэрлэж болох магадлалтай болов.

11	Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүнийг томилж	<p>16.2. Хэргийг гурван арбитрч шийдвэрлэх бол тал тус бүр нэг арбитрч томилж, томилогдсон хоёр арбитрч хурагдаан даргалах гуравдахь арбитрчийг томилно.</p> <p>16.3. Хэрэв аль нэг тал арбитраас мэдэгдэл авснаас хойш 14 хоногийн дотор арбитрчийг томилоогүй буюу томилогдсон хоёр арбитрч тогтоосон хугацаанд гуравдахь арбитрчийг томилоогүй бол түүнийг арбитрын дарга томилно.</p> <p>16.4. Хэргийг нэг арбитрчаар шийдвэрлүүлэхээр тохиролцсон боловч талууд түүнийг томилж чадаагүй бол арбитрын дарга томилно.</p>	<p>15.1. Энэ хуульд заасан эрх бүхий этгээд хуулиар хориглосноос бусад хэнийг ч арбитрчаар томилж болно.</p> <p>15.5. Аль нэг тал нь арбитрч томилох тухай нөгөө талын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрчийг томилоогүй, эсхүл томилогдсон хоёр арбитрч 30 хоногийн дотор гурав дахь арбитрчийг тохиролцон томилж чадаагүй бол сонирхогч талын хүсэлтээр давж заалдах шатны шүүх тэдгээрийг томилно.</p> <p>15.6. Талууд тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулах арбитрчийн тоо нэг байхаар тогтоосон бол уг арбитрчийг харилцан тохиролцож томилж ба ийнхүү тохиролцож чадаагүй бол сонирхогч талын хүсэлтээр давж заалдах шатны шүүх түүнийг томилно.</p>	<p>Гадаад худалдааны арбитрын хуулиар өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэний арбитрын бүрэлдэхүүнд томилохгүй зохицуулалттай байсан бол 2003 оны арбитрын хуулиар Үндсэн хуулийн Цэцийн гишүүн, шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шийдвэр гүйцэтгэгч, тухайн маргаанаар талуудын аль нэгэнд урьд нь эрх зүйн үйлчилгээ үзүүлж байсан өмгөөлөгч, нотариатч, хуулиар тогтоосон үүрэгт нь хамаарахгүй ажил, албан тушаал хавсрахыг хориглосон бусад албан тушаалтныг арбитрчаар томилохыг хориглосон ба давж заалдах шатны шүүхээс хэргийг шийдвэрлэх арбитрчийг томилох тухай шинэлэг зохицуулалттай болов.</p>
12	Арбитрын шийдвэр	<p>51.1. Арбитраас хэрэг хянан хэлэлцээд шийдвэр гаргана.</p> <p>51.2. Арбитрын шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх хүчинтэй байна.</p> <p>51.3. Арбитрын шийдвэр нь хэрэгт байгаа болон хуралдаан дээр хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гарсан, хууль ёсны үндэслэл бүхий байна.</p> <p>51.4. Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн арбитрын шийдвэрийг олонхийн саналаар бичгээр гаргаж, гарын үсгээ зурна.</p>	<p>35.1. Арбитрын бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэрийг тухайн арбитрын шийдвэр гэж үзэх ба талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн шийдвэрээ олонхийн саналаар гаргана.</p> <p>35.2. Арбитрын бүрэлдэхүүн санал нэгтэй зөвшөөрсөн бол арбитрын ажиллагааны явцад гарах горимын шинжтэй асуудлыг арбитрын хуралдаан даргалагч дангаараа шийдэж болно.</p>	<p>Гадаад худалдааны арбитрын хуулиар арбитрын бүрэлдэхүүний гаргасан шийдвэр эцсийнх байх тухай зохицуулж өгсөн байсан бол 2003 оны хуулиар энэ тухай шууд заагаагүй байна.</p>

13	Арбитрын шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах	<p>53.1. Шийдвэр гарсан өдрөөс хойш 60 хоногийн дотор арбитр өөрийн санаачилгаар буюу талуудын хүсэлтээр дараахь тохиолдолд нэмэлт шийдвэр гаргаж болно:</p> <p>1.Нэхэмжлэлийн ямар нэг шаардлагын талаар шийдвэр гаргалгүй орхигдуулсан;</p> <p>2.Нэхэмжлэгчийн шаардаж авах мөнгө, эд хөрөнгийн хэмжээ буюу хариуцагч нь ямар ажиллагаа гүйцэтгэхийг заагаагүй;</p> <p>3. Арбитрын зардлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлүүлээгүй;</p> <p>4.Шийдвэрийг тайлбарлах болон тооцооны алдааг залруулах шаардлагатай;</p> <p>5.Хэргийн оролцогчид эрхийн чадамжгүй болох нь илэрсэн;</p> <p>6.Энэ хуульд заасан харьяаллын бус маргаан шийдвэрлэсэн.</p> <p>4.Арбитр шаардлагатай бол нэмэлт шийдвэр гаргах хугацааг сунгаж болно.</p>	<p>39.1. Талууд өөр хугацаа тогтоогоогүй бол арбитрын шийдвэрийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор үг үсэг, тооцоо, хэвлэлийн болон тэдгээртэй адилтгах бусад алдааг засуулах тухай хүсэлтийг аль нэг тал гаргаж болох бөгөөд энэ тухайгаа нөгөө талдаа заавал мэдэгдэнэ.</p> <p>39.2. Энэ хуульд зааснаас өөр үндэслэлээр арбитрын шийдвэрт засвар оруулах хүсэлт гаргаж болохгүй бөгөөд тийм хүсэлт гаргасан бол арбитрын бүрэлдэхүүн болон шүүх авч хэлэлцэхгүй.</p> <p>39.3.Талууд өөр хугацаа тогтоогоогүй бол арбитрын шийдвэрийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор түүний тодорхой заалт, хэсгийг тайлбарлуулах тухай хүсэлтийг аль нэг тал арбитрын бүрэлдэхүүнд гаргаж болох бөгөөд энэ тухайгаа нөгөө талдаа заавал мэдэгдэнэ.</p> <p>39.5. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 39.1-д заасан алдааг шийдвэр гаргаснаас хойш 30 хоногийн дотор өөрийн санаачилгаар засч болно.</p>	<p>1995 оны Гадаад худалдааны арбитрын хуулиар арбитрын шийдвэрт нэмэлт шийдвэр гаргах тохиолдуудыг хуульчилсан бол 2003 оны арбитрын тухай хуулиар арбитрын шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах үндэслэлүүдийг өмнөх зохицуулалтаас өргөтгөсөн байдлаар зохицуулжээ. Эл асуудлыг хуулийн 39 дүгээр зүйлд заажээ.</p>
14	Арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болох ба түүнийг хүчингүй болгох	<p>1. Арбитрын шийдвэр нь гарсан өдрөөс хүчин төгөлдөр болно.</p> <p>2. Арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа хэргийн оролцогчид буюу тэдгээрийн эрх залгамжлагчид арбитраар нэгэнт шийдвэрлэсэн нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээр арбитрт болон шүүхэд дахин нэхэмжлэл гаргахгүй.</p>	<p>40.2. Давж заалдах шатны шүүх арбитрын шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй.</p>	<p>Гадаад худалдааны арбитрын тухай хуулиар арбитрын шийдвэр эцсийнх байхыг л тусгаснаас давж заалдах шатны шүүхээр үг шийдвэрийг хүчингүй болгох асуудал байгаагүй. Харин 2003 оны арбитрын тухай хуулиар энэ тухай зохицуулалтыг нэлээд дэлгэрэнгүй оруулсныг хуулийн 40 дүгээр зүйлээс танилцна уу!</p>

15	Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх	<p>1. Талууд арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй.</p> <p>2. Талууд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгүүлэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд хүсэлт гаргана. Уг хүсэлтэд арбитрын шийдвэр болон арбитрын тухай гэрээ, хэлэлцээрийн эх буюу түүний зохих ёсоор гэрчилсэн хуулбарыг хавсаргана.</p> <p>3. Арбитрын шийдвэрийг Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арванзургадугаар бүлэгт заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлнэ.</p> <p>4. Арбитрын шийдвэрийг гадаад улсад биелүүлэх тухай асуудлыг олон улсын гэрээ, конвенцид зааснаар зохицуулна.</p>	<p>42.1. Арбитрын шийдвэрийг холбогдох тал заавал биелүүлэх үүрэгтэй.</p> <p>42.2. Арбитрын шийдвэрийг холбогдох тал биелүүлээгүй бол нөгөө тал нь уг шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллаганы журмаар гүйцэтгүүлэхээр давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргаж болно.</p> <p>42.3. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 42.2-т заасан хүсэлтийг шүүхэд гаргах хөөн хэлэлцэх хугацаа тухайн арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил байна.</p> <p>42.4. Гадаадын арбитрын шийдвэрийг Монгол Улсад гүйцэтгүүлэх тухай шүүхэд хүсэлт гаргах хугацаа энэ хуулийн 42.3-д заасантай адил байна.</p>	Бидний харьцуулан буй хуулиудад арбитрын хүчин төгөлдөр шийдвэрийг заавал биелүүлэх талаархи зохицуулалт нь ижил, хэн боловч 2003 оны хуулиар арбитрын шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд зохих этгээд давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргах бололцоог буй болгосон.
16	Арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэхээс татгалзах		<p>43.1. Давж заалдах шатны шүүх зөвхөн дор дурдсан тохиолдолд арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх хуудас бичихээс татгалзах эрхтэй:</p> <p>43.1.1. энэ хуулийн 40.2-т заасан нөхцөл байдал тогтоогдсон;</p> <p>43.1.2. арбитрын шийдвэр талуудын хувьд хүчин төгөлдөр болоогүй байгаа буюу арбитрын шийдвэр гаргасан улсын шүүх тухайн шийдвэрийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон.</p>	1995 оны гадаад худалдааны арбитрын хуулиар арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэхээс татгалзах тухай зохицуулалт байхгүй байсан бол 2003 оны арбитрын хуулийн 43 дугаар зүйлд давж заалдах шатны шүүхээс арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх хуудас бичихээс татгалзах эрхтэй байна.

Дүгнэлт

1. Арбитрын тухай 2003 оны хуулиар арбитр нь эрх зүйн этгээдүүд хоорондын эдийн болон эдийн бус баялагтай холбоотой иргэний эрх зүйн маргааныг талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр арбитрын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага болохыг хуульчлав. Энэ нь практикийн чухал ач холбогдолтой хэм хэмжээ мөн.

2. Арбитрыг байгуулах үндсэн 2 хэлбэрийг (байнгын, түр) олон улсын практикт нийцүүлэн хуульчилсан тул талууд тухайн маргаанаа шийдвэрлүүлэх зорилгоор хуульд нийцүүлэн, түр арбитрыг байгуулж болох нөхцөлийг бүрдүүлэв.

3. Арбитрын журмаар маргаанаа шийдвэрлүүлэхээр хандаж буй субъектүүдийн хувьд илүү өргөн хүрээг хамрах, өөрөөр хэлбэл, зөвхөн олон улсын хувийн эрх зүйн субъектүүд төдийгүй үндэсний эрх зүйн субъектүүд хоорондын иргэний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх шинэ зохицуулалт бий болсон.

4. Арбитрын хэлэлцээрийн тухай ойлголтыг илүү өргөн хүрээнд авч үзэж, энэхүү хэлэлцээрт хамарч болох хэлцлүүдийг нарийвчлан тусгасан нь талуудын тохиролцоонд хүрч чадахгүй байгаа маргаантай асуудлыг маргааны өмнө ба дараа арбитрын хэлэлцээр хийж зохицуулах ач холбогдолтой. Энэ тухай зохицуулалт нь "талуудын гарын үсгээр баталгаажсан бие даасан арбитрын хэлэлцээр (гэрээний шинж, хэлбэр бүхий) болон арбитрын хэлэлцээр хийх тухай саналыг зөвшөөрсөн талын

хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс, эдгээртэй адилтгах бусад баримт бичиг арбитрын хэлэлцээрт хамаарна" гэсэн заалтуудаар хэрэгжиж байна.

5. Арбитрын тухай 2003 оны хуулиар арбитрын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний хувьд тухайн маргааныг шийдвэрлүүлэх арбитрчаа талууд харилцан тохиролцож томилдог систем нь 1995 оны гадаад худалдааны арбитрын хуультай ижил зохицуулалттай хэдий ч хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний тооны хувьд 3 арбитрчаас илүү тооны арбитрч тухайн маргааныг шийдвэрлэх боломж нь бий болсон. Арбитрын тухай 2003 оны хуулиар "Арбитрын бүрэлдэхүүн нэг буюу хэд хэдэн арбитрчаас бүрдэж болно гэж заасан нь тухайн маргааныг хэдэн ч арбитрч шийдвэрлэж болох магадлалтай болов. Ийнхүү арбитрын бүрэлдэхүүнийг бий болгохтой уялдуулан тус хуулиудаар талуудад арбитрчаа томилох эрхийг олгосон хэдий ч хэрэв талуудын хүсэлтээр арбитрчийн нэрсийн жагсаалтаас арбитрчийн нэр цохон гаргаж буй тохиолдолд арбитрчийг сонгох, харин талууд сонгох буюу тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд арбитрчийг томилох гэсэн ялгаатай зохицуулалт үйлчлэх болов.

6. Арбитрын тухай 2003 оны хуулиар арбитрчыг томилох асуудлаар сонирхогч тал давж заалдах шатны шүүхэд хандаж болох тухай шинэ зохицуулалт бий болсон. Давж заалдах шатны шүүх арбитрчийг томилохдоо тухайн

этгээд арбитрын хуульд заасны дагуу арбитрчаар томилогдох боломжтой, маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэх чадвартай, талууд тохиролцсон гэх мэт шалгуурыг үндэслэл болгоно.

7. Арбитрын тухай 2003 оны хуулиар шаардлагатай гэж үзвэл аль нэг талын хүсэлтийг үндэслэн арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор зохих арга хэмжээ авахыг талуудад үүрэг болгож болохыг хуульчилжээ.

8. Гадаад эдийн засгийн гэрээ, хэлэлцээр төдийгүй Монгол Улсын дотоодод хэрэгжиж гэрээ, хэлэлцээртэй холбоотой маргаан, талуудын үл зохицох асуудлыг арбитрч хянан шийдвэрлэдэг болсон нь арбитрын тухай 2003 оны хуулийн онцлог болно. 2003 оны энэ хууль үйлчлэх болсон үеэс Монгол Улсад орон нутгийн арбитрууд ажиллаж түншлэгчид гэрээ, хэлэлцээртээ маргаанаа арбитрээр шийдвэрлүүлэх тухай заасныг үндэслэн арбитрч маргааныг хянан зохицуулах болжээ. Өөрөөр хэлбэл, 2003 оноос эхлэн Монгол Улсад арбитрын үйл ажиллагаа өргөссөн, гадаад, дотоодын түншлэгчид хоорондын маргааныг хянан шийдвэрлэх болов.

Өмнө дурдсанаас үзэхэд, 2003 оны арбитрын тухай Монгол Улсын хууль нь 1995 оны Гадаад худалдааны Арбитрын тухай хуулийн зохицуулалтыг өргөтгөн боловсронгуй болгосноор Монгол Улс дахь арбитр, түүний үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлжээ гэж үзэж болох юм.



Интернетээр гэрээ байгуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал

Монгол Улс 1992 оноос дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэхийг зорилго болгон улмаар эдийн засгийн харилцааг чөлөөт хэлбэрт оруулснаар иргэд, аж ахуй эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх цоо шинэ бизнесийн гарцыг эрэлхийлэх болсон. Эдүгээ дэлхийн эдийн засгийн харилцаа улам бүр даяарчлагдаж байгаа нь мэдээллийн шинэ гарц интернетийн сүлжээний ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд гэрээ, хэлцэл байгуулахад электрон шуудан, электрон мэдээлэл, телефакс, интернетийн сүлжээг өргөн хэрэглэх болсон нь орчин үеийн мэдээллийн гол шугам болох интернетийн ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Учир нь ихэнхи бизнес эрхлэгч өөрсдийн ашиг, орлого, үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний тоог зөвхөн интернетийн тусламжтайгаар, хамгийн бага зардлаар нэмэгдүүлж байна. "Forester Research" технологийн судалгааны хүрээлэнгээс гаргасан судалгаагаар 2003 онд дэлхийн хэмжээнд 3,2 триллион ам.долларын худалдаа интернетээр дамжин хийгдсэн нь 2000 оны дэлхийн худалдааны нийт орлогын 5 хувьтай тэнцсэн байна.¹ Түүнчлэн АНУ-ын холбооны худалдааны комиссоос хийсэн судалгаагаар Convisint.com веб сайтаар дэлхийн нийт авто машины худалдааны 63 гаруй хувь нь хийгддэг байна. Монгол Улсын



"Отгонтэнгэр" Их сургуулийн
ХЗС-ийн багш Р.Очирбал

Засгийн газраас баталсан Электрон Монгол Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаагаар Монгол Улсад электрон худалдааг нэвтрүүлснээр 2012 он гэхэд бизнесийн салбарын /B2B/ зах зээлийг 10 дахин, бизнес эрхлэгч - хэрэглэгчдийн хоорондын /B2C/ зах зээлийг 20 дахин нэмэгдүүлэх урьдчилсан тооцоо гарчээ.

Интернетээр гэрээ байгуулах гэж юу вэ?

Интернетээр гэрээ байгуулах нь гэрээний бие даасан төрөл, хэлбэр бус харин гэрээ байгуулах, хэлцэл хийх өрдийн хэрэгсэл юм. ОХУ-ын эрдэмтэн С.В.Васильев "Электрон худалдаа гэдэг бол гэрээний шинэ төрөл бус, харин уламжлалт үүргийг хэлбэржүүлсэн, сайжруулсан орчин үеийн арга юм" хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.

Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1-д "Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй", мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2-т "Хэлцэл хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс, эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал нь хүлээн авсан" тохиолдолд хэлцлийг бичгээр хийсэн гэж үзж, 196 дугаар зүйлийн 196.1.2-т "гэрээг бичгээр байгуулахаар хуульд заасан буюу талууд тохиролцсон бол талууд нэг баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурах буюу гэрээний саналыг зөвшөөрснөө илэрхийлсэн тал гарын үсэг зуран захидал албан бичиг, телефакс эдгээртэй адилтгах баримт бичгийг нөгөө тал хүлээн авснаар" гэрээ байгуулсанд тооцохоор заасан нь интернетээр гэрээ байгуулж болох агуулгыг илэрхийлсэн боловч интернетээр гэрээ байгуулахад гэрээ байгуулсанд тооцох, гэрээний хэлбэр, гэрээ байгуулагдсан газар, цаг хугацааг тодорхойлох асуудал судлаачдын анхаарлыг татсаар байна.

Дээрхээс үзвэл интернетээр гэрээ байгуулах гэдэг нь "Интернетийн сүлжээг ашиглан электрон баримт бичиг солилцох замаар бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, худалдан авах, тээвэрлэх зэрэг эдийн засгийн болон бусад зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн ирээний эрх зүйн харилцаанд оролцогчдын үйлдлийг хэлн". Өөрөөр хэлбэл, электрон баримт хэлбэрээр иргэний

¹ Орчин үеийн эдийн засаг, нийгмийн харилцаанд электрон харилцаа холбооны хэрэгсэл интернетийн сүлжээг ашигласнаар электрон худалдаанаас олох ашиг орлого дэлхийн хэмжээнд өсч байгааг судалгааны байгууллагын тоо баримтаас харж болно. Forester Research компанийн судалгаагаар Интернетийн зах зээлийн гүйцэтгэл нь 2001 онд 550 сая ам доллар хүрсэн нь 2000 онтой харьцуулахад 92 хувиар өссөн бол 2002 онд энэ хэмжээ 1 триллион ам долларт хүрсэн байна. Вадим Дрыганов "Основные аспекты правового регулирования электронной коммерции в Беларуси и за рубежом" <http://www.russianlaw.net/law/doc/a201.doc>

² Закон Республики Молдова об электронной торговле, ст.4, N 248-XY, 22.07.2004;

эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж дуусгаавар болгоход чиглэгдсэн эрх зүйн харилцаанд оролцогчдын үйлдлийг хэлнэ.²

Харин Монгол Улсын Электрон хэлцлийн тухай хуулийн төсөлд тодорхойлсноор электрон хэлцэл гэдэг нь "Нэг тал хүсэл зоригоо илэрхийлэх, нөгөө тал хүсэл зоригийн илэрхийллийг хүлээн авах ажиллагааг электрон баримт бичгийн хэлбэрээр илгээж, хүлээн авч байгаа иргэд, хуулийн этгээдийн үйлдлийг хэлнэ" хэмээн тодорхойлсон байна. Энэ тодорхойлолтоос үзэхэд иргэний талууд хүсэл зоригоо илэрхийлэх, хүлээн авах ажиллагааг заавал электрон хэлбэрээр үйлдсэн байхыг шаардаж байна. Гэтэл гэрээний нэг тал гэрээ байгуулах хүсэл зоригоо уламжлалт хэлбэрээр гаргаж, хүсэл зоригийг хүлээн авагч тал хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа электрон хэлбэрээр хариу өгч болно. Энэ тохиолдолд гэрээний санал нь off-line хэлбэрээр, саналын хариу нь on-line хэлбэрээр хэлбэржсэн боловч гэрээ электрон хэлбэрээр байгуулагдсан гэх бүрэн үндэслэлтэй юм. Иргэний эрх зүйн үндэс гэрээ байгуулах эрх этгээдээс гэрээ байгуулах тухай саналын хариуг хүсэл зоригоо илэрхийлж талд илэрхийлсэн эсэх нь гэрээ байгуулсанд тооцох гол хууль зүйн факт болдог.

Хэрэв гэрээний нэг тал гэрээ байгуулах тухай саналаа электрон хэлбэрээр бусдад илгээсэн, гэрээний нөгөө тал гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн тухайгаа уламжлалт хэлбэрээр илэрхийлсэн тохиолдолд уг гэрээг интернетээр байгуулсан гэж үзэх үндэслэлгүй юм. Нэгэн жишээ авъя. "А" интернетээр худалдаа явуулдаг нэгэн дэлгүүрээс сүүлийн үеийн компьютер худалдаж авахыг хүссэн. Тэрээр барааны санал болгосон үнийг хүлээн зөвшөөрч болон мөнгө төлөн дэлгүүрээс нь худалдан авсан. Энэ тохиолдолд уг гэрээ нь Иргэний хуулийн 196 дугаар зүйлд зааснаар интернетээр байгуулагдаагүй. Харин тэрээр интернетэд байршуулсан гэрээний нөхцөлүүдийг хүлээн

зөвшөөрч төлбөрийн цахим карт / Credit card/, эсхүл Электрон дансаар төлбөрийг төлсөн бол уг гэрээг интернетээр байгуулагдсан гэж үзнэ. Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.1.1-д Эд хөрөнгө шилжүүлснээр гэрээ байгуулахаар хуульд заасан бол гэрээний гол нөхцөлийн талаар талууд тохиролцож, тухайн эд хөрөнгийг шилжүүлснээр гэрээ байгуулагдсанд тооцохоор заасан. Энэ тохиолдолд төлбөрийг электрон хэлбэрээр илгээж байгаа нь гэрээний саналыг хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулагдсанд тооцох үндэслэл болно.

Иймээс электрон хэлцлийн тухай хуулийн төслийн тодорхойлолтыг дахин эргэн харж, ямар тохиолдолд уг гэрээ электрон хэлбэрээр байгуулсан гэж үзэхийг онолын үндэслэлтэй тодорхойлох нь зүйтэй.

Иргэний эрх зүйн гэрээний эрх зүйн институтэд гэрээ байгуулах үе шатны тухай асуудал чухал ач холбогдолтой. Гэрээ байгуулсанд тооцох урьдчилсан нөхцөлүүд нь гэрээ байгуулагч талууд харилцан бие биедээ хандсан хүсэл зоригийн илэрхийлэл, мөн тэдний илэрхийлсэн хүсэл зоригийн илэрхийлэл нь хоорондоо харилцан холбоотой байх явдлаар илэрнэ. Гэрээний нэг тал гэрээ байгуулах саналаа өгснөөр, нөгөө тал үүнийг өөрчлөлгүйгээр хүлээн зөвшөөрснөөр тухайн гэрээ байгуулагдсанд тооцогддог. Интернетээр гэрээ байгуулахад гэрээ байгуулах санал, саналын дуудлага, саналын хариуг электрон хэлбэрээр үйлдэж болох бөгөөд 1996 оны НҮБ-ын Ерөнхий ассамблейн 51/162 дугаар тогтоолоор батлагдсан "Электрон худалдааны жишиг хууль"-ийн 11 дүгээр зүйлд зааснаар "Гэрээний талууд өөрөөр тохиролцоогүй бол гэрээний санал, саналын хариуг интернетийн мэдээллийн сүлжээний тусламжтайгаар илгээж болох бөгөөд гэрээний үйлчлэл, нэхэмжлэлийн хууль зүйн хүчин чадлын хувьд дутмаг байж үл болно". ОХУ-ын Электрон худалдааны тухай хуулийн 5 дугаар зүйлд хувь хүн,

хуулийн этгээд нь өөрийн хүсэл сонирхлооо илэрхийлэн электрон худалдааны салбарт эрх, үүрэг хэрэгжүүлж болохоор заасан нь түүний хууль зүйн хүчин чадлыг хүлээн зөвшөөрсөн жишиг болно.

Интернетээр гэрээ байгуулах үед гэрээ байгуулах санал буюу оферт нь уламжлалт гэрээний саналаас хэд хэдэн өвөрмөц ялгаатай бөгөөд уг оферт гэрээ байгуулах нөхцөлтэй холбоотойгоор:

- Электрон мэдээлэл ашиглан гэрээ байгуулах журам;
- Электрон аргын усгэ ашиглах журам;
- Акцелтыг хэрхэн илгээх журам;
- Төлбөрийг хэрхэн гүйцэтгэх зэрэг

электрон гэрээний нөхцөлүүдийг тусгадаг. Дээрх нөхцөлүүд нь энгийн журмаар байгуулагдах гэрээний хувьд чухал биш боловч интернетээр гэрээ байгуулах гол нөхцөл болно.

Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.1-д "Нэг этгээд өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх, үүргийн хувьд холбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд хандан хүсэл зоригоо бодьтойгоор, хангалттай тодорхой илэрхийлсэн илэрхийллийг гэрээ байгуулах санал гэнэ", мөн хуулийн 195.2-д "Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна", 196.3-д "Хуульд заасан буюу гэрээнд зайлшгүй тусгавар зохих, түүнчлэн нэг талын хүссэний дагуу нөгөө тал нь зөвшөөрсөн нөхцөлийг гэрээний гол нөхцөл гэнэ" хэмээн зааснаас үзэхэд гэрээний санал нь гэрээ байгуулах тухай хүсэл зоригийг хангалттай тодорхой илэрхийлсэн байхын зэрэгцээ түүнд гэрээний гол нөхцөл, түүнийг тодорхойлох журмыг заасан байх ёстой.

Гадаадын ихэнх улс орон интернетээр гэрээ байгуулахтай холбоотой нэмэлт нөхцөлүүдийг гэрээний саналд хангалттай тодорхой илэрхийлсэн байх шаардлагыг хуулиар тогтоодог.

ОХУ-ын Электрон худалдааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д электрон гэрээний гол нөхцөлүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна.³ Үүнд:

¹ "Юнстрал. Типовой закон об электронной торговле и Руководство по применению 1996 г."

² Федеральный закон "Об электронной торговле" /Российский Федерации/

- Гэрээ байгуулах үе шат, бадгуулах журам;
- Хувийн электрон гарын үсэг ашиглах журам;
- Гэрээний нөхцөлд нэмэлт оруулах болзол, журам;
- Гэрээний саналын харуу өгөх арга, журам;
- Алдаатай илгээгдсэн гэрээний саналын харууг буцаан татах арга, журам;
- Электрон баримтыг хадгалах журам;
- Электрон баримтаас цаасан хуулбар хийх нөхцөл гэх зэрэг болно.

Харин Молдав улсын Электрон худалдааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т зааснаар электрон гэрээнд дараах гол нөхцөлүүдийг тусгасан байна. Үүнд:

- Гэрээ байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үе шат, журам;
- Электрон цифрэн гарын үсэг ашиглах журам;
- Гэрээ байгуулах хэл;
- Гэрээний офферт, акцептыг илэрхийлэх, буцаан татах эрх;
- Талуудын эдлэх үндсэн эрх, үүрэг;
- Бараа үйлчилгээний үнэ, тариф, төлбөр төлөх журам;
- Гэрээнээс татгалзах нөхцөл, журам;
- Үүрэг гүйцэтгэх нөхцөл, журам;
- Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, журам;
- Гэрээний үйлчлэл дуусгавар болох нөхцөл;
- Талуудын банкны харилцах дансны дугаар болон электрон хаяг.

Интернетээр гэрээ байгуулахад гэрээ байгуулах үе шат нь ердийн гэрээ байгуулах журамтай адил мэт боловч гэрээний санал илгээгдсэн, хүлээн авсан цаг хугацаа буюу хүсэл зориг хэдийд илэрхийлэгдснийг тодорхойлох асуудал хууль зүйн чухал ач холбогдолтой.

Бид гэрээ байгуулах санал болон саналын харууг мэдээлэл

гэж үзвэл уг мэдээллийг илгээх, мэдээллийг хүлээн авах гэсэн өөр хоорондоо харилцан холбоотой үйл ажиллагааны үе шат ажиглагдана.

Мэдээлэл буюу гэрээний саналыг илгээсэн болон хүлээн авсан цаг хугацааг тодорхойлох дараах хувилбар байж болно.

Гэрээний саналыг илгээсэн хугацаа нь ихэвчлэн гэрээний санал гаргагч өөрийн мэдээллийн системээс уг гэрээний саналыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд оруулснаар, эсхүл мэдээлэл илгээгч, хүлээн авагчдын зөвшилцсөний дагуу мэдээлэл хүлээн авагч мэдээллийг мэдээллийн сангаас татаж авснаар илгээгдсэнд тооцож болдог.¹

Гэхдээ зарим улс орон мэдээллийн харилцаанд оролцогчдын хооронд үүсэх үл ойлголцох харилцааг урьдчилан зохицуулах, тэдний эрхийг хамгаалах зорилгоор андуу ташаа илгээгдсэн, хаяглтачаа буруу сонгосон гэх мэт тохиолдолд мэдээлэл илгээгдээгүйд тооцож үндэслэлийг хуульчлан зохицуулдаг.

ОХУ-ын Электрон худалдааны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар дараах тохиолдолд мэдээлэл илгээгдээгүйд тооцдог:²

- Мэдээлэл хүлээн авагч нь уг электрон баримт мэдээлэл илгээгчээс илгээгдээгүй тухай мэдээгдлийг өөрийн боломжит хугацааны дотор авсан;
- Мэдээлэл илгээгчтэй тохиролцсны дагуу мэдээлэлд шалгалт хийх явцдаа уг мэдээлэл нь илгээгчээс илгээгдээгүй тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан;
- Мэдээлэл илгээгчтэй тохиролцсны дагуу мэдээлэлд шалгалт хийх явцад уг электрон мэдээлэл нь буруу ташаа болохыг мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан;
- Мэдээлэлд шалгалт хийх явцад уг электрон мэдээлэл нь бусад мэдээлэл илгээгчдээс автоматаар зэрэгцүүлэгдсэн гэдгийг мэдсэн, мэдэх ёстой байсан гэх зэрэг болно.

Харин мэдээлэл хүлээн авсан цаг хугацааг тодорхойлох нь нилээд хүндэтгэж бөгөөд дээрх цаг хугацааг тооцох дараах арга байж болно:

- а. Санал гаргагчийн илгээсэн мэдээлэл нь санал хүлээн авагчийн мэдээллийн сүлжээнд орсноор;
- б. Мэдээллийг санал хүлээн авагч өөрийн мэдээллийн сүлжээнээс татснаар буюу уншснаар.

Гэрээний талууд гэрээний саналыг хүлээн авсан цаг хугацааг тодорхойлох асуудлыг урьдчилан тохиролцож болох хэдий ч энхийн хувилбараар гэрээний саналыг хүлээн авсанд тооцох нь дараахь дутагдалтай. Үүнд:

- Гэрээ байгуулах санал нь хүлээн авагчийн мэдээллийн системд орсон бөгөөд хүлээн авагч мэдээллийг татаагүй /уншаагүй/ байсан ч санал хүлээн авагсад тооцогддог. Нөгөөтэйгүүр хэн нэгэн этгээдийн санаатай эсхүл хайхрамжгүй үйлдлийн улмаас мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байсан хүсэл зориг устгаж гэмтсэн тохиолдолд гэрээ байгуулах хүсэл зоригийг хүлээн авсныг тодорхойлоход бэрхшээлтэй болно. Иймээс энэ хувилбар нь гэрээний санал хүлээн авч байгаа этгээдийн үйлдлийн үр нөлөөг орхигдуулах талтай.

- Мэдээлэл хүлээн авагч мэдээллийн сүлжээнээс гэрээ байгуулах саналыг татаж аваагүй тохиолдолд харуу өгөх боломжгүй болно. Гэтэл Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.2-д Бусдад үйлчилгээ үзүүлэх аж ахуй эрхлэгч нь ажил төрлийн байнгын холбоо бүхий этгээдээс тухайн төрлийн үйл ажиллагаа гүйцэтгүүлэх тухай саналыг хүлээн авсан бол өөрийн боломжит хугацааны дотор харуу явуулах үүрэгтэй. Хэрэв үүрэгээ биелүүлээгүй бол түүнийг гэрээ байгуулахаар дуугүй хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр заасан нь эрх зүйн маргааныг үүсгэх боломжтой.

"Олон улсын хооронд бараа худалдах, худалдан авах гэрээний тухай" Венийн конвенцийн 20 дугаар зүйлд зааснаар "Санал гаргагчаас утас, цахилгаан буюу түрэгэн нэвтрүүлэх холбооны бусад хэрэгслээр санал явуулсан бол саналын харуу хүлээн авах

¹ "Юстирал Типовой закон об электронной торговле и Руководство по принятию 1996 год", ст. 15.2.а-1

² Федеральний закон "Об электронной торговле", глава 2, ст. 13.

хуваагаа санал хүлээн авагч тал уул саналыг хүлээн авсан үеэс эхлэн тоолно". Мөн НҮБ-ын Олон улсын худалдааны байгууллагаас батлан гаргасан "Электрон хэлцлийн тухай жишээ хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.а-и — д "хэрэв мэдээлэл хүлээн авагч тал нь мэдээллийн сүлжээнээс мэдээллийг татаж авсан тохиолдолд мэдээлэл илгээгдсэнд тооцно", мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д "мэдээлэл хүлээн авагч нь мэдээллийг хүлээн авсан тухайгаа баталгаа-жуулахаар заасан тохиолдолд уг мэдээллийг хүлээн авсныг баталгаажуулах хүртэл уг мэдээллийг илгээгдээгүйд тооцохоор", ОХУ-ын Электрон худалдааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д "мэдээлэл илгээгч нь мэдээллийг хүлээн авсан тухай баталгаажуулах ердийн боломжит хугацааг тоотгож болох бөгөөд уг хугацаанд мэдээллийг баталгаажуулаагүй бол мэдээлэл илгээгдээгүйд тооцно", "Мэдээлэл хүлээн авагч нь мэдээллийг хүлээн авсан тухайгаа мэдээлэл илгээгчтэй тохиролцсны дагуу түүнд мэдэгдэх" эрх, Монгол Улсын Иргэний хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д "Хүсэл зоригийн илэрхийлэл нь нөгөө тал түүнийг хүлээн авснаар хүчин төгөлдөр болно" хэмээн тус тус зохицуулсан байна.

Эрх зүйн хувьд гэрээ нь хоёр талын сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцсон хэлцэл байдаг. Хүсэл зориг болон хүсэл зоригийн илэрхийлэл нь хэлцлийн мөн чанар бөгөөд хүсэл зоригийн илэрхийлэл нь нөгөө тал түүнийг хэрхэн хүлээн авснаар хүчин төгөлдөр болдог. Хэрэв санал хүлээн авагч тал мэдээллийн сүлжээнээс гэрээ байгуулах саналыг татаж авснаар саналыг хүлээн авсанд тооцвол гэрээ нь хоёр талын хүсэл зоригийн илэрхийлэл болох зарчим хангагдах нөхцөл болно.

Харин гэрээ байгуулах саналыг мэдээллийн сүлжээнээс татснаар саналыг хүлээн авсанд тооцоход дараахь бэрхшээл тулгарна. Үүнд:

- Санал хүлээн авагч тал мэдээллийн сүлжээнээс гэрээ байгуулах саналыг татаж авах хүртэл гэрээний санал илэрхийлэгдээгүйд тооцогдоно. Хэрэв мэдээлэл хүлээн авагч тал

гэрээ байгуулах хүсэл зоригийг хүлээн авснаа баталгаажуулаагүй тохиолдолд мэдээллийг татаж авсныг мэдээлэл илгээгчээс мэдэхэд хүндрэлтэй. Зарим тохиолдолд мэдээлэл илгээгчээс гэрээ байгуулах саналыг дуугүй хүлээн зөвшөөрсөнд тооцон тодорхой үйлдэл хийхийг үгүйсгэхгүй. Иймээс гэрээний талуудыг эрсдэлээс хамгаалах зорилгоор хуульд "Хэрэв мэдээлэл илгээгчээс гэрээ байгуулах саналыг тодорхой хугацаатай буюу хугацаагүй илгээсэн бөгөөд мэдээлэл хүлээн авагч тогтоосон хугацаанд эсхүл ердийн боломжит хугацааны дотор мэдээллийг баталгаа-жуулаагүй тохиолдолд мэдээлэл илгээгдээгүйд тооцно. Энэ тохиолдолд мэдээлэл илгээгчээс гэрээ байгуулах саналыг дахин хугацаатай буюу хугацаагүй илгээх эрхтэй бөгөөд уг хүсэл зоригийг мэдээлэл хүлээн авагч тал дахин баталгаажуулаагүй тохиолдолд мэдээлэл илгээгдээгүйд тооцох"-оор зохицуулалтыг оруулах нь зүйтэй. Энэ нь гэрээний талуудад гэрээ байгуулах нэмэлт хугацаа, боломжийг олгож байгаагаараа онцлог юм.

- Санал хүлээн авагч тал мэдээллийн сүлжээнээс гэрээ байгуулах саналыг татаж авсан цаг хугацааг тодорхойлоход бэрхшээл учирч болно. Иймээс мэдээлэл илгээгч, хүлээн авагчид гэрээнд өөрөөр тохиролцоогүй бол мэдээлэл хүлээн авагч тал гэрээ байгуулах хүсэл зоригийг баталгаажуулснаар гэрээний санал хүлээн авсанд тооцох нь зүйтэй.

Интернетээр худалдаа арилжаа явуулах хүсэл зоригийн илэрхийлэл нь ихэвчлэн тодорхой бус этгээдүүдэд хандсан санал гаргах дуудлагын хэлбэртэй байдаг. Санал гаргах дуудлага нь төрөл бүрийн дүрс тэмдэглэгээ, үг хэллэг бүхий зург, плакат, сурталчилгаа байдлаар мэдээллийн системд хэлбэржсэн байдаг. Гэрээ байгуулах санал, саналын дуудлага хүлээн авсан этгээд нь илэрхийлэгдсэн хүсэл зоригийг хүлээн авсан тухайгаа тодорхой, үйлдлээр эсхүл албан ёсны харууг электрон хэлбэрээр илэрхийлэхэд л хангалттай.

Электрон мэдээллийг илгээх, хүлээх авах ажиллагаанд гардаг нэг бэрхшээл бол мэдээлэл

илгээгч, хүлээн авагчийг хууль зүйн хувьд хэрхэн тодорхойлох асуудал юм. Монгол Улсын Мэдээлэл, технологийн ерөнхий хуулийн төслийн 4 дүгээр зүйлд тодорхойлсоор:

- Мэдээлэл илгээгч өгөж илгээх, хадгалахаас нь өмнө электрон баримт бичгийг бүтээгч, эсхүл түүний нэрийн өмнөөс мэдээлэл илгээх эрхтэй этгээдийг;
- Мэдээлэл хүлээн авагч гэж илгээгчээс электрон баримт бичиг хүлээн авах этгээдийг хэлэхээр тус тус тодорхойлсон байна.

Дээрх тодорхойлолтод мэдээлэл илгээгч, хүлээн авагчийг тодорхойлохдоо тухайн үйлдлийг илгээсэн, хүлээн авсан үйлдлийг чухалчлахгүйгээр зөвхөн мэдээллийг илгээх, хүлээн авах бүрэн эрхтэй байх шаардлагыг чухалчилж байгаа нь эрх зүйн зохицуулалтын алдааг бий болгох боломжтой. Зарим улс оронд "мэдээлэл үнэн хэрэгтээ илгээсэн", "мэдээлэл үнэн хэрэгтээ хүлээн авсан этгээд" хэмээн үйлдлийг голчлон тодорхойлсон байдаг. Ингэснээр электрон харилцаанд оролцогчдын үйлдлийн хууль зүйн уг дагаарыг тогтооход хялбар болох юм. Нэгэн жишээ дурдаа "Нэгэн залуу өөрийн найзын интернет дэлгүүрийн ID-ийг ашиглан их хэмжээний бараа захиалжээ" энэ тохиолдолд мэдээллийг илгээх эрхтэй этгээд нь интернет дэлгүүрийн ID эзэмшигч боловч үнэн хэрэгтээ түүний найз уг мэдээллийг илгээсэн. Төсөл хуулийн тодорхойлолтоос үзвэл энэ тохиолдолд мэдээлэл илгээх эрхтэй этгээд нь мэдээллийг үнэн хэрэгтээ илгээсэн этгээдийн үйлдлийн хариуцлагыг хүлээж болохоор байна. Гэтэл эрх зүйн онолоор эрх зүйн чадвар, чадамж бүхий этгээд өөрийн үйлдэл, эс үйлдлийн улмаас учирсан хууль зүйн хариуцлагыг өөрөө хариуцах ёстой. Түүнчлэн дээрх тодорхойлолтод мэдээлэл хүлээн авсан этгээд, мэдээллийг хүлээн авах эрхтэй этгээд хоёрын хоорондын алгаар нарийн гаргаж хуульчлан зохицуулах шаардлагатай.¹

¹ Эндрийо МкЛафлин "Мэдээллийн технологийн хуулийн төсөлд өгөх санал шүүмжлэл, дүн шинжилгээ" 2003 он /ITLaw_comments_mong.pdf/

Интернетийн сүлжээнд мэдээллийн аюулгүй байдлаа алдагдаж, хэрэглэгчид бүрэн бус мэдээллийн улмаас эрх нь зөрчигдөж, өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх зүйн механизм хангалтгүй байгаагаас хэрэглэгчдийн интернетээр үйлчлүүлэх итгэлгүй байдал улам бүр нэмэгдсээр байна.¹ Интернет дэх ихэнхи харилцаа нь тодорхой нэргүй, гарын үсэггүй, биет бус харилцаа байдаг тул интернет дэх гэрээ нь үр дүнгүй гэсэн шүүмжлэл барууны судлаачдын дунд нилээд түгээмэл байдаг.² Ялангуяа гэрээ байгуулж байгаа этгээд нь уг мэдээллийн сүлжээг ашиглах бүрэн эрхтэй субъект мөн эсэх, тэрээр гэрээ, хэлцэл байгуулах эрх зүйн чадвар, чадамжийг хангаж байгаа эсэх, өөрийн хүсэл зоригийн дагуу гэрээ байгуулж байгаа эсэх гэх зэрэг эрсдийг тооцоход бэрхшээлтэй байдаг.

Энэ харилцааг төрийн оролцоо, хяналт шалгалт, эрх зүйн зохицуулалтын тусламжтайгаар шийдвэрлэх боломжтой боловч зохицуулалтын хүрээний хувьд хязгаарлагдмал байдаг. Төрийн зүгээс интернетээр тогтмол худалдаа, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг хянан зохицуулах боломжтой боловч жирийн иргэд хоорондын харилцааг зохицуулахад хүндрэлтэй байдаг. Дээрх бэрхшээлийг шийдвэрлэхэд улс бүр харилцан адилгүй хамгаалалтын хэрэгслийг хэрэглэж байна.

ОХУ-ын 1992 оны 2 дугаар сарын 17-нд батлагдсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль"-ийн 8 дугаар зүйлд "Хэрэглэгч буюу худалдагч нь үйлчлэгч буюу худалдагчийн талаархи шаардлага тэй мэдээллийг гаргуулан авах эрхтэй", мөн хуулийн 9.1-д "Худалдагч нь өөрийн байгууллагын нэр, оршин байгаа газар болон үйл ажиллагааны хүрээний тухай мэдээллийг хэрэглэгчдэд үнэн зөвөөр өгөх үүрэгтэй. Хэрэв үйлдвэрлэгч буюу худалдагч нь

интернет дэлгүүрийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бол өөрийн дэлгүүрийн веб-сайтын мэдээллийг санд дээрх мэдээллийг үнэн зөвөөр оруулах, цаашлаад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, өөрийн улсад бүртгүүлсэн бүртгэлийн гэрчилгээг электрон хэлбэрээр байршуулсан байх ёстой." гэсэн шаардлагыг тавьдаг байна. Харин интернетээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хувьд харилцагч иргэдийн эрх зүйн чадвар, чадамжийг үнэн зөвөөр мэдэхэд бэрхшээлтэй боловч тэдгээр байгууллага харилцагчдийн талаархи мэдээллийг бүрдүүлэх, гэрээний хууль зүйн хүчин төгөлдөр байдлыг хангах зорилгоор бүртгэлийн хуудсыг нээн ажиллуулдаг байна.

Молдав улсын Электрон худалдааны тухай хуульд хэрэглэгчдийн эрхийг хамгаалах зорилгоор худалдааны байгууллагуудад тавигдах хэд хэдэн шаардлагыг хуулиар тогтоожээ. Электрон худалдаа эрхлэгч нь электрон харилцааны бусад оролцогчид түүнчлэн төрийн хяналтын байгууллагуудыг өөрийн үйл ажиллагааны талаархи хангалттай, үнэн зөв мэдээллийг хангах үүрэгтэй байхаар хуульчилж, хуулийн этгээдийн оноосон нэр, үйл ажиллагааны хэлбэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хууль ёсны болон электрон шуудангийн хаяг, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэх журам, үнэ зэрэг шаардлагатай бусад мэдээллээр заавал хангахаар хуульчилжээ.

Канад улсын хувьд интернетийн эрх зүйн зохицуулалтаар дэлхийд тэргүүлэх улсын нэг бөгөөд интернетээр худалдаа эрхлэгчид, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах зорилгоор интернет худалдааны гэрээний журмыг / Internet Sales Contract Regulation/ боловсруулсан нь интернетийн худалдааг улам хөгжөөгчиж байна. Уг журам нь интернетээр

худалдаа эрхлэгчдийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсны зэрэгцээ хэрэглэгчдийн эрхийг хамгаалах механизмыг бүрдүүлэхэд ихээхэн анхаарсан нь түүний агуулгаас тодорхой харагдана. Журмад зааснаар электрон бизнес эрхлэгчид хэрэглэгчдэд өөрийн байгууллага болон бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хангалттай үнэн зөв мэдээллийг өгөх үүрэгтэй. Хэрэв энэ журмыг зөрчсөн тохиолдолд үйлчлүүлэгч нь гэрээг өөрийн санаачлагаар цуцлаж, мөнгөө буцаан шаардах эрхтэй. Түүнчлэн интернетээр бизнес эрхлэгч нь үйлчлүүлэгчийг гэрээний нөхцөлтэй танилцаж, захиалгын яцад гаргасан алдаагаа засах боломжоор чөлөөтэй хангаж, гэрээг бүртгэлд оруулахаас өмнө гэрээгээс сайн дураар татгалзах эрхийг олгох үүрэгтэй байна.³

Мөн журамд зааснаар интернетээр худалдаа эрхлэгч нь гэрээ байгуулахаас өмнө дараах мэдээллийг үйлчлүүлэгчид өгөх үүрэгтэй. Үүнд:

- Интернетээр бизнес эрхлэгчийн нэр, хаяг, утасны дугаар, e-mail хаяг, факсын дугаар;
- Бараа, үйлчилгээний үндсэн үнэ болон татвар, тээвэрлэлтийн үйлчилгээний нэмэгдэл зардал;
- Интернетээр бизнес эрхлэгч нь гэрээний үүргээ тодорхой шалтгаанаар биелүүлээгүй тохиолдолд гэрээгээр хүлээх нэмэлт хариуцлага;
- Мөнгөн гүйлгээ хийх дэвсгэрт, дансны дугаар;
- Гэрээ цуцлах, бараа, үйлчилгээг буцаах, солих нөхцөл;
- Бараа, үйлчилгээг нийлүүлэх хугацаа болон элээлцэн тохиролцох хугацаа гэх зэрэг болно.

Ийнхүү хэрэглэгчдийг мэдээллээр хангах үүргийг бизнес эрхлэгчдэд хүлээлгэж байгаа нь хэрэглэгчдийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилготой

¹ Barry Sookman, Computer, Internet and Electronic Commerce Law (Toronto: Carswell, 2001)

² Marc Andre Gimmy "Neuere Entwicklung in Internetvertragsrecht"

³ Keenan Moroz. "The Alberta Internet Sales Contract Regulation: Stimulating E-Commerce Through Consumer Protection"

бөгөөд төрийн зүгээс бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн талаархи мэдээллийг бүрдүүлэхийн тулд domain name буюу хэрэглэгчийн ондоошуулсан нэр, түүнчлэн хэрэглэгчийн хууль ёсны гарын үсгийн бүх төрлийн бүртгэлийг өөрийн хяналт, хамгаалалтад авдаг байна.

Бүртгэлийн системийг төр өөрийн хяналтад авснаар электрон харилцаанд оролцож байгаа этгээдийн эрхийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлэх цаашлаад энэ салбар дахь төрийн нэгдсэн бодлогыг тодорхойлоход тус дөхөм болно. Гэхдээ электрон худалдаа эрхлэгчдийг төр өөрийн хяналтандаа байлгах нь үйл ажиллагааг лицензжүүлж, тусгай зөвшөөрөл олгох гэсэн санаа огтхон ч биш юм. Хэрэв электрон худалдааны бүхий л үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн тогтолцоонд оруулвал худалдаа эрхлэгчдийн интернет ашиглан хэрэглэгчидтэйгээ харьцаж, бизнесийн цар хүрээгээ нэмэгдүүлэх сонирхол буурч улмаар энэ салбарын хөгжил зогсонги байдалд орох аюултай. Иймээс бүртгэлийн тогтолцоо, зөвшөөрлийн тогтолцоо гэсэн ойлголтуудыг онолын үндэслэлтэй хуульчлах нь зүйтэй. Бүртгэлийн тогтолцоо нь төрийн байгууллагын зүгээс электрон худалдаа эрхлэгчдийн талаарх мэдээллийг нэгдсэн журмаар эмхтгэн цэгцлэх үйл ажиллагаа бол зөвшөөрлийн тогтолцоо нь электрон худалдаа эрхлэгч нь үйл ажиллагаа эрхлэхдээ төрийн эрх бүхий байгууллагаас хуульд тогтоосон журмаар электрон

худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах үйл ажиллагаа юм. Гэхдээ лиценз зөвшөөрөл олгодог тогтолцоо бол цаад санаа нь хэдий зөв байвч өөрөө авилга үүсэх шалтгааныг төрүүлдэг зохицуулалтын зохиомол саад бэрхшээл болдог жамтай. Уоллостоны тэмдэглэсэнчлэн лицензийн буюу зөвшөөрлийн тогтолцоо нь Засгийн газар болон аж үйлдвэрийн хооронд үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахад компаниудаас хээл хахууль гаргуулдаг тийм харилцан нөлөөлөл, огтолцлын цэгүүдийг нэмэгдүүлдэг. Харин тусгай зөвшөөрөл олгохын оронд өргөн хэрэглэгддэг альтернатив хувилбар болох ерөнхий бүртгэлийн нэвтрүүлэх талаар нягтлан үзэх хэрэгтэй. Ерөнхий бүртгэл хөтөлснөөр хянан зохицуулах эрх бүхий байгууллага нь зөвшөөрөл олгохоос татгалзах буюу барьж удаашруулах гэсэн ямар нэг болгоомжлол үгүй болж, электрон худалдааны салбар хөгжих нөхцөл бүрдэнэ.

Монгол Улсын Мэдээллийн технологийн хуулийн төсөлд электрон худалдаа, үйлдвэрлэл эрхлэгч нь үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг Засгийн газраас авахаар зохицуулсан нь шинэ дугаар хөгжиж байгаа электрон сүлжээний хэрэгтэй, ач холбогдлыг улам бүр бууруулахаар байна. Мэдээлэл, харилцаа, холбооны салбарт боловсруулж буй хуулийн төслүүдийг судлахад төрийн зүгээс электрон худалдааны салбарт ямар бодлого, зарчим баримтлаж байгаа нь тун ойлгомжгүй байгаа нь энэ мэт зохицуулалт хийх үндэслэл

болж байна. Гэтэл ХБНГУ, ОХУ, АНУ, Беларус, Молдав гэх зэрэг улсын хуульд электрон худалдаанд төрийн баримталж буй бодлого, зарчим тун тодорхой байдаг. Тухайлбал, Молдав улсын Электрон худалдааны тухай хуулийн 5 дугаар зүйлд электрон худалдаа эрхлэгч нь үйл ажиллагаагаа урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр хууль тогтоомж, өрсөлдөөний зүй ёсны болон эрх чөлөөний зарчимд нийцүүлэн явуулахаар заасан.¹

Иймээс мэдээлэл технологийн салбар дахь хуулийн төслийг боловсруулахдаа зөвшөөрлийн болон бүртгэлийн тогтолцоог зүй зохистой хэлбэрээр ашиглаж, Электрон хэлцлийн тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд интернетээр худалдаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа этгээдүүдийн эрх, үүрэг /үйл ажиллагааны талаарх мэдээлэл, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, бараа, үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөх гэх зэрэг/, болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаархи нарийвчилсан зохицуулалт оруулах шаардлагатай.

Интернетээр гэрээ байгуулахад гэрээ байгуулагдсан газар, гэрээний хэлбэр, гэрээний эх ба хуульбарын тухай асуудал, гэрээтэй холбоотой маргааныг аль улсын хуулиар зохицуулах гэх мэт шийдвэрлэвэл зохих олон асуудал үүсдэг. Судлаачийн зүгээс эдгээр асуудлыг дараагийн дугаарт та бүхэнд хүргэх болно.



¹ Гэхдээ хуулиар зөвшөөрөл авах бизнесийн үйл ажиллагааны хувьд заавал зөвшөөрөл авахыг шаарддаг! Закон Республики Молдава об электронной торговле, ст.5, N 248-XY, 22.07.2004.

ГЭРЛЭЛТ БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ ЗАРИМ АСУУДАЛ

ИБМУТ-ийн Төв, орон нутгийн иргэний бүртгэл хариуцсан
ахлах мэргэжилтэн Д.Янжмаа

Монгол Улсын "Гэр бүлийн тухай хууль"-д "гэрлэлт" гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг; "гэр бүл" гэж гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг; "гэрлэгчид" гэж гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг; "гэр бүлийн гишүүн" гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг хэлнэ хэмээн хуульчилсан билээ. Тэгэхээр гэр бүл бол хамтын амьдралын үр дүнд бий болж, тэд харилцан зөвшилцөж, улмаар оршин суугаа газрынхаа Засаг даргын Тамгын газрын иргэний бүртгэлийн байгууллагад очиж гэрлэснээ албан ёсоор бүртгүүлж, баталгаажуулна гэсэн үг юм.

Улсын хэмжээнд 1990-ээд оноос хойш хугацаанд жилд дунджаар 11000-16000 орчим хүсч гэрлэлтээ төрийн захиргааны эрх бүхий иргэний бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, амьдралаа холбон аз жаргалаар дүүрэн амьдарчгааж байна. Нөхөр, эхнэр 2 гэрлэлтээ бүртгүүлснээр тэдний нийгмийн өмнө хүлээх үүрэг өндөржиж, хамтын амьдралаа сайн сайхан авч явах, үр хүүхдээ өсгөн хүүхүүлэх хариуцлага нэмэгдэнэ. Гэр бүлийн гишүүд, гэрлэгчид бие биеэ, эцэг, эх нь үр хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ хуулийн дагуу тээжэн тэтгэх үүрэгтэй.

Албан ёсоор гэрлэлтээ батлуулсан хосуудын хувьд "сална" гэж хэлсний зоргоор хоёр тийшээ

болчихдоггүй, өөрөөр хэлбэл, хууль ёсны гэрлэлтээ цуцлууслны дараа л тэд сая салах боломж бүрдэнэ. Тэгэхээр албан ёсны баталгаатай гэрлэгчдийн тухайд хүлээх үүрэг, хариуцлага хуульчлагдсан байдаг юм. Гэрлэлтийг албан ёсоор бүртгүүлсэн үеэс эхлэн хосууд нь гэр бүлд тооцогдож, улмаар тухайн гэр бүлийн гишүүд бие биенийхээ өмнө харилцан үүрэг хүлээж, эрх эдлэнэ. Мөн хосууд гэрлэлтээ бүртгүүлэн албан ёсоор гэр бүл болсноор төрөөс үзүүлэх халамж, дэмжлэгийг эдлэх эрх бий болно.

Монгол Улсын Их хурлаар залуу гэр бүлийг дэмжих зорилгоор "Хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль"-ийг батлан 2006 онд гэр бүл болж, гэрлэлтээ бүртгүүлсэн хосуудад төрөөс тусламж үзүүлэх арга хэмжээг авсан билээ. Энэ хууль батлагдан гарсантай холбогдон улсын хэмжээнд 2006 онд 50502 гэр бүл гэрлэлтээ бүртгүүлсэн нь өмнөх оны гэрлэгчдийн тооноос 3,1 дахин өссөн байна. Энэ онд Улаанбаатар хог, Хөвсгөл, Орхон, Өвөрхангай аймагт хамгийн олон иргэд гэрлэлтээ бүртгүүлсэн байна.

Нийт гэрлэгчдийн 98,6 хувь нь анх удаа, 1,3 хувь нь хоёрдахь удаагаа гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Албан ёсоор гэрлэлтээ бүртгүүлээгүй, хамтран амьдарч байсан, хүүхэдтэй залуучууд ч гэрлэлтээ бүртгүүлсэн болох нь дээрхи тоон үзүүлэлтээс харахад илэрхий байна. Нөгөө талаас 2004 оны сонгуулийн үед улс төрийн намууд хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэн хэмээн амлаж байсныг хүлээж, гэрлэлтээ бүртгүүлээгүй байсан залуучууд ч гэрлэлтээ бүртгүүлсэн болно. Энэ нь 2004 оноос хойших хугацаанд нийт 11463 хүүхдийн эцэг тогтоосны

бүртгэлд бүртгэгдсэн Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн мэдээ, судалгаагаар нотлогдож байна.

2006 онд гэр бүлээ бүртгүүлсэн гэрлэгчдийн талаар судлаж үзэхэд нийт гэр бүл бологчдын 43988 буку 87,1 хувь нь 35 хүртэл насны гэрлэгчид байгаа нь гэрлэх нас харьцангуй хойшлогдож байгааг харуулж байна. Жишээлбэл: судалгаанаас үзэхэд 20-29 хүртэл насны гэрлэгчид нийт гэрлэгчдийн 70,6 хувийг эзлэж байна.

Гэрлэлтийн асуудалтай хамт хөндөн бичигдэх нэг сэдэв бол гэр бүл цуцлалт билээ. Түүнчлэн 2006 онд улсын хэмжээнд 1354 гэр бүл гэрлэлтээ албан ёсоор цуцлуулсан нь 2005 онтой харьцуулахад 22 хувиар буурсан байна. Нийт гэр бүл цуцлуулагчдын 16 хувь хүүхэдтэй болснохоо дараа гэр бүл салжээ.

Судалгаанаас гэр бүл цуцлуулж байгаа шалтгаан, нөхцөлийг авч үзвэл амьдралын явцад зан харьцаа тохироогүй, бэлгийн харьцаа таараагүй, албан тушаал нөлөөлсөн, тэр бүлийн талаар тогтворгүй гэх шалтгаан зонхилж байгаа юм. Сүүлийн үед гэрлэлтийн бүртгэл нэмэгдэхийн чашуу гэр бүл салалт өснө хэмээн олон хүн таамаглан ярьж байсан. Гэтэл гэр бүл цуцалтын байдал ийнхүү багассан нь залуучууд гэрлэхдээ бие биенээ сайтар судалж, боловсрол, мэргэжил эзэмшиж, амьдрах орон гэр, байр сууц, ажил алба зэрэг нийгмийн асуудлаа шийдвэрлэснийг эрхэмлэдэг болсон, нөгөө талаар гэрлэх насны тухайд 3-5 жилээр хойшлогдсон явдал хэмээн нийтлэл бичигчийн зүгээс үзэж байна.

Гэрлэсний бүртгэлийн явцад гарч буй нэг асуудал нь иргэд гэр бүл болж хамтран амьдардаг боловч, гэрлэлтээ албан ёсоор

бүртгүүлдэггүй, дундаасаа хүүхэд төрүүлсэн хэрнээ хүүхдээ төрсөн эцгээр нь овоглуулж, эцэг тогтоосны бүртгэл хийлгэх явдал сүүлийн 3 жилд нилээд өсөх хандлагатай байсан. Судалгаанаас үзэхэд нийт гэрлэсэн хосуудын 12,4 хувь нь гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө хүүхэд төрүүлсэн байсан. Энэ нь тэд гэр бүлээ батлуулахгүйгээр, гэр бүлийн адил хамтран амьдардаг боловч, нийгэмд хүлээх үүрэг, хариуцлагаас зайлсхийх өөрөөр хэлбэл, албан ёсны гэрлэлтийн гэрчилгээгүй учир "салъя" л гэвэл тэдэнд ямар нэгэн хаалт саад байхгүй амархан салчихна гэсэн ойлголтыг давхар агуулдаг болов уу гэсэн эмзэглэлийг төрүүлдэг билээ.

Залуучууд сүүлийн үед хамтран амьдрахыг хүсдэг бөгөөд тэднийг гаднаас харахад адилхан гэр бүл атлаа хамтран амьдрагчид нь хууль ёсны баталгаатай гэр

бүлээс хамаагүй хэврэг, салахад саадгүй байдаг нь илэрхий харагддаг. Эндээс л гэр бүлийн хос багана болж амьдарч байгаа хэрнээ хамтран амьдрагсад яагаад ийм баталгаагүй нөхцөлд байхыг хүсдэг юм бэ гэсэн асуулт сонирхол татаж байгаа юм. Энэ асуудлаар явуулсан судалгаа байдаг юм билээ. Гэхдээ л гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлэхгүйгээр хамтран амьдрахыг хүсэгчид нь Монгол Улсын "Гэр бүлийн тухай хууль"-д хүлээсэн эрх, үүргийг биелүүлэхээс татгалзсан, гэр бүлээ батлуулахын давуу талыг ойлгодоггүй хэсэг бүлэг хүмүүсийн асуудал юм болов уу.

Төрөөс "Хүүхдэд тэтгэмж олгох, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль"-ийг батлан гаргасан явдал нь хамтран амьдрагчид болон гэрлэлтээ бүртгүүлээгүй байсан гэр бүлийг төрийн эрх бүхий байгууллагад

"гэрлэлтээ" бүртгүүлэх хандлагыг нэмэгдүүлсэн эрх зүйн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон. Нэгэнт л гэр бүлийн адил хамтран амьдарч, үр хүүхэдтэй болсон л бол тэд Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль- иар гэрлэлтээ бүртгүүлж, эцэг, эх байх эрхээ эдэлж, үр хүүхэд, гэр бүлийн гишүүд, төрийн өмнө хүлээх үүргээ биелүүлэн аж төрөх нь хууль ёсны эрхийн асуудал билээ.

Гэрлэлтийн бүртгэл нь улсын хэмжээнд 2006 онд 3.1 дахин нэмэгдсэн явдал нь төрөөс гэр бүлд үзүүлж буй мөнгөн тэтгэмжээс хамааралтай байсан ч гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлж, гал голомтоо бадраан, сайн сайхан амьдрах нь монголчуудын уламжлалт зан заншил, хууль ёсоо дээдлэдэг ард түмний ухаалаг шийдэл байх болно хэмээн билэгдэж энэхүү нийтлэлийг төгсөе.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ПАЛЕРМОГИЙН КОНВЕНЦОД НИЙЦҮҮЛЭХ НЬ: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ШААРДЛАГА

Монгол Улсын язгуур ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нь Монгол төрийн бодлого, үйл ажиллагааны гол цөм байдаг. Монгол Улс үндэснийхээ аюулгүй байдлыг хамгаалах арга, хэлбэрийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа тодорхойлон заасан бөгөөд үүний нэг нь хууль зүйн арга буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал юм.

Энэхүү үзэл баримтлалын үүднээс, дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд олон улсын хэмжээнд ач холбогдол өгч НҮБ-аас батлан гаргасан олон тооны гэрээнд манай улс нэгдэж ороод байгаа. Даяаршин буй орчин үеийн дэлхий ертөнцөд тус тусын тулгамдсан асуудал багасч улам бүр нийтлэг шинжид шилжих байгаа нь уг асуудлуудыг шийдвэрлэх бодлого, арга, хэрэгслээ нэгтгэх шаардлагыг буй болгож байна. Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэж орох уу, сугарч үлдэх үү, гэдгийг олон улсын болон үндэсний эрх ашигтай нягт уялдуулан шийдвэрлэх хэрэгтэй.

Хүйтэн дайны үе нэгэнтээ түүх болон үлдэж, дэлхийн оршин суугчид үзэл бодол, хил хязгаарын заагт баригдахгүй чөлөөт харилцаанд орох хязгааргүй боломж нээгдсэн нь манай эрин үеийн онцлогийг тодорхойлж байна. Гэвч олон улсын энэхүү нааштай, таатай өөрчлөлтийг дагалдан нийгмийн сөрөг үзэгдлүүд ч урьд хожид байгаагүйгээр даяарших хандлагатай болов. Үүний хамгийн анхаарал татсан хэлбэр нь үндэстэн дамнанс зохион байгуулалттай гэмт явдал юм.

Үндэстэн дамнанс зохион байгуулалттай гэмт явдал олон улсын хэмжээнд бодитой оршиж үйл ажиллагаагаа маш идэвхтэй үргэлжлүүлж байгаа нь тодорхой



ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрхлэгч
Хууль зүйн доктор,
профессор
Д.Зүмбэрэллхам

болж, үүний хор аюулаас ангид улс орон үлдэх боломжгүй нь нэгэнт, нийтэд илэрхий болжээ. Энэ байдлыг иш үндэс болгон НҮБ-аас Үндэстэн дамнанс зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцийг батлан гаргасан бөгөөд энэ баримт бичгийг өдгөө дэлхийн олон орон дэмжин түүнд нэгдэж ороод байна.

Монгол Улс энэ төрлийн гэмт хэргийн халдлагаас ангид үлдэх боломжгүй, ийм гэмт хэргийн сүлжээ байрлаж үйл ажиллагаагаа чиглүүлэх боломжтой бүс нутагт байрлаж байгаа эсрэг олон хүчин зүйлээ тооцож энэхүү конвенцид нэгдэн орох эсэх асуудлыг зайлшгүй судалж шийдвэрлэх хэрэгтэй болж байна.

Энэ асуудлын хүрээнд Үндэстэн дамнанс зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц буюу Палермогийн

конвенцид нэгдэн орох тохиолдолд оролцогч улсын хувьд үндэсний хууль тогтоомжийг түүнд нийцүүлэхэд юунд гол анхаарах талаар зарим судалгаа хийснээ та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын хууль тогтоомжийг Үндэстэн дамнанс зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Үндэстэн Үндэстний Байгууллагын конвенц (Палермогийн конвенц)-ийн зарим хэм хэмжээтэй харьцуулан авч үзвэл:

5 дугаар зүйлд: "Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн оролцоо, шинж чанарын талаар заасан байх ба түүнд гэмт бүлэглэл болон бүлэглэлийн ойлголтыг тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолтог үндэсний Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг харьцуулан үзэхэд төдийлөн зөрөөгүй, үндсэндээ тохирно гэж үзэж болохоор байна.

6 дугаар зүйлд: Гэмт хэргийн орлогыг угаах үйлдлийн талаар тусгажээ. Энэ зүйлд мөнгө угаах гэмт хэргийн хамгийн гол шинжийг юуны өмнө тухайн хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдэж байсан, ийнхүү мэдсэний үндсэн дээр тухайн хөрөнгийн хууль бүс эх үүсвэр, шинж чанар, байршил, захиран зарцуулах арга, эзэмших эрхийг нуун далдлах, өөрчлөх явдал гэж тодорхойлсон байна. Мөн түүнээс гадна гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах нь мөнгө угаах гэмт хэргийн үндсэн хэлбэрт хамаарахаар заажээ. Манай Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 163 дугаар зүйлд "Хууль бусаар олж авсан хөрөнгө, мөнгийг ашиглах" гэмт хэргийг заасан байгаагаар харьцуулахад мөнгө угаах гэмт

хэргийн агуулга нь хэт явцуу, Конвенцийн тодорхойлолтыг бүрэн агуулж чадахгүй байна. Энэ зүйлд мөнгө угаахыг "Илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгийг мэдсэн байж санхүүгийн болон ахуйн үйл ажиллагаанд оруулсан" үйлдлийг л хамааруулсан байх ба эх сурвалжийг нуун далдах, өөрчлөхтэй холбоотой ойлголтууд бүрхэг байгаа юм. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлийг гэмт хэргийн орлогыг угаах гэмт хэрэг гэж танихад төвөгтэй байна.

7 дугаар зүйлд: Мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээний талаар тусгай түүнд банк, банк бус санхүүгийн байгууллага, мөн бусад төстэй үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд өөрийн эрх мэдлийн хүрээнд үйлчлүүлэгчийн хэн болохыг мэдэх, сэжигтэй мөнгөний гүйлгээний талаар мэдээлэх үүрэг хүлээх асуудлыг хамааруулсан байна. Мөн энэ зүйлд сэжигтэй гүйлгээний талаар мэдээллийг авч дүн шинжилгээ хийх зорилготой санхүүгийн мэдээллийн шуурхай албaг байгуулах асуудлыг тусгажээ. 2006 онд батлан гаргасан "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн агуулга нь конвенцийн шаардлагыг үндсэндээ хангаж байна гэж үзэхээр байна.

8 дугаар зүйлд: Авлигын шинжтэй эрх зүйн зөрчлийн талаар, түүний гол шинжүүдийг тусгажээ. Манай улсад 2006 оны 11 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Авлигын эсрэг хууль Конвенцийн шаардлагыг үндсэнд нь хангаж байна. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 ба 269 дүгээр зүйлүүдэд хээл хахууль авсан, эсхүл өгсөн бол хээл хахуулийн гэмт хэрэгт тооцохоор заасан нь Конвенцийн шаардлагаас явцуу байх ба хээл хахууль өгөөгүй боловч өгөхөөр амласан, санал болгосон, хээл хахууль аваагүй боловч өгөхийг хүссэн, шаардсан нь төгс үйлдэгдсэн гэмт хэрэгт тооцохоор конвенцид тусгасан байгаа юм.

9 дүгээр зүйлд: Авлигын эсрэг арга хэмжээний талаар тусгаж түүнд энэ асуудлыг дагнан эрхлэх бие

даасан байгууллага болон түүний чиг үүргийн талаар заасан нь одоо манай улсад байгуулагдаад байгаа Авилгатай тэмцэх байгууллага, түүний чиг үүрэгтэй үндсэндээ тохирч байна.

10 дугаар зүйлд: Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгаж зохион байгуулалттай гэмт бүлэглэлд оролцсон хуулийн этгээд хариуцлага хүлээх ёстойг заагаад тэрхүү хариуцлага нь эрүүгийн, иргэний, захиргааны байж болно гэжээ. Эрүүгийн болон эрүүгийн бус хариуцлагын арга хэмжээ нь үр ашгтай, нөлөө бүхий байх ёстойг онцолж түүний дотор мөнгөн торгуулийн хэлбэр байж болохыг зориуд заасан байна. Манай улсын Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудал тусгагддаггүй байгаа. Эрүүгийн хуульд уг асуудлыг шинээр нэмж тусгахгүй бол конвенцийн энэхүү шаардлагыг биелүүлэх боломжгүй юм. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь манайд цоо шинэ асуудал бөгөөд конвенцийн шаардлагыг хүлээж авсан нөхцөлд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар зүйлд "Эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэнэ" гэсэн зарчмыг өөрчлөхөд хүрнэ.

11 дүгээр зүйлд: Мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэр гарах болон шийтгэлийн арга хэмжээ, 12 дугаар зүйлд: Эд хөрөнгийг хураан авах, 13 дугаар зүйлд: Эд хөрөнгийг хураан авах зорилгоор олон улсын хамтын ажиллагаа явуулах тухай заасан шаардлагуудыг үндэсний хууль тогтоомж ямар нэгэн хэмжээнд агуулж байгаа гэж үзэхээр байна.

14 дүгээр зүйлд: Хураан авсан гэмт хэргийн орлого эд хөрөнгийг захиран зарцуулах талаар тусгаж дотоодын хууль тогтоомжид энэ талаар тусгайлан зохицуулах шаардлагатайг заасан байна. Ингэхдээ хууль ёсны эзэмшигчид буцаах, уг гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох асуудлыг нэн тэргүүнд авч үзэхийг заажээ. Одоогоор манай үндэсний хууль тогтоомжид уг орлогыг хэрхэн захиран зарцуулах, хууль ёсны эзэмшигч улсад нь хэрхэн

буцаах, хохирогч хувь хүнд нөхөн төлбөр олгох асуудлыг хуульчилан зохицуулсан зүйл төдийлөн байхгүй байна.

15-23 дугаар зүйлүүдэд тухайн төрлийн гэмт хэргийг цуцхад харьяалан шийдвэрлэх, хэргийг болон гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, эрх зүйн тусалцаа харилцан үзүүлэх, хамтарсан мөрдөн байцаалт явуулах зэрэг асуудлуудыг тусгасан байх ба тус Конвенцид нэгдэн ороход үндэсний хууль тогтоомждоод энэ талаар саад болох зөрчилтэй зүйл байхгүй. Нэгдэн орсны дараа зохион байгуулалтын урьд тухайн үед арга хэмжээ авах замаар конвенцийн шаардлагыг биелүүлж болохоор байна. Түүнээс гадна энэхүү конвенцийн ихэнх шаардлага нэгдээд уян хатан, үндсэний эрх зүйн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон шинжтэй байгаа юм. Гэхдээ зөвлөмжийн шинжтэй гэж хүлээн авахаас аль болох зайлсхийх хэрэгтэй.

Палермогийн конвенцийн 24, 25 дугаар зүйлд уг конвенцид хамаарах гэмт хэргийг байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байх гэрч, хохирогч, тэдгээрийн ойр дотны хүмүүс болон төрөл төрөгсдийг байж болзошгүй өшөө авалт, сүрдүүлэл, заналхийллээс үр дүнтэй хамгаалах зорилгоор боломжтой тохиолдолд нүүлгэн суурьшуулах, тэдгээрийн биеийн байцаалт болон оршиж байгаа газрын тухай мэдээллийг задруулахгүй байх эсхүл задруулахыг хязгаарлах журмыг тогтоох, мөн аюулгүй байдлыг нь хангах үүднээс мэддүүлэх өгөхийг зөвшөөрсөн, түүнчлэн харилцаа, холбооны технологийг түүний дотор видео холбоо буюу бусад дүйдэх хэрэгслийг ашиглаж замаар мэдүүлэх өгөхийг зөвшөөрөх журам гаргах, хохирогчид нөхөн олговор олгох болон хохирлыг арилгах, өөр бусад тусалцаа үзүүлэх талаар боломжтой арга хэмжээ авахыг оролцож улсуудад үүрэг болгосон байна. Үндэстэн дамнанс, зохион байгуулалттай гэмт хэрэг, ялангуяа хүн худалдах гэмт хэргийн хохирогч, гэрч нарын хувьд давхар хохирол хохирол амсаж байдаг онцлогтой.

Монгол Улсын ЭБШХ-д гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эдийн болон эдийн бус хохирлыг арилгах аас бусад эрхийг хамгаалах, туслах талаар зохицуулалт байхгүй. Эдийн бус хохирлыг арилгах талаар зохицуулсан боловч уг хохиролд ямар хохирол багтах, хохирлын хэмжээг хэрхэн тогтоох тухай материаллаг хуулиар зохицуулаагүй тунхагийн шинжтэй зохицуулсан зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг арилгах эрх зүйн бодит боломж бүрдээгүй. Тэгэхээр Монгол Улсын ЭБШХ-д, эсвэл Гэрч, хохирогчийг хамгаалах, туслах тухай хууль батлан гаргах, гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах, тэдэнд тусалцаа үзүүлэх эрх зүйн зохистой зохицуулалт бий болгох шаардлагатай юм.

Монгол Улсын хууль тогтоомжийг Палермогийн конвенцийн нэмэлт болох "Хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх таслан зогсоох ба шийтгэх тухай протокол" (Палермогийн протокол)-той харьцуулан авч үзвэл:

Палермогийн протокол нь хүн худалдах гэмт хэргийн асуудлыг тал бүрээс нь авч үзсэн олон улсын эрх зүйн баримт бичиг бөгөөд үүгээр хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхийн тулд гэмт этгээдийг шийтгэх, хохирогчийг хамгаалах олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай байгааг цохон тэмдэглэх, хүүхэд, эмэгтэйчүүдийн ашиг сонирхлыг хамгаалсан жендерийн болон хүүхэд төвтэй шүүх ажиллагаа явуулах зэргээр хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүн худалдах гэмт хэргийн шууд болон шууд бус хохирогчдын эрхийг хангах, хамгаалахад туслах үүргийг хүлээлгэсэн байна. Тухайлбал,

Палермогийн протоколд хүн худалдах, түүний зорилго, арга хэрэгслийг нарийн тодорхойлноос гадна албадан болон хүчээр, хуурч мэхлэх замаар 18-аас доош насны хүнийг секс худалдаанд хамруулах, боолчлох, боолчлолтой төстэй бүх хэлбэрээр худалдах, худалдан авахыг хүн худалдах гэмт хэргийн хүнд хэлбэр, мөн хүнийг худалдах

зорилгоор тээвэрлэсэн, шилжүүлсэн үйлдлийг гэмт хэрэг гэж үнэ хэмээн тодорхойлсон байна. Тэгвэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд хүн худалдах, худалдан авах гэмт хэргийг хуульчилсан боловч ямар арга хэрэгсэл, зорилгоор үйлдсэнгийг болон хүндрүүлэх бүрэлдэхүүнийг, мөн тээвэрлэсэн, шилжүүлсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцох асуудлыг протоколын агуулгаар бүрэн тусгаагүй байгаа юм. Иймд үндэсний хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, хүний эрхийг хамгаалах олон улсын шаардлагын үүднээс Монгол Улсын Эрүүгийн хууль дахь хүн худалдах, худалдан авах гэмт хэргийг илүү дэлгэрэнгүй тусгаж, хүлээлгэх хариуцлагыг ч нарийвчлан авч үзэх шаардлага тавигдах боллоо.

Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтаар гишүүн орнуудад хүн худалдах хэргийн хохирогчдод үүссэн гарз хохирлоо нөхөн төлүүлэх боломжийг бүрдүүлсэн дотоодын хууль, эрх зүйн тогтолцоотой байхыг үүрэг болгосон байна. Өнөөгийн байдлаар Монгол Улсад эрх зүйн энэхүү тогтолцоо бүрдээгүй байгаа тул энэ талаар зохих судалгаа хийж, шаардлагатай арга Хэмжээ авах асуудал нэн тэргүүнд тавигдах байна. Ер нь манай улсад зөвхөн энэ ч биш бусад төрлийн гэмт хэргээс ч учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх явдал тулгамдаж байгаа.

Энд Палермогийн Конвенц ба үндэсний хууль тогтоомжийн харьцуулсан зөвхөн тоймыг харууллаа. Тус конвенцид нэгдэн орох тохиолдолд илүү дэлгэрэнгүй судалгаа, төлөвлөгөө гаргаж хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээг жич зохион байгуулж хэрэгжүүлэх нь зайлшгүй. Мөн энэхүү конвенцийн бусад нэмэлт протоколуудад нэгдэн орох эсэхтэй холбоотой асуудлууд ч үүнд хамаатай.

Монгол Улс өнөөгийн байдлаар олон улсын 200 гаруй гэрээнд нэгдэн орсон хэдий ч нэгдэн орсон эдгээр гэрээ, конвенцид үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ

учир дутагдалтай байсаар байна. ХЗҮТ-өөс өнгөрсөн онд Эрүүгийн эрх зүйн холбогдолтой, манай улсын нэгдэн орсон Монгол Улсын Олон улсын гэрээнд үүргийг өөрийн улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох хэм хэмжээнд үүргийг харьцуулсан судалгаа хийсэн. Үүнд Монгол Улсын Олон улсын 29 гэрээ хамрагдсан. Манай улс эдгээр гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу үндэснийхээ хууль тогтоомжид тусгавал зохих заалтуудын 21.2 хувь үндэсний хууль тогтоомжид бүрэн бус буюу огт тусгаагаагүй байгаа гэсэн дүгнэлт гарсан юм. Аливаа олон улсын гэрээнд нэгдэж орох, түүгээр хүлээсэн үүрэг биелүүлэх асуудлуудын хооронд зарим учир дутагдалтай зүйл байгаа нь үүнээс харагдаж байна.

Иймд тэдгээрт нэгдэн орохын өмнөх судалгаа тооцоо маш сайн хийж нэгэнт гэрээнд нэгдэн орсон л бол түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн догц арга хэмжээ авч байх шаардлага тавигдах байгаа юм. Энэ нь Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг шударгаар сахин биелүүлэх" ёстой гэсэн заалтыг ажил хэрэг дээр сахин биелүүлэх, манай улс илүү санаачилга гарган ажиллах шаардлагатай.

Эцэст нь дүгнэж хэлэхэд "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн Конвенц болон түүний нэмэлт протоколууд манай улс нэгдэн ороход Үндсэн хуулийн болон бусад хуулийн үзэл баримтлал, үндсэн зарчмуудтай харшлах зүйлгүй бөгөөд харин тэдгээрт нэгдэн орох нь манай үндэсний аюулгүй байдлын эрх ашигт бүрнээ нийцнэ гэж үзэж байна.



БНХАУ-ЫН ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улс ардчилал, зах зээлийн нээлттэй эдийн засгийн бодлого хэрэгжүүлж эхэлсэн үеэс гадаадын иргэд манай оронд ирэх тоо их хэмжээгээр нэмэгдэх болсон бөгөөд үүний зонхилох шалтгаан нь ажил эрхлэх, оршин суух, Монгол Улсын иргэнтэй гэр бүл болох явдал юм.

Монгол Улсын иргэний харьяалалтай болсон гадаадын иргэн 2001 онд 5, 2004 онд 23, 2005 онд 11 байсан бол 2006 онд 25 болтлоо өссөн байна. Эдгээр иргэдийн 22 нь БНХАУ-ынх, 2 нь ОХУ-ынх, 1 нь Түвдийн иргэн байсан байна. Энэхүү тоон үзүүлэлтээс харахад Монгол Улсын иргэний харьяалалтай болсон иргэдийн дотор БНХАУ-ын иргэд ихэнх хувийг эзэлж байгаа нь энэ асуудлаар төрөөс үндэсний язгуур эрх ашигт нийцсэн бодлого баримтлах, тус улсын гэр бүлийн эрх зүйг судалж үзэх шаардлага зүй ёсоор гарч байна.

1980 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн III Их хуралдаанаар батлагдсан Ургийн буюу гэр бүлийн хуульд тус улсын хүн амын хэт өсөлтийг шийдэх аргын нэг нь болох орой гэрлэхийг дэмжих хандлага илт харагддаг; уг хуулийн 2 дугаар зүйлд зааснаар гэрлэгсэдэд "гэр бүл төлөвлөлт"-ийг үүрэг болгожээ.

Хуульд зааснаар 20 нас хүрсэн эрэгтэй, 22 хүрсэн эмэгтэй, харин цөөнх үндэстэний 20 нас хүрсэн эрэгтэй, 18 нас хүрсэн эмэгтэйн гэрлэлт нь тодорхой зарчимд тулгуурладаг. Эдгээр зарчмын агуулгыг товч авч үзвэл:

• Ургийн явдал эрх чөлөөтэй байх зарчим

Эрэгтэй, эмэгтэй хоёрын гэрлэх болон гэрлэлтээ цуцлуулах нь эрх чөлөөтэй, харин гуравдагч этгээд хөндлөнгөөс оролцож, эд хөрөнгө, мөнгө авах, худалдахыг



ХЗҮТ-ийн (ЭЗМНС-ийн)
ажилтан, хууль зүйн
магистр Ц.Түвшинзаяа

хуулиар хоригложээ. Хөндлөнгийн гуравдагч этгээд гэдэгт эцэг, эх багтана.

• Нэг эрэгтэй, нэг эмэгтэй байх зарчим

Эрэгтэйн эсвэл эмэгтэйн өмнөх гэрлэлт хүчинтэй байх үед гэрлэх буюу давхар гэрлэх, хоёр эхнэртэй байхыг хоригложээ. 1950 оны Ургийн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш ямар нэг шалтгаанаар давхар гэрлэхийг хууль зөрчсөнд тооцдог болсон. БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлд давхар гэрлэсэн буюу өмнөх гэрлэлт хүчин төгөлдөр байгааг мэдсээр байж хамтран амьдарсан тохиолдолд 2 жил хүртэлх хугацаагаар хорих, хорьж хөдөлмөрлүүлэх аргыг сонгож хэрэглэнэ гэж заажээ.

• Эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байх зарчим

Эрэгтэй, эмэгтэй буюу гэрлэгчид улс төр, нийгэм, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож харилцан бие биенээ хүндэтгэхийг хуульчилжээ. Эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байх зарчмын

агуулга нь нилээд өргөн утгатай. Тухайлбал, эхнэр, нөхөр хоёр өөр өөрсдийн овгоор овоглох эрхтэй, гэр бүл төлөвлөх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх эрхтэй.

Энэ зарчмын агуулга нь Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан зарчимтай адил юм.

• Эмэгтэйчүүд, хүүхэд ба өндөр настаны хуульд заасны дагуу тэдний эрх ашгийг хамгаалах, гэр бүл ба өндөр настан, нялхасын эрх ашгийг төр хамгаална " гэсэн нь манай улсын гэр бүлийн эрх зүйн зарчимтай төсөөтэй байна.

БНХАУ-ын Үндсэн хуульд

• Төлөвлөгөөт төрөлтийн зарчим

Энэ зарчмын гол агуулга нь Хятад улсын хүн амын өсөлтийн хурдацтай холбоотой юм.

Гэрлэх насанд хүрсэн, хуульд заасан харшлах шалтгаангүй эрэгтэй, эмэгтэй харилцан зөвшөөрлөснөөр гэрлэж болно.

Гэрлэхэд харшлах шалтгаан: - Цусан төрлийн ба гурван үеийн дотор гэрлэх

Манай улсын хувьд ч гэсэн гэр бүлийн тухай хуульд "төрөл, садангийн хүмүүс хоорондоо гэрлэх" гэсэн зохицуулалт бөгөөд Үдэлхийн олон улс оронд хүлээн зөвшөөрдөг юм. Энэхүү хориглоосон зохицуулалтад:

• Өмөн өвчинтэй бол /нийгэмд хор аюултай халдварт өвчин/;

- Гэхдээ энэ өвчинг эмчилж эдгэрсэн тохиолдолд гэрлэхийг зөвшөөрдөг юм байна.

- Эмнэлэгийн дүн шинжилгээгээр төрөлхийн оюуны хомсдолтой, мэдрэлийн өвчтэй гэж тогтоогдсон бол.

Гэрлэлт цуцлалт

Хэрэв эхнэр, нөхөр хоёр ямар нэг эд хөрөнгийн маргаангүй, хүүхдийн тэтгэлэг, сурган хүмүүжлийн зардал зэргийг даах талаар хэлэлцэн тохирч гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрсөн тохиолдолд иргэний байдлын бүртгэлийг хариуцсан албан тушаалтанд хандаж, зохих маягыг бөглөхөд хангалттай байдаг байна. Гэрлэлтээ цуцлуулах нь зөвхөн эрэгтэй, эмэгтэйн хоорондын харьцааг хүчингүй болгодог. Харин үр хүүхдээ асран тэтгэх үүрэг нь хэвээр байна. Хэрэв эд хөрөнгийн маргаантай байвал шүүх эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг хамгаалах зарчмыг баримтална. Гэрлэлт цуцлуулах үеийн өрийг гэрлэгсэд хамтран төлөх үүрэгтэй.

Харин цэргийн албан тушаалтан гэрлэлтээ цуцлуулах тохиолдолд заавал дээд албан тушаалтнаасаа зөвшөөрөл авсан байх ёстой.

Санал:

◆ Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-заалтанд Монгол Улсын иргэн гэр бүлээ албан ёсоор батлуулах насны доод хязгаарыг хуульчилан тогтоож өгсөн байдаг. Энэ нь гэр бүлээ батлуулж буй иргэний хувьд амьдралын хангалттай туршлага хуримтлуулаагүй, гэр бүлээ толгойлох чадвар, ажил хөдөлмөрийн туршлага, нийгэмд эзлэх байр суурь нь төлөвшөөгүй зэрэг байдалд гэр бүлээ батлуулах нь буцаад гэр бүлээ цуцлуулах нэг шалтгаан болоод байна. Иймд гэр бүлээ хууль ёсны дагуу батлуулах иргэний насны доод хязгаарыг 20 нас болгох саналтай байна.


◆ Монгол Улс дэлхийн олон улстай хоёр болон олон талын гэрээ, хэлэлцээр байгуулсан байдаг. Тэр дотроо хоёр талын "Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ" нь тухайн хоёр улсын иргэдийн эрх, эрх чөлөөт илүү нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгсөн нь ач холбогдолтой юм. 1989 оны 8 дугаар сарын 31-нд манай улс хөрш залгаа БНХАУ-тай эрх зүйн туслалцаа үзүүлэх хоёр талын гэрээ байгуулан одоог хүртэл энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

Гэвч уг гэрээг бусад улс оронтой байгуулсан адил төрлийн гэрээүүдтэй харьцуулан авч үзвэл:

Хүснэгт, графикаас харна уу.

Хүснэгтээс харахад БНС Вьетнам улстай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг харьцангуй тодорхой тусгасан байна. Өөрөөр хэлбэл, иргэний хэргээс гэр бүлийн эрх зүйн харилцааг тусад нь хэсэг болгон зохицуулсан байна. Тэгвэл БНХАУ-тай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ нь гэр бүлийн эрх зүйн харилцааг нарийвчлан зохицуулаагүй гэж хэлж болохоор. Иймд дээрх гэрээний зохицуулалтад гэр бүлийн эрх зүйн харилцааг нарийвчлан зохицуулах шаардлага байна.

Монгол Улсад гэр бүлээ гэрчлүүлсэн болон цуцлуулсан байдал сүүлийн 10 жилийн байдлаар:



БНХАУ 1989.08.31 Иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх	БНСВ 2000.12.28 Иргэн, гэр бүлийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа болон харилцаа
<ul style="list-style-type: none"> - шүүхийн зардлаас хөнгөлөх, чөлөөлөх - баримт бичгийг хургуулах болон шалгах нотлох - даалгавар биелүүлэх - биелэлтийг мэдэгдэх дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын эрх мэдэл - шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх хэмжээ хязгаар - шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах - шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх журам - шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх журам - шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай хүсэлт гаргах - хүсэлтэд хавсаргах баримт бичиг 	<p>Гэр бүлийн хэрэг</p> <ul style="list-style-type: none"> - гэрлэх - гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцаа - гэрлэлтийг цуцлах - гэрлэснийг хүчингүйд тооцох - эцэг, эх, хүүхдийн эрхийн харилцаа - хүүхэд үрчлэх - асран хамгаалах, харгалзан дэмжих

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн

Логан Түүрч нь 2007 оны №1 дугаар/

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үүсэл

Эвсэлд үл нэгдэх гэж юу болох, түүний шинж чанар, ач холбогдлыг ойлгосноор эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний талаар мэдэх зайшгүй шаардлага гарна. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь Ази, Африкийн 29 орны колоничлолтой тэмцэх зорилгоор Индонезийн Бандунг хотноо 1955 онд хийсэн уулзалтаас үүдэлтэй юм. Тус бага хурлын удирдагчдын нэг болох Жавахарлал Нэру хэлэхдээ, Ази, Африкийн орнуудын удирдагчид ийнхүү уулзаж буй нь маш ач холбогдолтой үйл явдал юм хэмээн үнэлж, Азийн төрснийг болон шинэ Африк бий болсныг цохон тэмдэглэсэн юм.

Гэсэн хэдий боловч эвсэлд үл нэгдэх нь олон улсын бүлгийн хувьд 1961 онд болсон Белградын бага хурлаар бий болсон юм. Тус бага хуралд Ази, Африкийн 26 орон, Европын нэг орон оролцсон юм. Түүнчлэн Латин Америкийн 3 орон ажиглагчийн статустайгаар оролцсон. Бага хурлаар 27 зүйлт Тунхаглалыг баталсан бөгөөд зарим чухал асуудлаас дурдвал, олон улсын энх тайвныг сахин хамгаалахад том гүрнүүдэд шахалт үзүүлсэн бөгөөд колоничлол болон империализмыг буруутгасан юм. Мөн тус бага хурлаар зэвсэглэлээр үл хөөцөлдөхийг авч хэлэлцсэн. Эдгээр зарчмыг Ази, Африкийн шинээр тусгаар тогтносон орнууд авч үзээд хөдөлгөөнд нэгдэн орсон юм.

Дараагийн бага хурал Кайрт 1964 орны 10 дугаар сард зохион байгуулагдсан. Тус бага хуралд 47 орон оролцсон ба 11 улс ажиглагчаар оролцов. Энэхүү бага хурал нь онцлогтой болсон ба эвсэлд үл нэгдсэн орнууд Белградтад уулснаас хойш маш олон чухал хөгжил, өөрчлөлт гарсан байхал. Энэ үед дэлхий ертөнцөд Кубын



ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр П.Баяр

пуужингийн хямрал, Панчшидгагийн зарчмыг зөрчсөн Энэтхэг, Хятадын 1962 оны зөрчилдөөн, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг санаачлагч Жавахарлал Нэру ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн байлаа. Кайрт болсон бага хурлаар "Энх тайван ба олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөр" нэртэй тунхаглалыг баталсан юм.

Тунхаглалд бүх нийтийн эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс харагдах болсон ба империализм, колоничлол ба нео-колоничлол үгүй болсон тэр үед энх тайвныг батлан хамгаалах юм гэж заасан байдаг. Мөн энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг цохон тэмдэглэж, олон улсын маргааныг энх тайвны замаар шийдвэрлэхийг шаардсан юм. 1970 оны 9 дүгээр сард Замби улсын Лусака хотноо эвсэлд үл нэгдсэн орнуудын гурав дахь хурал болсон. Тус бага хуралд 54 орон оролцсон ба 9 орон ажиглагчаар оролцсон байна. Бага хурлаар "эвсэлд үл нэгдсэн орнууд энх тайван, олон улсын хамтын ажиллагааны тусын тулд хамтын ухаанаа хэрэглэн эрх мэдлийг хуваарилахад нөлөөлж чадна" гэж тэмдэглэсэн бөгөөд цаашлаад "эвсэлд үл нэгдсэн орнууд маргаашийн ертөнцийг бий болгох

ба хүн төрөлхтний амьдралын үнэт зүйлсийг баяжуулах хөдөлгөөний тэргүүн манлайд байх ёстой" хэмээн уриалсан юм. Бага хурлаар Түгээмэл тунхаглал болон гол 6 тогтоолыг батлан гаргасан юм.

"Эвсэлд үл нэгдэх ба Эдийн засгийн хөгжил" түгээмэл тунхаглалаар эвсэлд үл нэгдэх ач холбогдлыг онцгойлон авч үзсэн ба маргааныг гагцхүү энх тайвны аргаар шийдвэрлэж байхыг ерөнхийдөө бүх улс гүрэнд, ялангуяа, том гүрнүүдэд уриалсан байна. Мөн улс орныг чөлөөлөх болон эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явцыг хурдасгах хэрэгцээ байгааг цохон тэмдэглэсэн байна. Колоничлолоос зайлсхийх, арьс өнгөөр ялгааварлах явдалтай холбоотой НҮБ-ын шийдвэрийг дагаж, биелүүлээгүй Португал болон Өмнөд Африктай эдийн засгийн болон дипломат харилцаагаа таслах шийдвэрийг хүлээн авсан бөгөөд мөн Израилийг эзлэн түрэмгийлсэн газар нутгаасаа гарахыг шаардсан байна.

1973 онд Алжирт болсон 4 дүгээр бага хуралд 76 гишүүн орон, 9 орны ажиглагч оролцсон байна. Энэ нь дэлхийн хамтын нийгэмлэгийн тал хувь бөгөөд дэлхийн олонхийг төлөөлсөн бага хурал болсон юм. Алжирийн бага хурлаар улс төр, эдийн засгийн маш нарийвчилсан тогтоолуудыг баталсан ба эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг жагсаасан байна. Тус бага хурлаар улс, үндэстэн бүр өөрийн баялгаа эзэмших эрхтэй ба эдийн засгийн үйл ажиллагаагаа хянаж эрхтэй гэсэн зарчмыг дэвшүүлж үндэстэн дамнансан корпорациудын явуулж буй бодлогыг буруушаасан юм. Учир нь тэдний явуулж буй үйл ажиллагаа нь хөгжиж буй олон буурял хөгжилтэй орнуудын хувьд эдийн засгийн хохиролтой бөгөөд монополийг эрх эзлэж байна гэж үзсэн. Бага хурлын дэвшүүлсэн хамгийн чухал зүйл бол хөгжиж буй орнуудад хандан "үзэл бодлоо солилцоход өөрсдөө голлох

үүрэгтэй оролцож, хамтран ажиллах явдлыг хөхиүлэн дэмжсэн" явдал юм.

Эвсэлд үл нэгдсэн орнуудын 5 дахь бага хурал 1976 оны 8 дугаар сард Колумбид болсон бөгөөд дэлхийн 86 орон оролцсон юм. Тус бага хурал нь олон талаараа ач холбогдолтой байсан. Оуны өмнө, энэхүү бага хурал нь эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний өлгий болсон Ази тивд анх удаа зохиогдсон юм.

Хоёрдугаарт, тус бага хурлаар Африк болон Латин Америкийн асуудлууд зонхилж байв.

Гуравдугаарт, бие даан шийдвэрлэх болон хамтын хэлэлцээ хийх хүч чадлыг ашиглан олон улсын хэлэлцээр хийх хууль ёсны эдийн засгийн эрхийг баталгаажуулах талаар авч хэлэлцсэн байна.

Дөрөвдүгээрт, НҮБ-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Аюулгүйн Зөвлөлийн хориг тавих тогтолцоог цуцлахыг шаардсан байна.

Тавдугаарт, шинэ, шударга олон улсын эдийн засгийн журмыг байгуулахыг уриалсан. Тэхдээ эвсэлд үл нэгдсэн хөгжиж буй орнууд нь эдийн засгийн хувьд чөлөөт байхыг хүсч байсан боловч том гүрнүүдтэй тулахыг хүсээгүй. Харин хөгжиж буй орнууд нь харилцаа ач холбогдолтой хамтран ажиллах эсрэгтэй болохыг цохон тэмдэглэж байсан.

Эвсэлд үл нэгдсэн орнуудын 6 дахь бага хурал Кубын Гаванад 1979 оны 9 дүгээр сард болсон. Тус бага хуралд дэлхийн хамтын нийгэмлэгийн 2/3, дэлхийн нийт хүн амын талаас илүү болох 94 орон оролцсон байна. Энэ бага хурлаар анх удаа фракцын асуудал хөндөгдсөн. Куба, Вьетнам мэтийн зарим нэг радикал үзэлтнүүд хоёр туйлтэй эн зэрэгцэж чадахгүйгээс хойш империализм, колоничлолын эсрэг тэмцэж байгааг нь харгалзан үзээд социалист пагерт нэгдэн орох нь зүйтэй гэж үзсэн байна. Нөгөө тал болох Сингапур, Зайр зэрэг улс барууныхантай ойртоё, тэд арвин их нөөцтэй бас техникийн давуу талтай нь бидэнд эдийн засгийн хөгжилд тустай юм гэсэн байна. Гэсэн хэдий ч, туйлын ухаантай зөвлөхүүд болон хөдөлгөөний гишүүдийн

олонх нь "хөдөлгөөн нь өөрийн бие даасан мөн чанарыг хадгалах ёстой" гэсэн байр суурийг баталсан. Бас нэгэн ноцтой аюул бол эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний эв нэгдэлд аюул учирсан. Энэ бол Египет Улс Арабчуудаас урван Израйльтэй "Camp David" гэрээ байгуулсан учраас Арабын орнууд Египетийг бүлгээс хөөхийг шаардаж байсан. Гэхдээ энэ асуудал нь явцтай байсан. Учир нь хөөх шалтгаан нь нэг талт Camp David-ийн гэрээ гэгч байсан юм.

Бага хурлын төгсгөлд гаргасан тунхаглалаар том гүрнүүдийн манлайсан бодлогыг буруушааж, цэргийн баазуудыг тараахыг уриалсан байна.

Улмаар 7 дахь бага хурал нь 99 орон оролцсон Нью Дели хотноо 1983 оны 3 дугаар сарын 7-12 -нд өргөн хэмжээнд болсон ч хоёр гишүүн орон оролцож чадаагүй байна. 20 орон ажиглагчаар оролцсон, 19 орон, олон улсын байгууллагууд зочноор оролцсон байна.

Хурлын төгсгөлд Их гүрнүүдэд хандан цөмийн хямралд хүргэж болох үйл ажиллагаагаа зогсоохыг хүссэн илгээлт гаргасан. Түүнчлэн протекционист болон дотогшоо харсан бодлогоосоо зайлсхийж, дэлхийн шинэ журмын төлөө ажиллах, хөгжлийн төлөө бага хурлуудыг мөнгө санхүүгийн хувьд оролцох, зөрчил, мөргөлдөөнгүй олон талт харилцааны амин сүнсгийг бий болгохыг уриалж, шаардсан байна. Мөн тус бага хурлаас улс төр, эдийн засгийн болон бусад тунхаглалыг батлан гаргасан байна. Улс төрийн тунхаглалд цөмийн зэвсгийг хэрэглэхийг шууд хориглох, цөмийн зэвсгийн туршилт хийхийг хориглох, цөмийн зэвсгээр үл хөвчлөх тухай иж бүрэн гэрээг байгуулахыг уриалсан байна. Эдийн засгийн тунхаглалаар олон улсын эдийн засгийн шинэ хэв журмыг бий болгохыг шаардсан. Үүгээр албан ёсны хөгжлийн тусламжийг буурай хөгжилтэй орнуудад үзүүлэх мөн тэдгээр улсуудын өрийг хүчингүй болгох, хөгжиж буй орнуудад үзүүлж буй хөгжлийн тусламжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг шаардсан. Тунхаглалыг өрөнхийдөө дэлхий даяар хүлээн зөвшөөрсөн байна.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний 8 дахь бага хурал Зимбабве улсын нийслэл Харарэд 1988 оны 9 дүгээр сарын 1-7-ны өдөр болсон ба 101 орон тэргүүн нар ба Зимбабве Улсын эрэнхий сайд Роберт Мугабиэй эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний даргаар сонгосон байна. Бага хурлаас арьс өнгөөр ялгаварлах үзэл бүхий Преторийн дэглэмээс үүдэлтэй тогтвортой бус байдалтай учраад байсан Африкийн хил залгаа орнуудыг бэхжүүлэх тодорхой хөтөлбөр батлан гаргасан байна. Түүгээр зогсохгүй тохирох төслүүдийг хэрэгжүүлэх Энэтхэгийн өрөнхий сайд Ражив Гандийн удирдлаган дор сан байгуулахаар шийдсэн байна. Бага хурлаар энэхүү дэглэмийн эсрэг цогц арга хэмжээ авахаар НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлөөр иж бүрэн, заавал биелүүлэх хариуцлагыг батлуулахаар өгсөн байна. Мөн НҮБ-ыг энэ талаар цаашид цаг алдалгүйгээр шаардлагатай арга хэмжээ авахыг шаардсан байна. Мөн бага хурлаас гаргасан тэмдэглүүштэй нэгэн шийдвэр бол эвсэлд үл нэгдсэн зарим орны Гадаад хэргийн сайд нарын зөвлөлийг байгуулсан юм. Энэхүү зөвлөл нь АНУ, Их Британи, Баруун Герман, Япон зэрэг улсад айлчилж, эдгээр улсын Засгийн газрын зүгээс Өмнөд Африкийн эсрэг хориг арга хэмжээ авахыг ятаж байсан. Бага хурлаас АНУ-ын өрөнхийлөгч Рейгэн, ЗХУ-ын дарга Михайл Горбачёв нарт цөмийн туршилтаг цуцлах арга хэмжээ авахыг мэдэгдэв.

Эвсэлд үл нэгдсэн орнуудын 9 дэх бага хурал 1989 оны 9 дүгээр сарын 4-7 -ны өдөр Белградэд зохион байгуулагдаж, 102 орны тэргүүн нар оролцов. Тэргүүнүүд буурай хөгжилтэй орнуудыг мөхлүүлж буй дарамт болох гадаад өрийн асуудлыг тэнгэх, эдийн засгийн хөгжлийг хөгжингүй орнуудаас шаардсан юм. Эвсэлд үл нэгдсэн орнууд бүх улсын хөгжлийн түвшинг баталгаажуулах олон улсын эдийн засгийн чуулганыг санаачилсан дөрвөн орны Парисын санаачилгыг дэмжсэн юм. Мөн дэлхийн энх тайван, аюулгүй байдла хөгжлийн асуудлаас улам бүр шууд замаарах болно гэдгийг цохон тэмдэглэсэн юм.

Чуулганаас зэвсэглэлээр үл хөөцөлдөхийг туйлд нь хүргэх, ялангуяа үй олноор хөнөөх зэвсэгтэй холбоотойгоор дорвитой арга хэмжээ авах, арьс өнгөөр ялгагдарах явдлыг устгахыг шаардсан юм. Хүний эрхийг онцгой анхаарах, хүний эрхийг хангахгүйгээр хөгжлийн тухай яриад хэрэггүй болохыг онцолсон байна.

1991 оны 9 дүгээр сард Эвсэлд үл нэгдсэн орнуудын гадаад хэргийн сайд нарын уулзалт Ганад болж, "Тэмцэл, мөргөлдөөнөөс олон улсын хамтын ажиллагаа руу дэлхийн хөдөлгөөн" тунхаглалыг баталснаар дэлхийн энх тайван ба хамтын ажиллагааны алсын харааг зөгнөж, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний шинэ хандлага ядуурал, өлсгөлөн, өлмөн зэлмэн байдал болон бичиг цусг үл мэдэх явдлыг арилгахад чиглэх ёстой бөгөөд энэ тал дээр олон улсын хамтын нийгэмлэгээс шаардлагатай тусламж үзүүлэхийг уриалсан байна.

Эвсэлд үл нэгдсэн орнуудын 10 дахь чуулган 1992 оны 9 дүгээр сарын 1-6 ны өдөр Жакарта хотноо болсон ба 108 гишүүн оролцсон байна. Хэдийгээр гишүүд Югославын асуудал дээр янз бүрийн байр суурьтай байсан боловч Босни-Герцогованийн асуудал дээр нэгдсэн нэг зөвшилцөлд хүрсэн юм. Төр засгийн тэргүүнүүд Босни-Герцогованийн нутаг дэвсгэрээс гадны хүчнийг яаралтай гаргах, НҮБ-ын эхнийг сахуулах хүчнийг тус улсын хил дагуу болон зарим газарт байршуулахыг шаардсан байна. Чуулганаас НҮБ-ыг "орнуулахгүйгээр" шинэ хэлбэрийн олон улсын дэг журмыг байгуулахыг уриалсан. Улмаар НҮБ-ын тогтолцоог дахин зохион байгуулах, ардчилсан саналыг бодитой түр дүнд хүргэх зорилготой дээд түвшний ажлын хэсгийг байгуулсан юм. Мөн тус чуулганаас Уругвайн үе шатны хэлэлцээрт оролцогч бүх талын эрх ашигт нийцсэн, хөгжиж буй орнуудад адил тэгш, тэнцвэртэй шийдвэрт хүрэхийг шаардсан байна. Тэргүүнүүд цөмийн зэвсэггүй ертөнцтэй байхыг хүсэмжилж буйгаа дахин тэмдэглэж, үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсгийг бууруулахын төлөө идэвхитэй ажиллахыг уриалсан байна.

Египтийн Кайрт 1994 оны 6 дугаар сард хүйтэн дайны дараахи дэлхий ертөнцөд зохицсон шинэчлэх хөдөлгөөн бүхий уриатай эвсэлд үл нэгдсэн орнуудын Гадаад хэргийн сайд нарын чуулган болсон байна. Гадаад хэргийн сайд нарын авч хэлэлцсэн асуудлууд дотроос хамгийн чухал асуудал бол хоёр гишүүн хоорондын маргаанд үл оролцох, зарим гишүүдийн шаардлаа дагуу 77-гийн бүлэгтэй Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг нэгдүүлэхгүй байх; худалдаа болон хөгжлийн бусад салбарт хөгжсөн болон хөгжиж буй орнуудын тэгш байдлад хүрэх зорилготой байсан юм. Мөн тус уулзалтаар бүрэн зэвсэггүй байх асуудал дээр дэлхий нийтээр нэгдмэл байр суурьтай байх талаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн онцгой чуулганыг хуралдуулах саналд хүрсэн юм.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүд болох 113 орон оролцсон 11 дэх чуулган 1995 оны 10 дугаар сард Колумбийн Картагенид зохион байгуулагдсан юм. Үй олноор хөнөөх зэвсгийг устгах зорилгод шаардлагатай эхний алхам болох цөмийн зэвсэггүй бус байгуулахыг уриалсан бөгөөд улс орнуудад хандан тэдгээр бүсийг байгуулах тухай гэрээг байгуулахыг уриалсан юм. Мөн санал хураах тогтолцооны хувьд хөгжиж буй орнууд дуугаа хүргэж чадахгүй байгаа Дэлхийн банк, Олон улсын валютын санг шинэчлэхийг шаардсан байна.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалт Шинэ Делид 1997 оны 4 дүгээр сард болсон байна.

Тус уулзалтаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг өргөжүүлэх болон Палестины асуудлаар эцсийн баримт бичиг ба хоёр тусгай тунхаглалыг баталсан байна. Төгсгөлийн баримт бичгээр Зэвсэглэлээр Үл Хөөцөлдөх Бага Хурлаас юуны өмнө тодорхой тогтоосон хугацааны дотор цөмийн зэвсгийг бүрэн устгах үе шат бүхий хөтөлбөр болон Цөмийн зэвсгийн тухай конвенцийн талаар зөвлөлдөж эхлэх түр хороог байгуулсан байна. НҮБ-ыг шинэчлэхтэй холбоотой тунхаглалаар хөгжингүй орнуудын тэргүүн нарыг адил тэгш ба

ардчилсан зарчмын үндсэн дээр хөгжиж буй орнуудтай мөн газар ажиллахыг уриалсан юм. Мөн тус нутгийн хувьд адил тэгш төлөөллийн болон улс гүрний тусгаар тогтнолын тэгш эрхийн зарчмыг үндэслэн Аюулгүйн Зөвлөлийн гишүүнчлэлийг нэмэгдүүлэхийг уриалсан юм. Түүнчлэн Аюулгүйн Зөвлөл ажил үргээг гүйцэтгэхэд ил тод, хариуцлагын болон ардчилсан зарчим шаардлагатай болохыг тэмдэглэсэн байна. Палестины асуудлаар Гадаад хэргийн сайд нар Израилтай харилцаагаа хөндийрүүлэх замаар Дундад Азид энх тайвны үйл ажиллагааг эрчимжүүлэхийг гишүүдэд мэдэгдсэн юм. Тус бага хурлаар мөн олон улсын эдийн засгийн шинэ зах зээлийг байгуулах эдийн засгийн шинжээчдийн хөндлөнгийн хэсэг байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Өмнөд Африкт болох дараагийн Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний Чуулганд тайлангаа ирүүлэхээр болсон.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний 12 дугаар чуулган Өмнөд Африкийн Дурбанд 1998 оны 9 дүгээр сард болсон байна. Тус чуулганаар хил дамнан терроризм, дэлхий нийтээрээ зэвсэглэлээр үл хөөцөлдөх болон эдийн засгийн глобальчлалын эрх үе дэх зэвсгийг үл нэгдэх хөдөлгөөний ач холбогдлыг авч хэлэлцсэн байна. Мөн чуулганаас эвсэлд үл нэгдсэн орнууд гадаадын цэргийн хүчнийг өөрсдийн нутаг дэвсгэр дээр байрлуулахгүй байхыг мэдэгдсэн.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний Гадаад хэргийн сайд нарын 13 дугаар чуулган Колумбын Картагенид 2000 оны 4 дүгээр сард зохион байгуулагдсан бөгөөд 115 орны Гадаад хэргийн 50 сайд нар энх тайван, зэвсэглэлээр үл хөөцөлдөх болон хөгжил гэсэн 3 асуудлыг хэлэлцсэн байна.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний 13 дугаар чуулган Куала Лампурт 2003 оны 2 дугаар сард болсон ба 2 шинэ гишүүн орон болох Зүүн Тимор, Ст.Винсантийг багтаасан 112 гишүүн орон оролцсон байна.

Чуулганаас "Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний шинэчлэлийг үргэлжлүүлэх нь" тунхаглалыг баталсан бөгөөд гишүүн орнууд

НҮБ-ыг хүчирхэгжүүлснээр олон туйлт ертөнцийг дэмжиж болох шийдвэрээ дахин илэрхийлсэн юм. Тунхаглалаар гишүүдийн нэгдлийг болон олон талт үйл ажиллагааг сайжруулах, ардчиллыг хөхиүүлэн дэмжих, Өмнөд-өмнөд хамтын ажиллагааг үлс төр, нийгэм, соёл, эдийн засаг ба шинжлэх ухааны салбарт өрнүүлэх "9 шүдэт" стратегийг гаргасан юм.¹

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний 14 дэх чуулган Кубын нийслэл Гаванад болсон бөгөөд Фидел Кастрог ерөнхийлөгчөөр сонгосон байна. Гэсэн хэдий боловч тэрбээр хагалгааны улмаас биечлэн оролцож чадахгүй болсон юм. Улмаар ерөнхийлөгчийн үүрэгт ажлыг гүйцэтгэж байсан түүний дүү болох Раул Кастро чуулганыг даргалсан юм. Тус чуулганаас баталсан тунхаглалд 2 цэргийг нь барьцаалсан Ливаний Хесболлах цэргийн бүлэглэлийн буруутай үйл ажиллагаанаас болж Ливаний эсрэг довтолсон Израйлийг буруушааж, НҮБ-ыг жижиг гишүүн орнуудыг илүүдлээр төлөөлөхийг уриалсан байна. Түүнчлэн, Ираны цөмийн энергийн хөтөлбөрийг дэмжихийн ялдамд АНУ-ын явуулж буй гадаад бодлогыг шүүмжилсэн байна.

Хэдийгээр Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд зарим нэг шүүмжлэлтэй зүйл байсан авч, 1961 онд Жакартад 25 орон оролцож байсантай харьцуулахад эвсэлд үл нэгдсэн орнууд одоо 113 болон нэмэгдсэн байна. Зарим гишүүний хувьд ялгаатай зүйл байсан ч гэсэн дэлхийн энх тайвны, зэвсэглэлээр үл хөөцөлдөх, хөгжлийн төлөө ба колоничлолын эсрэг чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Ялангуяа эвсэлд үл нэгдсэн орнууд НҮБ-д идэвхтэй байр суурьтай байж, сонгосон замаасаа хэзайгаагүй юм.

Эвсэлд үл нэгдсэн орнуудын оруулсан гол ач холбогдолтой зүйлс нь:

1. Эвсэлд үл нэгдсэн орнуудын тоо нэмэгдсэн нь хүйтэн дайныг намжаах болон шинээр тусгаар тогтносон орнуудыг хүчний лагериудаас ангид байлгахад урам зориг өгсөн байна. Яахын

аргагүй энэ нь хүчний улс төрийн учруулсан нилээд хэдэн асуудлыг шийдвэрлэхэд тус болсон.

2. НҮБ-ын мөн чанарыг үлэмж хэмжээгээр өөрчилж, Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн дурараа эрх мэдлээ хэрэгжүүлэхэд хяналтын үүрэг гүйцэтгэж байсан ба учир нь Ерөнхий Ассамблейд дийлэнх хүчнийхээ давуу талыг ашиглан эвсэлд үл нэгдсэн орнууд зарим нэг ёс зүйн хяналтыг том гурнуудад тавьж чадаж байсан.

3. Хэдийгээр хоёр их гүрний хувьд эвсэлд үл нэгдсэн орнуудын хувьд үл итгэсэн байр суурьтай байсан боловч цаг хугацааны явцад тэд таатай байдлыг олж авах нь зүйтэй юм гэж бодох болсон. Энэ нь аяндаа олон улсын улс төрд эвсэлд үл нэгдэх орнууд илүү үр дүнтэй үүрэг гүйцэтгэхэд түлхэц болсон.

4. Эвсэлд үл нэгдсэн орнууд хамтран оршихуйн номлол буюу "амьдар бас амьдрах боломж оло" гэсэн зарчмыг баримтласнаар дэлхийн 2 дугаар дайны дараа хуваагдаад буй 2 туйлаас ангид байлгахыг дэмжиж байсан юм.

5. Эвсэлд үл нэгдэх нь зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоож, ингэснээрээ дэлхийн энхийг тогтооход ажиллагаанд нэмэр хандив болж ирсэн. 1963 оны Москвагийн туршилт хийхийг хориглосон гэрээг байгуулахад эвсэлд үл нэгдсэн орнуудын оролцоо үлэмж их байсан.

6. Колоничлол, боолчлолын эсрэг гол үүрэг гүйцэтгэж байсан.

7. Эвсэлд үл нэгдсэн орнууд эдийн засгийн хөгжлийн асуудалд ихээр анхаарч, ЮНКТАД-г үүссэн байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн юм. Мөн 77-гийн бүлгийг байгуулахад чухал хэрэглүүр болсон юм.

8. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь гишүүн орнуудынхаа дунд үүссэн үл ойлголцол, зөрчлийг төдийлөн амжилттай арилгаагүй ч гэсэн шийдвэрлэхийг оролдож байсан. 1962 оны Кубын яамрал болон 1962 оны Сино Энэтхэгийн зөрчилд зуучлагчийн үүргийг эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь амжилттай гүйцэтгэснийг үгүйсгэж болохгүй.

9. Арьс өнгөөр ялгаварлах явдлыг эрс шүүмжилснээр илдэндээ түүнийг устгахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэж болно.

10. Хүчний бүлэглэлээс хоп байх замаар том гүрнүүдийн тоглоомонд цэг тавьсан. Эцэст нь хэлээд бодит байдал дээр Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь идеализм, реализмын бодит хослолыг илэрхийлж байгаа ба хүйтэн дайны үед их ач холбогдолтой байсан юм.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь үүссэнээсээ хойш үлэмж их өөрчлөлтийг хийсэн. Мөн илүү яргилттай олон улсын нөхцөл байдалтай тулгарсан юм. Олон хүчний төвүүд эвсэлд үл нэгдсэн болон хөгжиж буй орнуудтай гүнзгий харилцаатай байсан мэт харяагдаж, Буурай орны ард түмний улс төрийн идэвхи өндөр байдаг ба нийгэм, эдийн засгийн түвшинд тэгш бус байдал ба тэнцвэрт бус байдлыг арилгахыг шаардаж байлаа. Түүнчлэн, нөөц баялгийн ихэнхийг хөгжсөн орнууд дангаар эзэмшиж, хөгжсөн болон хөгжиж буй орнуудын зай өдөр өдрөөр холдсоор байна. Хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудад амьдарч буй хүмүүсийн 70 хувь нь дэлхийн бүтээгдэхүүний дөнгөж 15 хувийг авч байна. Хэдийгээр уламжлалт колоничлол нь мөхсөн гаж болговч нео-колониал болон капиталист империализмаар солигдсон юм.

Өөр нэгэн онцгой өөрчлөлт бол Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг одоо шинэ үеийн тэргүүлэгчид удирдаж байна. Энэтхэгийн Гадаад хэргийн сайд үүний талаар хэлэхдээ, "Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг үүссэн байгуулсан, хөгжүүлсэн эхний үеийн удирдагчид бол колоничлол, империализмын эсрэг эрч чөлөөний төлөө тэмцэлд хөтөлгөсөн байлаа. Харин өнөөдөр хөдөлгөөний удирдагчид 1960-1970-аад оны арваад жилийн олон улсын харилцааны реал-политик хязгаарлагдсан үндэсний улс төрийн заншилд ууссан байна," гэсэн байдаг. Хамгийн гол нь, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь ихээр өргөжин тэлж, одоогоор 113 тусгаар улс гишүүн нь болсон байна.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь өргөжин тэлсэн боловч бас зарим нэг асуудалтай тулгарсан байна. Юуны өмнө аливаа асуудлыг энхийн замаар шийдвэрлэх үүрэгтэй гишүүн орнууд олон улсын нээлттэй маргаанд оролцсноор хөдөлгөөнийг

¹Prakash Chander, Prem Arora "Comparative politics and International Relations" P.269

суп болгох хандлагатай болсон. Хоёрдугаарт, эвсэлд үл нэгдсэн зарим оронд батлан халгаалах салбартаа маш их хөрөнгө зарцуулснаар эдийн засгийн хөгжил нь удааширсан. Хэрэв эвсэлд үл нэгдсэн орнууд үр дүнтэй ажиллах, империалист хүчний эсрэг дорвитой арга хэмжээ авахыг хүсвэл гишүүн орнууд зөрчилдөөнт бодлогоос зайлсхийж, хөгжлийн асуудал дээрээ анхаарах шаардлагатай.

Цаашид эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг бэхжүүлэхийн тулд дараахь арга хэмжээг авч болох юм:

1. Эвсэлд үл нэгдсэн болон бусад оронд зэвсэглэлээр хөөцөлдөхгүй байж, аливаа нэг хүчний лагертай шууд ба шууд бусаар цэргийн аливаа холбоо харилцаагүй байх, нутаг дэвсгэр дээрээ байгаа бүх төрлийн стратегийн баазыг байхгүй болгох болон аливаа нэг маргааныг зөвхөн энх тайвны аргаар шийдвэрлэж байж; Энэ бүгд батлан хамгаалахын тэсвийн дарамтыг багасгах болно.

2. Эвсэлд үл нэгдсэн орнууд хэрэв аль нэг гишүүн орны эсрэг түрэмгийллийн ажиллагаа явагдах аваас бүх гишүүний эсрэг түрэмгийлэл гэж ойлгож, түрэмгийллийг зогсолт ёс зүйн, материаллаг болон цэргийн тусламж үзүүлнэ гэж амлан тунхаглах ёстой.

3. Эвсэлд үл нэгдсэн орнууд нь том гүрнүүдийг зэвсэглэлээр хөөцөлдөхийг нь зогсоох талаар бодитой, үр дүнтэй оролдлого хийх ёстой.

4. Эвсэлд үл нэгдсэн орнууд дэвшилтэт орнуудын мөлжсөн, хязгаарласан зан байдалтай тэмцэж, тэдгээр орноос хараат байдаг байдлаа бууруулахыг оролдох нь зүйтэй юм. Хөгжингүй орнуудтай болон өөр хоорондоо харилцан ашигтай эдийн засаг, худалдааны харилцааг хөгжүүлэх хэрэгтэй юм.

Зарим шүүмжлэгч олон улсын хөгжлийн өнөөгийн нөхцөлд хүйтэн дайн төгссөн, хүчний туйл нуран унасан, ЗХУ задарч, их хүчний нөлөөгөө алдсан зэрэг хүчин зүйлээс шалтгаалж эвсэлд үл нэгдэх нь ач холбогдлоо алдсан

бөгөөд эвсэлд үл нэгдсэн орнууд шинэ ертөнцөд олон улсын байр сууриа дахин тодрхойлох ёстой болж байна гэж үзэж байна.

Энэ нь эвсэлд үл нэгдэх нь хүйтэн дайнаас үүдэлтэй гэж үзсэнээс тэр юм. Хүйтэн дайн нь эвсэлд үл нэгдэхийг гадаад бодлого болгон хэлбэрт оруулахад нөлөөлсөн нь үнэн боловч дайн нь эвсэлд үл нэгдэх явдлыг бий болгосон шалтгаан нь биш юм. Бодит байдал дээр гадаад бодлого болохын хувьд дэлхий нийтийн энх тайван ба эрх чөлөөнд учирсан асуудлыг шийдэхийн тулд байдаг учраас хүйтэн дайны үед ч, бусад үед ч ач холбогдолтой юм. Хэдийгээр эвсэлд үл нэгдэх нь хүйтэн дайн болон их гүрний бодлого олон улсын харилцааны бодлогыг тодорхойлж байсан үед бий болсон боловч гол зорилго нь шинээр тусгаар тогтносон гишүүн орнуудынхаа тусгаар тогтнолыг хамгаалж, хадгалах болон эдийн засгийн хөгжлийг хөхиулэн дэмжихэд оршиж байсан юм. Өнөөдөр хүчний бодлого байхгүй ч гэсэн үй олноор хөвөөх зэвсэг дэлгэрч байгаа, хил дамнансан терроризм, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг бусад олон асуудалтай тулгараад байна. Энэ бүх хүчин зүйлс нь энх тайван, ардчилал, ноцтой заналхийлэл болж байна. Ертөнц дээр мөлжлөг, дайн, эвдрэл сүйрэл, өлсгөлөн, ядуурал, өвчин байсан цагт эвсэлд үл нэгдэх нь ач холбогдолтой хэвээр байх болно. Хөгжиж буй болон өндөр хөгжилтэй орнуудын хооронд шударга, тэгш зарчмын үндсэн дээр эдийн засаг, улс төрийн харилцааг хөгжүүлэх болон хөгжиж буй гуравдагч ертөнцийн орнуудын тусгаар тогтнолыг баталгаажуулахад тус болох юм. Магадгүй өөрчлөгдөж буй нөхцөл байдалд эвсэлд үл нэгдэхийн хамгийн ач холбогдолтой үүрэг нь адил тэгш эрхийн үндсэн дээр худалдааг хөгжүүлэх замаар гуравдагч орнуудын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах юм. Мөн НҮБ болон эдийн засгийн хөгжлийг ардчиллах нь Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үйл ажиллагааны чухал асуудлын нэг бөгөөд товчоор

хэлэхэд, тус хөдөлгөөний гүйцэтгэх үүрэг үлэмж их хэвээр байна.

Монгол Улс нь Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн орон бөгөөд Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд хөгжиж байгаа орнуудтай найрсаг харилцаатай байж, нийслэл зорилтоо шийдвэрлэх үүднээс бодит боломжийн хэмжээнд тэдгээртэй хамтран ажиллах явдал Монгол Улсын гадаад бодлогын зургаа дахь чиглэл байх бөгөөд энэ зорилтыг хоёр талын харилцааны хүрээндээ гадна голчлон олон улсын байгууллага, хөдөлгөөний хүрээнд, тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллага, "77"-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэгтэй хамтран ажиллах замаар хэрэгжүүлнэ" гэж тусгасан байдаг. Энэ бол Монгол Улс энхийг эрхэмлэсэн, эвсэлд үл нэгдэх бодлого баримтлах эрх зүйн ба бодлогын суурь хөрс юм. Эндээс дүгнэхэд, Монгол Улсын Засгийн газар солигдох эсэхээс үл хамааран эвсэлд үл нэгдэх бодлого бол Монгол Улсын гадаад бодлого байх юм. Гэгцхүү Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу Монгол Улсын язгуур эрх ашигт нийцсэн байх ёстой.



¹ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 1994 он, УИХ-ын 56 дугаар тогтоолын 2 дугаар хэсрэлт, II бүтгийн 12

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан зарим конвенцын судалгаа

Олон Улсын конвенц хэрэглэх талаар товч үзэх нь

Дэлхийн аль ч улс олон улсын гэрээ хэлэлцээрийг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орсноор түүнийг өөрийн орны үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил даган мөрдөж хэрэгжүүлэх үүргийг өөртөө хүлээдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-т "Монгол Улсын Олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ..." гэж заасан.

Олон улсын аливаа гэрээнд нэгдэн орох асуудал бол тухайн улсад түүнийг хэрэгжүүлэх үүргийг бий болгодог учраас үүргийн биелэлтийг хянах эрх зүйн зохицуулалт байх ёстой.

Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуульд энэ талаар эрхэн заагчгүй авч үзвэл: "Монгол Улсын Их Хурал нь соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээ болон шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын олон улсын аливаа гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж байна." Мөн хуульд "Монгол Улсын Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг зохион байгуулж ажиллана."¹

Мөн хуульд зааснаар "Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга олон улсын гэрээний биелэлтийг жил бүрийн 6 болон 12 дугаар сарын 20-ны дотор гаргаж, Гадаад хэргийн яаманд ирүүлж байх ба уг яам гэрээний биелэлтийг нэгтгэн, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байх ёстой.

Хэдийгээр манай улсад олон улсын гэрээний талаархи



ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр С.Ганцэцэг

эрх зүйн зохицуулалт хангалттай байгаа боловч түүний хэрэгжилт нь тааруу байна. Иймд олон улсын гэрээнд хяналт тавих механизмыг төлөвшүүлэх, шинээр баталж буй хууль тогтоомжийн заалтыг олон улсын гэрээний холбогдох заалттай уялдуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын /цаашид ОУХБ гэх/ гишүүн болоод багагүй хугацаа өнгөрч байгаа бөгөөд уг байгууллагаас гаргасан гэрээ, конвенц нэгдэн орж, гэрээ конвенцийн агуулга, заалтаас холбогдох хууль тогтоомждоо тусгасан билээ.

Энэ удаа өмнөх нийтлэлийн үргэлжлэл болгож ОУХБ-аас гаргасан Монгол Улс нэгдэн орсон зарим конвенцийн хэрэгжилт хийгээд холбогдох хууль тогтоомжид эрхэн тусгалаа олсон талаар цухас авч үзэхийг зорилго.

Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 111 дүгээр конвенцийн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэж заасан.

Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд "Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй эмэгтэй, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах давуу байдал тогтоохыг хориглоно" гэж заасан бөгөөд ийм байдал бий болсон тохиолдолд хүлээлгэх харилцаагүй нь ч мөн адил тусгасан. Зөвхөн энэ хоёр хуулиар хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах асуудлыг хуульчлаагүй ба бусад хуульд ч энэ төрлийн зохицуулалт байдаг байна.

Төрийн албаны тухай хууль /4.2.4/, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль /5.1.3, 14.1, 14.1.8, 5.1.3, 17.1.12/, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /10 дугаар зүйл/-д ялгаварлан гадуурхаж болохгүй талаар заасан ч энэ нь амьдрал дээр бараг хэрэгжигүй байна. Мөн Монгол Улс энэ талаар гаргасан олон улсын конвенц нэгдэн орсон хэдий ч түүний хэрэгжилт бодит байдал дээр тун хангалтгүй л байна. Монгол Улс ОУХБ-аас гаргасан "Алагчлахгүй байх (ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай" 111 дүгээр конвенц нэгдэн орсон билээ.² Юуны өмнө энд хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах гэдэг талаар товч авч үзье.

Ажилтны зан чанар, төрх, гэр бүл, амьдрал гэх мэт хувийн шинж бүхий байдалаар

¹ Монгол Улсын олон улсын гэрээний тухай хууль, 20, 21 дүгээр зүйл.

² 1958.6.25-ны өдөр баталж, 1960.6.15-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1969.05.10-нд нэгдэн орсон.

НҮБ-ыг хүчирхэгжүүлснээр олон туйлт ертөнцийг дэмжиж болох шийдвэрлэх дахин илэрхийлсэн юм. Тунхагалаар гишүүдийн нэгдлийг болон олон талт үйл ажиллагааг сайжруулах, ардчиллыг хөгжүүлэн дэмжих, Өмнөд-өмнөд хамтын ажиллагааг улс төр, нийгэм, соёл, эдийн засаг ба шинжлэх ухааны салбарт өрнүүлэх "9 шүдэт" стратегийг гаргасан юм.¹

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний 14 дэх чуулган Кубын нийслэл Гаванад болсон бөгөөд Фидел Кастрог ерөнхийлөгчөөр сонгосон байна. Гэсэн хэдий боловч тэрбээр хагалгааны улмаас биечлэн оролцож чадахгүй болсон юм. Улмаар ерөнхийлөгчийн үүрэгт ажлыг гүйцэтгэж байсан түүний дүү болох Раул Кастро чуулганыг даргалсан юм. Тус чуулганаас баталсан тунхагланд 2 цэргийг нь барьцаалсан Ливаний Хесболлах цэргийн бүлэглэлийн буруутай үйл ажиллагаанаас болж Ливаний эсрэг довтолсон Израйлийг буруушааж, НҮБ-ыг жижиг гишүүн орнуудыг илүүтэйгээр төлөөлхийг уриалсан байна. Түүнчлэн, Ираны цөмийн энергийн хөтөлбөрийг дэмжихийн ялдамд АНУ-ын явуулж буй гадаад бодлогыг шүүмжилсэн байна.

Хэдийгээр Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд зарим нэг шүүмжлэлтэй зүйл байсан авч, 1961 онд Жакартад 25 орон оролцож байсантай харьцуулахад эвсэлд үл нэгдсэн орнууд одоо 113 болон нэмэгдсэн байна. Зарим гишүүний хувьд ялгаатай зүйл байсан ч гэсэн дэлхийн энх тайван, зэвсэглэлээр үл хөөцөлдөх, хөгжлийн төлөө ба колоничлолын эсрэг чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Ялангуяа эвсэлд үл нэгдсэн орнууд НҮБ-д идэвхтэй байр суурьтай байж, сонгосон замаасаа зайгаагүй юм.

Эвсэлд үл нэгдсэн орнуудын оруулсан гол ач холбогдолтой зүйлс нь:

1. Эвсэлд үл нэгдсэн орнуудын тоо нэмэгдсэн нь хүйтэн дайныг намжаах болон шинээр тусгаар тогтносон орнуудыг хүчний лагериудаас ангид байлгахад урам зориг өгсөн байна. Яахын

аргагүй энэ нь хүчний улс төрийн учруулсан нилээд хэдэн асуудлыг шийдвэрлэхэд тус болсон.

2. НҮБ-ын мөн чанарыг үлэмж хэмжээгээр өөрчилж, Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн дураараа эрх мэдлээ хэрэгжүүлэхэд хяналтын үүрэг гүйцэтгэж байсан ба учир нь Ерөнхий Ассамблейд дийлэнх хүчнийхээ давуу талыг ашиглан эвсэлд үл нэгдсэн орнууд зарим нэг ёс зүйн хяналтыг том гүрнүүдэд тавьж чадаж байсан.

3. Хэдийгээр хоёр их гүрний хувьд эвсэлд үл нэгдсэн орнуудын хувьд үл итгэсэн байр суурьтай байсан боловч цаг хугацааны явцад тэд таатай байдлыг олж авах нь зүйтэй юм гэж бодох болсон. Энэ нь яандаа олон улсын улс төрд эвсэлд үл нэгдэх орнууд илүү үр дүнтэй үүрэг гүйцэтгэхэд түлхэц болсон.

4. Эвсэлд үл нэгдсэн орнууд хамтран оршихуйн номлол буюу "амьдар бас амьдрах боломж олго" гэсэн зарчмыг баримтласнаар дэлхийн 2 дугаар дайны дараа хуваагдаад буй 2 туйлаас ангид байлгахыг дэмжиж байсан юм.

5. Эвсэлд үл нэгдэх нь зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоож, ингэснээрээ дэлхийн анхний тогтоох ажиллагаанд нэмэр хандив болж ирсэн. 1963 оны Москвагийн туршилт-хийхийг хориглосон гэрээг байгуулахад эвсэлд үл нэгдсэн орнуудын оролцоо үлэмж их байсан.

6. Колоничлол, боолчлолын эсрэг гол үүрэг гүйцэтгэж байсан.

7. Эвсэлд үл нэгдсэн орнууд эдийн засгийн хөгжлийн асуудалд ихээр анхаарч, ЮНКТАД-г үүсгэн байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн юм. Мөн 77-гийн бүлгийг байгуулахад чухал хэрэглүүр болсон юм.

8. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь гишүүн орнуудынхаа дунд үүссэн үл ойлголцол, зөрчлийг төдийлэн амжилттай арилгаагүй ч гэсэн шийдвэрлэхийг оролдож байсан. 1962 оны Кубын хямрал болон 1962 оны Сино Энэтхэгийн зөрчлөлд зуучлагчийн үүргийг эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь амжилттай гүйцэтгэснийг үгүйсгэж болохгүй.

9. Арьс өнгөөр ялгааварлах явдлыг эрс шүүмжилснээр үндсэндээ түүнийг устгахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэж болно.

10. Хүчний бүлэглэлээс хол байх замаар том гүрнүүдийн тоглоомонд цэг тавьсан. Эцэст нь хэлэхэд бодит байдал дээр Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь идеализм, реализмын бодит хосоллыг илэрхийлж байгаа ба хүйтэн дайны үед их ач холбогдолтой байсан юм.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь үүссэнээсээ хойш үлэмж их өөрчлөлтийг хийсэн. Мөн илүү аарчлалт олон улсын нөхцөл байдалтай тулгарсан юм. Олон хүчний төвүүд эвсэлд үл нэгдсэн болон хөгжиж буй орнуудтай гүнзгий харицлаатай байсан мэт харагддаг. Буурай орны ард түмний улс төрийн идэвхи өндөр байдаг ба нийгэм, эдийн засгийн түвшинд тэгш бус байдал ба тэнцвэрт бус байдлыг арилгахыг шаардаж байлаа. Түүнчлэн, нөөц баялгийн ихэнхийг хөгжсөн орнууд дангаар эзэмшиж, хөгжсөн болон хөгжиж буй орнуудын зай өдөр өдөрөөр холдсоор байна. Хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудад амьдарч буй хүмүүсийн 70 хувь нь дэлхийн бүтээгдэхүүний дөнгөж 15 хувийг авч байна. Хэдийгээр уламжлалт колоничлол нь мөхсөн гэх боловч нео-колоничлол болон капиталист империализмаар солигдсон юм.

Өөр нэгэн онцгой өөрчлөлт бол Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг одоо шинэ үеийн тэргүүлэгчид удирдаж байна. Энэтхэгийн Гадаад хэргийн сайд үүний талаар хэлэхдээ, "Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг үүсгэн байгуулсан, хөгжүүлсэн эхний үеийн удирдагчид бол колоничлол, империализмын эсрэг эрх чөлөөний төлөө тэмцэлд хөтөлгөдсөн байлаа. Харин өнөөдөр хөдөлгөөний удирдагчид 1960-1970-аад оны арваад жилийн олон улсын харилцааны реал-политикт хязгаарлагдсан үндэсний улс төрийн заншилд ухамсга болна." гэсэн байдаг. Хамгийн гол нь, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь ихээр өргөжин тэлж, одоогоор 113 тусгаар улс гишүүн нь болсон байна.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь өргөжин тэлсэн боловч бас зарим нэг асуудалтай тулгарсан байна. Юуны өмнө аливаа асуудлыг энхийн замаар шийдвэрлэх үүрэгтэй гишүүн орнууд олон улсын нээлттэй маргаанд оролцсноор хөдөлгөөнийг

¹Prakash Chander, Prem Arora "Comparative politics and International Relations" P.269

сул болгох хандлагатай болсон. Хоёрдугаарт, эвсэлд үл нэгдсэн зарим оронд батлан халгаах салбартаа маш их хөрөнө зарцуулснаар эдийн засгийн хөгжил нь удашгирсан. Хэрэв эвсэлд үл нэгдсэн орнууд үр дүнтэй ажиллах, империалист хүчний эсрэг дорвитой арга хэмжээ авахыг хүсвэл гишүүн орнууд зөрчилдөөнт бодлогоос зайлсхийж, хөгжлийн асуудал дээрээ анхаарах шаардлагатай.

Цаашид эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг бэхжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч болох юм:

1. Эвсэлд үл нэгдсэн болон бусад оронд зэвсэглэлээр хөөцөлдөхгүй байж, аливаа нэг хүчний лагертай шууд ба шууд бусаар цэргийн аливаа холбоо харилцаагүй байх, нутаг дэвсгэр дээрээ байгаа бүх төрлийн стратегийн баазыг байхгүй болгох болон аливаа нэг маргааныг зөвхөн энх тайвны аргаар шийдвэрлэж байх; Энэ бүгд батлан хамгаалахын төсвийн дарамтыг багасгах болно.

2. Эвсэлд үл нэгдсэн орнууд хэрэв аль нэг гишүүн орны эсрэг түрэмгийллийн ажиллагаа явагдах аваас бүх гишүүний эсрэг түрэмгийлэл гэж ойлгож, түрэмгийллийг зогсолт ёс зүйн, материаллаг болон цэргийн тусламж үзүүлнэ гэж амлан тунхаглах ёстой.

3. Эвсэлд үл нэгдсэн орнууд нь том гүрнүүдийг зэвсэглэлээр хөөцөлдөхийг нь зогсоох талаар бодитой, үр дүнтэй оролдлого хийх ёстой.

4. Эвсэлд үл нэгдсэн орнууд дэвшилтэт орнуудын мөлжсөн, хязгаарласан зан байдалтай тэмцэж, тэдгээр орноос хараат байдаг байдлаа бууруулахыг оролдох нь зүйтэй юм. Хөгжингүй орнуудтай болон өөр хоорондоо харилцан ашигтай эдийн засаг, худалдааны харилцааг хөгжүүлэх хэрэгтэй юм.

Зарим шүүмжлэгч олон улсын хөгжлийн өнөөгийн нөхцөлд хүйтэн дайн төгссөн, хүчний туйл нуран унасан, ЗХУ задарч, их хүчний нөлөөгөө алдсан зэрэг хүчин зүйлээс шалтгаалж эвсэлд үл нэгдэх нь ач холбогдлоо алдсан

бөгөөд эвсэлд үл нэгдсэн орнууд шинэ ертөнцөд олон улсын байр сууриа дахин тодрхойлох ёстой болж байна гэж үзэж байна.

Энэ нь эвсэлд үл нэгдэх нь хүйтэн дайнаас үүдэлтэй гэж үзсэнээс тэр юм. Хүйтэн дайн нь эвсэлд үл нэгдэхийг гадаад бодлого болгон хэлбэрт оруулахад нөлөөлсөн нь үнэн боловч дайн нь эвсэлд үл нэгдэх явдлыг бий болгосон шалтгаан нь биш юм. Бодит байдал дээр гадаад бодлого болохын хувьд дэлхий нийтийн энх тайван ба эрх чөлөөнд учирсан асуудлыг шийдэхийн тулд байдаг учраас хүйтэн дайны үед ч, бусад үед ч ач холбогдолтой юм. Хэдийгээр эвсэлд үл нэгдэх нь хүйтэн дайн болон их гүрний бодлого олон улсын харилцааны бодлогыг тодорхойлж байсан үед бий болсон боловч гол зорилго нь шинээр тусгаар тогтносон гишүүн орнуудынхаа тусгаар тогтнолыг хамгаалж, хадгалах болон эдийн засгийн хөгжлийг хөхиулэн дэмжихэд оршиж байсан юм. Өнөөдөр хүчний бодлого байхгүй ч гэсэн үйл олноор хөвөөх зэвсэг дэлгэрч байгаа, хил дамнансан терроризм, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг бусад олон асуудалтай тулгараад байна. Энэ бүх хүчин зүйл нь энх тайван, ардчилалд ноцтой заналхийлэл болж байна. Ертөнц дээр мөлжлөг, дайн, эвдрэл сүйрэл, өлсгөлөн, ядуурал, өвчин байсан цагт эвсэлд үл нэгдэх нь ач холбогдолтой хэвээр байх болно. Хөгжиж буй болон өндөр хөгжилтэй орнуудын хооронд шударга, тэгш зарчмын үндсэн дээр эдийн засаг, улс төрийн харилцааг хөгжүүлэх болон хөгжиж буй гуравдагч ертөнцийн орнуудын тусгаар тогтнолыг баталгаажуулахад тус болох юм. Магадгүй өөрчлөгдөж буй нөхцөл байдалд эвсэлд үл нэгдэхийн хамгийн ач холбогдолтой үүрэг нь адил тэгш эрхийн үндсэн дээр худалдааг хөгжүүлэх замаар гуравдагч орнуудын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах юм. Мөн НҮБ болон эдийн засгийн хөгжлийг ардчиллах нь Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үйл ажиллагааны чухал асуудлын нэг бөгөөд товчоор

хэлэхэд, тус хөдөлгөөний гүйцэтгэх үүрэг үлэмж их хэвээр байна.

Монгол Улс нь Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн орон бөгөөд Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд хөгжиж байгаа орнуудтай найрсаг харилцаатай байж, нийтлэг зорилтоо шийдвэрлэх үүднээс бодит боломжийн хэмжээнд тэдгээртэй хамтран ажиллах явдал Монгол Улсын гадаад бодлогын зургаа дахь чиглэл байх бөгөөд энэ зорилтыг хоёр талын харилцааны хүрээндээ гадна голчлон олон улсын байгууллага, хөдөлгөөний хүрээнд, тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллага, "77"-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэгтэй хамтран ажиллах замаар хэрэгжүүлнэ" гэж тусгасан байдаг. Энэ бол Монгол Улс энхийн эрхэмлэсэн, эвсэлд үл нэгдэх бодлого баримтлах эрх зүйн ба бодлогын суурь хөрөс юм. Эндээс дүгнэхэд, Монгол Улсын Засгийн газар солигдох эсэхээс үл хамааран эвсэлд үл нэгдэх бодлого бол Монгол Улсын гадаад бодлого байх юм. Гагцхүү Үндэстний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу Монгол Улсын язгуур эрх ашиг нийцсэн байх ёстой.



¹ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 1994 он, УИХ-ын 56 дугаар тогтоолын 2 дугаар хэсэглэл, II бүлгийн 12

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан зарим конвенцын судалгаа

Олон Улсын конвенц хэрэглэх талаар товч үзэх нь

Дэлхийн аль ч улс олон улсын гэрээ хэлэлцээрийг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орсноор түүнийг өөрийн орны үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил даган мөрдөж хэрэгжүүлэх үүргийг өөртөө хүлээдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-т "Монгол Улсын Олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ..." гэж заасан.

Олон улсын аливаа гэрээнд нэгдэн орох асуудал бол тухайн улсад түүнийг хэрэгжүүлэх үүргийг бий болгодог учраас үүргийн биелэлтийг хянах эрх зүйн зохицуулалт байх ёстой.

Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуульд энэ талаар хэрхэн заахыг авч үзвэл: "Монгол Улсын Их Хурал нь соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээ болон шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын олон улсын аливаа гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж байна." Мөн хуульд "Монгол Улсын Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг зохион байгуулж ажиллана."¹

Мөн хуульд зааснаар "Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга олон улсын гэрээний биелэлтийг жил бүрийн 6 болон 12 дугаар сарын 20-ны дотор гаргаж, Гадаад хэргийн яаманд ирүүлж байх ба уг яам гэрээний биелэлтийг нэгтгэн, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байх ёстой.

Хэдийгээр манай улсад олон улсын гэрээний талаархи



ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магитр С.Ганццэг

эрх зүйн зохицуулалт хангалттай байгаа боловч түүнийг хэрэгжилт нь тааруу байна. Иймд олон улсын гэрээнд хяналт тавих механизмыг төлөвшүүлэх, шинээр баталж буй хууль тогтоомжийн заалтыг олон улсын гэрээний холбогдох заалттай уялдуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын /цаашид ОУХБ гэх/ гишүүн болоод багагүй хугацаа өнгөрч байгаа бөгөөд уг байгууллагаас гаргасан гэрээ, конвенцид нэгдэн орж, гэрээ конвенцийн агуулга, заалтаас холбогдох хууль тогтоомждоо тусгасан билээ.

Энэ удаа өмнөх нийтлэлийн үргэлжлэл болгож ОУХБ-аас гаргасан Монгол Улс нэгдэн орсон зарим конвенцийн хэрэгжилт хийгээд холбогдох хууль тогтоомжид хэрхэн тусгалаа олсон талаар цухас авч үзэхийг зорилгоо.

Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 111 дүгээр конвенцийн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэж заасан.

Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд "Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй эмэгтэй, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах давуу байдал тогтоохыг хориглоно" гэж заасан бөгөөд ийм байдал бий болсон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нь ч мөн адил тусгасан. Зөвхөн энэ хоёр хуулиар хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах асуудлыг хуульчлаагүй ба бусад хуульд ч энэ төрлийн зохицуулалт байдаг байна.

Төрийн албаны тухай хууль /4.2.4/, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль /5.1.3, 14.1, 14.1.8, 5.1.3, 17.1.12/, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түний удирдлагын тухай хууль /10 дугаар зүйл/-д ялгаварлан гадуурхаж болохгүй талаар заасан ч энэ нь амьдрал дээр бараг хэрэгжихгүй байна. Мөн Монгол Улс энэ талаар гаргасан олон улсын конвенцид нэгдэн орсон хэдий ч түүний хэрэгжилт бодит байдал дээр тун хангалтгүй л байна. Монгол Улс ОУХБ-аас гаргасан "Алагчлахгүй байх (ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай" 111 дүгээр конвенцид нэгдэн орсон билээ.² Юуны өмнө энд хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах гэдэг талаар товч авч үзье.

Ажилтны зан чанар, төрх, гэр бүл, амьдрал гэх мэт хувийн шинж бүхий байдалаар нь

¹ Монгол Улсын олон улсын гэрээний тухай хууль. 20, 21 дүгээр зүйл.

² 1958.6.25-ны өдөр баталж, 1960.6.15-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1969.05.10-нд нэгдэн орсон.

хөдөлмөрийн харилцаанд ажилтныг бусдаас нь зааглан үзэж, түүний хөдөлмөрлөх эрх ашигт хохирол учруулахыг ялгаварлан гадуурхах гэж үзнэ.¹ Үүний илрэх гол хэлбэр бол ажилтанд хуулиар эдлэх ёстой тэрхүү эрх болон бусад хангамж, хөнгөлөлт зэргийг эдлүүлэхгүй байх, тэр боломжийг нь хязгаарлах, хүлээх ёстой үүргийг нь үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх зэргээр илэрнэ. Тэгэхдээ ажил олгогч ажилтанд ялгаварлан гадуурхах байна гээд ямар нэг шаардлага тавьж болохгүй гэж уг ойлголтыг явцууруулан ойлгож болохгүй. Ажилтны эрхлэн гүйцэтгэх ажил үүргийн онцлогоос нь хамааруулан ажил олгогч иргэнийг ажилдаа авахдаа буюу өөрөөр хэлбэл хөдөлмөрийн гэрээ байгуулахаас өмнө мөн хөдөлмөрийн гэрээ байгуулсны дараа ямар нэг шаардлага тавьж болно. Гагцхүү тухайн шаардлага нь ажил үүргийн онцлогоос хамаарсан гэдгийг л нотлох ёстой юм.

Дээрхээс үзвэл хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах асуудлыг дан ганц дотоодын хууль тогтоомжоор төдийгүй олон улсын

конвенциор давхар зохицуулж байна гэж үзэж болно². Гэтэл хөдөлмөрийн харилцаанд буюу хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхах явдал газар авсаар байна. Өнөөдөр аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа иргэнийг ажилд авахдаа ажил үүрэгтэй нь холбоогүй шалгууруудыг тавьж байгаа нь цөөнгүй байна. Шүүхээр шийдвэрлэсэн хөдөлмөрийн харилцаанаас үүссэн маргааны төлөөлөх үзэл энэ талын маргаан бараг байхгүй байгаа боловч бодит байдал дээр ихээхэн зөрүүтэй байна. Хамгийн энгийнээр буюу өдөр тутмын сонин хэвлэлд өгсөн зарын байдалаас үзэхэд ажлын байрны талаархи зар мэдээнд иргэдийг хувийн байдлаар нь илт ялгаварласан, эсхүл аль нэгэнд нь хууль бусаар илт давуу байдал олгосон шинж бүхий шаардлага тавих нь түгээмэл болжээ. Тухайлбал, банкны харилцагчийн зөвлөх гэсэн сул орон тоон дээр "168-аас дээш өндөртэй, гадаад имидж сайн, 38 хүртэлх насны" хүнийг авахаар зарласан бөгөөд ийм хэлбэрийн зарыг өнөөдрийн бүхий л хэвлэлийн үүрнээс харж болно

гахэд хилсдэхгүй биз тус мэдээллийг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссийн илтгээсээ ишлэв. Түүнчлэн улс төрийн үзэл бодол, намын харьяалаар нь ялгаварлаж ажлаас халах явдал байсч л байна. Ийм байдал ихэвчлэн сонгуулийн дараа ихээр бий болдог нь илт байна.

Мөн хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах өөр нэг түгээмэл хэлбэр бол үндэслэлгүйгээр насны хязгаар тавих явдал байна. Энэ байдал нь хамгийн түгээмэл илэрч байгаа бөгөөд үүнтэй тэмцэж буй тохиолдол бараг үгүй хэмээн хэлж болно. Жишээ нь, ажилд явах гэсэн зарын нийтлэг төрхийг харвал эмэгтэйчүүдийн хувьд 40-өөс, эрэгтэйчүүдийн хувьд 50-иад наснаас ажилд орох боломж нь ихээхэн хязгаарлагдмал байгаа.

Мөн ижил хөдөлмөр адил цалин хөлс өгөх зарчим манайд зарим талаараа хэрэгжихгүй байгааг ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр гэж үзэж болно. Энэ зөрчил гадаадын хөрөнгө оруулалттай компанид ихээхэн ажиглагдаж байна.

Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц³

/1958 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1960 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Холбогдох хуулийн заалтууд	Тайлбар	Санал
1.	1 дүгээр зүйл. 1. Энэхүү Конвенцийн зорилгоор "алагчлах" гэсэн нэр томъёо нь дараахь утгыг агуулна: а)	Хөдөлмөрийн тухай хууль 7 дугаар зүйл Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох	1. Хөдөлмөрийн тухай хуульд ".....нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно" гэж заасан. Гэтэл тус конвенцид "гүйцэгэн гадуурхах" гэсэн томъёоллыг оруулсан байна. Энэ томъёолон нь манай Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдаагүй байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйл "нас, биеийн гадаад төрхөөр ялгаварлан гадуурхах, хязгаарлах, давуу байдал тогтоох" гэж нэмэх;
2.	2. Гадорхой ажлын онцлогтой холбоотой тавигдах шаардлагад үндэслэсэн ялгаарларлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үүргийг "алагчлах" хэмээх ойлголтод хамааруулахгүй.	2. Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно. 4. Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашныг нь тухай болон жиэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй.	2. Хуулийн 7.5-д ".....ажилтан түүнд хариулах үүрэггүй" гэж заасан. Гэтэл энэ заалтын агуулгаас харвал ажилтан ажлын томъёолоор эгтээд нь ажилд ороогүй байгаа эгтээд байна.	Мөн "гүйцэгэн гадуурхах" гэж нэмэх. Хуулийн 7.2-т заасан ажилтан гадгийг "ажилд орох гэж буй иргэн" гэж өөрчлөх; "Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" гэсэн ойлголтуудын талаар ажлын томъёолоор эгтээд албан ёсны тайлбар хийх; Хөдөлмөрийн тухай хуулийн 14.1.1.3-т заасан хариуцлалын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах;
3.	3. Энэхүү Конвенцийн зорилгоор "ажил мэргэжил" болон "хөдөлмөр эрхлэлт" гэсэн нэр томъёо нь иаргэжийн сургалт, гадорхой ажилын байр, ажлаар хангагдах боломж, хийж гүйцэтгэх ажлын нөхцлийн асуудлыг хамарна.	7.5. Энэ хуулийн 7.4-т заасныг зөрчиж асуулт тавьсан тохиолдолд ажилтан түүнд хариулах үүрэггүй. 7.3. Ажил олгогч нь иргэнийг ажилд авахад олон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлог шаардлагын улмаас ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол энэ тухай үндэслэлээ нотлох үүрэгтэй.		

¹ Б.Уранцэцэг. "Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль" (онол, арга зүйн тайлбар). УБ., 2001 он, 22 хаяг тал.

² Уг конвенц Хөдөлмөрийн тухай хуультай хэрхэн нийцэж байгааг хүснэгтээр харуулав.

³ Монгол Улс 1969.05.10-нд соёрхон баталсан.

	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 4 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого</p> <p>4.1. Төрөөс хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараахь бодлого хэрэгжүүлнэ:</p> <p>4.1.1. хүн амын хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх; 4.1.2. хөрөнгө оруулалтыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээтэй уялдуулах; 4.1.3. ажиллах хүчний эрэлт, нийцүүлэлтийг оновчтой зохицуулах; 4.1.4. ажиллах хүчийг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх; 4.1.5. хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох; 4.1.6. ажилгүйдлийн давталтд хамрагчийн хүрээг өргөтгөж, иргэн бүрийг ажилгүйдлээс хамгаалах.</p>	<p>1. Энэ хуульд "хөдөлмөр эрхлэлт", "хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" гэсэн ойлголтуудыг томъёолоогүй байна.</p>	
<p>2 дугаар зүйл. Энэхүү Конвенцийг дагаж мөрдөж байгаа гишүүн улс бүр ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэй холбогдсон аливаа алагчлалыг бүрмөсөн устгах зорилгоор ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш боломж, хандлагыг дэмжихэд ялгасан үндэсний бодлогыг тухайн улсын нөхцөл байдал, дадалд тохирсон аргаар тодорхойлж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.</p>	<p>Хөдөлмөрийн тухай хууль 141 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 141.1.3. хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, эрэгтэй, эмэгтэй, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгагарласан, хязгаарласан, давуу байдлыг тогтоосон, иргэнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн сонголттой холбоогүйгээр ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр шүүгч торгох;</p>	<p>1. Шүүхэд ирсэн ажлаас үндэслэлгүйгээр халсан тухай нэмэгдэл, мөн сонин хэвлэлд өгч байгаа ажилд авах тухай зар мэдээллийг харахад тэдгээрт ихэвчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг зөрчсөн байх бөгөөд энэ тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуульд хүлээлгэх хариуцлагыг нь тодорхойлсон боловч түүнийг төдийлөн тооцогүй байна.</p>	<p>Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага нь нийгмийн байдлаасаа хооронд байна. Хөдөлмөрийн зөрчил давтан гардаг гол шалтгаан бол Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага нь жинхэнэ хариуцлагын мөн чанарыг агуулж чадаагүйтай холбоотой. Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн хариуцлагын тогтолцоог эргэн харах нь зүйтэй.</p>

Тахир дутуу иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт ба тэдний хөдөлмөр эрхлэлтийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенцийн тухай

Манай улсад өнөөг хүртэл тахир дутуу буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи төрийн бодлого нь тусламж үзүүлэх, нөхөн олговор олгох тал дээр анхаарал хандуулдаг байна. Гэвч өнөөдөр улсаас тэдэнд тэтгэвэр, тэтгэмжийн хэлбэрээр мөнгөн тусламж олгож байгаагаас бус тэдний амьдралыг найдвартай эх үүсвэрээр нь хангаж төдийлөн чадахгүй байгаа билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нь эрүүл хүмүүстэй харьцуулан үзэхэд 2-3 дахин бага байдаг гэж

ОУХБ-аас гэрэгжээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2006 онд гаргасан судалгааны дүнгээс үзэхэд дэлхийн хүн амын 7-10 хувь тахир дутуу хүмүүс байдаг. Хөгжиж буй орнуудад 5.5 хувь нь тахир дутуу иргэд байна. Манай улсад 140 гаруй мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Энд хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэдэгт хэнийг оруулах талаархи эрх зүйн зохицуулалтын хувьд тахир дутуу хүн гэсэн ойлголтыг олон улсын конвенц, мөн манай улсын Хөдөлмөрийн тухай хуулиар тодорхойлжээ. ОУХБ-аас гаргасан "Тахир дутуу иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт ба тэдний хөдөлмөр эрхлэлтийн тухай" 159 дүгээр конвенцийн¹ 1.1-д "Тахир дутуу иргэн гэдэг нэр томъёо нь зүй ёсоор тогтоогдсон биеийн болон

оюуны гажигийн дүнд өөрсдийн хүч, бололцоонд тохирсон ажлаар хангагдах, ажлын байраа халдаглах болон ахин дэвших хэтийн төлөв нь ихээхэн буурсан хувь хүнийг хэлнэ" гэж тодорхойлжээ.

Харин Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар: төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг "хөгжлийн бэрхшээлтэй иргэн" гэж ойлгоно.

Эндээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн асуудлыг гагаад заавал тусгайлан хэм хэмжээгээр зохицуулах шаардлагын тухай асуулдаг гарч ирнэ. Тэд бодит шалтгааны улмаас бусдын адил хөдөлмөрлөх боломж нь хомс байдаг учир төрөөс илүүтэй анхаарал халамж, дэмжлэг хүсч байдаг. Хөдөлмөрийн тухай

¹ Уг конвенцийг 1983.06.20-ны өдөр баталж, 1985.06.20-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1998.02.03-нд соёрхон баталсан. Уг конвенцийг Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуультай хэрхэн нийцж байгааг хүснэгтээр харуулав.

хуулиар тогтоосон нэг давуу тал нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн асуудлыг төдийгүй одой иргэний хөдөлмөрийн асуудлыг давхар зохицуулж өгсөн явдал юм. Одой иргэн гэдэг нь бие бялдар оюун ухааны чадавхи нь ямар нэг өөрчлөлтгүй ч ердийн хөгжил бүхий иргэдтэй харьцуулвал биеийн уртын хэмжээгээр тэднээс дутуу иргэн байдаг.

Өнөөдөр ажил эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд албан тушаал, ажлын байрны үнэлгээ нь харьцангуй доогуур байна.

Ийм иргэдийн амьдрал ахуйд туслах хамгийн гол гарц бол тэднийг таарч тохирох ажлын байраар хангах явдал юм. Улсын хэмжээнд 140 гаруй мянган тахир дутуу иргэн байгаагийн дөнгөж 20 хүрэхгүй хувь нь ямар нэг хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байна. Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур байгаа нь дараахь хэдэн үндсэн шалтгаантай хэлбоотой гэж үзэж болох юм.

- Осолд орох магадлал өндөртэй;
- Тэдэнд тохирсон ажлын байр хомс;
- Дэд бүтэц гэх мэт асуудал.

Энэ бүхнээс харвал нийгмийн харилцаа хөгжих, технологийн дэвшлийн хурдцыг дагаад тэдэнд тохирсон ажлын байр улам бүр хумигдах хандлагатай байна. Тэдэнд тусгайлан зориулсан ажлын байр бий болгох нь зардал ихтэй, ийнхүү гарсан зардлыг нөхөх магадлал тааруу байдаг. Иймд энэ асуудалд төрийн дэмжлэг, бодит байдалд тохирсон хэрэгжих бүрэн боломжтой тийм л бодлого үгүйлэгдэж байна.

Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенц¹

/1983 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1985 оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон./

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Холбогдох хуулийн заалт	Тайлбар	Санал
1.	1 дүгээр зүйл. 1. Энэхүү конвенцийн зорилгод "тахир дутуу хүн" гэж бие махбодь, сэтгэхүйн согогтой гэдэг нь зохих ёсоор тогтоогогдож, түүний улмаас өөрт тохирсон ажлаар хангагдах, ажлын байраа хадгалах, ахиж дэвших хэтийн төлөв нь ихээхэн хумигдсан хувь хүнийг хэлнэ. 2. Энэхүү конвенцийн зорилгоор гишүүн бүр мэргэжлийн нөхөн сэргээлтийн зорилго нь тахир дутуу хүмүүст тохирсон ажлаар хангагдах, ажлын байраа хадгалах, ахиж дэвших боломж олгож, улмаар тэднийг нийгмийн амьдралд оруулах буюу эргэн оруулахад оршино гэж үзнэ. 3. Энэхүү конвенцийн заалтыг гишүүн бүр үндэсний нөхцөл болон далдалдаа нийцсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. 4. Энэхүү конвенцийн заалт нь тахир дутуу бүх хүнд хамаарна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль 3 дугаар зүйл 3.1. Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж ойлгоно. 8 дугаар зүйл 8.1. Энэ хуулийн 3 дугаар иргэн ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж түүний ажилладаг аж ахуйн нэгж байгууллагад хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлүүлнэ. 8.2. Аж ахуйн нэгж байгууллагын эрх баригчид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халах, энэ хуулийн 7.1-д зааснаас бусад тохиолдолд боломжтой ажил албан тушаалд авч ажиллуулахаас татгалзахыг хориглоно. 8.3. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуулийн 7.1.5-д заасны дагуу богиносгож болно.	Конвенцид тахир дутуу хүн гэж тодорхойлсон бол Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд тахир дутуу хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж томъёолсон байна.	1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэсэн томъёоллыг конвенцийн томъёоллолтой нийцүүлэх; 2. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.2. Аж ахуйн нэгж, байгуулага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд тахир дутуу буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө гэсэн заалтын дагуу бий болсон мөнгөн хуримтлалын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, түүний зарцуулалтын тайланг нээлттэй болгох.

¹ Монгол Улс 1998.2.3-нд соёрхон баталсан.

	<p>Хөдөлмөрийн тухай хууль</p> <p>71.5.Тахир дутуу болон одой хүний гүйцэтгэж байгаа ажлын шинж байдлаас хамааран ажилтны саналыг харгалзан ажлын цагийг богиносгож болно.</p> <p>111 дүгээр зүйл.Тахир дутуу буюу одой хүний хөдөлмөр</p> <p>111.1.50, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа гурав, түүнээс дээш хувийн орон тоонд тахир дутуу буюу одой хүнийг ажиллуулна /Энэ хэсэгт 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.</p> <p>111.2. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд тахир дутуу буюу одой хүн ажиллуулахгүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө.</p> <p>111.3.Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>111.4.Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн, уг хөрөнгийг тахир дутуу буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна /Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны, 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт орсон/.</p> <p>111.5.Тахир дутуу, одой хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохооргүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй бол тэдгээрийг уг шалтгаанаар ажилд авахаас татгалзахыг хориглоно.</p> <p>141 дүгээр зүйл</p> <p>141.1.4. тахир дутуу болон одой хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохооргүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй байгаа тохиолдолд уг шалтгаанаар түүнийг ажилд авахаас татгалзсан албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр шүүгч торгох;</p> <p>141.1.5.энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч торгох;</p>	<p>Энэхүү заалтын хэрэгжилт нь бодит байдал дээр тун тааруу байна.</p> <p>Ш ү ү х э э с хөдөлмөрийн тухай хуулийг хэрэглэж байгаа практик сэдэвт судалгааны ажлын явцад энэ талаар судалгаа хийхэд хуулийн энэ заалт бараг хэрэгждэггүй гэж саналасуулгаднийг 166 хүн оролцсоны 37.2 хувь нь үзсэн байдаг. Энэ нь тухайн заалтын хэрэгжилтэнд тавих хяналт сул, түүний зарцуулалт нь тодорхой бус байдагтай холбоотой.</p>	<p>3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон иргэний хөдөлмөрийн чадвар сэргээгдээгүй нөхцөлд өндөр насны тэтгэвэрт шилжүүлэхдээ өмнө авч байсан тахир дутуугийн тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх;</p> <p>4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон иргэний тахир дутуугийн тэтгэврийн хэмжээг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс хамааруулахгүйгээр дундаж цалингийн 100 хувиар тогтоодог болох, тахир дутуугийн тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх;</p>
--	---	--	--



ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Иргэний эрх зүйн
тэнхимийн ахлах багш А.Дугармаа

Монгол Улсын Үндсэн хуулийг дагаж мөрдөх үеэс эхлэн эрх зүйн шинэчлэлийг хийж, 1998 онд УИХ-аас Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлснээр Үндсэн хуульд тусгалаа олсон хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн баталгааг төр бүрдүүлж, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд эрх ашгийг нь хамгаалах чиглэлээр олон хуулийг батлан гаргасны нэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль юм.

Энэ хуулийн хүрээнд шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэр, эрх зүйн баримт бичгийн үндсэн дээр бусдын хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрх ашгийг сэргээж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбогдсон нийгмийн харилцаа зохицуулагдаж байна. Өөрөөр хэлбэл, иргэний хэргийг хянан шийдвэрлээд шүүхээс гаргасан шийдвэр, шүүхээр баталгаажуулсан нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, захиргааны шийтгэвэр тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг төрөөс эрх олгогдсон байгууллага, төлбөр авагч, төлбөр төлөгч бусад субъектийн оролцоотойгоор гүйцэтгэх ажиллагааг энэ хуулиар зохицуулж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд зааснаар хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн хэн боловч эрх ашгаа хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрхтэй. Энэхүү мэдүүлэх эрх нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгжиж байдаг бөгөөд бусдын гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүх хүлээн авч иргэний

хэрэг үүсгэх, анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх, анхан шатны журмаар хянан хэлэлцэж шийдвэр гаргах, анхан шатны шүүхээс гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргасан бол давж заалдах болон хяналтын журмаар хянан хэлэлцэн зөрчигдсөн эрхийг сэргээж шийдвэр, магадлал, тогтоол гаргана.

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, магадлал, тогтоолыг зохих этгээд сайн дураар эс биелүүдбэл шийдвэрийг албадан гүйцэтгүүлнэ.

ИХШХШХ-ийн 11 дүгээр зүйлд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр заавал биелэгдэх зарчим тусгалаа олсон төдийгүй хуулийн 18 дугаар бүлэг нь "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл" хэмээн нэрлэгдэж, шийдвэр гүйцэтгэлийн албадах ажиллагааны үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичгийн эрх зүйн зохицуулалтыг баталгаажуулсан.

Иргэний хэрэг, маргааныг шүүхээс шийдвэрлээд гаргасан шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг ИХШХШХ болон Шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулиар тус, тус зохицуулж байгаа билээ.

Хэдийгээр шүүхийн шийдвэр гарсан ч шийдвэр бүхэн бүрэн дүүрэн, бодитой биелэгдэхгүй олон сар жил болдог, шүүхийн шийдвэрийг биелүүлэх явцад хүний өмчлөх эрх ноцтой зөрчигддөг, шийдвэр гүйцэтгэгч нарын мэдлэг чадвар сул, зан байдал, ёс суртахууны хувьд дартай, ялангуяа төлбөр төлөгч нартай зүй бусаар харьцдаг, ажилдаа хөшүүлн хойрго ханддаг, ямар ч ажиллагаа хийгээгүй атлаа шийдвэр гүйцэтгэлийн явцад тэдний оролцоогүйгээр төлөгдсөн төлбөрөөс их хэмжээний мөнгөн урамшуулал, зардлын мөнгө авч хохироодог талаар амьдрал дээр

ихээхэн шүүмжлэл гарч байдаг.

Тийм учраас ийнхүү иргэдийн анхаарал татсан иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны зарим асуудлын талаар та бүхэндэй саналаа солилцохыг зорилго.

1. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны салшгүй нэгэн хэсэг буюу үе шат болох тухай

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох тухайд...

Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны явцад иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны мөн чанар, зарчим, түүний зорилгоос үүдэн ихэнхи судлаач шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулах зүйлийн хүрээнд багтааж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төгсгөлийн үе шат хэмээн үзэх үзэл баримтлал давамгайлж, харин тухайн харилцааг зохицуулсан хууль тогтоомоо иж бүрдэл шинжиж агууна гэж тодорхойлсон байдаг. Энэ тухай Академич С.Нарангэрэлийн бичсэн "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо" номын 82-83 дахь тал болон "Шихихутаг" сэтгүүлийн 2000 оны №1-ийн 85 дахь тал, МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимээс бэлтгэн гаргасан "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" /Ерөнхий анги/ сурах бичгийн 17 дахь талуудаас тус, тус тодруулан үзэж болно.

Мөн зарим судлаач шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйд иргэний хэргийн шүүхийн шийдвэр

гүйцэтгэлийн болон ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг хамтад нь нийлүүлэн авч үзээд эрх зүйн системд бие даасан салбар эрх зүй хэмээн тодорхойлж бичсэн нь бэс бий.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд тусгай бие даасан үе шат байдлаар авч үзэх нь энэхүү ажиллагааны зарчим, мөн чанар, ажиллагаанд оролцогчдын бүрэн эрх, албадан биелүүлэх ажиллагааны журамтай салшгүй холбоотой гэж үзэж байна.

Энэхүү ажиллагааны ойголтыг тодорхой болгохын тулд:

1. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа гэдэг нь иргэний хэргийн талаарх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа журам юм;

2. Шүүхээс гарсан шийдвэр, мөн түүнчлэн шүүхээс баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэрийг албадан гүйцэтгэх явцад шийдвэр гүйцэтгэх байгууллага ба ажиллагаанд оролцогч бусад субъектийн хоорондын үйл ажиллагааны нийлбэр;

3. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг хамгаалах явцад үүссэн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны нийлбэр мөн гэдэг байдлаар тус тус тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа гэдэг нь иргэний хэргийн талаарх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэр төдийгүй шийдвэр гүйцэтгэх байгууллага шийдвэр гүйцэтгэгч, төлбөр төлөгч, төлбөр авагчийн хооронд төлбөрийг биелүүлэхтэй холбогдсон эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах харилцааны нийлбэр юм.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлсэн, хоорондоо хамаарал бүхий тодорхой үе шатуудыг дамжиж хэрэгждэг бөгөөд үе шат бүр өөрийн гэсэн онцлогтой тэдгээрийг тодруулан авч үзэх нь зүйтэй юм.

1. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд оролцогч

субъектуудын хувьд онцлогтой.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал байх субъект нь шүүх бөгөөд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, бичдэгийн өмгөөлөгч, төлөөлөгчийн хооронд үүсч буй болох харилцаа шүүхээр дамждаг.

Тэгвэл иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд заавал оролцох субъект нь шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч бөгөөд төлбөр авагч, төлбөр төлөгчийн эрх, үүрэг энэ байгууллагаар дамжин хэрэгжиж байдаг. Шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх засаглалын байгууллага

хэрэгжүүлж байна. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэхэмжлэгч нь Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны төлбөр авагч бол хариуцагч нь төлбөр төлөгчийн эрх, үүргийг эдэлнэ.

2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэхэмжлэлийг хүлээн авах, иргэний хэрэг үүсгэх, анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд бэлтгэх, анхан шатны болон, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүх хуралдааны дэг, шийдвэр, магадлал, тогтоол, хуулийн хүчин төгөлдөр болох журам зэргийг ИХШХШХ-аар зохицуулж байгаа бол төлбөр төлөгчийн орон байранд нэвтрэн орох, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, үл хөдлөх хөрөнгийг албадан дуудлага худалдаа зохион байгуулах зэрэг ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай төрөлжсөн хуулиар зохицуулж байна. Өөрөөр хэлбэл, ажиллагааг зохицуулж буй эх сурвалжаараа ялгагдах онцлогтой юм.

3. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд ИХШХША /цаашид "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа" гэх/ нь үндсэн болон тусгай зарчим болох хуулийн өмнө эрх тэгш байх, хууль дээдлэх, диспозитив буюу зөвшилцөх, мэтгэлцэх, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр заавал биелэгдэх зэрэг зарчим онцлог байдлаар хэрэгжиж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд тусгалаа олсон байдаг.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны эцсийн зорилго нь шүүхээс гарсан болон шүүхээс баталгаажуулсан шийдвэрийг албадан гүйцэтгэж, зөрчигдсөн эрх ашгийг нь бодит байдлаар сэргээхэд оршиж байдаггаара иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шатны ажиллагаанаас ялгагдах онцлогтой.

Ийнхүү иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны онцлог шинжүүдийн талаар авч үзэж байгаа нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжилсэн, эцсийн үе шат гэдгийг тодруулах, эрх зүйн системд эзлэх байр суурийг судлахад ач холбогдолтой юм.

Мөн түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, зохион байгуулалтын асуудлыг боловсронгуй болгоход ч ач холбогдолтой гэж үзэж байна.

Гадаадын улс орнуудын хувьд улс бүрийн нийгмийн хөгжлийн тодорхой үе шатанд улс төр, эдийн засгийн амьдралын онцлог байдлаас шалтгаалан шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа өвөрмөц байдлаар явагдаж, тухайн ажиллагааг эрхэлдэг байгууллагын бүтэц, тогтолцоо нь хүртэл өөр боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, зөрчигдсөн эрх ашгийг нь хамгаалах, зөвхөн хуулийн хүрээнд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулах, төлбөр авагч, төлбөр төлөгч талуудын эрх тэгш байдлыг хангах, талуудад аль болох зөвшилцөлд хүрч тохиролцох боломжийг бүрдүүлэх зэрэг нийтлэг зарчмууд улс бүрийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хэрэгжиж байдаг байна.

Мөн түүнчлэн шийдвэр биелүүлэх байгууллага нь тухайн улсын шүүхээс гаргасан шийдвэрийн бодит биелэлтийг хангах гэсэн нэгдсэн чиг үүргийг гүйцэтгэж байдаг онцлогтой.

Гадаадын зарим орон тухайлбал, ХБНГУ, Япон, АНУ зэрэг улсад шийдвэр биелүүлэх ажиллагааны эрх зүйн тогтолцоо ямар байдгийг товч дурья.

Япон улсад "Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх

тухай” хуулийг 1979 оны 3 дугаар сарын 30-ны өдөр баталж 1980 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн бөгөөд 4 бүлэг, 198 зүйлтэй.

Эрхний үндэслэл, Албадан биелүүлэх ажиллагааны тухай, Барьцаалах эрхийн биелэлтийг хангах дуудлага худалдаа, Торгох гэсэн бүлгээс бүрдэх ба Албадан биелүүлэх ажиллагааны тухай 2 дугаар бүлэг нь дотроо олон хэсэг, зүйлд ангилалдсан байна.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг нутаг дэвсгэрийн шүүхэд харьяалагддаг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлэх ба шийдвэр гүйцэтгэгчийн харьяалагддаг нутаг дэвсгэрийн шүүхийг шийдвэр гүйцэтгэх байгууллага гэнэ гэж тодорхойлсон.

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг Шүүхийн тухай хуульд зохицуулсан байна.

Энэ хуулиар хуулийн хамрах хүрээ, хэргийн харьяалал, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гомдол гаргах журам, зардал, албадан гүйцэтгэх ажиллагааны журам, эд хөрөнгийг барьцаалах, битүүмжлэх, хадгалах, үл хөдлөх хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах болон усан онгоц, хөдлөх хөрөнгөгүй холбогдсон ажиллагааны журам, гүйцэтгэх хуудсыг хүргүүлэх онцгой нөхцөл, гүйцэтгэлийн ажиллагаанд төрийн захиргааны байгууллагаас тусалцаа үзүүлэх, Иргэний процессийн хуулийг энэхүү ажиллагаанд хэрэглэх журам зэргийг зааж тусгажээ.

Япон улсад иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг шүүх мэргэжлийн удирдлагаар хангаж, төлбөр төлөгч, төлбөр авагчийн эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй байна.

Мөн албадан биелүүлэх ажиллагааг Дээд шүүхээс баталсан заавар, журмын дагуу явуулдаг.

Харин эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар зохицуулдаг байна.

ХБНГУ-д 1950, 1990 онд зохи нэмэлт, өөрчлөлт орсон 1877 оны Иргэний процессийн хуулийн 5 дугаар бүлэг, 704-

945 дугаар зүйлүүдэд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмыг зохицуулсан байна. Хуульд гүйцэтгэлийн ажиллагааны нийтлэг үндэслэл, төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгөөс төлбөр гаргуулах, хуулийн этгээдийн төлбөрийг төлүүлэх журам зэргийг тогтоож өгсөн бол тус хуулийн 166, 753, 808, 831 дүгээр зүйл, Шүүхийн байгууламжийн тухай хуулийн 154 дүгээр зүйлд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлжээ.

Шийдвэр гүйцэтгэгч шийдвэрийг биелүүлэх ажиллагааг шүүхийн хяналтын дор гүйцэтгэж, төлбөр төлөгчийн эд хөрөнгөд халдах эрхийг хэрэгжүүлж байдаг байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн төсөв, санхүү, боловсон хүчнийг шилж сонгох ажиллагаа нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын харьяалалд хамаараад бол шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангагдаж байгууллага нь шүүх байна.

АНУ-д шүүхээс гаргаж байгаа шийдвэрийг төлбөр авагч, төлбөр төлөгч нар аль болох харилцан тохиролцоо хэлбэрээр биелүүлэх зорилго тавих бөгөөд харилцан тохиролцоо чадаагүй, төлбөр төлөгч сайн дураараа төлбөрийг төлөөгүй бол шийдвэрийг албадан биелүүлэхээр шүүхэд ханддаг байна. Энэ тохиолдолд шийдвэрийг албадан биелүүлэх болно. Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх олгогдсон төрийн эрх бүхий байгууллага шийдвэрийг албадан биелүүлнэ.

АНУ-ын холбооны болон муж улсуудын шүүхийн дэргэд шүүхийн шийдвэр, тогтоолыг албадан гүйцэтгэх ажиллагааг явуулж байдаг ажилтан байх ба холбооны шүүхэд түүнийг маршал, мужийн шүүхэд шериф гэж нэрлэдэг боловч хэрэгжүүлж байдаг чиг үүргийн хувьд зарчмын ялгаа үгүй учраас нийтэд нь шериф гэдэг нэрийг хэрэглэдэг байна.

Шериф шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэхээс гадна шүүхийн барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах, хариуцагчид нэхэмжлэлийг гардуулах, гэрчийг дуудаж зэрэг шүүхийн ажлыг давхар гүйцэтгэдэг. Зарим муж улсад цагдаагийн үүрэг

ажлыг ч амжуулдаг байна. Шериф шийдвэрийг биелүүлэх ажлыг төлбөр авагч, түүний өмгөөлөгчийн заавраар гүйцэтгэдэг учраас харьцангуй хувийн эхлэл дээр энэ ажиллагаа явагддаг гэж үзэж байна.

Төлбөр авагчийн өмгөөлөгчийн санаачилга, идэвхи зүтгэлээс гүйцэтгэлийн ажлын эцсийн үр дүн ихээхэн хамаардаг учраас ажиллагааны гол оролцогч нь өмгөөлөгч, шериф, шүүхийн нарийн бичгийн даргаас төлбөр авагчид өгсөн гүйцэтгэх хуудсын үндсэн дээр ажилладаг. Гүйцэтгэх хуудсыг хүлээн авахаас эхлээд төлбөр төлөгчийн эд хөрөнгийг барьцаалах, битүүмжлэх зэргээр шийдвэрийг бүрэн гүйцэтгэх хүртэл шерифээс явуулах бүх процесс ажиллагааг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж ойгодог байна.

Гүйцэтгэх хуудсыг хүлээн авмагч төлбөр төлөгчийн өмчлөлийн эд хөрөнгийг илрүүлэх, битүүмжлэх ажиллагааг нэн даруй явуулдаг ба төлбөр авагчийн өмгөөлөгч төлбөр төлөгчийн нуугдал эд хөрөнгийг хаанаас эрж болох, ямар эд хөрөнгө байгаа эсэх талаар өргөн мэдээллийг шерифт өгнө. Үүний үндсэн дээр шериф хөдлөх эд хөрөнгийг битүүмжилж, эд хөрөнгө хадгалах газар хүлээлгэж өгөх, авчирч болохгүй овор ихтэй хөрөнгийг лацдаж өмчлөгчид мэдэгдэнэ.

Эд хөрөнгийг битүүмжилсэн бол хадгалах асуудлыг шүүх хариуцах бөгөөд хадгалалтын үйлчилгээ эрхэлдэг байгууллага болон бусад этгээдэд хадгалуулах асуудлыг шийдвэрлэдэг байна. Дараа нь дуудлага худалдаагаар худалдан борлуулахад тухайн хөрөнгөд хамгийн өндөр үнэ өгсөн оролцогч тухайн хөрөнгийн өмчлөгч болно. Шериф хөрөнгийг борлуулахдаа үнэ нь төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц хэмжээтэй байхад анхаарна. Хэрэв битүүмжилсэн хөрөнгийн үнэ төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол өөр эд хөрөнгийг барьцаалах тухай шийдвэр гаргадаг байна. Мөн үүнчлэн шериф гүйцэтгэлийн ажиллагаа явуулсан тухай тайлангаа тухай бүр бичнэ. Шериф төлбөр төлөгчийн өмчлөлийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах чадаагүй бол бусдад байгаа эд хөрөнгө.

цалин орлого, хадгаламжид байгаа мөнгө, үнэт зүйлээс гаргуулахаар шүүхээс гүйцэтгэх хуудсыг авч болох ба энэ ажлыг нарийн зохион байгуулах үүрэг шерифт ногддог байна.

Европын зарим оронд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хувийн шийдвэр гүйцэтгэгч нар хэрэгжүүлдэг зохицуулалт бий. Тухайлбал, Франц, Бельги, Люксембург зэрэг улсад шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тусгай зөвшөөрөл авсан ямар ч мэргэжлийн хүн гүйцэтгэх боломжтой ба тэдгээр нь хариуцлагын даатгалд заавал даатгуулж байж энэ ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Харин Англид төрийн албан хаагч энэ ажиллагааг гүйцэтгэхийн зэрэгцээ хувийн шийдвэр гүйцэтгэгч ч бас ажиллаж болдог байх жишээтэй.

Ийнхүү гадаадын зарим улс орны иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг судалж үзэхэд:

1. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгч гол, чухал үүрэг гүйцэтгэдэг учраас тэднийг бусдаас хараат байж, гүйцэтгэлийн ажиллагааг түргэн, шуурхай, нээлттэй явуулахад мөрдөх хууль тогтоомж, дүрэм, заавар гэх мэт эрхийн актууд нь хэрэглэхэд ойлгомжтой, хоёрдмол санаа агуулаагүй, гүйцэтгэх арга хэмжээг нарийн зохицуулсан байх нь чухал гэж үзэж байна;

2. Шийдвэр гүйцэтгэгч төрийн нэрийн өмнөөс бүсдын өмч хөрөнгөд хэний ч зөвшөөрөлгүй халдах тусгайсан эрхийг эзэлдэг учраас тэдэнд мэдлэг, мэргэжил, мэргэшил, ёс суртахууны хувьд өндөр шаардлага тавигдах тийм эрх зүйн орчинг бий болгох;

3. Шийдвэр гүйцэтгэгчийг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг шүүх гүйцэтгэж байхаар бүтэц, зохион байгуулалтын боловсронгуй болгох.

Шүүхийн үйл ажиллагаа хүний эрх, эрх чөлөө, хууль, шударга ёсны баталгаа болдог учир шүүх эрх мэдлийг бодитой хэрэгжүүлэх нь хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн үндэс болно.

Тийм ч учраас гадаадын ихэнх улс оронд иргэний хэргийн

шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах байгууллага шүүх байдаг байна.

Энэ байдлаас дүгнэвэл иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шүүхээс тусгаарлаж, салгах үндэслэл байхгүй байна.

Манай улсын тухайд иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шүүх мэргэжлийн талаас нь удирддаг, шүүгч гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавьж харилцан уялдаатай ажилладаг тогтолцоо байсан үе бий.

1997 оноос Засгийн газрын тухай хууль, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн дагуу Хууль Зүйн сайдын эрхлэх ажлын хүрээнд ял эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, зарчмын ялгаатай өөр ажиллагаануудыг нэгтгэсэн нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндэрл учруулж байгаа гэж үзэх үндэслэлтэй.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд төлбөр төлөгч, төлбөр авагчийн хоорондын харилцааг диспозитив аргаар зохицуулах боломж илүүтэй байхад харин ял эдлүүлэх ажиллагаанд императив арга зонхилдог төдийгүй, аль алинд нь хэрэгжих зарчим нь ч өөр байдаг.

Үүнээс өмнө иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа нь шүүхийн Тамгын газрын дэргэд, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн тогтоол биелүүлэх ажиллагаа тусдаа хорих ял эдлүүлэх байгууллагын харьяалалд явж ирсэн.

Цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц тогтолцоог боловсронгуй болгож, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг мэргэжлийн чиг үүргээр эрхлэх үүргийг шүүхэд шилжүүлэх, зарчмын хувьд ял эдлүүлэх байгууллагаас салгах, цаашид төсөв, санхүүгийн хувьд бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх үүднээс хувийн хэвшилд ажиллагаа явуулах, эрх олгох боломжийг судлан хуульчлах нь зүйтэй санагдаж байна. Хувийн шийдвэр гүйцэтгэгчид тавих мэргэшлийн болон ёс суртахууны шаардлааг өндөржүүлж, тэднийг

шилж сонгох, эрх олгох, мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн тогтолцоог бий болгох нь судалбал зохих асуудлын нэг мөн гэж үзэж байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийг боловсронгуй болгох зарим асуудлын талаар

А. Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ", "Шийдвэр гүйцэтгэлийн цалингаас бусад үйл ажиллагааны зардлыг энэ хуулийн 83 дугаар зүйлд заасан урамшууллаас санхүүжүүлнэ" гэж зааснаар шийдвэр гүйцэтгэгч төрийн албан хаагчийн хувьд төрөөс цалинжиж, харин бусад бүх зардлаа урамшууллаас санхүүжүүлж байна.

Гэтэл шийдвэр гүйцэтгэлийн зардлыг санхүүжүүлж байгаа эх үүсвэрийг "урамшуулал" хэмээн нэрлэж байгаа нь хэр зэрэг нийцтэй байна вэ, гэдгийг эргэж харах шаардлага тавигдаж байна.

Я. Цэвэлийн "Монгол хэлний тайлбар толь" бичгийн 597 дугаар хуудаснаас шь татвал "Урамшуулал гэдэг нь урамшигчдын үйлдүүлэх хэв, шагнах, хөхиүүлэх, урамшуулал шагнах юм" гэжээ.

Урамшуулал гэдгийг нь хэн нэгэн сайн ажилласан, амжилт гаргасны төлөө хөхиүлэн дэмжиж байгаа хэлбэр гэдэг талаас нь ойлгодог. Хуульд хэрэглэгдэж байгаа нэр томъёо нь төрөөс тогтоосон байдгаараа албан ёсны шинжтэй боловч утга агуулгын хувьд иргэдэд ойлгомжтой, тодорхой, нэг л утгыг илэрхийлсэн байх ёстой.

Жирийн иргэд шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгоого гэвэл шийдвэрийг биелүүлээд дууссаны дараа ажилласныг урамшуулал олгож байгаа хөлийг нь өглөө гэж ойлгоно. Гэтэл энэхүү урамшууллын хөрөнгөөр боловсруулж эрсдийн сан, албаны байр, цахилгаан дулаан, тоног төхөөрөмж, урсгал зардал, сургалт семинар, томилолт зэрэгт шаардагдах зардлыг санхүүжүүлж байгаа тул энэ нь шийдвэр гүйцэтгэгчид бүрэн хэмжээгээр хүрч байгаа мөнгөн хөрөнгө биш юм. Гэтэл Шүүхийн

шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 83 дугаар зүйл "Шийдвэр гүйцэтгэлийг урамшуулах" хэмээн нэрлэгдэж, шийдвэр гүйцэтгэлийг л урамшуулах зохицуулалт хийгджээ.

Иймд шийдвэр гүйцэтгэлийн албаны санхүүжилтийг бий болгож байгаа "шийдвэр гүйцэтгэлийн урамшуулал" гэдэг нэр төмөр бодит байдалд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

ХЗДХ-ийн Сайдын 2002 оны 208 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Шийдвэр гүйцэтгэлийн урамшууллыг суутгаж, хуваарилах журам"-ын 3.1-д урамшууллын доод хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуульд заасан хэмжээнээс ихээр тогтоосон нь уг журмыг илт хууль бус гэдгийг илтгэж байна.

Шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд урамшууллын хэмжээ, төлбөрийг хангуулахаар гаргасан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,5-10 хүртэл хувь байхаар тогтоосон бол журамд энэ хувь хэмжээг 5,5-10 хувьтай байхаар тогтоосон байна.

Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг зохих хугацаанд нь бодитойгоор, бүрэн гүйцэтгэсэн тохиолдолд урамшууллыг олгож байхаар журамд заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгчөөс төлбөрийг ямар хугацаанд албадан гаргуулах талаар нарийвчилсан зохицуулалт бараг үгүй бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд эд хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг түүнийг хураан авснаа хойш 2 сарын дотор гүйцэтгэх зохицуулалт бий. Харин дээр нэрлэсэн журмын 5.1-д шийдвэрийг гүйцэтгэх хугацааг үл хөдлөх хөрөнгө борлуулж шийдвэр гүйцэтгэх бол 4 сар, бусад тохиолдолд 2 сарын дотор гэж тогтоож өгсөн нь сайшаалтай. Энэ хугацааг хэтрүүлсэн бол урамшууллыг суутгаж хуваарилахгүй байх боломжтой болж байна.

Практикт энэ журамд заасан хугацааг баримталж төлбөрийг бүрэн хэмжээгээр барагдуулсан тохиолдолд нийт биелсэн шийдвэрийн хэдэн хувийг эзлэх талаар судалгаа явуулбал сонирхолтой тоо баримт гарах

байх гэж үзэж байна. Гэтэл урамшууллыг шийдвэрийг бүрэн, хугацаанд нь биелүүлсэн эсэхийг харгалзахгүйгээр төлбөр авагчаас шаардан авсаар л байгаа юм

Төлбөр авагч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, урамшуулал зэргийг шийдвэр гүйцэтгэх байгууллагад гэрээний үндсэн дээр төлдөг учраас шийдвэр гүйцэтгэгч жинхэнэ хуулийн дагуу түргэн, шуурхай ажиллаж төлбөрийг гаргуулж чадна гэж бүрэн итгэдэг. Тийм ч учраас энэ ажиллагаанд өмгөөлөгчөөс эрх зүйн туслалцаа авах эрх хязгаарлагдадаг. Өмгөөлөгчид үйлчилгээ үзүүлсний хөлөнд төлөх төлбөрөө шийдвэр гүйцэтгэх байгууллагад төлдөг гэх мэт.

Б. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглох нь...

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтаас хархад шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, бусад байгууллагын шүүхээс баталгаажуулсан шийдвэр байх, шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглосон төдийгүй энэхүү баримт бичгийн агуулга, түүнд тавигдах шаардлага, үр дагаврын талаар ч тодорхой зааж өгсөн байна.

Гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчөөс төлбөр авагчид олговол зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, захирамж, шүүхээс баталгаажуулсан мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, захиргааны шийтгэвэр, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас зэрэг багтаж байхаар хуульчилжээ.

Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4-д үндэслэлгүйгээр ажлаас халагдсан буюу өөр ажилд илшжүүлсэн, ажилтныг өмнө гүйцэтгэж байсан ажил албан тушаалд згүүлэн тогтоох тухай шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй, албадан гүйцэтгэх тухай мэдэгдлийг хүлээн авсан боловч шийдвэрийг биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч ажилтны ажилгүй байсан бүх хугацааны

цалин хөлс буюу бага цалин авч байсан бол зөрүүг шийдвэр гарсан өдрөөс эхлэн шийдвэр гүйцэтгэх хүртэл хугацаанд шийдвэрийг гүйцэтгээгүй буруутай албан тушаалтнаас албадан гаргуулах арга хэмжээ авна гэжээ.

Энэ нь шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичиг буюу шүүхийн шийдвэрт заагаагүй төлбөрийг гаргуулах ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ цаашилбал, буруутай албан тушаалтныг тогтоож, арга хэмжээ авах үүрэгтэй болж байгаа мэт.

Нөгөөтэйгүүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д зааснаар хүүхдийн тэтгэлэг гаргуулах журмыг Гэр бүлийн тухай хуулиар тогтооно гэж заасан. Гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтаас хархад хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг бий болсон тохиолдолд талууд тэжээн тэтгэх зэрэг байгуулж тэтгэлийн хэмжээг тогтооно хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг хэрэгжүүлэх боломжтой. Тэжээн тэтгэх гэрээг сайн дураар биелүүлэхгүй байгаа тохиолдолд гэрээний талуудын хэн нэгний хүсэлтээр шүүгч захирамж гарган, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмаар биелүүлнэ. Энэ тохиолдолд Нотариатын тухай хуульд зааснаар нотариатын мэдэгдэх хуудас бичиж, түүнийг албадан биелүүлэхээр хүсэлт гаргасныг шүүхээс баталгаажуулан захирамж гаргасны үндсэн дээр гүйцэтгэх хуудас бичигдэж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмаар биелүүлнэ.

Үүнээс гадна, хүүхдийн тэтгэлэг тогтоолох хүсэлтийг шүүх хянан шийдвэрлээд, шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдунсан оног тутамд тогтоосон тэтгэлийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлнө гэсэн заалт бий. Энэ тохиолдолд шүүхийн шийдвэр заагаагүй, үнийн дүн нь тодорхой бус алдангийг шийдвэр гүйцэтгэгч л албадан биелүүлэх шаардлагатай болж байгаа юм.

Ийм учраас шийдвэр гүйцэтгэгч зөвхөн гүйцэтгэх баримт бичгийн үндсэн дээр шийдвэр биелүүлэх ажиллагааг явуулах зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтыг

боловсронгүй болгох шаардлагатай байна гэж үзэж байна.

В. Нэгэнт эхэлсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгч давж заалдах болон хяналтын гомдол гаргасан гэсэн үндэслэлээр түдгэлзүүлэх боломжтой эсэх талаар...

ИХШХШХ-ийн 11 дүгээр зүйлд зааснаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг заавал биелүүлэх, сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ. Мөн хуулийн 120 дугаар зүйлийн 120.1-д зааснаар шийдвэр нь уншиж сонсгосноор хуулийн хүчин төгөлдөр болох бөгөөд энэ үеэс эхлэн шийдвэрийг талууд сайн дураараа эс биелүүлбэл албадах ажиллагааны журмаар биелүүлэх боломжтой. Гэтэл ИХШХШХ-ийн 122 дугаар зүйлийн 122.1-д давж заалдах болон хяналтын гомдол гаргасан бол тэдгээрийг хянан шийдвэрлэх хүртэл шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдахгүй гэж заажээ.

Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгэд тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч давж заалдах

болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрх нь ИХШХШХ-ийн 25, 120 дугаар зүйлд зааснаар баталгаажсан байдаг. Шийдвэрийг гардан авснаас хойш давж заалдах, хяналтын гомдол гаргах хугацаа тоологдож эхэлдэг учраас энэ эрхийг эдлэхдээ ихэнхи тохиолдолд хариуцагч "хойрго" хандаж, шийдвэр биелэхгүй хугацаа алддаг. Давж заалдах болон хяналтын гомдол гаргах эсэх ньтодорхойгүй, гомдол гаргах хуулийн хугацаа хэтэрсэн, нэхэмжлэгч шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлт гаргасан бол шүүгч захирамж гаргах, гүйцэтгэх хуудсыг бичих улмаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэн албадан биелүүлэх ажиллагаа явуулна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байх үед төлбөр төлөгч давж заалдах болон хяналтын гомдол гаргасан бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үү гэдэг асуудал практикт гарч ирж байна. Энэ тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл байхгүй учраас нэгэнт эхэлсэн шийдвэр

гүйцэтгэлийн ажиллагааг зогсоох боломжгүй. Учир нь Шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д "Энэ хуулийн 15.1, 15.2-т зааснаас бусад үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно" гэж заасан байна.

Иймд ИХШХШХ-ийн 122 дугаар зүйлийн 122.1-ийн "... шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдахгүй" гэсэн заалтыг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг нь шийдвэрлэвэл зохиолтой асуудлын нэг болж байгаа юм.

Цаашид ИХШХШХ-ийн 119 дүгээр зүйлийн 119.2-т зааснаар шийдвэрийг гаргаснаас хойш 7 хоногийн дотор бичгээр үйлдэж бүрэн эхээр нь зохигчдоод хүргүүлсэн тохиолдолд шийдвэрийг биелүүлээгүй, төлбөр авагч шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан, шийдвэрийг даруй биелүүлэх шаардлагатай гэж шүүгч үзсэн бол шүүгчийн захирамж гарган шийдвэрийг албадан биелүүлдэг зохицуулалтыг хуульд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Нэг. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн харилцан хамаарал

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс шууд хамааралтай байх онцлогтой. ЗХХШХ¹-ийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэгт ЗХШ (Захиргааны хэргийн шүүх) нь гаргаж байгаа шийдвэртээ тухайн шийдвэрийг гүйцэтгэх арга, журмыг заажээ. Тэгэхээр Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар биш, үндсэндээ шүүхийн шийдвэрээр тогтоогдоно гэсэн үг. Гэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд огт хамааралгүй гэсэн үг биш, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ИХШХШХ²болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмыг зарчмын хувьд баримтална.

Хариуцагч шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэрт заасан шийдвэр гүйцэтгэх арга, журмын дагуу шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явагдана. Хэрвээ шүүхийн шийдвэрт шийдвэр гүйцэтгэх арга, журмыг тодорхойлоогүй бол шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах боломжгүй болно. Ийм тохиолдолд энэ нь шүүхийн алдаа болох юм. Ийм учраас гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авахдаа тухайн шийдвэрт шийдвэр гүйцэтгэх арга, журмыг нь заасан байна уу, үгүй юу гэдгийг нягтлах шаардлагатай болж байна.

¹Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2002.12.26



ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Оросоо

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх талаар ямар нэг нэмэлт, өөрчлөлт ороогүй юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 67 дугаар зүйлд тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасан шийдвэрийг гүйцэтгэх тухайд барилга, орон байрнаас нүүлгэн гаргах, хүүхдийг цэцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх, мөн ажлаасаа халагдсан хүнийг ажилд нь буцаан авах зэрэг цөөн хэдэн тохиолдлыг албадан гүйцэтгэхээр заасан байдаг. Харин захиргааны акт гаргахыг даалгасан болон уул ахтыг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн зэрэг захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэрийг хариуцагч биелүүлээгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн ямар ажиллагаа явуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд

нэрлэж заагаагүй юм.

Улсын Дээд шүүхээс 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарласан байдаг. Уг тайлбарт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10.1.1-д заасан "Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр" гэдэгт захиргааны хэрэг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хамаарна гэж заасан. Энэ нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл нь иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил зарчим, журмаар явагдана гэсэн үг.

ЗХХШХ-ийн 72 дугаар зүйлийн 72.5, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэгт заасан шийдвэр биелүүлэх "арга" гэдэг нь шийдвэрийг нэг бол сайн дураар биелүүлэх эсхүл албадан гүйцэтгэх тухайг, харин "журам" гэдэгт хариуцагч болон шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх буюу гүйцэтгэхийн тулд ямар үйлдэл хийх, үйл ажиллагаа явуулахыг, "хугацаа" гэдэгт шийдвэрийг сайн дураар, эсхүл албадан гүйцэтгэх хугацааг тус тус ойлгоно.

Хоёр. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлд тулгамдсан асуудал бий юу?

Захиргааны хэргийн анхан шатны шүүх хэрэг хянан хэлэлцээд хуульд заасан 9 төрлийн шийдвэрийн аль нэг буюу холбогдох хэсгийг гаргах бөгөөд түүнийг нь давж заалдах болон хяналтын шатны шүүх хянаад хэвээр үлдээх, өөрчлөх эсхүл хүчингүй болгох шийдвэрийг аль нэгийг гаргана.

Захиргааны хэргийн шүүхээс гаргасан зарим шийдвэрийг албадан гүйцэтгэх шаардлага бага байж

болно. Жишээ нь, захиргааны хэргийн шүүхээс захиргааны актыг хүчингүй болгосон, захиргааны акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн, эрх зүйн харилцаа байгааг тогтоож, хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргадаг. Энэ мэт тодорхой эрх зүйн байдлыг тогтоосон (хүчингүй болгосон, илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн зэрэг), хэлбэржүүлсэн шийдвэрийг албадан гүйцэтгэх шаардлага бага юм, учир нь энэ төрлийн шийдвэр нь өөрөө яандаа биелэгдэх шинж чанартай байдаг. Эрх зүйн харилцаанд оролцогч этгээд тухайн шийдвэрийг албадлагаар бус өөрөө ашиглах, дагаж мөрдөх, биелүүлэх замаар хэрэглэдэг.

Харин захиргааны байгууллага, албан тушаалтны зүгээс ЗХШ-ийг үл хүндэтгэн хууль бус болох нь тогтоогдож хүчингүй болгосон акт, мөн илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн актыг хэрэглэх, түүнийг үндэслэл болгох зэрэг эрх зүйн зөрчил гарч болох юм.

Өнөөдрийн захиргааны хэргийн шүүхийн практикаас харахад дээр дурдсан төрлийн шийдвэрт шүүхээс шийдвэр гүйцэтгэх арга, журмыг өөрөөсө тодорхойлохгүй явж байгаа. Хэрвээ эдгээр шийдвэрийг албадан гүйцэтгэх шаардлага гарч ирвэл гүйцэтгэлийн ажиллагаа явагдах боломжгүйд хүрч, маргаантай асуудал гарч болзошгүй.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлд тулгамдаж байгаа, нэн даруй шийдвэрлэх ёстой хэд хэдэн асуудлаас хоёр зүйлийг онцлохд:

1. Захиргааны хэргийн шүүх гаргаж байгаа шийдвэртээ ихэнх тохиолдолд шийдвэр гүйцэтгэх арга, журмыг тодорхой зааж өгөхгүй

байна. Хуулиар шийдвэр гүйцэтгэх арга, журмыг тодорхой зааж үүрэг бий. Энэ нь шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт тавигдаж байгаа нэг шаардлага бөгөөд практик цаашид хэвээр үргэлжлэх юм бол захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явагдахгүй гэсэн үг. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэртээ шийдвэр гүйцэтгэх арга, журмаа тодорхой заасан байхыг шаардах, тийм шаардлага хангасан гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авдаг байх хэрэгтэй юм;

2. Газрын хэрэг, маргаан дээр гаргасан Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн "захиргааны актын биелэлт"-ийг түдгэлзүүлсэн захирамжийг албадан гүйцэтгэх асуудал удаан, чирэгдэл ихтэй хэрэгжиж байна. Ер нь захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн гүйцэтгэлийн асуудлаас захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн захирамжийг албадан гүйцэтгэх асуудал нь илүү анхаарал татсан сэдэв юм. Шийдвэр гүйцэтгэх арга, журмыг тодорхойлох нь зөвхөн шүүхийн шийдвэрт хамааралтай бус шүүгчид дээр дурдсан захирэмжинд ч бас хамаатай гэж үзэх үндэстэй. Иймд шүүгч захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн захирамжиндаа уг захирамжийг албадан гүйцэтгэх арга, журмыг мөн тодорхойлох шаардлагатай гэж ойлгож байна.

Практик дээр шүүгч гаргасан захирамжиндаа шийдвэр гүйцэтгэх арга, журмыг төдийлэн оновчтой заахгүй, зөвхөн газар ухах, барилга барихыг хориглосон заалт оруулсан харагдана. Энэ нь хэрэглэхэд үр дүнтэй биш байна.

Нөгөө талаар шийдвэр гүйцэтгэгч шүүгчийн захирамж, түүний зөв ойлгож, тайлбарлан хэрэглэх, гүйцэтгэлийн ажиллагааг бүрэн гүйцэт хийх тал дээр дутмаг зүйл бий. Өөрөөр хэлбэл, газрын хэрэг, маргаантай холбоотой захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн буюу газар ухах, барилга барих ажлыг зогсоосон шүүгчийн захирамжийг шийдвэр гүйцэтгэх алба, шийдвэр гүйцэтгэгч "албадан" гүйцэтгэх чадвар сул байгаа юм. Шийдвэр гүйцэтгэгчээс барилга барьж байгаа этгээдэд мэдэгдэл өгдөг, барилга барих ажиллагааг нь зогсоож, битүүжилсэн шийдвэр, тэмдэглэл үйлддэг, шийдвэр гүйцэтгэгчийг явсны дараа нь (барга явж амжаагүй байхад) нь компанийн захирал, барилгын даамал нь "би өөрийнхөө юмыг өөрөө мэднэ", "та нар юу ч мэдэхгүй, та нарт мэддэг юм гэж байхгүй, ажилтай чинь ярина шүү" гээд барилгаа үргэлжлүүлэн барьж, "дарга нартай чинь ярина", "би УИХ-ын гишүүний бие төлөөлөгч байна..." гэж "томроод" ажлаа зогсоодоггүй. Шийдвэр гүйцэтгэгч үг газар дээр дахин 2-3 удаа очоод яаж ч чаддаггүй, цахилгааныг нь тасдаад ч нэмэргүй, 2-3 цагийн дараа шууд залгуулчихна, тэгээд танил талаараа хэлүүлэхээс гадна, дээрээс нь янз бүрийн албан тушаалтнаар хэлүүлж, яриулж, эцэст нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа мухардалд орж "хүчгүй" болж үнэн хэрэгтээ зогсдог. Үндсэндээ суурийн ажил дуусаад 2-3 давхартаа ороход нь сая шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй гэсэн үндэслэлээр Эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр шийдвэр гүйцэтгэлийн алба хэрэг бүртгэх албанд гомдол гаргадаг. Иймд цаашид шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгэх ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.



Нотариатчийн ёс зүйн үндсэн зарчим, нотариатч төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг болох нь

Баянгол дүүргийн тойргийн
нотариатч Д.Дуламцоо

Нотариатчийн ёс зүй нь нийгмийн итгэлийг бүрэн хүлээж чадах мэргэжлийн нотариатчийг төлөвшүүлэн бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Мэргэжлийн ёс зүй гэдэг нь ёс журамтай байх, шударга байх, нэр төртэй байх тухай буюу эрх зүйн ойлголт гэхээсээ ёс суртахууны тухай ойлголт юм.

Түүхээс товчхон авч үзье. МЭ V зуунд Ромын императорууд ялангуяа император Юстиниан нотариатын дүрэм, зарчмыг тогтоосон байдаг. Энэ заншил нь Дундад зууны үед алдарт Болонскийн Их сургууль, Италиас эхлэн бүх Европоор тархсан байна. Мэргэжлийн ёс зүйн гол дүрэм нь энэ мэргэжлээр ажиллагсдын үүргийг тодорхойлох замаар чанартай үйлчилгээ үзүүлэхэд оршиж байсан байна.

Парисын хууль тогтоох Академийн Профессор Массегийн 1803 онд хэлсэн үг одоо ч ач холбогдолоо алдаагүй байна. Тэрээр "Нотариатчийн үүрэгт юуны өмнө шударга байх явдал орно. Зөвхөн өөрийн хэргийн талаар санаа тавьж буй хувь хүний шударга байдлын бус харин иргэдэд тэдний ашиг сонирхол, иргэний эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй албан тушаалтны шударга байдлын тухай ярьж байна. Нотариатч талуудад яг адил хэмжээгээр тэдний эрх, үүргийн агуулга, хэмжээ, хүлээсэн Үүргээс үүдэх хариуцлага, үр дагавар, тэдний хүсэл зоригтоо хүрэх арга замууд, хуулиар олгогдсон урьдчилсан сэргийлэх арга хэмжээнүүдийг тайлбарлаж өгөх үүрэгтэй" гэжээ.

ОХУ-ын Нотариатын тухай хуульд "Нотариатчийн үүргээ хуулийн дагуу, чин сэтгэлээсээ гүйцэтгэж, мэргэжлийн нууцыг

хадгалан, хүнийг хүндэтгэх, хүнлэг байх зарчмыг өөрийн үйлдэлдээ удирдлага болгохоо ёс төртэйгээр тангараглаа" хэмээн нотариатчийн эрхээ хэрэгжүүлж эхлэхийн өмнө тангаралах тухай заасан байна. Швейцарьт, "Өөрийн албан тушаалын үүргээ нэр хүндтэйгээр, нэг бүрчлэн, шударга биелүүлэх, хуулийн чанд баримтлах, нийгмийн хэв журам, ёс зүйд харш хэлцэлийг дэмжихгүй байхаа амлаж байна" хэмээн тангарагладаг байна.

Нотариатчийн ёс зүйн Европын хуулийг 1995 оны 2 дугаар сард болсон Латин нотариатын Олон улсын Холбоонд оролцдог Европын Холбооны нотариатчдын Холбооны бага хурлаар баталсан байна. Уг хуульд нотариатын үйлчилгээ үзүүлэх үед үйлчлүүлэгчид тэгш хамгаалалтаар хамгаалах нотариатчдын хүсэл эрмэлзлэлийг тусган дараах зарчмуудыг тодорхойлсон байна.

Үүнд:

- мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэх үедээ ёс зүйн хувьд шударга, ёс журамтай байх;
- аль нэг талд нь илүү үйлчлэхгүй, хэнээс ч хамааралгүй байх;
- мэргэжлийн нууцыг хадгалах;
- хууль эрх зүйн өндөр чадвартай байх;
- ганцаарчилсан зар сурталчилгааг хориглох.

Мэргэжлийн ёс зүйн нэгдлийг хангахад нотариатын сахилга батын дүрэм нь маш чухал үүрэгтэй.

Нотариатчийн ёс зүйд өмгөөлөгчөөс ялгагдах нэг онцлог нь талуудад тэгш зөвлөгөө өгөх, аль нэгнийх нь талд илүү үйлчлэхгүй байх үүрэгтэй байдаг. Харин өмгөөлөгч бол аль нэг талынх нь төлөө үйлчлэхэд бүх хүч чадлаа дайчилж, хэргийг судлах явцад олж

мэдсэн, эсрэг тал сөргөөр ашиглаж болох зарим мэдээллийг ч нууж чадах ёстой байдаг байна.

Мэргэжлийн нууцыг хадгалах зарчим

Аливаа нууцыг ямар нэгэн байдлаар мэдсэн этгээд нууцыг хадгалах нь ёс зүйн хэрэг байдаг бол Нотариатчийн хувьд энэхүү үүрэг нь нийгмийн асар их ач холбогдол бүхий онцгой үүрэг болж хувирдаг.

Иргэний болон Эрүүгийн хэргийн шүүхээс, зарим тохиолдолд Татварын байгууллагаас нотариатын үйлдлийн баримт бичгийг шаардаж болох юм. Гэхдээ зөвхөн тодорхой акт эсвэл тодорхой үйлчлүүлэгчтэй холбоотой баримт бичгийг шаардаж болохоос бус нотариатчид хадгалагдаж байгаа бүх баримтыг ерөнхий хяналтдаа авна гэсэн үг биш ээ. Мэргэжлийн нууцын холбогдолтой мэдээллийг нээхийн тулд нотариатчийн нууц хадгалах үүргээс нь чөлөөлсөн талуудын зөвшөөрөл шаардагдаж болно.

Нотариатч төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг болох нь

Төр, эрх зүйн онолын үүднээс авч үзвэл Төрийн чиг үүргүүдийг төрийн эдийн засгийн чиг үүрэг, төрийн хүмүүнлэгийн чиг үүрэг, төрөөс иргэдийн эрх, эрх чөлөөг хангах чиг үүрэг, төрийн хууль ёс, дэг журмыг бэхжүүлэх чиг үүрэг, төрийн шинжлэх ухаан, технологийн чиг үүрэг, төрийн экологийн чиг үүрэг, төрийн гадаад чиг үүрэг гэх мэт ангилдаг байна.

Монгол Улсын Үндсэн хуульд "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг

бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасан байдаг.

Нотариат нь чухамхүү хууль зүйн баталгааг бүрдүүлэх, эрх, эрх чөлөөг зөрчихөөс сэргийлэх, төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх Төрийн чиг үүргийг шүүх хэрэгжүүлдэг байна.

Төрийн тогтолцооны түүхээс авч үзвэл нотариатын байгууллага нь 1925 онд анх байгуулагдахдаа Шүүх явдлын яамны 5 хэлтэсийн нэг болж байгуулагдаж байсан байна. 1964 оноос Шүүх яам татан буугдахад Төрийн тогтолцооны түүхээс авч үзвэл нотариатын байгууллага нь 1925 онд анх байгуулагдахдаа Шүүх явдлын яамны 5 хэлтэсийн нэг болж байгуулагдаж, байсан байна. 1964 оноос Шүүх Яам татан буугдахад нотариатын үйл ажиллагааг Дээд шүүхэд шилжүүлсэн, 1985 оноос Улсын нотариатын контор болон өргөжсөн бол 1992 оноос анхны хувийн нотариатчдийг томилоноор нотариатын үйл ажиллагааны зарим хэсэг төрийн зохицуулалттай хувийн хэлбэрт шилжсэн байна. Ийнхүү нотариатын хэлбэр нь өөрчлөгдсөнөөс бус чиг үүрэг нь хэвээр байгаа гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ.

Одоо төрийн энэ үйлчилгээг төрийн албан хаагчид /Гадаадад консулын ажилтан, сумдад сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар/ болон Төрөөс олгогдсон тусгай зөвшөөрлийнхөө дагуу хуульч

мэргэжилтэй иргэд үзүүлж байна. Иймээс ч Засгийн Газрын 41 дүгээр тогтоолоор батлагдсан зааврын 2 дугаар зүйлд дор дурдсан төрийн байгууллага, албан тушаалтан тамга хэрэглэнэ гэж заагаад 2 К-д Төрийн архив, нотариат, шүүхийн шийдвэр биелүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага, 16-ийн К-д баг, хорооны Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын тамга, тосгоны захирагч, нотариатч, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага, аймгийн архивын тасгийн тамга.....түүний төв хэсэгт соёмбо байрлуулсан байна гэж заажээ.

- Нотариатч төрөөс олгосон албан тушаалын үүргийг хэрэгжүүлдэг учраас түүний мэргэжлийн үйл ажиллагааг Төрөөс хязгаарлаж, хянаж байдаг. ХЗДХЯ-ны сайдын тушаалаар Нотариатчдын танхимын дэргэдэх сахилгын зөвлөлийн дүрэм, нотариатын үйлдэл эрхлэн хийх заавар, нотариатын үйлчилгээний хөлс, зардлын жишиг зэргийг баталсан байна.

- ХЗДХЯ-нд нотариатын үйл ажиллагааны асуудлыг хариуцсан мэргэжилтэн ажилладаг бөгөөд зөрчилсөн үйлдлийн эх материал, үйлдлийн талаар тэйлбар гаргахыг Шүүх, Прокурор, Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах байгууллагын шаардсаны дагуу нотариатч гаргаж өгөх үүрэгтэй. Харин энэхүү шаардах эрх нь эрх зүйт төрийн нийтлэг зарчмуудын хүрээнд, нотариатчийн бие даасан байх зарчмыг алдагдуулахгүйгээр

хэрэгжих нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, энэхүү эрх нь нотариатчийн үйл ажиллагааг бүхэлд нь хянах гэсэн үг биш юм. Нотариатч нь шүүгчийн нэгэн адил бие даасан байна.

- Нотариатчдын орон тоог төрөөс тогтоодог. Энэхүү тоог тогтоохдоо нэг талаас нотариатын үйлчилгээ хүн амд аль болох ойр дөт, хүрэлцээтэй байх нөгөө талаас нотариатчийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахуйц байхыг тооцоолон хэт цөөн, эсвэл хэт олон болгохдоо зорьтог.

- Төрөөс нотариатчийн албан тушаалд томилох, чөлөөлөх нөхцөлийг хуулиар тодорхойлдог. Мөн нотариатчийн үйл ажиллагааны хүрээ буюу тойргийг тодорхойлдог.

- Төрөөс нотариатчийн үйлчилгээний хөлсийг тогтоодог. Энэхүү хөлсийг нотариатч ажлын байраа өөрийн онцлог бүхий үйлчилгээг үзүүлэхэд хангалттай байхаар тоноглох, эдийн засгийн бие даасан байдал, хамааралгүй байдлыг хангах баталгаатай байхаар тооцон тогтоодог.

Иргэд нотариатын үйлчилгээний ач холбогдлыг мэдэрч, заавал батлуулахаар хуульд зааснаас бусад тохиолдолд ч нотариатчид хандах нь ихсэж байгаа, нотариатчид итгэх итгэл нэмэгдэж байгаа нь нотариатч бидэнд өдөр тутамд ажиглагдаж байдаг.



Эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн Хууль
2. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. "Монгол Улсын Төр, Эрх Зүйн Түүхэн Уламжлал", 1997 он
3. Журнал "Дойче Нотариатшриффт", 1993 он
4. Материалы Шведарской Конфедерации: "Квалифицированная юридическая помощь, защита прав граждан и юридических лиц, 2000г.

Багш нь гэмт хэрэгтэн байжээ

С.Коростелева

Баруун Сибирийн Аникановкийн дунд сургуулийг төгсөж, боловсролын үнэмлэхээ гардаж авсан Аня Перминова, Вера Камышина нар төрөлх тосгонд нь ажлын байргүй тул хол явж, хөдөлмөр эрхлэхээр шийджээ.

Их хот охидод найр тавьсангүй. Тэд өдөржингөө тэнүүчлэн, зур уншиж, зах дээр очиж юухан хэзээнд тусалж чадахаа хэлээд, манаач, ачигч ч байсан хийнэ гэж гуйж байлаа. Гэвч энд тэдэн шиг ажилгүйчүүд дүүрэн байв.

Тоос шороо татсан талбайн тэндэх вандан сандал дээр сууж амрангаа халуун савтай цайнаасаа ууж, эмээгийнхээ пирожиг идэн, цаашид юу хийх тухайгаа бодож байлаа. Гэнэт тэд хоёр жилийн өмнө Биений тамир, хөдөлмөр, иргэний хамгаалалтын хичээл орж байсан багш Геннадий Николаевичийг олж харлаа.

Тэрээр сургуульдаа ганц эрэгтэй нь, бас ч гэж залуу сайхан эр байсан тул багш хүүхнүүд Скориковыг Гена гэж дууддаг байв. Бүх л охин түүнд нууцхан дурлаж байсанд гайхах зүйлгүй. Тэгээд түүнийг гэнэт халагдан яваад өгсөнд маш их харамсаж байсан юм.

Охид түүн рүү авран хамгаална гэсэн итгэл найдвар дүүрэн очиж, хонох газар олж өгөхийг гуйлаа. Ямар гудамжинд хонолтой биш дээ. Геннадий Николаевич гараа дэлгэн та нарыг яалтай ч юм билээ дээ гээд охидыг холгүй орших гэр рүүгээ дагуулаад явлаа.

Аня Вера хоёр замын турш Геннадий Николаевичид хэн хэнтэй гэрлэсэн, хэн нас барсан, хэн тосгоноос авсан талаар сүүлийн үеийн сонинг хөөр баяр дүүрэн ярина.

Багш ч асууж сонирхон байв. Учир нь тэрээр Аникановкад байхдаа гооно эр гэгдэн, англи хэлний багш Новосибирскийн их сургуулийг төгссөн, боловсролтой, сайхан бүсгүйг эргүүлдэг байсан юм. Скориков өөрөө дээд боловсрол

зэмсээгүй нэгэн ч тосгоныхон үүнийг дутагдал гэж үздэггүй байлаа.

"Англи бүсгүй"-г гэрлэсэн эсэхийг асуугаад "Одоохондоо үгүй" гэдэг хариултыг сонссон Геннадий маш их гайхав.

Скориков сурагчдаа гэртээ дагуулж очтол хаалга онгойлгож өгсөн эхнэр нь гоолиг, сайхан охид ирснийг хараад шууд л хэрүүл хийж эхэллээ. Учрыг нь олъё ч гэж бодсонгүй нөхрөө тасхийтал нь алгадаад, урилгагүй зочдыг хаалганыхаа гадна хөөж гаргав. Ингээд хаалгаа дангинатал нь түгжиж аваа.

Шатны хөндийд Аня, Вера хоёр хартай эхнэр нь хөөрхий Генег эхрэн хамаг л муу муухай үгээр хараахыг сонсож суухдаа золтой л уйлчихсангүй. Тэд тийм эр хүн ийм хачин царай муутай авгайныхаа танд байх юм гэж бодож ч байсангүй.

Охид зөвлөлдсөний эцэст олдож буй боломжоо алдахыг хүссэнгүй. Вера хаалга цохисон боловч удтал онгойлгосонгүй. Охид байсхийгээд л хаалгыг нүдээд байлаа.

Ашгүй нэг хүйтэн харцтай, хадам эх нь бололтой хижээл эмэгтэй гарч ирэв. Ташаа тулан урилгагүй зочдын талаар юу бодож байгаагаа урсгах гэж байтал Вера түүнээс урьтлаа. Аяны цүнхээ онгойлгон гахайн том мах гаргаж ирэв:

– Үүнийг Танд, Дөнгөж өчигдөр төхөөрсөн тоорой. Хар л даа шинэ мах байгаа биз дээ! гэв.

Хадам эх бэлгийг үнэлж, найз охидыг гэртээ орууллаа. Удалгүй өнөөх эхнэрийн ааш ч нааштай болж, тэдэнд шалан дээр ор засаж өгөв. Өглөө хадам эж нь охидыг хөрш байшингийн танилгындаа хүргэж өгчээ. Тэднийд хүн байлгах сул өрөө байжээ.

Танил эмэгтэй нь охидоос хэдий хэрийн мөнгөтэй байгааг нь асуугаад, байрныхаа мөнгийг сарын өмнө урьдчилаж өгөхийг шаардла. Халасандаа сохор ч зоосгүй, унд хоолгүй үлдсэн охид ажил улам ч эрчимтэй хайж эхэлжээ.

Гэвч юу ч олж чадсангүй. Дахиад л Скориковын дээр яваад очив. Түүнээс өөр таних хүнгүй газарт тусламж үзүүлэхийг уйлж унжин байж хүсчээ. Хуучин багш эхэндээ эрс татгалзсан боловч дараа нь бага зэрэг бодсоны эцэст нэгэн байж боломгүй хүсэлт тавив. Охид ч "Бид бүхэнд бэлэн!" гэж хариулав.

Тэр зундаа тухайн дэвсгэрийн цагдаагийн газар дээрэмдүүлсэн эрчүүдийн өргөлдөлд даруулжээ. Нэгэн эр дажгүй охинтой кафед оройн хоол идэхээр уриаад, нойрны эм хольсон дарсанд согтож унажээ. Энэ хооронд нөгөө охин нь түүнийг хоосолсон байв. Өөр нэгэн залуу кинотеатрт сүүлийн кино үзэхээр үзэсгэлэнтэй үл таних бүсгүйтэй явжээ. Хамгийн арвн эгнээнд суугаад, үнсэлцэж байгаад гэнэт л үхсэн мэт унаад өгөв. Өглөө нь толгой нь өвдчихсэн, түрийвч нь хоосорчихсон босжээ. Сүүлийн киноны өмнөхөн нөгөө охин буфетнээс авсан оргилуун дарсаар дайлнаас өөр юу ч санахгүй байв.

Тэдгээр эр хоёулаа л сайн хувцасласан, бийлгэжүү, дайлахдаа мөнгө хайрлахгааргүй байв.

Тэднээс өөр хэчнээн ч эр хохирогч болчихоод цагдаад очоогүй байгааг мөрдөн байцаагчид мэдэхгүй.

Мөрдөн байцаагчид сэжигтний ам зургийг ч гаргаж чадахгүй байлаа. Зарим нь шаргал үстэй, өндөр гоолиг гэхэд нөгөө хэсэг нь улаан үстэй гээд байв. Нэг хүн хиймэл үс зүүгээд байна уу, эсвэл гэмт хэрэгтэн хоёулаа юу гэдгийг бүрэн тогтоосонгүй. Зөвхөн тэднийг өөрсдийгөө илчлэхийг хүлээхээс өөр зам үлдсэнгүй. Хоёр долоо хоног өнгөрлөө.

Цагдаагийн газар руу төмөр замын зогсоолоос холгүй орших, хүний хөл ихтэй кафегасаа угасджээ. Айсандаа болоод үйлчлэгч бүсгийн хэл нь эдэрсэн байв. Ширээний цаана суугаа таван хүн унтаад байгаа, үхсэн эсэхийг мэдэхгүй юм гэжээ. Зөндөө удсан ч хөдлөх ч үгүй. Тэдэнд ойртож очиход аймаар байгаа, чөмөдөн, цүнх нь газраар нэг

хөглөрсөн бөгөөд тэднийг дээрэмдсэн юм болов уу гэж үйлчлэгч бүсгүй уялган хэлэв.

Цагдаагийнхан яаралтай тусламжийнхантай хамт хэргийн газар очив. Эмч нар хэн нь үүрд унтсан, хэн нь хэсэг хугацааны дараа сэргэхийг үзэж мэдэх ёстой байлаа. Судасны цохилтыг шалгалтал бүгд амьд гагцхүү унтаж байв. Тэднийг хүчтэй нойрсуулагч эмээр унтуулж, дараа нь тонож орхисон нь тодорхой. Хамгийн эхний сэжигтэн цагдаа нарыг дуудсан үйлчлэгч бүсгүй өөрөө болов.

Түүнийг байцаагаад юунд ч буруугүй олж тогтоон суллагээ. Тэрээр дараахь зүйлийг ярьсан байна.

...Өглөө кафег дөнгөжонтойтол эхний үйлчлүүлэгч болох сүүлийн үеийн загвараар хувцасласан, хар шил, нүүрээ халхалсан урт, бейсболын саравчтай малгайтай охин орж иржээ. Тиймээс түүний гадаад төрхийг тодорхойлоход хэцүү юм.

Аялж байгаа хүмүүсийн хөтөч хийж байгаа охин ажээ. Тэрээр Москвагийн галт тэргэнд хохирогчидтой таарсан бөгөөд галт тэргэний буудлын тавцан дээр байхдаа тэднийг тухайн нутгийн сонирхолтой хэсгээр аялал хийх санал тавьсан аж. Явах унаагаа хүлээх тэд цаг өнгөрөөхийн тулд түүний тавьсан саналыг хүлээж авчээ. Өнөөх охин аяллын автобус шатахуунаа цэнэглэж байгаа тул удахгүй ирнэ гээд тэднийг бүгдийг нь кофе ууж, амраач гэж кафе д урилаа.

Кафе хэдийгээр хоосон байсан ч тэрээр бургас сүлжсэн хайсан засал чимэглэл халхалсан ширээний хажууд очиж суужээ. Яагаад бүхний нүднээс далд орсон нь одоо ойлгомжтой.

"Эхэндээ аяллаар явахаар 12 хүн хүссэн боловч ихэнх нь яваад тав нь л үлдсэн. Тэд кофе, цай захиалсан. Сууцааж, алиалж хөгжмид, хэзээ автобус ирэхийг лавлаж байсан. Хөтөч бүсгүй хүмүүс бага байгаа учир том автобусыг буцаасан. Маршрутын такси дуудсан учир жаахан хүлээх л үлдээд байна гэж учирлаж байсан" гэж үйлчлэгч бүсгүй яриу.

Бармен нь пуйварчинг баарны лангуунд ирж, таван шил пелси авахад нэг охин тусалсан гэдгийг

санажээ. Гэвч тэр нь хохирогчийн нэг үү, залилагч уу гэдгийг тогтооход хэцүү юм. Гадаад төрхийг нь санахад хэцүү. Бейсболын малгай, цүнх үүрсэн, жийнс, майктай байжээ. Яг л аяллын хөтөч охин шиг хувцасласан байв. "Тэд аялагчдын тоогоор таван шил пелси авсан" гэж эцэст нь бармен хэллээ.

Энэ үед жижүүрийн эрлийн хэсгийнхэн тэдэнтэй адил охидыг олсонгүй.

Нутгийн аяллын товчоо руу яриад өнөөдөр ямар ч аялал байгаагүйг олж мэдлээ. Энэ мужид автобус, маршрутын такси байдаггүй аж. Өрөөлдөгч байгууллагын талаар хэзээ ч сонсож байсангүй гэжээ. Үйл явц нь адилхан ч арай өөр газар гэмт хэрэгтнүүд хуулиас гадуур ичгүүр сонжуураа алдаж байна.

...Унтаж буй хүмүүсийн эрүүл мэндийг бодоод сэрээсэнгүй. Кафед харуул манаа тавилаа. Хэдэн цагийн дараа хүмүүс сэрж, цүнх, турийвчээ үзээд нэг ч төгрөг үлдээгээгүй мэдэв. Бүгд л үнэгүй пелсигээр дайлахад уусандаа харамсана. Тэд нэг нэг шилийг уугаад л унтаад өгчээ.

Аяллын хөтөч бүсгүйд тусалцаа үзүүлэх эмэгтэй байсныг тэд гэнэт саналаа. Нэг нь яриагаараа тэднийг сатааруулах зуур нөгөөх нь пелсид нойрсуулах эм хийж байжээ. Хамгийн сонор сэрэмж сайтай хохирогч бүсгүй нойронд явахдаа гудамжны эсрэг талд судалтай цамцтай, гучин тав орчим насны эр байсныг хэлэв. Тэр тэдний холоос ажиглан, тамхи угсруулан сорж, байсхийгээд л кафе руу хараад байсан тул гэмт хэргийн хамтрагч мөн гэж итгэлтэй өгүүлээ.

Гэмт хэрэгтнүүд хэтэрхий гэмээр мэргэжлийн ажиллаж, хохирогчид тийм гэх баримт юу ч үгүй хоцорч байв.

Долоо хоногийн дараа судалтай цамцтай эрийг мөрдөн байцаагчид олжээ. Тэр нь нутгийн оршин суугч Геннадий Николаевич Скориков хэмээх өмнө нь залилангийн хэргээр шүүхийн хаалга татсан нэгэн байв. Түүнийг баривчлан, холбоотой байдаг, байнга ирдэг хоёр охиныг хараандаа авчээ. Тэд Аня, Вера хоёр байлаа. Гэмт хэрэгтнүүд хэргээ хүлээсэн юм.

Геннадий Скориков нутгийн цагдаагийн газарт хангалттай алдартай нэгэн. Хорих газраас таван жилийн өмнө суллагдсан тэрээр

ажилгүй гэртээ суудаг, авгайтайгаа байнга хэрэлдэж, муудалцаж гэнэ.

Аникановкийн дунд сургууль түүний хар бараан өнгөрсөн талыг мэдсэнгүй. Баримт бичгээ хаясан гээд захиралд нь танилцуулахгүй байж дөнгөжээ. Гэвч сонор сэрэмжтэй захирал бүсгүй юунаас ч юм сэжиглээд, халж орхисон байна.

Багш, сурагч нарт Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйлээр ял оноосон юм. Скориковт давтан хэрэг үйлдсэн, эхэндээ ганцаараа залилан хийдэг байсан бол эцэстээ бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн гэдгээр хамгийн хатуу шийтгэлийг оноожээ. Насанд хүрээгүй Аня, Вера нарыг гэмт хэрэгт уруу татагдсан гэж үзээд баривчлах ял эдлүүлэхээр болов.

Орос хэлнээс орчуулсан Д.Унган

